UNIYERSITY OF INTERNAL AFFAIRS
SCHOOL FOR COURT DECISION EXECTION SERYICE

COURT DECISION EXECUTION STUDY

THEORETICAL AND METHODOLOGICAL QUARTERLY JOURNAL

2024
№02

Ulaanbaatar

Дугаарыг эрхлэн гаргаж
эмхэтгэсэн: Хурандаа Э.Батбаяр,
дэслэгч Б.Уянга

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхим

Эх бэлтгэсэн: Б.Тулга
Хэвлэл, редакцын хэлтсийн
эх бэлтгэгч-дизайнер, дэд ахлагч

Хэвлэлийн хуудас: 35.8
Хэвлэлийн тоо: 20

ISBN: 978-99978-770-2-4

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” сэтгүүл

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Цагдаагийн академийн өргөн чөлөө,
Хилчний гудамж,
Дотоод хэргийн их сургууль
И-мэйл: setguul.cd@gmail.com
Веб: uia.gov.mn

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ	JOURNAL EDITOR BOARD
Сэтгүүлийн эрхлэгч **Дамдинцэрэн Д.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор, бригадын генерал	**Editor of the journal** **Damdintseren D.** Director, School For Court Decision Execution Service, Ph.D, Brigadier general
Нарийн бичгийн дарга **Галбадрах Б.** Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн профессор, доктор, дэд профессор, дэд хурандаа	**Editor of the journal** **Galbadrakh B.** Professor of Social work and psychology department, Ph.D, Associate professor, Lieutenant colonel
Гишүүд **Алтангэрэл Б.** Доктор, профессор, хурандаа	**Members** **Altangerel B.** Ph.D, Professor, Colonel
Очгэрэл Ц. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны багийн тэргүүлэх профессорын орлогч, доктор, дэд профессор, хурандаа	**Ochgerel Ts.** Deputy professor of Professor research team ofCourt Decision Execution, Ph.D, associated Professor, Colonel
Баттулга Г. Аюулгүй байдлын тэнхимийн профессор, хурандаа	**Battulga G.** Professor, the Department of Security, Colonel
Батгэрэл Я. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, дэд хурандаа	**Batgerel Ya.** Professor of Civil Court Decision Execution Department, Lieutenant colonel
Батбаяр Э. Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, доктор, дэд профессор, хурандаа	**Batbayar E.** Professor of Department of Penal Law, Ph.D, Associate professor, Colonel
Мягмарсүрэн Д. Ахлагчийн мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа	**Myamarsuren D.** Head of Department of the Court Decision Execution Service of the Sergeant Profession, Training and Production Center, Ph.D, Lieutenant colonel

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн сэтгүүл

ДУГААРЫН ТОВЧООН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Үндсэн хуулийн эрх зүй

Б.Хулан
Монгол улсын үндсэн хуулийн үндсэн бүтэц ба түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, үзэл баримтлалын асуудал 2

Н.Бадраа
Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн тулгамдаж буй асуудал 16

Иргэн, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Г.Банзрагч
Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог 24

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ

Э.Батбаяр
Эрх хасах ялын харьцуулсан судлал 30

Б.Өнөрмаа
Өсвөр насны хүнд оногдуулж буй нийтэд тустай ажил хийлгэх ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний үр нөлөө 34

Д.Буяннэмэх
Пробацын үйл ажиллагааны мөн чанар, онцлог 41

Б.Уянга
Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан зарим асуудал 66

Б.Уянга
Цахим орчинд сошиал хаяг эзэмшихэд аюулгүй байдлыг хангах асуудал 81

С.Бямба-Эрдэнэ
Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах асуудал 93

Ч.Нансалмаа
Үе үеийн эрүүгийн хуульд нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулж ирсэн түүхэн уламжлал 114

Эрүүгийн эрх зүй

П.Эрдэнэбаатар
Залилах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн уламжлал, эрх зүйн дүн шинжилгээ 123

Ц.Очгэрэл
Галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ял, онцлог 142

Б.Наргулан
Монгол Улсад хохирогчийн эрх зүйн байдалд анхаарах зарим асуудал 153

Ц.Нандинцэцэг
Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр насныхны сэтгэцэд учирсан хор уршиг 169

Боловсрол судлал

Б.Батбаяр
Сургалтын танин мэдэхүйн үйл явц, арга хэлбэр 177

Ц.Өнөболд
Хүүхдийн хөгжилд оруулах хөрнгө оруулалтын зарим асуудал 192

Судлаач сонсогч, оюутан, суралцагч

Д.Буянхишиг
Эмэгтэй хоригдлын сэтгэл зүйн онцлогт тулгуурлан нийгэмшүүлэх асуудлыг судалсан нь 207

Н.Гэрэлчимэг
Өсвөр насны хүнд хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт 219

Ц.Шинэжаргал, С.Дулам
Гэрлэлт шүүхийн журмаар цуцлах ажиллагаа 231

Е.Гүлнур
Хүүхдийн тэтгэлэх гаргуулах ажиллагааны талаар 247

А.Янжин
Хоригдлын бие, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийхэд анхаарах асуудлууд 256

ЦАГ УЕ, ҮЙЛ ЯВДАЛ

“Монгол туургатны аварга-2024” цэргийн гардан тулааны аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо 267

"Сонсогчийн бие даан суралцах хөтөлбөр”-ийн хүрээнд гурван багц цагийн болзол хангасан сонсогчдод энгэрийн тууз гардуулж өглөө 268

“Миний сонирхол”, “миний бүтээл” үзэсгэлэн зохион байгууллаа 270

Сонсогчдын 2024 оны марш, тусгай бэлтгэлийн тэмцээний аваргууд тодорлоо 272

Манай сонсогчид өсвөр үе, залуучуудын дэлхийн аваргын тэмцээнээс 8 хүрэл медаль хүртлээ 274

“Young womens leadership” хөтөлбөр амжилттай хэрэгжлээ 276

“Манай сургууль-90 жил” эссэ бичлэгийн уралдаан зохион байгууллаа 277

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчид мод тарилаа 292

Монгол улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит “сонсогчийн алдар” гардан тулааны нээлттэй тэмцээн эхэллээ 293

Төгсөгчдөд боловсролын зэргийн диплом, энгэрийн тэмдэг, цол гардуулах ёслолын ажиллагаа боллоо 297

Төгсөгчдийн “туяат оройн тооллого” ёслолын ажиллагаа боллоо 300

"Мөрдөгч клуб"-ын төгсөгчдөд сертификат, энгэрийн тэмдэг гардууллаа 302

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм хүндэт уншигч Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас улирал тутам эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” онол-арга зүйн сэтгүүлийн 2024 оны №2 дугаарыг тус сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхим эрхлэн гаргаж уншигч та бүхэнд хүргэж байна.

Тус сэтгүүл нь 2012 онд анхны дугаараа нийтийн хүртээл болгосноос хойш 48 дугаарыг тасралтгүй хэвлэн нийтлүүлсэн байна. Ингэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын судалгааны голлох эх сурвалж болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын үе үеийн эрдэмтэн профессорууд болон судлаачдын судалгаа, эрдэм шинжилгээ өгүүлэл, ял эдлүүлэх ажиллагаа, иргэн, захиргаа, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ зэргийг хэвлэн нийтэлдэг манай салбарын шинжлэх ухаан практикт өөрийн өнгө аяс бүхий хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болон хөгжиж ирсэн билээ.

Тус сэтгүүл нь 2018 оноос хойш олон улсын цуврал сэтгүүлийн хэвлэлтийн бүртгэлд ISBN:978-99978-720-2-4 дугаартайгаар бүртгэгдсэн нь олон улсын хэмжээнд баталгаажсан болохыг илтгэж байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүлийн II улирлын дугаарын онцлог нь Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойд зориулагдсанаараа онцлогтой болно. Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн судлагдахууны хүрээгээр хязгаарлахгүйгээр үндсэн хуулийн эрх зүй, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, шинжлэн магадлахуй, боловсрол судлал, удирдахуйн ухааны онол, практикийн тулгамдсан асуудлыг хөндөн судалсан багш, судлаагчдын судалгааны ажлыг нийтийн хүртээл болгож байгаа юм.

Тус сэтгүүлийг орчин үеийн технологийн хөгжил, дэвшилд нийцүүлэн цахим хэлбэрт шилжүүлэн олны хүртээл болгохоор ажиллаж байна.

Уншигч, судлаач та бүхэн Монгол улс болон олон улсын түвшинд дүйцэхүйц шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын сэтгүүлийг буй болгох үйлсэд бидэнтэй хамтран ажиллаж, хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Уншигч Таны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тань өндөр амжилт хүсье.

Хүндэтгэсэн:

ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ТЭНХИМИЙН
ПРОФЕССОР, ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР,
ХУРАНДАА Э.БАТБАЯР

Үндсэн хуулийн эрх зүй

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮНДСЭН БҮТЭЦ БА ТҮҮНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН АСУУДАЛ

BASIC STRUCTURE OF THE CONSTITUTION OF MONGOLIA AND THE PROBLEM OF OPINIONS ON ADDITIONS AND AMENDMENTS TO IT



Б.Хулан

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн ахмад

Товч утга: Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц түүнд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын асуудал сэдвийн хүрээнд Үндсэн хуулийн үндсэн бүтцэд юуг хамааруулан ойлгож буй талаар мөн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага буюу Үндсэн хуулийн ямар заалтын юуг нь яаж өөрчлөх, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа юунд анхаарах түүний хэрэгжилтэд тулгамдаж асуудлын талаар олон улсын жишигтэй харьцуулан судаллаа.

Түлхүүр үгс: Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын үндсэн хуулийн үндсэн бүтэц, нэмэлт өөрчлөлт, тулгамдсан асуудал

Abstract: The basic structure of the Constitution of Mongolia, within the framework of the conceptual issue of amending it, what is understood in relation to the basic structure of the constitution, and the need to amend the constitution, or how to change what provisions of the constitution, additions, what to pay attention to when making changes, the problems in its implementation were studied in comparison with international standards.

Key words: Constitution of Mongolia, basic structure of the Constitution of Mongolia, amendments, pressing issues.

ҮНДСЭН ХЭСЭГ

Сүүлийн 25 гаруй жилийн хугацаанд Улсын Их Хурал 605 хууль баталсны 200-аад нь Үндсэн хуулийн зөрчилтэй байдгийг Үндсэн Хуулийн Цэц хүлээн зөвшөөрч байна. Эндээс үзвэл Үндсэн хууль буруутай байна уу, эсвэл Үндсэн хуулийг зөрчиж байгаа эрх мэдэлтэн, албан тушаалтнууд буруутай байна уу гэдэг асуудлыг дотроо авч хэлэлцэх шаардлага урган гарч байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ямар үндэслэл болон шалтгаан байгаа, өөрчлөлт оруулах санал санаачилга нь хэний хүсэл сонирхол вэ? гэдгийг огт хөндөхгүй хэлэлцэхгүй, бодитой судалгаа шинжилгээ хийгээгүй байж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж буй нь өмнө нь оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд харуулж байна.

Үндсэн хууль бол хувийн болоод нийгмийн өдөр тутмын элдэв учрал, ээдрээтэй асуудлыг зохицуулдаггүй. Харин Үндсэн хууль бол аливаа орны гол хууль төдийгүй улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч хууль. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн тогтвортой байдал нь төрийн тогтвортой байдлын үндэс болдог. Гэвч тэрхүү тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр Үндсэн хуульдаа хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах болон оруулсан нэмэлт, өөрчлөлтийг нэг мөр, хоёрдмол утгагүйгээр ойлгох, түүний хэрэгжилтийг хэрхэн хангах зэрэг асуудлууд биднийг тойрон эргэж байна.

Б.Чимид гуай “Дээдсийн мэдлийг хязгаарлан барьж, иргэдийн эрхийг хүндэтгэн дээдлэх, улсаа төвхнүүлэх, засаг төрөө байгуулах эцэг хэм хэмжээг Үндсэн хууль гэдэг. Түүний хил хязгаарыг давж алхах эрх хэнд ч байхгүй бөлгөө”[1].

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь аль ч орны хувьд байдаг зүйл боловч нэмэлт, өөрчлөлт бүхэн Үндсэн хуулийн чанар чансааг сайжруулдаг гэж үзвэл хараахан тийм биш ажээ. АНУ-ын Чикагогийн Их сургуулийн профессор Росалинд Диксон “Нэмэлт, өөрчлөлт гэдэг үг нь туршлага болон улс төрийн ойлголтын өсөн хуримтлагдсан мэдээллийн хүрээнд зөвхөн дахин засах, сайжруулах гэдэг утгыг л илэрхийлдэг юм”

[1] Батбаяр, Б. Пүрэвцэцэг, Л. “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал”, Уб, 2017он, 206дах тал

гэжээ. Үндсэн хуулийндаа нэмэлт өөрчлөлт оруулах, үндсэн бүтцийн талаарх асуудал Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн нэг гэж үзэхээр байна.

НЭГ. ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ БА ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ХУУЛЬ ЗҮЙН АГУУЛГА

Эхлээд Үндсэн хууль нэмэлт оруулах гэж чухам юуг хэлэх вэ? Үндсэн хуульд өөрчлөлт хийх гэж яахыг хэлэх вэ? Гэдэг хууль зүйн өөр хоорондоо адилгүй өөр өөр эрх зүйн үр дагавар бүхий зааг ялгаатай зүйлийг манай улсын Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн яамны мэргэжлийн ажлын албадын олон жилийн практикт зүгээр л "тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" гэж нэг нийлмэл зүйл болгон хэтэрхий хялбарчилж адилтгадаг болчихсон буруу сэтгэлгээг халах хэрэгтэй. Дэлхийн чиг хандлагыг харахад Үндсэн хуульд бол ихэвчлэн нэмэлт л ордог, "өөрчлөлт" гэдгийг бараг хийдэггүй, хийсэн ч маш нарийн процедур, хатуу дэг журмыг баримтлахад гадна судалгаа шинжилгээний бодит үр дүнд тулгуурладаг байна.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэдэг нь аливаа улс гүрэн тухайн цаг үеэ мэдэрч, ирээдүйг харсан урт удаан жилээр нийгмийн харилцааг зохицуулж чадахуйц зүйл, заалтаар урьд нь орхигдсон буюу дутагдалтай тусгагдсан зүйл, заалтыг нэмж оруулах буюу өөрчлөх явдал юм[1].

Зарим улсын Үндсэн хуулиас түүвэрлэж үзвэл хэн дуртай этгээд Үндсэн хуулийн нэмэлт ярьж, олон нийтийг үймүүлээд байлгахгүйн тулд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд доорх хууль зүйн шаардлага тавигддаг байна. Үүнд:

- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл ба шалтгааныг нийгэм, эдийн засаг, хууль зүйн талаас нь тодорхойлсон танилцуулга, судалгааны тойм гаргах;

- Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийн томьёоллыг гаргаж уг асуудлыг боловсруулсан этгээд олон нийтэд товч тодорхой танилцуулна;

[1] Нармандах, Б. "Үндсэн хуулийн эрх зүй" 4 дэх хэвлэл, Уб, 2017он, 36 дах тал

- Санаачлагчдын гарын үсэг /иргэд санаачилж байгаа тохиолдолд дунджаар 20-150 мянган иргэний гарын үсэг цуглуулах гэх мэтээр/;

- Уг нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль мөн болохыг зориуд зааж өгсөн байх зэрэг шаардлагууд юуны урьд тавигддаг байна[1].

Монгол Улсын одоогийн цаг үе, нийгмийн байдал нь Үндсэн хуулийг боловсруулж байсан 1991 оны үеэс ихээхэн өөрчлөгдсөн бөгөөд эдгээр нийгэм, эдийн засаг, улс төрийн өөрчлөлтөөс хамаарч Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсэж байна. Тодруулбал, шинэ Үндсэн хуулийн дэглэм үйлчилсэн 25 жилийн хугацаанд төрийн эрх мэдэл хоорондын харилцан хяналт-тэнцлийг хангах, улс төрөөс хараат бус, мэргэшсэн чадварлаг, нэр хүндтэй төрийн албыг бэхжүүлэх, засаг захиргаа, нутгийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх, төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлж, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулахтай холбогдсон зарим нэг асуудлыг шийдвэрлэх шаардлага нийгмийн хөгжлөөс урган гарч байна. Ингэхдээ энэхүү асуудалд хөнгөн хуймгаа хандах бус олон улсын нийтлэг жишгийг баримтлан нарийн процедур, хатуу дэг журам, судалгаа шинжилгээний бодит үр дүнд тулгуурлах бидний хийх ёстой хамгийн чухал алхмын нэг болж буйг[2] судлаачид эрдэм шинжилгээний бүтээлдээ дурдсан байна.

ХОЁР. ҮНДСЭН ХУУЛИЙН ҮНДСЭН БҮТЭЦ УХАГДАХУУН

Монгол Улсын Үндсэн хуульд 2000 онд оруулсан 7 өөрчлөлт, түүнийг тойрон өрнөсөн олон жилийн маргаан, мэтгэлцээний явцад юуны түрүүнд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ямар журмаар хийх ёстой вэ? гэдгийг тусгайлсан хууль гарган зохицуулж өгөх нь зүйтэй гэдэг дээр хууль тогтоогчид болон судлаачид 2010 оны үед үндсэндээ санал нэгдсэн юм. Ингээд “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай” хуулийн төслийг 2010 оны эхээр боловсруулж уг хуулийн төслийг Улсын Их Хурал мөн оны 12 дугаар сарын 23-ны өдөр хуульчлан баталсан байна. Ийнхүү “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

[1] Батбаяр, Б. Пүрэвцэцэг, Л. “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал”, Уб, 2017он,187-188 дах тал

[2] Лүндээжанцан, Д. “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үзэл баримтлалын асуудал” илтгэл, 89-90 дах тал

журмын тухай” хууль батлагдсанаар манай эрх зүйд “Үндсэн хуулийн үндсэн бүтэц” хэмээх нэр томьёо шинээр бий болсон гэж үздэг[1]. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад байхгүй шинэ томьёоллоор зохих бүлэгт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг Үндсэн хуулийн нэмэлт гэх бөгөөд тэр нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байна.” гэж заасан бөгөөд хуулийн үндсэн бүтэц гэдэгт юуг хамааруулж ойлгох вэ? гэдгийг уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтаар тодорхойлсон байна. Уг заалтад “Үндсэн хуулийн Нэг, Хоёр, Гурав, Дөрөвдүгээр зүйл, Тавдугаар зүйлийн 1-4 дэх хэсэг, Зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөв, Арван тав, Арван ес, Хорьдугаар зүйл, Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин нэг, Дөчин долдугаар зүйл, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран найм, Жаран есдүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно” гэж заасан юм. Өөрөөр хэлбэл энэ зүйлд заасан Үндсэн хуулийн зүйл, хэсэг, заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтцийн бүрэлдэхүүн гэж үзнэ.

Тэгвэл Хүний эрх, эрх чөлөөг тунхагласан хоёрдугаар бүлгээс зөвхөн Арван дөрөвдүгээр зүйл, Арван тавдугаар зүйл, Арван ес дүгээр зүйлийг Үндсэн хуулийн Үндсэн бүтцэд оруулж, Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг үлдээсэн байна[2]. Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд тусгаж өгсөн хүний үндсэн эрхийг Үндсэн хуулийн үндсэн бүтцэд хамааруулаагүй нь учир дутагдалтайг харуулж байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШАЛТГААН, ҮНДЭСЛЭЛ

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага. Аливаа философи суурь болон тохиолдлын бүтэцтэй байдгийн адил Үндсэн хуулийн философи ч ялгаагүй хуулийн амин сүнс болох хүний эрхийг хамгаалж, улс төрийн өөрчлөлт, сонгуулийн үр дүн, хүчтэй тэнцвэрийн

[1] http://www.conscourt.gov.mn/?page_id=3238
[2] Одбаяр, Д. “Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц” илтгэл, 69 дах тал

харьцаанаас үл хамааран засаглалыг хязгаарлаж байхын тулд тэрээр тогтвортой үйлчилж, нийгэмд тогтсон эрх зүйн дэг журмыг суурь бүтцээрээ баталгаатай хангах ёстой [1] . Нөгөө талаас Үндсэн хуулийг хэзээ ч өөрчлөгдөшгүй мөнхийн зүйл гэж туйлшруулан ойлгож болохгүй. Амьдрал үргэлж хувьсан дэвшиж байдаг болохоор түүнийг дагаж эсхүл дагуулж Үндсэн хуульд зохих өөрчлөлтийг цаг тухайд нь оруулж байх нь зүй ёсны үзэгдэл бөгөөд хэрэв нийгмийн өөрчлөлийн зүй тогтлыг мэдрэхгүй бол тэрээр нийгмээс хоцорч ирээдүй рүү тэмүүлсэн баримт бичиг гэхээсээ илүү хөгжлийг сааруулж боомилох аюултай байдаг байна.

Үндсэн хууль тогтвортой байх нь туйлын чухал боловч түүнд зарим нэг өөрчлөлт, нэмэлт оруулах онцгой шаардлага улс орны амьдралаас урган гарч, ард түмний өмнө тулгарч болно. Тэр шаардлага нь аль нэг улс төрийн нам, бүлэглэлийн биш, харин бүх нийтийн нийтлэг ашиг сонирхлыг тусгасан бодит үндэслэлтэй байх ёстой. Ийм учраас хууль санаачлахаас гадна ард түмнээсээ асуудаг тогтолцоо ч байдаг. АНУ-ын Үндсэн хуулийн 5-р зүйлд зааснаар Конгрессын хоёр танхимын гишүүдээс гадна муж улсынхаа гуравны хоёрын / 50 муж улсын 34-өөс доошгүй нь/ хууль тогтоох хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь чухал гэж үзсэн бол уг асуудлыг үүсгэн хэлэлцэх үндэстэйд тооцдог зэрэг бусад улсын жишээ бий.

Манай улсын хувьд ард түмнээсээ асуух үндэслэл бий юу? Үндсэн хууль бол эцсийн дүнд ард түмний эрх мэдэл дэх хууль юм. Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлээс:

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар... ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна~ /68.2/

Энэ заалт бол Үндсэн хуулийг хөндлөнгийн оролцооноос сэрэмжилж тогтвортой байлгах нэгэн гол баталга мөн. Түүнчлэн дээрх заалт нь яахыг ард түмэн “асуугдах” төдийгүй, төгс шийдвэрлэх бүрэн эрхтэйг илтгэнэ. [2]

Ард нийтийн санал асуулгаар нэмэлт өөрчлөлт оруулахдаа Ард нийтийн санал асуулгын хуулиар болон Сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулна. Санал асуулга явуулах өдрийг энэ тухай УИХ албан ёсоор

[1] Тэмүүжин, Х. “Үндсэн хуулийн дархлаа ба хамгаалалт” өгүүлэл, Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал сэдэвт бага хурлын эмхэтгэл, Уб, 2005он
[2] Чимид, Б.Үндсэн хуулийн мэдлэг, Уб, 2008он, 419-420 дах тал

нийтэлнэ. Энэ үндсэн дээр бүх бэлтгэл болон кампанит ажлыг товлосон хугацаанд зохион байгуулдаг.

Ийнхүү иргэд эцсийн дүнд Үндсэн хууль тогтоон батлах эрхтэй байгаа нь энэ тухай зохих мэдлэгтэй байж, Үндсэн хуулийн тогтвортой байдалд хяналт тавих, зөрчил гажуудал илэрвэл ҮХЦ-д хандах, эсэргүүцэл илэрхийлэх "хууль зүйн өргөн боломжтойг харуулна." Гэвч ард иргэдийн дунд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ард нийтийн санал асуулгын талаар төдийлөн зохих мэдлэггүйн улмаас хамрагдаж чаддаггүй. Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ард нийтийн асуулга нь яг бодитоор тусгалаа олж чадахгүй байна.

Улс төрийн нам, иргэний нийгмийнхэнтэй хэлэлцэж, ард түмэндээ танилцуулж, санал бодлыг нь авч, бүхий л түвшний ойлголцол зөвшилцлийг ханган ажилласны үндсэн дээр 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон 64 гишүүний 100 хувийн саналаар Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны Үндсэн хуульд оруулсан 19 зүйл, 36 заалт бүхий нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, утга санааг ягштал, нэг мөр хэрэгжүүлэх асуудал монголын нийгмийн хойшлуулшгүй бөгөөд нэн тулгамдсан зорилт болон тавигдаж байна. Энэ нь нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, хэлэлцэж батлахаас бүр ч илүү нарийн чимхлүүр, хариуцлагатай, нөр хичээнгүй ажил үйлсийг шаардаж байна"[1] хэмээн МУИС-ийн Эмерит профессор, Монгол Улсын Их Хурлын гишүүн асан С.Нарангэрэл илтгэлдээ дурдсан байдаг.


Монгол Улсын Үндсэн хуульд тодорхой асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Улсын Их Хурлын гишүүдээс 2000, 2011, 2012, 2015 онуудад Монгол Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлж байсан.

Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос явуулсан судалгаа[2]: Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос /ҮХЭЗХ/ судалсан байна. Судалгааны мэдээллийг танилцуулбал, Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэсэн 296 маргааны 141 нь Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгтэй холбогдож,

[1] Нарангэрэл, С. "Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, утга санааг хэрэгжүүлэх асуудал" илтгэл
[2] http://conscourt.gov.mn/?p=7697

иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, мөн эрх бүхий байгууллагын хүсэлт байжээ. Судалгаанаас харахад, ҮХЦ-д иргэд 98 хувьтай хандсан байгаа юм.


Зураг №01. Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурлын шийдвэртэй холбоотой иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт




Зураг №02. Үндсэн хуулийн цэцэд Ерөнхийлөгчийн шийдвэртэй холбоотой ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт



Зураг №03. Үндсэн хуулийн цэцэд Шүүхийн шийдвэртэй холбоотой ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт



Зураг №04. Үндсэн хуулийн цэцэд Засгийн Газрын шийдвэртэй холбоотой ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт



Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос /ҮХЭЗХ/ судалсан байна. Судалгааны мэдээллийг танилцуулбал, Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэсэн 296 маргааны 141 нь Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгтэй холбогдож, иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, мөн эрх бүхий байгууллагын хүсэлт байжээ. Судалгаанаас харахад, ҮХЦ-д иргэд 98 хувьтай хандсан байгаа юм. ҮХЦ-ийн нийт 296 шийдвэрийн дүгнэлт, тогтоолыг тодруулбал, Үндсэн хуульд нийцсэн эсэх хууль 287, зарлиг хоёр, УИХ-ын тогтоол 20, Засгийн газрын тогтоол 15, СЕХ-ны тогтоол дөрөв Үндсэн хууль зөрчсөн эсэх

УИХ-ын дарга гурав, УИХ-ын гишүүн гурав, Ерөнхий сайд дөрөв, Ерөнхий шүүгч нэг, Ерөнхий прокурор нэг, Огцруулах, эгүүлэн татах үндэслэл бий эсэх УИХ-ын дарга нэг байна. Үндсэн Хуулийн Цэц хянан шийдвэрлэсэн 296 маргааны 141 нь Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгтэй холбогдож иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээлэл мөн эрх бүхий байгууллагын хүсэлт байна. Тэгвэл Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт 20 гаруй зүйлд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулсан ба судалгаанаас авч үзэхэд Үндсэн хуульдаа энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан нь маргаантай байгааг харуулж байна.

ДӨРӨВ. ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ЖИШИГ

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах горим ба процедур нь ердийн хуультай харьцуулахад маш өндөр (критери) шалгууртай, илүү нарийвчилсан бөгөөд тусгайлсан журмаар хэрэгжих хатуу зарчимтай. Энэ нь Үндсэн хуулийн цөм болсон зарим заалтуудыг өөрчлөхийг шууд хориглоход чиглэгддэг. Тухайлбал, ХБНГУ-д Үндсэн хуулийн зарчим, төрийн байгууламжийн үндэс, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон заалтуудыг өөрчлөхийг хориглосон бол Франц, Итали улсад засаглалын бүгд найрамдах хэлбэрийг өөрчлөхийг хориглосон байна.

Дэлхийн ихэнх улс оронд Үндсэн хуульдаа нэмэлт ба өөрчлөлт оруулахад доорх хэм хэмжээг жишиг болгон баримталж байна.[1]

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах үйл явц өөрөө тусгайлсан журам баримтлахыг шаарддаг. Үндсэн хууль гэдэг үнэт зүйл рүү амтай болгон дайрч давшилдаггүй, Засгийн газар, Парламентын зарим нэг сайд, гишүүн бүү хэл бүлэг фракцаараа ч Үндсэн хуулийн үзэл санаа санаачилга гаргах эрхгүй болохыг Үндсэн хуулийн түүхэн сургамж өөрөө харуулсан юм. Учир нь Үндсэн хууль нийгмийн хамтын амьдралын үндсийг тодорхойлоод зогсохгүй ялангуяа, хууль болон хуулийг дагалдан гаргах Үндсэн хуульд холбогдох эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх зарчимд үндэслэгдэнэ.

[1] Батбаяр, Б. Пүрэвцэцэг, Л. “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал”,Уб, 2017он,195-197 дах тал

2. Парламент Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа уг шийдвэрийг Референдум явуулж түүний үр дүнг харгалзан баталдаг туршлага бас байна /Дани, Египет, Швейцар/.

3. Холбооны зарим улсуудад муж улсуудын олонхын саналаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг (АНУ-д 3/4) хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ үйлчлэх зарчим ч бий.

4. Зарим тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа бүх шатны албан ёсны хэлэлцүүлэг явагдаж дууссаны дараа урьдчилсан болон эцсийн гэсэн хоёр удаагийн чуулганаар шийдвэрлэдэг бөгөөд эцсийн чуулганы шийдвэр ердийн дийлэнх олонх биш “онцгой нэмэгдүүлсэн дийлэнх олонх”-ын саналаар батлагддаг тохиолдол /Украйн/ байна.

5. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуралдааны санал хураалтын квот нь ихэнхдээ ердийн биш дийлэнх олонх байдаг. Жишээ нь, Болгарт ¾, Францад танхимуудын хамтарсан хуралдааны 3/5, Казахстанд 4/5-ын санал авсны дараа Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг рефендумд шилжүүлдэг жишиг байна.

6. Зарим орнууд Үндсэн хуулийнхаа тодорхой бүлэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг бүр мөсөн хориглодог. Тухайлбал, Германд эрх зүйт, ардчилсан, холбооны төрийн зарчимд, Испанид онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэх мэт.

7. Үндсэн хууль нь батлагдсанаас хойш тодорхой хугацаанд түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох /Бразил, Грек, Португал-5жил/ нь бий.

8. Мөн улсын нийт нутаг дэвсгэрт болон хэсэгчилсэн байдлаар онц болон дайны байдал зарласан, мөн харийн түрэмгийлэлд өртсөн үед Үндсэн хуульд гар хүрэхийг хориглодог.

9. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал, санаачилга гаргах байгууллага, субъектийг хязгаарладаг байна. Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Арбитрын дээд шүүх хууль санаачлах эрхтэй боловч энэ эрх нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд хамаардаггүй гэх мэт нийтлэг жишиг үйлчилж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын оршин тогтнох үндэс бол бидний Үндсэн хууль бөгөөд эрх зүйн тогтолцооны хөдөлшгүй чиг баримжаа болж, хуулиас дээгүүр буюу гадуур хэн нэгний аливаа хүсэл зориг ноёрхох явдлыг хязгаарладаг. Үндсэн хууль бол аливаа орны гол хууль төдийгүй улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч хууль мөн. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн тогтвортой байдал нь төрийн тогтвортой байдлын үндэс болдог.

Гэвч Үндсэн хуулийг хэзээ ч өөрчлөгдөшгүй мөнхийн зүйл гэж туйлшруулан ойлгож болохгүй. Амьдрал үргэлж хувьсан дэвшиж байдаг болохоор түүнийг дагаж эсхүл дагуулж Үндсэн хуульд зохих өөрчлөлтийг цаг тухайд нь оруулж байх нь зүй ёсны үзэгдэл бөгөөд хэрэв нийгмийн өөрчлөлийн зүй тогтлыг мэдрэхгүй бол тэрээр нийгмээс хоцорч ирээдүй рүү тэмүүлсэн баримт бичиг гэхээсээ илүү хөгжлийг сааруулж боомилох аюултай байдаг талаар дээр дурдсан билээ. Харин төрийн тогтвортой байдал, улс орны тулгуур багана болсон Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж илүү төгөлдөржүүлэхийн тулд хийж буй алхмуудад хэд хэдэн асуудал тулгамдаж байна хэмээн үзэж байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлал, утга санааг ягштал, нэг мөр хэрэгжүүлэх асуудал нийгмийн тулгамдаж буй асуудлын нэг болж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, заалтыг хэрэглэх талаар үүссэн хоёрдмол утга, ойлгомжгүй байдлыг арилгах хууль ёсны арга зам нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, утга санааг гуйвуулахгүйгээр түүний зүйл, заалтыг зөв тайлбарлах явдал нь бодитой хэрэгжиж чадахгүй байна.

Үндсэн хуулийн үндсэн бүтэц гэдэгт юуг хамааруулж ойлгох вэ? гэдгийг уг хуулийн 5 дугаар зүйлд тусгаж өгсөн байна хэмээн дээр дурдсан тэгвэл Хүний эрх, эрх чөлөөг тунхагласан хоёрдугаар бүлгээс зөвхөн Арван дөрөвдүгээр зүйл, Арван тавдугаар зүйл, Арван ес дүгээр зүйлийг Үндсэн хулийн Үндсэн бүтцэд оруулж, Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг үлдээсэн байна. Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд тусгаж өгсөн хүний үндсэн эрхийг Үндсэн хуулийн үндсэн бүтцэд хамааруулаагүй нь учир дутагдалтайг харуулж байна.

Мөн ард иргэдэд Үндсэн хуулийн тухай мэдлэг, эрх зүйн боловсрол дутмаг байгаагаас Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар Ард

нийтийн санал асуулгад идэвхтэй хамрагдаж чадахгүй байна. Иймд Үндсэн хууль, эрх зүйн талаар ард иргэдэд мэдлэг боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Бид Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дээр дурдсанчлан нэмэлт, өөрчлөлт оруулах горим ба порцедураа маш өндөр(критери) шалгууртай, илүү нарийвчилсан бөгөөд тусгайлсан журмаар хэрэгжүүлж хатуу зарчмыг ягштал баримталж, гадаад улсуудын туршлагыг шууд хэрэглэх бус тэдгээрийн туршлага дээр өөрсдийн улс төр, нийгэм, эдийн засагтаа тохирсон зарчмыг боловсруулах хэрэгтэй хэмээн дүгнэж байна.

САНАЛ

Үндсэн хуулийн үндсэн бүтцэд юуг хамааруулан ойлгож буй талаар мөн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага буюу Үндсэн хуулийн ямар заалтын юуг нь яаж өөрчлөх, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа юунд анхаарах түүний хэрэгжилтэд тулгамдаж асуудлын талаар судалж дараах саналыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд оруулсан зүйл, заалтыг хэрэглэх талаар үүссэн хоёрдмол утга, ойлгомжгүй байдлыг арилгах. Үндсэн хуулийн үзэл баримтлал, утга санааг гуйвуулахгүйгээр зөв тайлбарлах;

2. Улс орнууд эрх зүйн тогтолцоо, төрийн байгууламжийн хэлбэр, засаглалын дэглэм, газар нутаг, нийгмийн хөгжил зэргээс хамаар өөр өөрсдийн хөндөж үл болох Үндсэн хуулийн заалтыг тодорхойлдог. Манай улс ч гэсэн Үндсэн хуулийн үндсэн бүтцийг тодорхойлон хөндөж үл болох заалтуудыг тусгасан гэвч тэр нь хүний эрх, эрх чөлөөг тусгаж өгсөн Хоёрдугаар бүлгийн хоёрхон зүйлийг оруулсан учир дутагдалтай тиймээс Үндсэн бүтцийг дахин засварлах;

3. Ард иргэдийн Үндсэн хууль болон эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж, ард нийтийг идэвхтэй хамруулахад анхаарах;

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ (BIBLIOGRAPHY)

1. Б.Нармандах, “Үндсэн хуулийн эрх зүй” 4 дэх хэвлэл, УБ, 2017он

2. Б.Батбаяр, Л.Пүрэвцэцэг, “Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал”,УБ, 2017он

3. Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг, УБ, 2008он

4. С.Нарангэрэл “Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, утга санааг хэрэгжүүлэх асуудал” илтгэл

5. Д.Одбаяр “Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц” илтгэл

6. Б.Чимид, “Үндсэн хуулийн үзэл баримтлал”, УБ

ЭРХ ЗҮЙН АКТ (LEGAL ACT)

1. Монгол Улсын Үндсэн Хууль. УБ, 1992.

2. Монгол Улсын үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай. УБ , 2010.

3. Ард нийтийн санал асуулгын тухай. УБ, 2016.

ИНТЕРНЭТ ЭХ СУРВАЛЖ

1. https://legalinfo.mn/mn/
2. http://conscourt.gov.mn/?p=7697
3. http://www.conscourt.gov.mn/?page_id=3238

---o0o---

ХҮНИЙ ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

CHALLENGING PROBLEMS OF HUMAN RIGHTS TO LIVE IN A SAFE ENVIRONMENT



Н.Бадраа

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга:

Энэ өгүүллээр эрүүл аюулгүй орчинд амьдрах хүний эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зарим саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: In this report, some suggestions on how to the implementation of the right to live in a healthy and safe environment, the problems, and the measures to be implemented in the future have been put forward.

Түлхүүр үг: Үндсэн хууль, Хүний эрх, Эрүүл аюулгүй орчин, Орчны бохирдол, Засгийн газар

Key words: Constitution, Human Rights, Healthy and Safe Environment, Environmental Pollution, Government

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2т зааснаар Монгол улсын иргэн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Гэвч иргэний энэхүү үндсэн эрх бодитой хангагдаж чадахгүй байгаад нийт иргэд шүүмжлэлтэй хандсаар байна.

Үндсэн хуулийн энэ эрхийг хангах зорилгоор Монгол Улс иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг улам бүр баталгаажуулах үүднээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн

орох, түүнчлэн дотоодын эрх зүйн актуудад тухай бүр тусган баяжуулах арга хэмжээг тасралтгүй авч ирсэн. Энэ хүрээнд Монгол Улс Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенц, Биологийн олон янз байдлын Конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Конвенциудад нэгдэн орсон байдаг.

Хүний эрхийн конвенц, зохицуулалт заалтуудыг хэрэгжүүлэх асуудал дэлхийн улсуудын хувьд өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна. Монгол Улсын хувьд "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах … эрхийг" бодитоор хамгаалах, хэрэгжүүлэх асуудал тунхаглалын шинжтэй оршсоор байна.

Дэлхийн нийтийн жишигт энэхүү эрхийг бодитоор хэрэгжүүлэх үндэслэл нь дараах хоёр төрлийн идэвхтэй үйлдлээр илэрдэг. Нэгдүгээрт хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын идэвхтэй үйл ажиллагаа хоёрдугаарт шүүхийн байгууллага энэхүү үндсэн эрхийн зөрчлийг харьяалан шийдвэрлэх эрх хэмжээ ба хүсэл зоригтой шууд холбогддог. Харин эрх бүхий албан тушаалтнууд түүнийг эдийн засгийн байдалтай шууд холбон идэвхгүй хүлээлтийн байдал үүсгэдэг. Энэ тохиолдолд Монгол улсын шүүх байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагаа нь энэхүү хүний эрхийн заалтыг бодитойгоор хэрэгжүүлж, гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагад хууль ёсны шахалт үзүүлэх нь гол гарц юм.

Монгол Улсын дэвшил хөгжлийн мөн чанар, шинж төрхийг бүрэлдүүлэн төлөвшүүлэх нийгэм-эдийн засгийн зорилтуудын хэрэгжилт нь бодит байдал дээр илт хангалтгүй байгаа нь олон зүйлээр илэрч байна Эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс байгаль орчны стандартуудыг батлан мөрдүүлсэн. Хүний эрх болон байгаль орчин хамгаалалт хоорондын хамаарлыг Үндсэн хуульдаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд тусгаж хүлээн зөвшөөрсөн. Агаарын бохирдол, ашигт малтмал зэрэг нарийвчилсан байгаль орчны талаарх хуулиудыг батлан гаргасан. Хэдийгээр зарим нэгэн дутагдал байсаар байгаа боловч гол асуудал нь стандартуудын чанарт бус тэдгээрийн хэрэгжилтэд байна.

Төрийн албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагаандаа холбогдох байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж, хувийн хэвшлийн оролцогчид болон төрийн албан тушаалтнууд эдгээр стандартуудыг зөрчихөөс урьдчилан сэргийлж, мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэж, стандартын

хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

1.ҮНДСЭН АСУУДАЛ

Хүн амьд явах салшгүй эрхтэй. Мөн эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Харин эдгээр эрхээ зүй ёсоор эдлэхийн тулд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах зэргээр байгаль, нийгмийн элдэв сөрөг нөлөөллөөс ангид байх ёстой юм. Амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас төр иргэнээ хамгаалах үүрэг хүлээдэг.

Эрүүл, аюулгүй орчин гэж юу вэ? Энэ нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэндэд халтай орчны аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж юм. Эрүүл орчин нь гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдал дээр Үүнд: агаар, ус, газар болон үүнтэй холбоотой бусад өргөн хүрээний байгалийн болон хүний хүчин зүйлс багтдаг. Харин аюулгүй орчин нь илүү нийгэм-улс төрийн шинжтэй ойлголт юм. Нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх, хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодын аюулгүй байдалд амьдрах зэргийг ойлгоно.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүс ямар ч үед амь бие, эрүүл мэндэд халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломжийг баталгаажуулсан хүний эрх юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүрээлэн буй орчны асуудлаарх чуулга уулзалтаар Стокгольмын тунхаглалыг 1972 оны 6 дугаар сард баталж, “Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцөлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ өмнө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ” хэмээн хүн төрөлхтний оршихуйн үндсийг тодорхойлжээ. Өнөөдрийн байдлаар 140 гаруй улс хүрээлэн буй орчныг хамгаалах талаар төрийн хүлээх үүрэг хариуцлагыг Үндсэн хуульдаа тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх”-ийг баталгаажуулсан.

Монгол Улсын хамгийн ноцтой байгаль орчны асуудал нь агаарын бохирдол. Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны агаарын нарийн ширхэгтэй тоосонцор (PM2.5) дунджаар жилийн 70 μg/m3 байгаа нь Монгол Улсын агаарын чанарын стандарт (25μg/m3)-аас өндөр байгаа бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын тогтоосон хэмжээ (10 μg/m3)-ээс давсан байна.[1] Хүхрийн диоксид болон азотын оксид зэрэг бусад бохирдуулагч нь мөн дотоодын болон олон улсын стандартуудаас давсан түвшинд байна.[2] Энэхүү их хэмжээний агаарын бохирдол нь эрт нас баралтад хүргэдэг амьсгалын замын болон зүрх судасны өвчин үүсгэх аюултай тул хүний амьд явах, эрүүл байх эрхэд сөргөөр нөлөөлж байна. Улаанбаатар хот дахь гучаас дээш насны хүмүүсийн нас баралтын 10 хувь, нийт улс даяарх нас баралтын 4 хувь нь агаарын бохирдолтой холбоотой байх магадлалтай.[3]

2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг нийт 1,864 буюу жилд дунджаар 155 бүртгэгджээ. Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн дэлгэрэнгүй судалгаа, Монгол Улсын шүүхийн цахим сан (www.shuukh.mn)-д тулгуурлан “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн талаар явуулсан судалгаа” зэргээс үзэхэд хууль бусаар буюу зохих зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнасан, ой мод бэлтгэсэн, ашигт малтмал олборлосон, химийн хорт бодис ашигласан, болгоомжгүй байдлаас гал алдсан, хээрийн түймэр тавьсан зэрэг үйлдлүүд зонхилж байна.[4]

Улсын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбогдох зөрчилд 2023 оны байдлаар 244 акт тавьж, 72,658 заалт бүхий 9,817 шаардлага тавьсныг тухайн үеийн хууль тогтоомжид заасан байгаль орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн зүйлчлэлээр үүсгэн шалгасан 145 гэмт хэрэгтэй харьцуулж үзэхэд энэ

[11] ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм:- 2014 он УБ., Монгол Улс, 354 дэх тал. 2.5 микрометр буюу түүнээс бага диаметртэй учраас нарийн тоосонцрууд уушгинд нэвтрэн орж, хүний эрүүл мэндэд богино болон урт хугацааны сөрөг нөлөө үзүүлэх боломжтой. ДЭМБ, хүрээлэн буй орчны агаарын бохирдол: Дэлхий нийтийн өвчлөлд өртөмтгий байдал болон хүндрэлийн үнэлгээ, 2016, 19 дэх тал.

[2] ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: -2014, УБ., Монгол Улс, 190 дэх тал

[3] Дээрхтэй адил, 354 дэх тал.

[4] Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016, УБ., 2017 он, 249 дэх тал

төрлийн гэмт хэрэг ихээхэн нуугдмал түвшинд байна гэж дүгнэжээ.[1] Энэ нь байгаль орчныг хамгаалах, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэгэн илрэл юм.

Эрүүгийн хуульд заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль хамгаалах түүнийг зохистой ашиглах, элдэв халдлагаас хамгаалах зорилгоор төрөөс газар, түүний хөрс, газрын хэвлий түүний баялаг, ус ургамал, амьтан агаарт халдаж хор уршиг учруулдаг тул энэ төрлийн гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын хэмжээг бодитой, бүрэн тогтоох аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах хэрэгтэй байна.

Эрүүл, аюулгүй, эсвэл бохирдолгүй хэмээх ойлголтуудыг хэрхэн ойлгох вэ? Ялангуяа дээрх хийсвэрлэлийн хувьд эрүүл, аюулгүй, бохирдолгүй гэж юуг ойлгох вэ? “0” агаарын бохирдол, 100% эрүүл, аюулгүй байдал хэмээх агуулгаар энэхүү ойлголт нь тайлбарлагдах уу? Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь Хүн-Байгаль-Нийгмийн шүтэлцээнээс уламжилсан жам ёсны үндэс болохын хувьд “хүлцэх түвшин” хэмээх ойлголттой шууд холбогдоно. Өөрөөр хэлбэл бохирдлын ямар түвшин, ямар боломжит нөхцөлийг эрүүл, аюулгүй гэж үзэх вэ гэдгийг хууль, хууль тогтоомжийн бусад актаар тогтоож, тохиолдол тус бүрд хянан шийдвэрлэснээр бодитоор хамгаалагдах юм. Тийм учраас энэхүү эрхийг хамгаалахад зөвхөн хуульч, хууль тогтоогчдийн шийдэл бус харин хими, физик, байгалийн ухааны эрдэмтдийн хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй болдог. Учир нь хүн гэдэг нийгмийн амьтан болохынхоо хувьд байгаль, хүрээлэн буй орчиндоо нөлөөлж, ихэнх тохиолдолд гол бохирдуулагч нь болдог ба “0” бохирдолгүй, эрүүл, аюулгүй орчин гэдэг нь өөрөө утопи шинжтэй юм.

Иргэдийн үндсэн эрхийг хамгаалах асуудал тухайн эрхийг хүлээн зөвшөөрч, Үндсэн хуулиар баталгаажуулахаас эхэлнэ. Үндсэн хуулиар тогтоосон эрхийг бодитой эдлүүлэх үндэслэл нь УИХ-аас хууль батлах, Засгийн газар батлагдсан хуулийг хэрэгжүүлснээр биеллээ олдог. Харин эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн тухайд энэхүү эрх нь Үндсэн хуулийн тунхаглал хэвээр хадгалагдсаар байна. Үүний шалтгаан нь: Нэг

[1] Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016, УБ., 2017 он, 248 дахь тал

бол Хууль тогтоох байгууллага шаардлагатай хуулийг батлахгүй байна эсвэл батлагдсан хуулийг Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлэхгүй байна. Хэрэв дээрх хоёр байгууллага Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ хангалттай түвшинд биелүүлэхгүй бол иргэнд ямар боломж байна вэ? Үндсэн эрхийн (эрүүл, аюулгүй орчинд амьдрах … эрх) зөрчил, хөндөлтийг шүүх хянан шийдвэрлэх боломжтой болсноор хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагыг идэвхжүүлж болно.

Procedure хэмээх ойлголтыг Монгол хэлнээ хөрвүүлэхдээ Журамлал, Процесс, Substantive гэх ойлголтыг Материаллаг эрх зүй гэж хөрвүүлсэн байдаг. Өгүүллийн турш яригдсан үндсэн эрхээс ялгагдахын тулд Материаллаг гэдэг орчуулгыг "Журамлалын[1] болон Материаллаг[2] эрх": дэлгэрүүлэх

"Эрүүл, аюулгүй орчинд амьдрах … эрхийг" хамгаалах, тулгамдаж буй асуудлыг хөндөгдсөн тохиолдолд сэргээх асуудал нь журамлалын эрхийг хамгаалах, сэргээх харилцаатай шууд холбогдоно. Судлаачдын дунд энэхүү эрхийг хамгаалах, сэргээх асуудал нь утопи шинжтэй гэх шүүмжлэл байдаг ч өнөөдөр журамлалаар дамжуулан зохих төвшинд хамгаалж байна. Энэ эрхтэй холбоотой журамлалын үндсэн агуулга бол иргэд хүрээлэн буй орчинд нөлөөлж болох үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, түүнчлэн шийдвэр гаргах ажиллагаанд хяналт тавих, оролцох боломжоор хангагдах зэрэг юм.

Гэхдээ энэхүү журамлалын эрх нь "эрүүл, аюулгүй орчинд амьдрах … эрхийг" хамгаалах шууд үндэслэл болохоосоо илүүтэйгээр иргэний оролцоо, хяналт төдийхөн байдаг нь иргэний үндсэн эрхийн шууд баталгаа болж чаддаггүй. Монгол улсын хувьд шүүх байгууллага "журамласан эрхийн" зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх замаар "эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийг" бодитоор хамгаалах нөхцөл бүрэн байна. Энэ нь шүүхийн идэвхийг өдөөх (Judicial Activism), иргэний "эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийн" мэдрэмжийг дээшлүүлэх үндсэн эхлэл мөн.

ДҮГНЭЛТ

Үндсэн хуулийн байгаль орчны эрх буюу явцуу утгаар "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийн" заалтыг хэт тодорхой бус, хүний

[1] С.Нарангэрэл, Хууль зүйн Англи-Монгол эх толь, 2012 он, 442-р тал.
[2] С.Нарангэрэл, Хууль зүйн Англи-Монгол эх толь, 2012 он, 514-р тал.

эрхийн бусад заалттай давхардсан, ардчилалтай харшилдсан, хэрэгжүүлэх боломжгүй гэх зэргээр шүүмжилдэг. Хэдийгээр эдгээр шүүмжлэл нь зарим талаараа үндэслэлтэй мэт боловч “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрх” нь хүний эрхийн бусад заалт бүрэн утгаараа хэрэгжих суурь нөхцөл нь болдог үндсэн эрх юм.

Иргэдийн зарим эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлаж болох ч хэзээд хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байхыг... хязгаарлаж болохгүйн адилаар “эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрх ”-ийг дордуулж, хязгаарлаж болохгүй юм. Учир нь энэ эрхийн тайлбар нь зөвхөн орчны цэвэр, бохирдолгүй, эрүүл, аюулгүй байдалтай холбоотой бус хүний амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрхийн заалтаар мөн тайлбарлагдаж буйд оршино. Олонх судалгаагаар “эрүүл аюулгүй орчинд амьдрах... эрх” зөрчигдөж тэдгээрийн хэрэгжилтүүд бодитой хэрэгжихгүй байна. Иймд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагаандаа холбогдох байгаль орчны тухай хууль, стандартуудыг дагаж мөрдөх, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх, хяналт шинжилгээ хийх замаар хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангах шаардлагатай байна.

САНАЛ

Ерөнхий боловсролын дунд сургуулиудад эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх түүний агуулгын талаар олон нийтэд сурталчлах сургалт, дадлагын тогтолцоог бий болгох

Агаар орчны бохирдлоос шалтгаалж эрүүл мэндийн байдал хохирсон талаар Монгол улсын хэмжээнд нарийвчилсан судалгааг гаргах, мэргэжлийн салбарын сургалт болон сургалтын орчин, чанарыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол улсын үндсэн хууль, 1992он
2. Монгол улсын Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль 1997 он.
3. Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016, УБ., 2017 он
4. С.Нарангэрэл, Хууль зүйн Англи-Монгол эх толь, 2012 он
5. Монгол хэлний эх тайлбар толь

6. ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм:- 2014 он УБ.,

7. Дэлхий нийтийн өвчлөлд өртөмтгий байдал болон хүндрэлийн үнэлгээ, 2016 он

8. Том Гинсбург, Шинэ ардчилсан тогтолцоо дахь Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ, 2003

---o0o---

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

CHARACTERISTICS OF ADMINISTRATIVE DECISION EXECUTION



Г.Банзрагч

Улсын дээд шүүхийн захиргааны танхимын шүүгч, хууль зүйн доктор /Ph.D/

2015 онд батлагдаж, 2016 оны 7 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Захиргааны ерөнхий хууль (ЗЕХ) нь Монгол Улсад “эрх зүйт төр”-ийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж буй эрх зүйн хэм хэмжээ юм. Учир нь уг хуулиар захиргааны байгууллагын үйл ажиллагааны нийтлэг журам буюу минимум стандартыг тогтоосон бөгөөд захиргаа уг хуулийг дагаж мөрдсөнөөр төрийн хууль бус үйл ажиллагаанаас иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хамгаалагдах эрх зүйн баталгаа нэмэгдсэн гэж болно.

Энгийнээр хэлбэл, ЗЕХ-аар захиргааны байгууллагаас иргэд, хуулийн этгээдтэй харилцахдаа, тухайлбал тэдэнд чиглэсэн захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа, захиргааны гэрээ байгуулахдаа ямар хэм хэмжээг дагаж мөрдөх вэ гэдгийг зохицуулсан. Тухайлбал, захиргаанаас гаргах шийдвэр нь ямар төрөлтэй байх, тэдгээр нь ямар үндсэн шинжээрээ хоорондоо ялгагдах, тухайн шийдвэрт ямар эрх зүйн шаардлага тавигдах ёстой, захиргаа шийдвэр гаргахдаа ямар журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй, хэрэв иргэд тухайн шийдвэрийг зөвшөөрөхгүй бол ямар журмаар гомдол гаргах, түүнийг нь захиргаа хэрхэн шийдвэрлэх, мөн уг хуулийг зөрчсөн албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх зэргийг тодорхой зохицуулсан байна.

Дээрхээс гадна ЗЕХ-ийн 8-р бүлэгт энэхүү өгүүллийн сэдэвт хамаарах “захиргааны шийдвэр гүйцэтгэл” гэсэн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нэг онцлог төрлийг тусгайлан зохицуулжээ.

“Захиргааны шийдвэр гүйцэтгэл” гэдэгт ерөнхий утгаараа захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх захиргааны үйл ажиллагааг ойлгоно. Хэдийгээр захиргааны шийдвэр гэдэгт захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ зэрэг эрх зүйн хэлбэрүүд хамаарах боловч ЗЕХ-д зөвхөн захиргааны актыг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулсан байна. Учир нь захиргааны шийдвэр гүйцэтгэл нь ихэнхдээ үүрэг хүлээлгэсэн захиргааны актын хувьд хэрэгждэг, гэхдээ энэ нь захиргааны бусад шийдвэрт хэрэгждэггүй гэсэн үг биш юм. Иймд дээрх ойлголтыг тодруулбал, захиргааны байгууллагаас тодорхой этгээдэд хандан үүрэг хүлээлгэсэн захиргааны акт гаргасан боловч тухайн этгээд биелүүлэхгүй тохиолдолд захиргаа өөрөө юмуу хуулиар эрх олгогдсон этгээд тухайн актын биелэлтийг хангах ажиллагааг явуулах тухай ойлголт юм.

Захиргааны шийдвэр гүйцэтгэл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлээс хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгжүүлэх субьекь, эрх зүйн хамгаалалтын журмаараа хоорондоо ялгаатай. Тухайлбал:

- захиргааны шийдвэр гүйцэтгэлийн үндэслэл нь тодорхой этгээдэд (хүн, хуулийн этгээдэд) үүрэг хүлээлгэсэн захиргааны акт байдаг бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хувьд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байна;
- захиргааны шийдвэр гүйцэтгэлийг захиргааны акт гаргасан захиргааны байгууллага өөрөө; дээд шатны захиргааны байгууллагын гаргасан актыг анхан шатны захиргааны байгууллага; эсхүл хуулиар тусгайлан эрх олгосон цагдаагийн болон мэргэжлийн байгууллага хэрэгжүүлдэг бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага л хэрэгжүүлдэг, харин захиргааны байгууллага шийдвэр гүйцэтгэлийн талаар өөр захиргааны байгууллагаас, тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тусламж авч болно (ЗЕХ§84);
- захиргааны шийдвэр гүйцэтгэл хууль бус явагдсан гэж үзвэл эрх нь зөрчигдсөн этгээдийн зүгээс захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар эрхээ хамгаалуулах боломжтой бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэдэг.

Дээр дурдсанаар захиргааны шийдвэр гүйцэтгэл нь өөрийн гэсэн онцлог шинжтэй ажиллагаа юм. Жишээлбэл:

- уг ажиллагааны үндэслэл болох захиргааны шийдвэр нь тодорхой нэгэн хүн, хуулийн этгээдийн хувьд үүрэг хүлээлгэсэн буюу дарамт учруулсан сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт байдаг;
- тухайн захиргааны акт нь хүчин төгөлдөр болсон байна, өөрөөр хэлбэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар хэрэгжүүлэх гэж буй захиргааны актад эрх нь хөндөгдсөн этгээдийн зүгээс гомдол гаргаагүй буюу хүлээн зөвшөөрсөн юмуу хуульд заасан гомдол гаргах хугацаа өнгөрсөн байх, мөн тухайн захиргааны актыг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болсон тохиолдолд явуулна (ЗЕХ§82.2);
- захиргааны акт хүчин төгөлдөр болсон боловч холбогдох этгээд актаар хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй тохиолдолд хэрэгждэг.

Түүнчлэн захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад буюу уг ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор янз бүрийн захиргааны актууд гардаг бөгөөд хэрэв тухайн актын улмаас хэн нэгний эрх зөрчигдсөн тохиолдолд шүүхээс эрх зүйн хамгаалалт хүсэх эрхтэй. Жишээ нь шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны дараах үе шатуудад захиргааны акт гарч болно. Үүнд:

1. Мэдэгдэх хуудас хүргүүлэх: захиргаанаас захиргааны актыг биелүүлэхийг мэдэгдэнэ.
2. Албадлага хэрэглэх тухай мэдэгдэл хүргүүлэх: үүрэг хүлээгч мэдэгдэх хуудаст заасан хугацаанд (14 хоног буюу түүнээс доошгүй хоногт) захиргааны актаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол захиргаанаас албадлага хэрэглэх тухай мэдэгдэл хүргүүлнэ.
3. Албадлага хэрэглэх шийдвэр гаргах: үүрэг хүлээгч дээрх мэдэгдэлд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй бол захиргаа албадлага хэрэглэх шийдвэр гаргана.
4. Албадлагыг хэрэглэх: үүнд торгууль оногдуулах, бусдаар гүйцэтгүүлэх, албадан гүйцэтгэх хэлбэрээр захиргааны шийдвэрийг хэрэгжүүлнэ.

Эдгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шат болгонд гарах мэдэгдэх хуудас, мэдэгдэл, албадлага хэрэглэх шийдвэр, тухайлбал торгууль оногдуулах, албадлагын хэрэгслийг тогтоох, шууд албадлага хэрэглэх, орлох ажиллагааны зардлыг тооцож холбогдох этгээдээс

гаргуулах зэрэг нь бүгд ЗЕХ-ийн §37.1-д заасан захиргааны актын үндсэн шинжийг бүхэлд нь агуулдаг тул захиргааны акт болдог.

“Захиргааны акт” гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно. Тэгвэл захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гарах дээрх шийдвэрүүд нь:

- “захиргааны байгууллага”-аас хэрэгжүүлдэг;

- тодорхой хүн, хуулийн этгээдэд чиглэсэн, нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа байдгаараа “тодорхой нэг тохиолдол” болдог;

- ЗЕХ болон бусад захиргааны хууль тогтоомжийн үндсэн дээр хэрэгждэг тул “нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн”;

- захиргааны дотоод хүрээнээс хальж, хүн, хуулийн этгээдэд чиглэдэг тул “гадагш чиглэсэн”;

- чиглэсэн буюу хандсан этгээдийн хувьд үүрэг хүлээлгэдэг тул “эрх зүйн шууд үр дагавар бий болгодог”;

- захиргааны байгууллагын нэг талын хүсэл зоригийн үндсэн дээр хэрэгжиж, заавал биелэгдэх албадлага тул “захирамжилсан” шинжтэй бөгөөд ихэнхдээ бичгээр илэрч, бодит үйлдлээр хэрэгждэг онцлогтой.

ЗЕХ-аар захиргааны шийдвэр гүйцэтгэлийг эхлүүлэх, үргэлжлүүлэх, дуусгах үндэслэл, нөхцөл, журам, хэрэгжүүлэх хэлбэр зэрэг нийтлэг хэм хэмжээг зохицуулсан, мөн захиргааны эрх зүйн тусгай ангийн салбарын хуулиудаар тусгай журмыг нарийвчлан зохицуулсан байдаг тул (жишээ нь татварын актын хувьд татварын хууль тогтоомжоор, газартай холбоотой шийдвэр гүйцэтгэлийг газрын тухай хууль тогтоомжоор гм.) захиргаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа хуульд заасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Хэрэв захиргаа хууль журмыг зөрчвөл эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн этгээд хуульд заасан журмын дагуу эрх зүйн хамгаалалт шаардах эрхтэй. Гэхдээ албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны актад зөвхөн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдол гаргана, өөрөөр хэлбэл үндсэн захиргааны акттай (шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаагаар хэрэгжигдэж буй) холбоотой гомдол гаргахгүй бөгөөд ЗЕХ-д заасан захиргааны акт гаргах журам үйлчлэхгүй (ЗЕХ 90.2). Мөн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн актын эсрэг

гомдол, нэхэмжлэл гаргасан тохиолдолд ЗЕХ 97.1.4-т заасны дагуу түдгэлзүүлдэггүй зэрэг онцлог зохицуулалт бий.

Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн талаар дээд шатны захиргааны байгууллагад нь зохих журмаар гомдол гаргасан боловч амжилт олоогүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн зүгээс захиргааны хэргийн шүүхэд захиргааны шийдвэр гүйцэтгэлийн актыг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох, хууль бус актын улмаас учирсан хохирол гаргуулах зэрэг нэхэмжлэлийг гаргаж, эрхээ хамгаалж болно. Түүнээс гадна захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэхгүй байгаа захиргааны эс үйлдэхүйн улмаас хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болно. Энэ тохиолдолд тухайн этгээд эс үйлдэхүйн эсрэг хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэхийг "даалгах" нэхэмжлэлийн шаардлага гаргах боломжтой. Мөн шийдвэр гүйцэтгэл нь хуульд заасан тохиолдолд нэн даруй хэрэгждэг онцлог шинжтэй. Ийнхүү захиргааны шийдвэр гүйцэтгэл бодит байдалд нэгэнт хэрэгжээд дууссан тохиолдолд захиргааны актыг хүчингүй болгох юм уу илт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргах боломжгүй, учир нь эрх зүйн нөлөөгүй актыг хүчингүй болгох тухай ойлголт байхгүй юм. Гэхдээ эрх нь зөрчигдсөн этгээдийн зүгээс гомдол, нэхэмжлэл гаргах хуульд заасан хугацаа дуусаагүй байхад захиргааны шийдвэр гүйцэтгэл хэрэгжээд дууссан бөгөөд үүний улмаас маргаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, мөн түүнд хамгаалагдах онцгой эрх, ашиг сонирхол байгаа тохиолдолд "захиргааны акт/захиргааны шийдвэр гүйцэтгэл хууль бус байсан болохыг тогтоолгох" нэхэмжлэлийг шүүхэд анхнаас нь гаргах боломжтой байдгаараа бусад захиргааны актаас ялгаатай юм. Тодруулбал, эрх зүйн үйлчлэлгүй болсон бусад захиргааны актын хувьд шүүхэд анхнаас нь хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийг гаргах боломжгүй байдаг.

ДҮГНЭЛТ

- захиргааны шийдвэр гүйцэтгэл нь өөрийн гэсэн тусгай зохицуулалт бүхий захиргааны байгууллагын үйл ажиллагааны нэг онцлог төрөл;
- уг үйл ажиллагааны явцад янз бүрийн захиргааны акт гарах боломжтой;
- иймд тэдгээр захиргааны актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд өөрийн эрхийг хамгаалуулахаар захиргааны актад гаргаж болдог нэхэмжлэлийн төрлүүдээр шүүхэд хандах эрхтэй;

- харин нэн дариу хэрэгжсэн шийдвэр гүйцэтгэлийн тухайд тухайн акт буюу шийдвэр гүйцэтгэл хууль бус байсан болохыг тогтоолгохоор шүүхэд анхнаас нь нэхэмжлэл гаргаж болдог онцлогтой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

1. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2023
2. Д.Сүнжид, Захиргааны ерөнхий хууль, 2016
3. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3.Хэвлэл, 2016
4. Mauer, Harmunt, Allgemeines Verwaltungsrecht, 12.Хэвлэл, 1999

--o0o---

ЭРХ ХАСАХ ЯЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ

A COMPARATIVE STUDY OF PRINCIPAL PENALTIES



Э.Батбаяр
Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа

Харьцуулсан судлал нь эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, ял түүний мөн чанар, зорилго, төрөл, хэлбэрийг зөв танин мэдэх, Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сургалтыг чанаржуулах, хуульчдын мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлэх зэрэгт өндөр ач холбогдолтой судалгааны сэдэв болжээ.

Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал хэрхэн яаж үүссэн, түүний ач холбогдол, арга зүй, онолын үндэслэл зэргийн талаар “торгох ялын харьцуулсан судлал” гэсэн сэдэвт дэлгэрэнгүй авч үзсэн тул энд давхцал үүсэхийг үгүйсгэхгүй учир түүнээс тодруулж үзэхийг зөвлөж байна.

Эрх хасах ялын талаар гадаадын улс орнууд хэрхэн хуульчлан зааж байгаа талаар харьцуулан судалбал, тухайлбал, Үүнд:

- **Швейцарын** Эрүүгийн хуульд “тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, арилжаа эрхлэх, архидан согтуурагчийг ресторан, баараар үйлчлүүлэхийг хорих, эрх мэдэлтнийг албан тушаалаас халах, эцэг, эх, асран хамгаалагч байх эрхийг хасах” гэсэн нэмэгдэл ялуудыг хэрэглэж байна;
- **Испани** улсын Эрүүгийн хуулиар хүнд гэмт хэрэгт “бүх эрхийг хасах, эсхүл 3-аас дээш жилээр тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6-аас дээш жилээр хасдаг” харин хөнгөн бол “тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 3 сараас 1 жилийн хугацаагаар” хасдаг.

Харин **ОХУ-ын** Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн б/ тодорхой албан

тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, мөн в/ тусгай, цэргийн болон хүндэт цол, зэрэг дэв, төрийн шагналыг хураах ялын төрлүүд заагджээ. Жишээ нь: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлд:

1. Тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрх хасах нь төрийн алба, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад албан тушаал хаших эсхүл тодорхой мэргэжлийн буюу бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоход оршино;

2. Тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартайгаар 1-5 жилийн хугацаагаар, нэмэгдэл ялын чанартайгаар 6 сараас 3 жилийн хугацаатай оногдуулна. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэмэлт ялаар 20 жил хүртэл хугацаагаар оногдуулна" гэжээ.

Манай урд хөрш болох **БНХАУ-ын** Эрүүгийн хуулийн "Эрүү шийтгэл" гэсэн 3 дугаар бүлгийн 32 дугаар зүйлд эрүү шийтгэлийг гол эрүү ба дагалдвар эрүү гэж хувааж, эрх хасах буюу "улс төрийн эрхийг нь хасах" ялыг дагалдвар эрүүгийн төрөл зүйл гэж үзсэн байна /үз. 34 дүгээр зүйл /хоёр/.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд "сонгох ба сонгогдох эрх, саналаа хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөтэй эрх, төрийн байгууллагад тушаал үүрэглэх эрх, улсын өмчийн гун-сы, аж ахуйлал, ажил үйлсийн нэгж хийгээд ардын бүлгэмийн удирдах тушаал үүрэглэх эрх" хасах, 55 дугаар зүйлд "... хугацаа 1-5 жил байх", 57 дугаар зүйлд "... алах шийтгэл ба хугацаагүй хорих шийтгэлээр шийтгэгдсэн ялт этгээдийн улс төрийн эрхийг нэг насаар нь хасах хэрэгтэй" гэж тус тус заажээ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн "нэмэгдэл ял" гэсэн 44 дүгээр зүйлд "жолооны эрхийг хасах", 45 дугаар зүйлд "төрийн алба хаших, сонгогдох болон саналын эрхийг хасах", 70 дугаар зүйлд "мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах", 69b дүгээр зүйлд "гадаад улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах" тухай заасан байна. Тухайлбал:

- хорих, торгох ял авсан этгээдийн бүх төрлийн тээврийн хэрэгсэл жолоодох буюу тодорхой ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг шүүх 1-6 сар хүртэл хугацаагаар хасаж болно /үз. 44 /1/;

- төрийн алба хаших, сонгогдох болон саналын эрхийг хасах ялыг ... багадаа 1 жилийн хорих ялаар шийтгүүлсэн этгээдийн хувьд төрийн алба хаших болон олон нийтийн сонгуультай холбоотой эрхийг 2-5 жилийн

хугацаагаар хасаж болно /үз. 45/;

- мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг 1-5 жил, хуульд заасан ялын хугацааны дээд хэмжээ нь гэмт хэрэг учруулж болох аюулаас хангалттай урьдчилан сэргийлж чадахгүй гэж шүүх үзвэл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хугацаагүй хасаж болно /үз. 70 /1/[1].

Дани зэрэг бусад өндөр хөгжилтэй улс орнуудад тухайлбал: жолоодох эрхийг хасах ял шийтгэгдсэн бол согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхээ эхлээд үлээж шалгасны дараа тээврийн хэрэгсэл нь асаж замын хөдөлгөөнд оролцох арга хэмжээг шүүхээс 1-2 жилийн хугацаагаар авч хэрэгжүүлсэн байдаг.

2015 оны **Вьетнам** улсын Эрүүгийн хуулиар, цаазаар авах, хорих, торгох, бүх насаар хорих, сануулгын шийтгэл ял, олон нийтийн хяналтад байлгах, албадан гаргах ялаас гадна нэмэгдэл ялаар "... тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой ажил хийхийг 1-5 жил хориглох, зорчих эрхийг 1-5 жил хязгаарлах, иргэний тодорхой эрхийг 1-5 жил хасах" зэрэг эрхийн хязгаарлалт тогтоосон санкцуудтай.

БНАСАУ-ын 1987 оны Эрүүгийн хуулийн 28 дугаар зүйлд зааснаар "... албан тушаал хаших эрхийг хугацаагүй хасах, тодорхой хугацаагаар албан тушаал хаших эрхийг хасах гэх 2 төрлийн ял" байх ба уг ялыг "албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн байдал, дахин гэмт хэрэг үйлдэх боломж, нөхцөл зэргийг харгалзан шүүхээс хугацаагүй ба хугацаатай /3 жил хүртэл/ оногдуулж" болохоор **зааж**[2].

БНСУ-д эрх хасах ял нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах / үз. 43 дугаар зүйл/ болон түдгэлзүүлэх /үз. 44 дүгээр зүйл/ гэж 2 ангилагддаг бөгөөд тус улсын Эрүүгийн хуулиар 1-15 жилийн хугацаагаар болон цаазаар авах, бүх насаар хорих зэрэг ялын хамт "... төрийн албан хаагч байх, сонгох, сонгогдох, захирал гэх мэт албан тушаал хаших" явдлыг хориглохоор заасан байна.

---

[1] Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль /хамтын бүтээл, орчуулж нэгтгэсэн анхны хэвлэл/. УБ., 2021., 112, 268-271., 362-382 дахь тал

[2] **Г.Гантөмөр.** БНАСАУ-ын Эрүүгийн хууль, түүний онцлог. Гэмт явдалтай тэмцэх асуудал / сэтгүүл/. УБ., 2020., №2., 40 дэх тал.

Дээрх байдлаар эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлалын хүрээнд тухайлсан сэдвийг авч үзэж судлах нь олон талын мэдлэг, мэдээлэл өгөхийн зэрэгцээ зөв үзэл сэтгэлгээ, зарчимч чиглэл, зохистой хандлага тогтоход туслах учир таныг энэ асуудлаар илүү ихийг уншиж мэднэ гэдэгт итгэж байна.

Харьцуулсан судлал нь өөрийн улс орны үндэсний эрх зүйн тогтолцоог танин мэдэхэд туслаад зогсохгүй гадаадын бусад улс орнуудын эрх зүйн тогтолцоо, түүх, уламжлал, хууль зүйн онол, практик, соёл ахуйг ойлгоход дөхөм үзүүлж, эрх зүйн ижилсэх ба ондоосох шинж чанарыг судлах, үл мэдэх байдлыг арилгах, мэдлэгийн цар хүрээг тэлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн хөгжилд хүргэх зэрэгт онцгой нөлөө үзүүлдэг.

Иймд цаашид хөгжингүй улс орнуудын эрх зүйн тогтолцооны сонгодог жишиг, үндсэн чиглэлийг судлан үзэж харьцуулах, уламжлал шинэчлэлийг хослуулах, дэлхий дахины хөгжлийн хандлагад ойртох, рецепци оновчтой хийх, эрдэмтэн, судлаач нараа хөхиүлэн дэмжих, ном эрдэмд ач холбогдол өндрөөр өгч үнэлэх нэн шаардлагатай байна.

---o0o---

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛЖ БУЙ НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ, ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨ

THE OUTCOMES OF SENTENCING A COMMUNITY SERVICE AND TAKING COERCIVE MEASURES FOR ADOLESCENTS



Б.Өнөрмаа
Хууль зүйн доктор (Ph.D)

Товч утга: Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн өсвөр насны хүмүүсийн тоо өсөж байгааг нийгэм, эдийн засаг, гэр бүл, хувь хүний гээд олон хүчин зүйлтэй холбож тайлбарлаж болно. Нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан ял шийтгэл нь үр дүнтэй байсан уу эсхүл тухайн ял шийтгэлийг эдлэх эрх зүйн орчин, нөхцөл бодит байдал дээр ямар байна гэдэг нь бидний анхаарал хандуулах сэдвийн нэг юм. Энэхүү нийтлэлээр Өсвөр насны хүнд оногдуулж буй нийтэд тустай ажил хийлгэх ял, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ үр дүнтэй хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулан, судлаачийн хувьд тодорхой санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: The increase in the number of juveniles who have committed crimes and been sentenced in recent years can be explained by social, economic, family, and individual reasons. In addition, whether the sentences were effective, or what the legal issues and conditions for serving that imposed sentences are in reality, are should be raised up as well. Consequently, this article shed lights that insufficient results of sentencing a community service and taking coercive measures for adolescents and then to propose specific recommendations.

Түлхүүр үгс: Criminal law, imposing sentences for adolescents, community service, coercive measures, criminality, physical, health, and mental development of juvenile

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нийтэд тустай ажил хийлгэх ялын олон улсын эрх зүйн үндэслэл нь НҮБ-аас 1966 онд баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, НҮБ-аас 1990 онд баталсан “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм”, 1950 онд Европын зөвлөлөөс баталсан “Европын хүний эрхийн конвенц”, НҮБ-аас 1984 онд баталсан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”, НҮБ-аас 1985 онд баталсан “Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм”, НҮБ-аас 1981 онд баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 155 дугаар конвенц” зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхой хэм хэмжээ болон тусгагдсан байна.

Монгол Улс Эрүүгийн хуулиа 2015 онд шинэчлэн баталсан бөгөөд өмнө нь “Албадан ажил хийлгэх ял” гэж нэрлэгдэж байсан ялын төрлийг “Нийтэд тустай ажил хийлгэх ял” гэж өөрчилж хорихоос өөр төрлийн ялыг илүү чухалчлах болсон нь нэг талаас ялын бодлогод хүмүүнлэгийн чиг хандлага түгээмэл нэвтэрсэн, нөгөө талаас хүний эрхийн үнэт зүйлсийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах шаардлага өсөн нэмэгдсэнтэй холбоотой.[1]

2015 оны Эрүүгийн хуулийн Наймдугаар бүлэгт Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх журам, баримтлах нийтлэг шаардлагыг тодорхойлж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын үзэл санаа, агуулгыг үндэсний хууль тогтоомжид баталгаажуулан хуульчилсан.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ

Шүүхээс 2021 онд 269, 2022 оны III улирлын байдлаар 361, нийт 630 өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэснээс 17.5 хувь буюу 110-т нь хорих, 13.3 хувь буюу 84 хүнд зорчих эрх хязгаарлах, **9.7 хувь буюу 59-д нь нийтэд тустай ажил хийлгэх,** 1.7 хувь буюу 11 хүнд торгох ял оноож, 8.1 хувь буюу 51 хүнд хорих ял оногдуулан хойшлуулж, 31.3 хувь буюу 197 хүнд ял оногдуулахыг тэнсэж, хүмүүжлийн чанартай

[1] https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/CommunityWork%20ResearchReport.pdf

албадлагын арга хэмжээ, 0.8 хувь буюу 5 хүнд ял оногдуулахгүй тэнсэж, албадлагын арга хэмжээ авч, 11.4 хувь буюу 72-ыг нь Өршөөл үзүүлэх тухай хуульд зааснаар холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл ялыг өршөөн хэлтрүүлж, 5.4 хувь буюу 34 хүнийг ялаас чөлөөлсөн байна.

Улсын хэмжээнд 2022 онд Шүүхээс 209 хүүхэд ял шийтгүүлсэн нь 2021 онтой харьцуулахад 84-өөр буюу 59,8 хувиар өссөн дүнтэй байна.[1]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын хамтарсан 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/138, А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2022 онд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нийт 491 (аймаг 298, нийслэл 193) хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Гэвч ХЭҮК-оос аймаг, нийслэлийн жилийн эцсийн тайлан мэдээнд дүн шинжилгээ хийхэд 13 аймаг тайландаа хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 89 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн тухай дурдсан боловч хэдэн хүүхдэд тусгайлсан сургалтын төлөвлөгөө гаргаж ажилласан нь тодорхойгүй, нийт тоо мэдээ, дүн шинжилгээ хийсэн тоо, мэдээнүүд зөрүүтэй гарч байна.

Шүүхээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд үйлчилгээ үзүүлэх асуудлыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны Ажлын алба зохион байгуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, прокурор хэрэгжилтэд хяналт тавьдаг бол **нийтэд тустай ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч дангаараа хариуцан гүйцэтгүүлдэг байна**. Мөн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдтэй ганц мэргэжилтэн ажиллаж байгаа нь ч хангалтгүй юм.

Шүүгч хууль зөрчсөн хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шийдвэрийг “зан үйлээ засах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсугай” хэмээн хэт ерөнхий байдлаар гаргаж байгаа нь тухайн хүүхдэд нэг эсхүл хэдэн удаагийн ямар арга хэмжээ

[1] https://www.judcouncil.mn/site/news_full/12877 (Монгол Улсын Шүүхийн 2022 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, 14-15 дахь тал)

авснаар зан үйл засрах нь тодорхойгүй бөгөөд зан үйл нь засарсан эсэхэд хяналт тавих боломжгүй байна[1].

Эрүүгийн хуулийн 8.3 дугаар зүйлийн дагуу гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулж байгаа бөгөөд нийтэд тустай ажил хийлгэх ял дээр нэмж Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж байна. Хууль зөрчсөн хүүхдэд оноосон нийтэд тустай ажил хийх ялыг хэрхэн эдлүүлэх талаар тусгайлан заасан журам байхгүй учир насанд хүрэгчидтэй хамт энэ ялыг эдэлж байна.

ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтад гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болох тухай зохицуулсан. Шүүх арван найман насанд хүрэхийн өмнө анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял шийтгэхгүй хүмүүжих боломжтой гэж үзвэл Эрүүгийн хуульд заасан хүмүүжлийн чанартай арга хэмжээг хэрэглэдэг.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэх зорилгоор шүүхээс хэрэглэж буй ялын бус төрийн албадлагын арга хэмжээ, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээний нэг төрөл юм.

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫН ЗОРИЛГО, ҮНДСЭН ШИНЖ

Олон улсад нийтэд тустай ажил хийлгэх ялын зорилго, чиг үүргийн хувьд хүмүүнлэгийн шинжтэй нийгэмшүүлэх агуулга бүхий, дор дурдсан онцлог шинжийг өөртөө агуулдаг байна[2] . Үүнд:

---

[1] Хүний эрхийн үндэсний комисс, Монгол улс дахь “Хүний эрх, эрх чөлөөний байдлын тааархи илтгэл” 2023 он

[2] https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2020/CommunityWork%20ResearchReport.pdf. “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт” бодлогын судалгааны тайлан 2019 он. Нээлттэй нийгэм форум. 2016 оны байдлаар Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эрүүгийн хууль тогтоомждоо бие даасан заалт, институт болгон оруулсан буюу түгээмэл хэрэглэж буй 68 орон байгаа гэсэн судалгаа бий. (Макс-Планкын хүрээлэнгийн 2016 оны судалгааны тайлан)

1. Хорихоос өөр төрлийн ялын тогтолцоонд хамгийн түгээмэл хэрэглэгдэхээр хуульчлагдсан ял бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засан төлөвшүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн;

2. Энэ ялын нөхцөл, агуулга нь үндсэн ялын төрлөөр сонгох нөхцөлтэйгөөр хэрэглэгдэх бөгөөд дотроо олон төрөл байхаар зохицуулагдсан;

3. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь тухайн ялтныг нийгэмд ач тустай, нийтийн ашиг сонирхолд нийцэхүйц ажил үүргийг цалин хөлсгүйгээр хөдөлмөрийн тодорхой нөхцөл, дэглэмийн дагуу ногдуулж эдлүүлэхэд чиглэгдсэн;

4. Уг ял нь нийгэм төдийгүй нийтийн ашиг сонирхолд нийцэхүйц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн байдгаараа харьцангуй үр дүнтэй байдаг;

5. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь зарим орнуудад үндсэн ялын чанартайгаар, орлуулах нөхцөлгүйгээр хуульчлагдсан байхад зарим улсад энэ нь онцгой тохиолдолд өөр ялаар орлуулан тооцох нөхцөлтэй байдаг;

6. Энэхүү **ялын төрлүүдэд** иргэний болон төрийн бус байгууллагуудад хүмүүнлэгийн шинжтэй ажил үүрэг гүйцэтгэх, нийтийн зориулалтын үйлчилгээний болон нийгмийн ажил үүрэг гүйцэтгэх байгууллагуудад ажиллуулах, сургалтын болон мэргэжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцох, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт ажиллуулах, гал түймэртэй тэмцэх, нийтийг хамарсан гамшгийг арилгах үйлсэд оролцуулах, иргэний болон хүний эрхийн байгууллагатай ажил үүргийн гэрээ хийсний үндсэн дээр тодорхой даалгавар биелүүлж ажиллах, орон нутгийн өөрөө удирдах байгууллагад нийтэд тустай ажил үүрэг гүйцэтгэх гэх мэт олон талт үйл ажиллагаа явуулахад оролцох байдлаар хэрэгждэг;

7. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь хугацааны хувьд ихэнхдээ цагаар хэмжигдэх нөхцөлөөр хуульчлагдсан байх ба тухайн ялыг эдлэх явцад хариуцлага болон үр дүнг тусгасан үнэлгээний тодорхой шалгууруар (кредит итгэлцүүрийн нөхцөл, стандарт) тодорхойлсон байдаг;

8. Уг ялын хэрэглээг шүүхийн төдийгүй нийгмийн бодлогын хэмжээнд судалж, төрийн хүмүүнлэгийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлдэг байна.

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ, ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙГАА ШАЛТГААН

2015 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд дурдсан “Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхэд түүний нас, хүйсэд тохирсон, эрүүл мэнд ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна” гэж заасан боловч тухайлбал 15 настай эрэгтэй эсхүл эмэгтэй хүүхэд бие бялдар, оюун санааны хөгжлийн хувьд эсхүл тусгай хэрэгцээтэй буюу сонсголын бэрхшээлтэй мөн эрүүл мэндийн асуудалтай ямар төрлийн ажил хийвэл тохиромжтой болох талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий ажлын байрны стандарт байхгүй байна.

Монгол улсын Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял” гэж тодорхойлон “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг ..... тогтооно” гэжээ.

Гэвч “...шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажил” гэдэгт юуг хамаарах нь тодорхойгүй

- ялын биелэлтийг хангахад төрийн бус байгууллагуудын оролцоо байхгүй

- өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн шинжээс хамаарч нийтэд тустай ажлын төрлийг тодорхойлдоггүй /хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг үйлдсэн бол Хүчирхийллийн эсрэг төвүүд, хамгаалах байр, ахмадын асрамжийн газар ажиллуулах гэх мэт/ нь дээрх ялын зорилго олон улсын хэм хэмжээнд тусгагдсанаар биелж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Дахин гэмт хэрэг үйлдээгүй гэдэг нь дээрх ялын хэрэгжилтийг тооцох шалгуурын зөвхөн нэг хэсэг бөгөөд тухайн хүүхдийг нийгэмшүүлэх зорилго биелсэн эсэхийг олон шалгууураар авч үзэх шаардлагатай байна.

САНАЛ

1. Өсвөр насны хүний бие бялдар, эрүүл мэнд, оюун санааны хөгжлийн хувьд ямар төрлийн ажил хийвэл тохиромжтой болох талаар шинжлэх ухааны үндэслэл бүхий ажлын байрны стандартыг бий болгох.

Хуульд заасан *“хүний хувийн байдлыг харгалзах”* гэдэг шалгуурыг тодорхой болгож олон улсын жишгийг нэвтрүүлэх.

2. Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн шинжээс хамаарч нийтэд тустай ажлын төрлийг тодорхойлох. Тухайлбал хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг үйлдсэн бол Хүчирхийллийн эсрэг төвүүд, Хүүхэд хамгаалах байр, ахмадын асрамжийн газар ажиллуулах буюу иргэний болон төрийн бус байгууллагуудад хүмүүнлэгийн шинжтэй ажил үүрэг гүйцэтгэх зэргээр тухайн ял эдлэх нөхцөлийг шүүхийн шийдвэрт тусгайлан заадаг болох. Ингэснээр хүн хоорондын харилцаа, тухайн орчны нөхцөл, бусдыг асрах бусдад туслах ажил нь “зан үйлээ засах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ”-ний бодит үр дүнг үзүүлэхээс гадна нийгэмших боломжийг бүрдүүлнэ.

3. Тухайн ялыг эдлэх явцад хариуцлага болон үр дүнг тусгасан үнэлгээний тодорхой шалгуурыг бий болгох. Тухайлбал Өсвөр насны хүнд оногдуулж буй нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөө нь дараах шалгуурыг агуулж чадсан байгаа эсэхийг тодорхойлох. Үүнд:

- ✓ Өөрийн сэтгэлийн зовнилоо илэрхийлэх, ил гаргах, дургүйцлээ нийгэмд зөвөөр илэрхийлэх боломжийг бүрдүүлсэн эсэх
- ✓ Биеийн энергиэ бүтээмжтэй зүйлд зарцуулж, өөрийгөө илүү ойлгоход нь тусалж чадсан эсэх
- ✓ Ял нь залхаан цээрлүүлэх биш сонирхолтой болон хөгжөөнт хэлбэрээр тухайн хүүхдийн сонирхлыг өдөөсөн агуулгатай байсан эсэх
- ✓ Тэдэнд өөртөө итгэх итгэл, эрүүл өрсөлдөөний зарчмыг ойлгуулж чадсан эсэх
- ✓ Багийн ажиллагаа, шударга өрсөлдөөн, дүрэм журамд захирагдах талаар зааж сургасан эсэх
- ✓ Шинэ сонирхол, ур чадварыг нээж өгөхөд чиглэсэн эсэх
- ✓ Нийгмийн ерөнхий чиг хандлагыг ойлгоход тусалсан эсэх

---o0o---

ПРОБАЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨН ЧАНАР, ОНЦЛОГ

CHARACTERISTICS OF PROBATE PROCEEDINGS



Д.Буяннэмэх

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), хошууч

Хүний эрхийг хүндэтгэн дээдлэх болсон өнөө цаг үед аливаа улс орон ялын бодлогоо энэрэнгүй, хүнлэг болгон шинэчлэх, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоог шинэ шатанд гаргах чиглэлд анхаарч байгаатай уялдан хорих ялыг аль болох сонгох хувилбартай ялыг сонгон хэрэглэх асуудал чухалд тооцогдох болсон.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс дэлхийн олон улс оронд уламжлал болсон хорих ялын тогтолцоо бат бөх оршсоор байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорьж цагдах, эрх чөлөөг нь хасах, хязгаарлах зэргээр хүний эрхийг зөрчих үндсэн шалтгаан болж байна гэж үзжээ. Учир нь олон улсын практикаас үзэхэд шоронгийн нөхцөлд хүнийг засаж хүмүүжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга нь үр нөлөө багатай байгаагийн дээр нийгэмд төдийгүй хувь хүний төлөвшилд сөрөг үр дагавартай болох нь нэгэнтээ нотлогджээ[1].

Хорих ял нь дараах сул талыг агуулж байна. Үүнд:

а) хорих ялын хувьд “нийгэмшүүлэх” ба “цээрлүүлэх” гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Цээрлүүлэх хэлбэр нь цээрлүүлэх гэсэн агуулгаар бус тодорхой нөхцөл, журмын хүрээнд хүний эрхийг хязгаарлан, шүүхээс тогтоосон хугацаагаар хорьж буй байдлыг илэрхийлнэ. Энэ утгаараа хорих ялд хүмүүжлийн гэхээсээ илүүтэй цээрлүүлэх шинж давамгайлна. Хорих

[1] Compendium of conventions, recommendations and resolutions relating to penitentiary questions. Strasbourg:
Council of Europe Publishing, 2009. p. 171.

газарт хэрэгжүүлж байгаа аливаа үйл ажиллагаа нь чөлөөт сонголтын бус албадлагын хэлбэрээр явагдах ба хоригдлыг нийгмээс тусгаарлан хүмүүжүүлнэ гэдэг өнөөгийн нөхцөлд боломжгүй, хүндрэлтэй;

б) хорих ялд хүнлэг бус шинж чанар давамгайлдаг, өөрөөр хэлбэл хорих дэглэм нь цээрлүүлэх аргад тулгуурлах тул хоригдлын зүгээс аливаа чөлөөт үйлдэл хийх, авьяас чадвараа хөгжүүлэх боломж хязгаарлагдмал;

в) хоригдлын Үндсэн хуулиар тогтоосон зарим эрх, эрх чөлөө хязгаарлагдана;

г) хорих ял эдлэх нөхцөлөөс шалтгаалан нийгэм, ар гэр, хамт олноосоо тусгаарлагдана;

д) хоригдолд бусад хоригдлын зүгээс дарамт шахалт, сөрөг муу нөлөө үзүүлснээс засарч хүмүүжүүлэхээс илүүтэй мэргэшлийн гэмт хэрэгтэн болох магадлалтай юм.

Эдгээр хүчин зүйлс нь хоригдлын хүмүүжил, зан үйл, сэтгэл санаа, бие бялдар, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ түүнийг нийгэмшүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Учир нь нийгмийн зүгээс хорих ялыг гол төлөв эергээр хүлээн авдаггүй тул хорих ял эдэлсэн хоригдлын амьдралд болон гэр бүлийн гишүүдийн насан туршийн хар толбо үлддэг.

Олон улсад сүүлийн 2 жилд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад дараах хүндрэлтэй асуудал тулгараад байна. Үүнд:

1. Эрүүгийн ял, ялын гүйцэтгэлийн бодлогын уялдаа холбоо, тухайлан, давтан гэмт хэргийг бууруулах асуудал;

2. Хорих байгууллагын эрүүл мэндийн үйлчилгээ, “COVID-19” цар тахлын эсрэг хариу арга хэмжээ;

3. Бүс нутаг, тодорхой улс орныг хамарсан дайн тулаан, нийгмийн тогтворгүй байдал, байгалийн гамшиг;

4. Хорих байгууллагын хүний нөөцийн асуудал, тухайлан, хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээрх олон нийтийн оролцоо;

5. Хорих байгууллагын санхүүжилт хангалтгүй, жишээ нь: Камбож, Төв Африкийн Бүгд Найрамдах улс зэрэг улсад хоригдолд өдөрт 1 доллар хүрэхгүй зардал оногдож буй нь хорих орчин нөхцөл муу, эрүүл мэндийн үйлчилгээний хомсдолд хүргэсэн;

6. Эмэгтэй хоригдлын эрх, тэр дундаа хорих ангид төрсөн ээжтэйгээ цуг байгаа хүүхдийн асуудал;

7. Хорих байгууллага дахь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний доголдол, хоригдлын зүгээс үйлдэж буй гэмт хэрэг, хүчирхийлэл, нас баралт (хорих ангид үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн 50-аас дээш хувь нь хүчирхийллийн шинжтэй, 7% хүн алах, 20% нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг) ихэссэн;

8. Хорих ангид хоригдож буй тодорхой бүлгийн (хөгжлийн бэрхшээлтэй, лесби, гей, бисексуал, трансжендер ба интерсекс хоригдол) эрхийн асуудал зэрэг байна[1].

Дээрх хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх хүрээнд улс орнуудын Засгийн газар, бодлого боловсруулагчдаас хорих ял эдлэгсдийн тоог бууруулах, хорихоос өөр төрлийн ял, арга хэмжээний үр дүнтэй хэлбэрийг нэвтрүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүн бүрд хорих ял оногдуулах нь төдийлөн оновчтой сонголт биш юм. Хорихоос өөр төрлийн ял буюу олон улсад алтернатив гэж нэрлэгддэг ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгжиж байна.[2]

Судалгааны ажлыг хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй пробацын үйл ажиллагааны мөн чанарыг нээн илрүүлэхийн тулд ойлголт, шинжийг тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ.

Пробац (probation) гэсэн нэр томьёо нь “probatio” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах гэсэн нэршил юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ял оногдуулж, нийгмээс тусгаарлахгүйгээр олон нийтийн дунд хяналтын болон нийгэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах нөлөөллийн арга хэмжээ гэж ойлгож болно.

Энэхүү ойлголтыг шүүхээс гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорихгүйгээр нийгэмд нь хянах, турших, боломж олгох үйл ажиллагааг төрийн

[1] Алтангэрэл, Б. Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны чиг хандлага. Хууль сахиулахуй. 2022. № 3.

[2] Очгэрэл, Ц. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. //Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2017. №1

байгууллагаас хянах буюу ажиглах гэсэн утгыг илэрхийлж байна гэж үзэж байна.

Олон улсад пробац, парол гэдэг нэр томьёог хамтатган хэрэглэх тохиолдол байдаг. Энэ нь үйл ажиллагааны хувьд ялгаатай ба пробац нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлдэг тогтолцоог, парол нь хорих ялын хугацаа дуусаж болон хугацааны өмнө суллагдсан этгээдэд тавих хяналтын тогтолцоог хэлнэ.

Судлаачийн зүгээс пробацыг эх хэлнээ хөрвүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл, хянан харгалзах (хянах гэдэг нь үйл ажиллагааны тогтолцоо, харгалзах гэдэг нь тодорхой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд чиглэсэн үйлчилгээ) гэж тайлбарлаж болох юм.

Пробацын үйл ажиллагаа гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицоход чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд болон хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад мэргэшсэн гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Европын улс орнуудад XIX дүгээр зууны сүүлч буюу 1872 онд Англи, 1887-1930-д оны хооронд Бельги, АНУ-ын ял эдлүүлэх ажиллагаанд хөгжиж иржээ.

Пробацын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн болон ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг сахиж мөрдүүлэх, улмаар нийгэмшүүлэхэд оршдог бол үйл ажиллагааны үндсэн шинж нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын мэдэлд шилжүүлэн хяналт тогтоон, нийгэмшүүлж буй шийтгэлийн нэг хэлбэр юм.

П.К.Фрайдийн үзэж байгаагаар пробац нь эрх зүйт төрийн тогтолцоотой улс оронд бий болж, төлөвших өндөр магадлалтай гэжээ[1]. Түүнийхээр ял шийтгэл нь залхаан цээрлүүлэх хэрэгсэл болохын хувьд ялын зорилгыг тодорхойлдоггүй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн хэрэгсэл болдоггүй. Учир нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хувийн зан чанар, зан үйлийн төлөвшил болон нийгмийн хүчин зүйл нөлөөлдөг гэжээ.

[1] Friday P.C. 1979. Critical Issues in Adult Probation. Washington, D.C.: International Assessment of Adult Probation, p.73.

Дэлхийн улс орнуудын пробацын үйл ажиллагаанд дараах ижил төстэй тал байна. Үүнд:

Нэг. Пробац нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ болох тухай:

Манай улсад хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ял гэх нэр томьёо нь дэлхийн улс орнуудад:

1. Нийгэм-олон нийтэд тулгуурласан ял нь (community sentence, community based sentence[1]);

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй сонгох ял (alternative sentence);

3. Хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence)-ын нэгэн адил хэрэглэгдэх нэгдмэл нэршил бүхий ойлголт[2] юм.

Нийгмээс тусгаарлахгүй ял, сонгох хувилбараар оноох ял гэсэн ойлголт зарчмын хувьд ижил утгыг илэрхийлнэ. Сонгох хувилбараар оноох гэдэгт нийгэмд учруулсан аюул занал, хохирлын хэмжээг харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдлэх ялыг нийгмээс тусгаарлах шинжгүй ялаар орлуулан хэрэглэж буй төрийн албадлагын арга хэмжээг ойлгоно. Хорихоос өөр төрлийн ялыг дэлхийн ихэнх улсад нийгмээс тусгаарлахгүйгээр ял гэж нэрлэж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, үйлдсэн хор уршгийг арилгах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлж шийтгэх явдлыг эрс шүүмжилсэн, нийгэм-олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг тусламжид тулгуурласан, эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр гэж үзэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ялын төрөл, хэлбэрийг илүү боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь өнөөг хүртэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих арга барил хууль сахиулах, шүүхийн практикт бат бөх оршсоор байна. Иймд олон нийтийн зүгээс эрүүгийн ялын бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй,

[1] Зарим судлаачид “нийгэмд үйлчлэх ял”, “нийтийн тусын тулд үйлчлэх ял” зэргээр нэрлэх нь бий.

[2] www.gov.uk.

ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлсээр байна. Эдгээр арга замын нэг нь нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял буюу хорихоос өөр төрлийн ял гэж үзлээ.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял нь ялтны зарим эрхийг тодорхой болзол, нөхцөлтэйгөөр хязгаарлах замаар оноож буй ялыг ойлгох ба гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн зан байдал, зан үйл, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн шинж, учруулсан хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулдаг байна.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ялын давуу тал нь:

1. Хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан;

2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх олон талын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой;

3. Хүний үндсэн эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хорих ялтай харьцуулахад сул, хувь хүнд үлдээх сөрөг үр дагавар багатай;

4. Хорих ялтай харьцуулахад эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэгт оршино.

Олон улсад ялын сонгох хувилбарын хүрээг тэлж өргөжүүлэхийн тулд юуны өмнө тухайн орны эрүүгийн болон ял эдлүүлэх ажиллагааны тухай хуульд[1] нийгмээс тусгаарлахгүй ялыг[2] түлхүү тусгадаг туршлага байна. Түүнчлэн ял оногдуулах зарчимд тодорхой санкцыг хуульчлан, оногдуулахаас аль болох зайлсхийх, сонгох боломжит шийдлээр зохицуулах, хүнд биш хэргийн хувьд тэнсэх, торгох ялыг хэрэглэх, баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох, торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр илэрхийлэх, хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэн, ял солих процедурыг оновчтой хэрэглэх практик түгээмэл хэрэглэгдэж байна[3].

Эрүүгийн эрх зүйн салбарт глобалчлал, интеграцчиллын үйл явц нэвтэрч эхэлсэнтэй холбоотойгоор дэлхийн хэмжээний эрүүгийн загвар хууль гаргах, олон улсын хэмжээнд дагаж мөрдөх ялын бодлогын үзэл баримтлал боловсруулах ажил 2003 оноос эрчимтэй өрнөж байна. Үүний үр

[1] Монгол Улсын хувьд уг хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай гэж нэрлэсэн байна.
[2] Монгол Улсын хувьд уг ялыг “хорихоос өөр төрлийн ял” гэж нэрлэсэн байна.
[3] Алтангэрэл, Б. Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ судалгааны ажлын тайлан. -Уб., 2018.

дүнд 2007 онд НҮБ-ын болон харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалын олон улсын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр В.Коннор, С.Раушь нарын редакторлаж, олон улсын шинжээч, судлаач, эрдэмтдийн оролцоотой гаргасан Дэлхий дахины эрүүгийн загвар хууль гарчээ.

Энэ загвар хууль 17 бүлэг, 200 зүйл, 300 шахам тайлбарыг өөртөө багтаасан 526 хуудас бүхий томоохон хэмжээний чухал хэрэглэгдэхүүн болжээ[1].

Ялын бодлогын хувьд загвар хууль аль нэг системийн онцлогийг тусгаагүй, харин дундын буюу жишгийн зарчим, хандлага түлхүү тусгагджээ. Ялын төрлийг үндсэн, сонгох, нэмэлт гэсэн гурван ангиллаар авч үзэн, үндсэн төрөлд бүх насаар нь хорих, хугацаатай хорих, торгох, сонгох төрөлд шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах, нийгмийн үйлчилгээнд хамруулах, гэрийн хяналтад байлгах, нэмэлт төрөлд торгууль, нөхөн төлбөр, эрх хасах, хянан харгалзах, үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох, эх орноосоо албадан гаргах зэрэг ялыг багтаажээ.

Ял оноохдоо тухайн гэмт хэргийн хор аюул, гэм буруу, хор уршиг, яллагдаж буй этгээдийн засрах боломж болон нийгмийн шударга ёс сэргээгдсэн эсэхийг харгалзан оновчтой шийдэж байх нөхцөлийг заажээ. Ял нь хууль тогтоомжид эрх зүйн үндэслэлийн хувьд тодорхой томьёологдсон байхаас гадна хуулиас гадуур хэнийг ч яллаж, шийтгэж болохгүй тухай өгүүлсэн нь бий.

Хүснэгт 1. Дэлхийн Эрүүгийн загвар хуульд тусгагдсан ялын төрөл.

Ялын төрөл		
Үндсэн	Сонгох	Нэмэлт
Бүх насаар нь хорих	Шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах	Торгууль, нөхөн төлбөр
Хугацаатай хорих	Нийгмийн үйлчилгээнд хамруулах	Эрх хасах, хянан харгалзах

[1] Model Codes for Post-confilt Criminal Justice Model Criminal code. Vivienne Conner and Colete Raush editors, Peasbuilding and the Rule of law. W,P,L, 2007.

Торгох	Гэрийн хяналтад байлгах	Үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох
		Эх орноосоо албадан гаргах

Өнөө цаг үед дэлхий дахинд ялын бодлогод дараах өөрчлөлт хийгдэж байна. Үүнд:

- цаазаар авах ялыг халах (одоо 99 улсад бүрэн халсан, зөвхөн 58 улсад хэрэглэдэг);

- бие махбодын шийтгэлээс татгалзах;

- цөллөгийн хөдөлмөрийг халах (Европ, Ази тивийн олон улс, АНУ-ын хууль тогтоомжоос хассан);

- нийт хөрөнгө хураах ялаас татгалзах;

- хорихоос өөр төрлийн ял хэрэглэх (торгууль, албадан ажил, тэнсэн, нийтэд тустай ажил, гэрийн хорио);

- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг нэмэх (хохирогчтой эвлэрсэн, аргагүй хамгаалалтын хэмжээ хязгаарыг өргөтгөсөн, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэсэн ойлголт бий болсон);

- насанд хүрээгүй гэмт хэрэгтний эрүүгийн эрх зүйн дэглэмийн хэрэгжилтийг өргөтгөх;

- олон үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо больж, захиргааны зөрчлийн хэмжээнд авч үзэх (жижиг хулгай, танхай, үр хөндөх г.м[1]).

Зарим улс ялын төрлийг тогтоохдоо хүмүүнлэгийн чиглэлийн хүрээнд өөрчлөлт хийж эхэлсэн ба баруун Европын дийлэнх улс, орон цаазаар авах ялыг халж, албадан ажил хийлгэх, эд хөрөнгийг бүхэлд нь хураах ялыг хязгаарлан, нийгмийн үйлчилгээ, хөтөлбөрт хамруулах, нөхөн төлбөр төрлөөр сольж, ялын бодлогодоо өөрчлөлт оруулсаар байна.

Монгол Улсын хувьд өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2015 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт

[1] Болдбаатар Ж. Эрүүгийн ялын бодлогын шинэчлэлт. // Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2018. №3.

хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял тэнссэн, эсхүл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан. Тухайлбал, гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг арга хэмжээ нь олон улсын пробацын үйл ажиллагаанд хамаарах чиг үүрэг адил байна гэж үзэж болно.

Хорихоос өөр төрлийн буюу нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих газарт хорихгүйгээр, ар гэр, амьдралд нь байлган нийгэмшүүлэхэд чиглэгдсэн ялын зорилгыг хангахад чиглэгдсэн төрийн албадлагын арга хэмжээ гэж дүгнэлээ.

Хоёр. Пробац нь ялын гүйцэтгэлийг хангах тогтолцоо болох тухай:

Олон улсад пробацыг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, хорих ял тэнссэн, хойшлуулсан, хорих ангиас суллагдсан этгээдэд хяналт тавьж буй тогтолцоо буюу ялын гүйцэтгэлийг хангах бие даасан тогтолцоо гэж үзэх хандлага байна. Тухайлбал, А.У.Садыковын үзэж байгаагаар пробац нь бие даасан ялын төрөл гэж үзэн дараах хэв шинжийг агуулдаг гэжээ. Үүнд:

- ял шийтгэлийн төрөл;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх арга, хэлбэр;

- ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлэх тогтолцоо;

- нийгэм, эрх зүйн хүрээнд хяналт тогтоох хэлбэр;

- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх хэрэгсэл [1] гэж тодорхойлсон байна.

[1] Учебник. Уголовно-исполнительное право. Под ред. Шмарова И.В. Москва: Бек, 1996.

АНУ, Англид пробац нь шүүхээс тогтоосон туршилтын хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгай байгууллагын хяналтад байлгахаар шилжүүлж буй тэнсэн харгалзах ялын төрөл, ял эдлэх хугацаанд шүүхээс заасан газар нутагт зорчих, тодорхой хүнтэй уулзаж, харилцах эрхийг нэмэлтээр хязгаарлаж болдог байна.

Олон улсын практикт пробацын үйл ажиллагааны чиглэл, агуулга нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- тэнсэгдсэн этгээдэд тавих хяналт;

- нийтэд тустай ажил хийлгэх ялын хэлбэр;

- хорих ял хойшлуулсан, шүүхээс тодорхой төрлийн эрхийн хязгаарлалт тогтоосон нөхцөл;

- зорчих эрхийг хязгаарлах ялын хэлбэр;

- хорих газраас суллагдсан хүмүүст нийгмийн амьдралд ороход туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх;

- насанд хүрээгүй этгээд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд;

- гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүнд туслалцаа үзүүлэх;

- гэмт хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрүүлэх, зуучлах зэрэг чиглэлээр ажиллаж байна.

Пробац нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхийн тулд оноосон хорихоос өөр төрлийн ял буюу сонгох хувилбартайгаар хяналт тогтоох арга хэмжээг хэрэгжүүлж буй хөтөлбөр бөгөөд энэхүү хөтөлбөр, тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд хорих байгууллагад шилжүүлж, ялыг биеэр эдлүүлдэг байна.

Пробац нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр засаж хүмүүжүүлэх зорилготой ялын төрөл тул хяналтын хугацаанд өмнө эрхэлж байсан ажлын байраа хэвээр хадгалан үлддэг. Тухайлбал, пробацын байгууллагын зүгээс гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль, эрх зүйн мэдлэг олгох, хүмүүжил төлөвшил суулгах, соён гэгээрүүлэх, мэргэжил олгох чиглэлээр бүх хэлбэрийн сургалтыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулахын зэрэгцээ архи, мансууруулах бодисын донтолт зэрэг гаж зуршлыг засах эмчилгээнд хамруулдаг.

Улс орон бүр эрх зүйн зохицуулалтын онцлог, нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын өсөлт хөгжил, боловсрол, эрүүл мэнд, гэмт хэргийн гаралт зэрэг хүчин зүйлээс хамаарч ял эдлүүлэх байгууллагын бүтэц, тогтолцоо харилцан адилгүй байх хэдий ч дэлхий нийтээр хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх болсон энэ цаг үед харилцан туршлага судлах, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч байна. (Хавсралт 4-өөс үзнэ үү)

Пробацын тогтолцоо бүхий улс орнуудын хувьд эрүүгийн бодлого, хэрэгжүүлэгч байгууллага нь төрийн тусгай байгууллага байх тогтолцоо давамгайлдаг хэдий ч хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллага нь олон нийтийн оролцоонд тулгуурлах, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон сайн туршлага байна.

Пробацыг ялын гүйцэтгэлийг хангах тогтолцоо гэж үзэх дараах 3 хэлбэр байна. Үүнд:

1. Төрийн ялын бодлогыг хэрэгжүүлэгч болохын хувьд:

Эрүүгийн ялыг тогтоосон эрх зүйн зохицуулалт, ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд тулгуурлан ялын гүйцэтгэлийн бодлого тодорхойлогддог. Эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого гэдгийг төрийн зүгээс эрүүгийн ялын зорилгыг тодорхойлох, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах болон шүүхээс ял оноосон этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг ойлгоно.

Эдгээрийн хэрэгжилтийг төрийн эрх бүхий байгууллага хариуцах бөгөөд ялын гүйцэтгэлийн бодлоготой уялдуулан тухайн байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх;

3. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг засаж хүмүүжүүлэх, хорих ангиас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх зэрэг болно.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хууль сахиулах, хянан шийдвэрлэх, ялыг гүйцэтгэх чиг үүрэгтэй байгууллагын зүгээс олон

нийтийн оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд нарийн зохион байгуулалттай явуулж буй үйл ажиллагаа юм.

Эрх зүйн хүрээнд эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого дараах хэлбэрээр илэрнэ. Үүнд:

- хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

- удирдлага, зохион байгуулалт;

- дүрэм, журмыг өөрчлөх;

- практик үйл ажиллагаа.

Эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлогын агуулгыг тусгах үндсэн хэлбэр нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тогтолцоо, үндэслэл, журмыг тогтоосон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж юм.

Удирдлага, зохион байгуулалт нь хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглал, хүний эрхийг хамгаалах байгууллага зэргээс дэвшүүлж буй гол үзэл санаа, шаардлагыг тусгасан баримт бичиг юм. Тухайлбал, хоригдлын эрх, эрх чөлөөг сахин хамгаалахын тулд хорих ангийн орчин, нөхцөлийг сайжруулахаас гадна хүнлэг харилцааг төлөвшүүлсэн байх шаардлагатай. Үүний тулд хорих ялыг сонгох хувилбартайгаар оноох чиглэлд эрүүгийн ялын бодлогыг хандуулах нь зүйтэй гэж Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд тусгасан байна.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогыг тусгасан дараагийн хэлбэр нь хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх явцад дагаж мөрдөх нөхцөл, журмыг нарийвчлан тогтоож өгсөн төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж буй хэм хэмжээний акт юм.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогыг тодорхойлж буй дөрөв дэх хэлбэр нь эрүүгийн ялыг гүйцэтгэх ажиллагааг гардан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаа юм.

Олон улсад эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогын үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна:

- хорих байгууллагын орчин, нөхцөлийг олон улсын эрх зүйн стандартад нийцүүлэх;

- сонгох хувилбартай ялын хүрээг өргөжүүлэх;

- эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулах;

- хорих ангийн бүтэц, үйл ажиллагааг шинэ хэлбэрээр зохион байгуулах;

- нийгэмшүүлэх чиг үүрэгтэй албыг эрүүгийн ялыг гүйцэтгэх тогтолцооны бүтцэд байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогын үндсэн агуулга нь ялын гүйцэтгэлийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангахад чиглэсэн зорилго, зорилт, зарчмыг онолын үндэслэлтэйгээр тодорхойлоход оршино.

Төрийн ялын бодлогын тогтолцоо нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зүгээс хүлээх үүрэг, хариуцлагыг хуулиар нарийвчлан тогтоох, ялыг гүйцэтгэх ажиллагааг хангах, албадлагын арга хэмжээ хэрэглэх арга, хэрэгслийг боловсронгуй болгоход чиглэсэн төрийн байгууллагын нягт уялдаатай, нарийн зохион цогц ажиллагаа юм.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго, зорилт, зарчимд тавигдах гол шаардлага нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх, олон улсын стандартад нийцсэн байх, эрх зүйн хэм хэмжээтэй уялдсан байх, харьцангуй тогтвортой байх ёстой.

Эрүүгийн ялыг гүйцэтгэх бодлогын зорилго, зарчмыг хуулиар тогтоох ба бодлогын зорилго нь:

- эрүүгийн ял хэрэгжүүлэх ажиллагааг оновчтой бодлогын хүрээнд зөв зохион байгуулах замаар иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас сахин хамгаалах;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засарч хүмүүжихэд эергээр нөлөөлөх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг сахин хамгаалахад чиглэсэн хүмүүжлийн тогтолцоог бий болгох зэрэгт оршино.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, нийгэмшүүлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон

нийтийн анхаарлыг хандуулах, суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах зорилтыг хангах учиртай.

Харин эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэтийн бодлого нь хорих байгууллагын үйл ажиллагааг ардчилсан тогтолцоонд шилжүүлэх, нийгмээс тусгаарлахгүй оноох ялын шинэ хэлбэрийг эрэлхийлж, шүүхийн практикт нэвтрүүлэх, засаж хүмүүжүүлэх чиглэлд олон нийтийн зүгээс үзүүлэх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх зэрэг байна.

НҮБ-ын гишүүн орнууд эрүүгийн хууль тогтоомждоо дээрх зарчмыг баримталж, хорих ялаас татгалзан, хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх, уг ялыг хэрэглэхдээ олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нэмэгдүүлж, нийгмийн хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, зөрчил гаргагч, хохирогчийн хоорондын харьцааг хангах, үндэсний хууль тогтоомж, нийгмийн шударга ёсны шаардлагад нийцүүлж хуульчлах шаардлагатайг дурдсан байгаа нь ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоог илэрхийлж байна гэж үзэж болох юм.

2. Пробацын үйл ажиллагаа нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий цогц арга хэмжээ болохын хувьд:

Олон улсад пробацын үйл ажиллагааг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр нийгэмд нь ял эдлүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ гэж үзэн дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

а) шүүхийн шат буюу гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг цагдан хорихгүйгээр зорчих эрхийг хязгаарлах, батлан даалтад өгөх зэргээр хяналт тогтоох арга хэмжээ;

Гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээдийг цагдан хорих нь эцсийн бөгөөд зайлшгүй тохиолдолд хэрэглэх нь зүйтэй юм.

Цагдан хорихоос илүү түгээмэл арга хэмжээ болох нь барьцаа (бэлэн мөнгөний эсвэл баталгаа өгөх), гэрээсээ гарахгүй байх тухай мэдэгдэл өгөх (бичиг баримт хураан авах), нутаг дэвсгэр, оршин суугаа газрын хязгаарлалт (гэрийн хорио), төрийн байгууллагын цахим хяналтад байлгах зэргийг ашиглаж байна.

Дээрх арга хэмжээг зайлшгүй шаардлагатай эмнэлгийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд тодорхой хүмүүстэй харилцах, чөлөөтэй зорчих,

тээврийн хэрэгсэл жолоодох, согтууруулах төрлийн зүйл хэрэглэх зэрэг эрхийг нь хязгаарлана.

НҮБ-ын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 16-р зорилтын хэрэгжилтийн амжилтыг үнэлэх нэг үзүүлэлт нь цагдан хоригдсон этгээд болон хоригдлын тоо байдаг.

2021 оны байдлаар дэлхий даяар 6 сая хүн цагдан хоригдож байгаагаас 46 орон, тухайлбал, Африк, Азид цагдан хоригдсон хүний тоо шүүхээс ял шийтгэгдэн ял эдэлсэн хүний тооноос илүү байжээ.

Олон улсад гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнийг цагдан хорихоос өөр арга хэрэгслийг хэрэгжүүлэхийн тулд батлан даалтад өгөх, цахим хяналтад байлгахад эмзэг бүлгийн буюу орон гэргүй, ядуу хүмүүст боломжгүй байгаа зэрэг хүндрэлтэй асуудал үүсгэж байна.

б) шүүхийн шийдвэр гарсны дараах буюу хорихоос өөр төрлийн ял оногдуулах, ял тэнссэн, хойшлуулсан болон эмнэлэг, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг гүйцэтгэх арга хэмжээ;

Судалгаанаас харахад хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа ялтны тоо улс орон, бүс нутгуудад ялгаатай байна. Европ, Хойд Америкийн ихэнх орнуудад хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтны тоо хоригдлоос илүү байдаг. Тухайлбал, Европын Холбооны гишүүн 36 улсад 2022 оны нэгдүгээр сард пробацын хяналтад 1.76 сая гаруй хүн, өөрөөр хэлбэл 100 мянган хүнд дунджаар 202 хүн хяналтад байгаа нь хоригдлын *(100 мянган хүнд ногдох хоригдлын тоо 102)* тооноос бараг хоёр дахин их байна[1].

Пробацын хяналтыг Европын Холбооны 28 улсын 15 нь хар тамхитай холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлсэн, Африк тивийн Гамби, Кени, Малави, Нигери, Танзани зэрэг оронд түгээмэл хэрэглэж байна Кени, Уганда, Танзани зэрэг улсад цалин олгохгүйгээр нийтэд тустай хөдөлмөр хийлгэх арга хэмжээ хорихоос өөр төрлийн ялын дийлэнх хувийг эзэлдэг ба цахим хяналт, гэрийн хорио, мөнгөн торгууль, эд хөрөнгө хураах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах, олон нийтэд үйлчлэх, нийтэд тустай хөдөлмөр эрхлэх зэрэг хамаарна.

в) хорих ял эдлээд суллагдсан буюу хугацааны өмнө суллагдсан этгээдэд хяналт тогтоох арга хэмжээ.

[1] www.Cep-probation.org.

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах асуудал анх 1885 онд Францад үүссэн гэж үздэг. Энэ цагаас хойш Европын бусад орноор дэлгэрч улмаар хорих ялаас өмнө тэнсэн суллах институт нь дэлхийн ихэнх оронд хэрэглэгдэж байна[1].

Хорих ялаас хугацааны өмнө болон хугацаа дуусаж суллагдсан, ял тэнссэн, ял эдлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулсан этгээдэд тавих хяналтыг дэлхийн ихэнх оронд пробацын алба гүйцэтгэж байна. АНУ-д 2021 оны жилийн эцсийн байдлаар пробацын хяналтад 6.7 сая хүн байсны 4.6 сая хүн нь ял тэнссэн, ял хойшлуулсан, тэнсэн суллагдсан хүн байжээ.

Энэхүү тогтолцоо тус бүрийн гүйцэтгэх үүрэг, онцлогийн талаар судалгааны ажлын дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

3. Пробац нь төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоо, дэмжлэг дээр суурилсан хуулиар эрх олгогдсон байгууллагын гүйцэтгэж буй үйл ажиллагаа болохын хувьд:

Дэлхийн улс орон, өөрсдийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт тохируулан пробацын албыг нэршил, чиг үүрэг, харьяаллын хувьд өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүрж зэрэг улсад “Пробацын алба”, Норвег, Финлянд, Дани, Эстони зэрэг улсад “Хяналтын алба” гэсэн нэршилтэйгээр ажиллуулж байгаа бол харьяаллын хувьд Англи, Дани, Япон, Финлянд, Норвег, Латви, Чех, Эстони зэрэг улсад Хууль зүйн яаманд, АНУ, ХБНГУ, Унгар зэрэг улсад Шүүхэд, Голландад Прокурорын байгууллагад, Швед, Казакстан зэрэг улсад Хорих байгууллагад, Сингапур улсад Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагддаг.

1990-д оноос хойш хуучин социалист тогтолцоо бүхий улс орнуудад үүссэн нэг хүндрэл нь хорих ял эдлэгсдийн тоо ихэссэн, төсвийн зардал их байсны зэрэгцээ, шоронжсон буюу гэмт зан авир, төлөвшил бүхий нийгмийн давхарга, томоохон бүлэг хүмүүс гарч ирсэн явдал юм. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шоронжуулахгүй байх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор пробацын үйл ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн байдаг.

[1] Додонов В.Н. Сравнительное уголовное право. Общая часть под общ. ред. С. П. Щербы—М., Юрлитинформ, 2009. -С. 397, 448.

Дэлхийн улс орнуудад эрх зүйн тогтолцоо өөр хэдий ч пробацын үйл ажиллагаа, зорилго, ач холбогдлын хувьд ижил төстэй байдлаар хөгжиж иржээ.

Ихэнх улс орон пробацын үйл ажиллагааг төрийн бусад байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгж, хувийн хэвшлийн болон сайн үйлсийн байгууллага, иргэд, сайн дурын ажилтны оролцоонд тулгуурлан зохион байгуулдаг бөгөөд тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, түүнчлэн пробацын албанаас заавал биелүүлэх нөхцөлийг даалгасан, эрхийг хязгаарласан үүргийг хэрэгжүүлэх нөхцөл болдог.

Зарим улс орны ял шийтгэлийн бодлого нь нийгэм, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, гэмт явдлыг тогтоон барих, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчихгүйгээр дагаж мөрддөг байх, нийгмийн эсрэг зан үйлийг өөрчлөх агуулгаар хэрэгжиж байгаа бөгөөд ялын бодлогодоо өөрчлөлт оруулсан жишээ бий. Тухайлбал, Сингапурт 1965 онд баримталж байсан ялын бодлого нь зөвхөн гэмт хэрэгтэнд оногдуулах шийтгэлийн арга хэмжээ[1] гэж үзэж байсан бөгөөд энэ нь дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг өндөр түвшинд хүргэсэн туршлага[2] гэж үзсэн байдаг. Тус улсын Шүүхийн шинэчлэлийн нэг асуудал нь нийгэм, олон нийтийн оролцоонд тулгуурласан ялын төрлийг ашиглах явдлыг дэмжсэнд оршиж байгаа ба 2006 оны 6 сард байгуулагдсан “Олон нийтийн шүүх”-ийн үйл ажиллагаа энэхүү нөхцөлийг нэмэгдүүлсэн байна.

Энэхүү шинэчлэлийн үзэл баримтлал нь шүүн таслах ажиллагааны болон “гэмт хэрэгтэн – хохирогч - олон нийт” гэсэн загварын тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэгдэж, ялын бодлогын нөхөн сэргээх ба хариуцлага үүрүүлэх, гэмт хэрэгтний эрх ба хохирогчийн зөрчигдсөн хэрэгцээг хангах, гэмт хэрэгтнийг үүрэгжүүлэх болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлын тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн гэж үзэж болно.

Олон нийтийн оролцоонд тулгуурласан ял эдлүүлэх шинэ хандлага нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх төдийгүй хохирогчдын эрхийг хангасан бодлого болохыг Засгийн газар, иргэдийн зүгээс дэмжиж, Хууль зүйн

[1] Peter English, “Sentencing in Singapore” (1981) 23 Mal.L.R. 1, at p.24.
[2] www.prisons.gov.

яамнаас нийгэм-олон нийтэд оногдуулах хувилбарыг нэмэгдүүлж, хэд хэдэн чиглэлээр ажиллах болжээ. Тухайлбал:

- шаардлагатай эмчилгээ хийх (бэлгийн хүчирхийлэл, садар самуунтай тэмцэх ажлыг хэрэгжүүлэхэд сэтгэцийн эмчилгээ хийх);

- богино хугацаанд цагдан хорих (гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, эрхэлж буй ажлаас нь түдгэлзүүлэхгүйгээр долоо хоногоос илүүгүй хугацаагаар хорих);

-“day reporting center”-т хамруулах (гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаа, тогтмол мэдээлэл авч байх ба шаардлагатай тохиолдолд цахим хяналтыг хэрэгжүүлэх);

- олон нийтийн ажил хийлгэх; (40 хүртэлх цагаар хийлгэх, тухайлбал, бусдын бие, эрхтэнд гэмтэл учруулсан бол тухайн өвчтөний хагалгааг хийлгэхэд шаардлагатай үйлчилгээний ажилд оролцуулах);

- олон нийтийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах (16-аас дээш насны гэмт хэрэгтэнд төлбөр төлөхийг шаардан, сайн дурын үйлчилгээний байгууллагад 40-340 цагаар ажиллуулах);

- тусгайлсан хөтөлбөрт хамруулах (шүүхээс оногдуулсан хугацаанд тухайн хүний зан үйл, хандлагыг өөрчлөх, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн 12-24 сарын хөтөлбөрт хамруулах) зэрэг ажлыг хэрэгжүүлж байна.

Пробац нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны нэгэн хэсэг болон оршсоор байгаа аль ч улс орны хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөхцөлийг судлах, хорих ялаас татгалзах, нийгмийн дунд ял шийтгэлийг эдлүүлэх аргыг одоо ч эрэлхийлсээр байгаа билээ.

Пробацын үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдлыг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хорих ялын өндөр зардлыг багасгах зорилгоор хэрэгжих эхэлсэн гэж үзэж болно.

Дэлхий улс орнуудад хорих газраас суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байна. Үүнд:

1. Нийгмийн хяналтын хэлбэр (Social control of criminals);

2. Нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр (Rehabilitation of criminals).

Энэхүү хоёр хэлбэр нь тухайн улсын хөгжлийн чиг баримжаатай холбоотой хандлагаар илэрхийлэгддэг. Жишээ нь: нийгмийн хяналт нь хорих газраас суллагдсан хүмүүсийг “засаршгүй хүмүүс” гэж үзээд “рицедив гэмт хэрэгтэн” хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг.

Нөгөө хандлага нь либерал баримжаатай барууны орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын үндэс 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.

Орчин үед Европын холбоо зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийг баримжаалан хөгжиж байгаа улс орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүст дэмжлэг үзүүлэх төрийн бодлого илүү үр дүнтэйг зөвлөж, гишүүн улс орнууддаа энэхүү ажлын стандартыг тогтоох шаардлага тавьж байна[1].

Хорих байгууллагад ял эдэлж байгаа хоригдол суллагдан гарсны дараа учрах бэрхшээлийн талаар асуулгад ихэнх нь “хорихоос суллагдахад бэрхшээл ихтэй байдаг, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах, хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх” гэсэн айдастай байхад, иргэд эсрэгээр суллагдсан хүмүүсийн талаар сөрөг төсөөлөл, хандлагатай байна.

Иймд манай улсад хорих байгууллагаас суллагдсан хүнийг нийгэмшүүлэхэд нийгмийн хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах ажлыг засаг захиргааны болон

[1] ХЗҮХ. Судалгааны тайлангийн эмхэтгэл. - Уб., 2012. 663 дахь тал.

төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын идэвх санаачилгаар дамжин хэрэгжих ёстой гэж үзлээ.

Гурав. Пробац нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаа:

Пробацын үйл ажиллагаа нь хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, хорих байгууллагаас суллагдах дөхсөн, түүнчлэн ял эдлээд суллагдсан иргэдэд туслалцаа үзүүлэхээс гадна ажилд зуучлах, санхүүгийн ухаанд суралцуулах, нийгэмшүүлэх зорилго бүхий хөтөлбөрт хамруулах, боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулах, хөдөлмөрийн биржтэй холбож өгөх зэрэг туслалцаа үзүүлж, хувийн бичиг баримттай болоход туслах, дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн зохист амьдралд ороход туслалцаа үзүүлэхэд голлон чиглэгддэг.

Пробацын албанд ихэвчлэн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, социологич зэрэг мэргэжлийн хүнийг ажиллуулдаг байна.

ХБНГУ-ын Пробацын албанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- зөвлөгөө өгч харилцан туслах;

- хорих ял эдэлж байгаа хоригдолтой холбоо тогтоох;

- гэр бүл, асран хамгаалагчаар нь дамжуулан нөлөөлөх;

- эмчилгээний сэдэл өгөх;

- донтох зуршлаас татгалзуулах (архи, тамхи, мансууруулах бодисын хамаарал г.м);

- эмчилгээнд хамруулах;

- төлбөрөө төлөх хөтөлбөр боловсруулахад үзүүлэх дэмжлэг;

- төлбөрөө барагдуулах төлөвлөгөө боловсруулах;

- төлбөрийн зөвлөгөө өгөх төвтэй холбоо тогтоох;

- ажлын байр хайх (сургалт, давтан сургалтад дэмжлэг үзүүлэх);

- амьдрах орон сууц хайхад дэмжлэг үзүүлэх;

- орон сууцны төсөл, хөтөлбөрт хамрагдахад туслах;

- эдийн засгийн бэрхшээлтэй холбоотой зөвлөгөө, тусламж;

- хүчирхийллийн эсрэг сургалт;

- хорих ангиас суллагдах бэлтгэл зөвлөгөө;

- урьдчилан саатуулах хувилбарыг бэлтгэх;

- хорихоос өөр төрлийн ялаар орлуулахад түлхэц үзүүлэх;

- бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

- ажил гүйцэтгэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл байдлыг сайжруулах;

- орон нутгийн зүгээс ялын хэрэгжилтэд оролцох (жишээ нь: донтолт, орон гэргүй байдал, урьдчилан сэргийлэх, нийгмийн халамж гэх мэт).


Түүнчлэн Япон[1], Англи, АНУ[2] зэрэг орны туршлага нь хорих ял эдлүүлэхэд гарах зардлаа хэмнээд зогсохгүй ял шийтгэгдэгсдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй сөрөг асуудлыг шийдэж чадсан байна.

Пробацын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж үзвэл дараах зураглал бий болж байна.

Зураг 1. Пробацын нийтлэг үйл ажиллагааны зураглал.

[1] Япон улсад 1995 онд “Гэмт хэрэг, зөрчил гаргагчийг нийгэмшүүлэх тухай” хууль, 1996 онд “Сайн дурын пробацын албаны тухай” хуулийг баталсан бөгөөд тус улсын Хууль зүйн яамны харьяанд Нийгэмшүүлэх буюу нийгмийн ажлын товчоо ажилладаг.

[2] АНУ-д Halfway house байгууллага нь хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа эргэн нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай, хууль сахиулах байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг, тусгайлсан институт байна.



Пробацын мөн чанар, ач холбогдол:

Судлаачийн зүгээс пробацын үйл ажиллагааны мөн чанарыг нь дараах байдлаар илэрнэ гэж үзлээ. Үүнд:

1. Эрүүгийн эрх зүйн хүрээнд ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэлбэр;

Эрүүгийн хууль тогтоомжоор гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тогтоодог бөгөөд пробац нь тухайн ял, шийтгэлийг эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах хэлбэр байна.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлыг тодорхойлон, шүүхээс цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээг авах, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг оногдуулахад чиглэсэн ажиллагаа;

Шүүхээс зайлшгүй хорихгүйгээр нийгэм, ар гэрийн хүрээнд байлган, сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх замаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шоронжих явдлаас сэргийлэхэд онцгой анхаарах нь чухал юм.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй дэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх хяналт, нийгэмшүүлэх тогтолцоо;

Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь ялын зорилгыг хангахаас гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч ялын үр нөлөөг хангах явдал байдаг. Шүүхээс зайлшгүй хорихгүйгээр нийгэм, ар гэрийн хүрээнд байлган, сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх замаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шоронжих явдлаас сэргийлэхэд онцгой анхаарах нь чухал юм.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй дэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх хяналт, нийгэмшүүлэх тогтолцоо;

Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь ялын зорилгыг хангахаас гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч ялын үр нөлөөг хангах явдал байдаг.

5. Криминологийн үүднээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгэм, эрх зүйн шинжтэй арга хэмжээ;

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгэмд үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах, улмаар иргэдийн аюулгүй орчинд аж төрөх нөхцөл бүрдэх юм.

6. Нийгмийн ажлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт зан үйлийг засах, нөхөн сэргээх, эмнэлэг, халамжийн үйлчилгээ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэрэгцээг тодорхойлсноор халамжийн болон эмнэлэг, сэтгэл зүй, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэн, гэмт зан үйлээс татгалзуулах, иргэншсэн бие хүн болгон төлөвшүүлэх нь чухал юм.

ДҮГНЭЛТ

1. Хоригдлын тоо багасах;

Дэлхийн улс орнуудын хэмжээнд хоригдлын тоо нэмэгдэн, 2002 онд 8 сая байсан бол 2020 оны судалгаагаар цагдан хоригдсон, захиргааны журмаар баривчлагдсан хүн орохгүйгээр 11 сая хүрсэн байна. Үүнд 2000 оноос хойш эмэгтэй хоригдлын тоо 50 хувиар нэмэгдэн 2020 онд 700,000 мянга давж, 19.000 мянган хүүхэд хорих ангид төрж, ээжтэйгээ хамт хоригдсон байна. Түүнчлэн 2020 онд 410,000 насанд хүрээгүй хүүхэд хорих ял эдэлж, 1 сая хүүхэд баривчлах шийтгэл эдэлж, 3 сая хүүхэд цагдан

хоригджээ. Дэлхий даяар дайны олзлогсдыг тооцохгүйгээр 11 сая гаруй хүн хорих ял эдэлж байгаа нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял оногдуулсан энэ бол дээд амжилт болж байна. Дэлхийн 102 улсад хорих ангийн багтаамж 100 хувиас илүү гарсан байна[1]. Дээрх тоо баримт нь аливаа улс оронд хоригдлын тоог бууруулах асуудал чухлаар тавигдсан ба үүнийг шийдвэрлэх үндсэн арга хэмжээ нь пробацын хяналтад байлгах явдал юм гэж хүлээн зөвшөөрчээ.

2. Хорих ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй зардал буурах;

Пробацын үйл ажиллагаа нь хоригдлыг хугацаанаас нь өмнө суллах бодлогын нэгэн адил хоригдолд зориулсан төсвийн зардлыг хэмнэхэд оршдог. АНУ-ын хувьд пробацыг өргөн хэрэглэдэг орны нэг зүй ёсоор тооцогддог бөгөөд энэ нь бусад ял, түүний дотроос хорих ялыг бодвол эдийн засгийн хувьд харьцангуй хэмнэлтэй ялын төрөлд тооцогддог. Тухайлбал, тус улсын татварын албаны хийсэн тооцоогоор хорих газарт ял эдэлж байгаа 1 хоригдолд жилд 20.000 ам.доллар зарцуулдаг бол пробацын албаны хяналтад байгаа 1 хүнд жилд 1000 ам. доллар зарцуулдаг байна[2]. Харин Канад улсад хоригдлын зардал 52,953 доллар, пробацын хяналтад жилд ойролцоогоор 10,951 доллар зарцуулж байна.

Монгол Улсад 2022 оны байдлаар хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 24.380 төгрөг буюу жилд 8.898.941 төгрөг байгаа ба хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох өдрийн дундаж зардал 2704 төгрөг буюу жилд 987.002 төгрөг байгаа нь хорих ял эдлүүлэх зардлаас даруй 89 хувиар бага байна[3]. Хэдийгээр хорих ял эдлүүлэх ажиллагаанд гарах зардлыг хэмнэх нь зүйн хэрэг боловч дэлхийн 54 орны хорих ял эдлүүлэх төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний 0,3 хувиас бага, түүнчлэн ихэнх зардал нь алба хаагчдын цалин, хангамжид зарцуулж байгаа нь хоригдлын хүнс, ахуй нөхцөл, нийгэмшүүлэх ажил, эмнэлгийн үйлчилгээнд маш бага зардал зарцуулж буй нь зайлшгүй анхаарал хандуулах асуудал гэж үзэж байна.

[1] www.Cep-probation.org.

[2] Аккулев А.Ш. Отдельные вопросы пробации // Научный журнал: Вестник Евразийского гуманитарного института 2010. №4.

[3] Хууль зүй, дотоод хэргийн яам. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоо. -Уб., 2020. 17 дахь тал.

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх ажлын үр нөлөө сайжрах;

Нийгэмшүүлэх ажлыг зөвхөн хорих ял эдлэгсдийн дунд бус гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлэг, хөдөлмөр, сэтгэл зүй, халамжийн үйлчилгээ зэргийг цогц байдлаар хүргэснээр амьдралын чадавх дээшлэх, зөв амьдрах хандлага төлөвших нөхцөл бүрдэнэ.

4. Давтан рицедив гэмт хэрэг буурах;

Ялын бодлогын шинэчлэлийн нэг хэсэг болох хорих ял биечлэн эдлэх явдлыг багасган, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулан, хөдөлмөр эрхлүүлж хохирлоо нөхөн төлүүлэх, бусад хоригдлоос суралцан мэргэшсэн гэмт хэрэгтэн болгохгүйн тулд авч байгаа шинэлэг арга хэмжээ юм.

5. Ял эдлүүлэх ажиллагаа дахь олон нийтийн оролцоог сайжрах;

Пробацын үйл ажиллагаанд төр, төрийн бус байгууллага, иргэд, тухайлан ажил олгогчдыг өргөнөөр татан оролцуулснаар нийгэмшүүлэх ажлын үр нөлөө сайжирч, ялын зорилго хангагдах боломж бүрдэх юм. Японд жирийн иргэдийн дундаас сайн дурын ажилтныг ажиллуулж байгаа нь үр дүнтэй байсан ба 2017 онд 47,909 сайн дурын ажилтан ажиллажээ.

6. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын нөхөн төлөлт сайжрах;

Пробацын үйл ажиллагааны гол онцлог нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зайлшгүй хөдөлмөр эрхлүүлж, учруулсан хохирлоо нөхөн төлүүлэхэд оршиж байгаа нь тухайн этгээд нэг талаас хөдөлмөрийн дадлага эзэмших, ажлын байртай болохоос гадна гэмт хэргийн улмаас учруулсан хохирол нөхөн төлөх байдал эрс сайжирдаг гэж үздэг байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл, Монгол Улсад хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд нийгэм-олон нийтийн оролцоонд тулгуурласан хэлбэрийг сонгож, эрх зүйн зохицуулалт, тогтолцооны үндсийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд пробацын үйл ажиллагааг жишиг хэлбэрээр бий болгон хөгжүүлэх, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийг татан оролцуулах боломжтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

---o0o---

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS FACED IN PENALTIES OF TRAVEL RESTRICTIONS



Б.Уянга

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, дэслэгч

Товч утга: Энэхүү илтгэлээр манай улсын эрүүгийн эрх зүйн ялын бодлогод шинээр нэвтэрсэн зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч, хяналтын тоног төхөөрөмжийн практик хэрэглээг судалж, тулгамдаж буй асуудлуудыг нээн илрүүлэх зорилготой.

Abstract: In this report, the purpose of this report is to investigate the practical use of electronic bracelets and control equipment used in sentencing to restrict the right to travel, which have been newly introduced in the penal policy of our country, and to discover the problems.

Түлхүүр үг: Зорчих эрхийг хязгаарлах ял, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, цахим бугуйвч, электрон мониторинг, цахим хяналт.

Key words: electronic bracelet, convict, punishment, electronic monitoring, punishment of restriction on freedom of travel.

УДИРТГАЛ

Дэлхийн ихэнх улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн

тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл баримтлал, зарчим давамгайлж байна[1].

Ял эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь их хэмжээний зардал үүсгэж байгаагийн зэрэгцээ суллагдсан хүмүүс нийгмийн орчинд дасан зохицох чадвар муу, гэмт хэрэг дахин үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ялыг үр дүн багатай ялын төрөлд тооцдог. Хорихоос өөр төрлийн буюу олон улсад алтернатив ял гэж нэрлэгддэг ял (alternative penalty) нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг.

1.Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай байна.

2.Манай улсын хувьд хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний онцлог байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял нэмж, хэрэгжилтийг нь цахим хэлбэрээр хянах нөхцөл бүрдүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдүүлнэ” гэх зорилтын хүрээнд “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем” хөгжүүлэн, ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна. Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжсэнээр Үндсэн хуулиар тунхагласан, ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрхийг дээдлэх тулгуур зарчимд нийцүүлэх, гэмт этгээд ажиллаж хөдөлмөрлөн, гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх, учруулсан хохирлоо нөхөн төлөх, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой. Өнөөдрийн байдлаар хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 7231 төгрөг буюу жилд 2.639.619 төгрөг байна. Харин зорчих эрхийг

[1] Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжил судалгааны тайлан. Уб., 2022. 2 дахь тал.

хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох өдрийн дундаж зардал 3313 төгрөг буюу жилд 1.209.173 төгрөг байгаа нь хорих ял эдлүүлэх зардлаас даруй 54.1 хувиар бага байна[1].

Манай улсын хувьд ч мөн адил хорих ялаас татгалзах, ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний зан байдалд тохирсон ялыг оновчтойгоор хэрэглэх замаар ял үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас баталсан "Эрүүгийн хууль"-д шинэ төрлийн ял болох "Зорчих эрхийг хязгаарлах ял"-ыг нэмж, хэрэгжилтийг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн[2].

Зорчих эрхийг хязгаарлах ял нь олон улсын эрүүгийн эрх зүйд "гэмт этгээдийг нийгмээс тусгаарлалгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг" ялын төрлүүд буюу хорихоос бусад төрлийн ялууд дундаас "эрүүгийн хариуцлага, ялын зорилго бүрэн хангагдах боломжтой, гэмт этгээдийг нийгэмшүүлэх өндөр үр нөлөө бүхий ялын төрөл гэдэг"[3]-тэй судлаачийн хувьд санал нэгддэг.

НЭГ. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ХЭРЭГЛЭЭ

Монгол улсын эрүүгийн хуульд хорих ялыг 469 гэмт хэрэгт буюу 43.4%, торгуулийн ялыг 267 гэмт хэрэгт буюу 25.3%, зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 гэмт хэрэгт буюу 20.3%, тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 44 гэмт хэрэгт буюу 4.5%, нийтэд тустай ажил хийлгэх ялыг 68 гэмт хэрэгт буюу 6.3% нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар зохицуулсан байна.

Эндээс үзэхэд шинэчлэн батлагдсан Монгол улсын Эрүүгийн хуульд нийт 1088 гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулахаас 619 буюу 60% орчимд нь бидний судалж буй хорихоос өөр төрлийн ялыг оногдуулахаар зохицуулсан нь энэ төрлийн ялуудын хэрэглээ шүүхийн практикт харьцангуй өссөн болохыг илтгэн харуулж байна.


---

[1] Нээлттэй нийгэм форум. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжил судалгааны тайлан. Уб., 2022. 4 дахь тал

[2] Дамдинцэрэн, Д. "Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах эмхэтгэл". Уб., 2021.11 дэх тал.

[3] Ходжалиев. С.А. Теория и практика ограничения свободы как вида наказания. Грозный., 2019.С.75. России. /00Ходжалиев.С.А. Зорчих эрхийг хязгаарлах ялын онол, практикийн асуудал. Грозны., 2019. 75 дахь тал. Оросын Холбооны Улс.

Хүснэгт 1. “Эрүүгийн хууль”-д тусгасан ялын төрлүүдийн тус бүрийн эзлэх хувь. (Эрүүгийн хууль 2017 он.)



	Нийт	Торгууль	Хорих	Эрх хасах	Эрх чөлөө хязгаарлах	Нийтэд тустай ажил хийлгэх
эзлэх хувь	100	25.3	43.4	4.5	20.3	6.3
тоо	1088	267	469	44	240	68

Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг - 240 төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар тогтоосон бөгөөд хөнгөн гэмт хэрэгт - 121, хүнд гэмт хэрэгт - 119 тохиолдолд тус тус оногдуулахаар тогтоосон байна. Үүнд:

- зорчих эрхийг хязгаарлах ял эсхүл хорих ялын аль нэгийг сонгож оногдуулахаар - 176 гэмт хэрэгт,
- зорчих эрхийг хязгаарлах ялыг торгох ялын аль нэгийг сонгож оногдуулахаар 153 гэмт хэрэгт;
- зорчих эрхийг хязгаарлах ял, торгох эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ялын аль нэгийг сонгож оногдуулахаар 48 заалтад оногдуулахаар тогтоожээ.

Дээрх судалгаанаас үзэхэд “*зорчих эрхийг хязгаарлах”* эсхүл *“хорих ял”*-ын аль нэгийг сонгож хэрэглэхээр ихэвчлэн хүнд гэмт хэрэгт буюу – 119 заалтад, хөнгөн гэмт хэрэгт буюу – 57 заалтад “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, болон “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг” “авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-т түлхүү оногдуулахаар хуульчилсан байна.

Өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эрүүгийн хуулийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуультай харьцуулахад шинээр батлагдсан эрүүгийн хууль гэм бурууtай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд

хорих бус хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэхээр хуульчилсан нь манай орны эрүүгийн ялын бодлого энэрэнгүй /гуманизация уголовной политики/ ёсны зарчимд суурилсан буюу ялын уян хатан, зөөлөн /гибкость/ бодлогыг баримталж буйг илтгэн харуулж байна.

ХОЁР. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭЕРЭГ ҮР НӨЛӨӨ

Шинэчлэн батлагдсан эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын хэрэглээний судалгааг харахад “зорчих эрхийг хязгаарлах” эсхүл “хорих ял”-ын аль нэгийг сонгож оногдуулах зохицуулалт түлхүү байх тул дээрх хоёр ялын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө /последтсвия/ талаас судалж үзэх нь зүйтэй юм.

Хорих анги, байгууллагад яд эдэлж буй хоригдогчийн тоо, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардал буурах, улсын төсөвт хэмнэлт хийх хүрээнд:

Хоригдолд ногдох нэг өдрийн дундаж зардал 14000 гаруй төгрөг, жилд 5 сая гаруй төгрөг байна. Шууд зардалд цахилгаан, түлш, халаалт, цэвэр бохир ус, урсгал засвар, хичээл үйлдвэрлэл, нормын хувцас зөөлөн эдлэл, хоол, эм, эрүүл мэндийн даатгал шууд бус зардалд харуул хамгаалалтын цалин, тээвэр шатахуун, харуул хамгаалалтын багаж, сэлбэг хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг оруулсан.[1]

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны нэг өдрийн дундаж зардлыг дараах байдлаар тооцсон. Үүнд: шууд зардалд сим карт, дата/500мв/ эрхийн үйлчилгээг оруулсан. Шууд бус зардалд алба хаагчдын цалин, тээвэр,

шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо интернэтийн төлбөрийг оруулан тооцон нэг өдрийн дундаж зардлыг эхний жил 3313 төгрөг, жилд 1.209.173 төгрөг гэж тооцоолсон. Хорих ялын зардлаас 3918 төгрөг буюу 54.1 хувиар бага байна.[2]

Шинэчлэн батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ийн 169 дүгээр зүйлийн 169.1-т "Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй” гэж заасан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зорчих

[1] Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо Хууль зүй, дотоод хэргийн яам. УБ 2020. 17 дахь тал
[2] Мөн тэнд 18 дахь тал

эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглагдаж байгаа цахим бугуйвчийн ашиглалтын зардал, эвдрэл гэмтлийн төлбөрийн зардалд 2021 онд 241.185.075 төгрөг, 2022 онд 748.5159.225 төгрөг, 2023 оны 05 дугаар сард 282.259.040 төгрөг нийт 1.271.603.340 төгрөгийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Улсаас хорих ангид ял эдэлж буй хоригдлын нэг өдрийн дундаж зардалд өдөрт 14 орчим мянга, 1 жилд дунджаар орчим 2.8 сая төгрөгний зардал гаргаж байгаа бол зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулж, биелэлтийг хангуулж эхэлснээр улсын төсөвт орлогоор 2 жил гаруй хугацаанд 1.271.603.340 төгрөг орж ирсэн нь зорчих эрхийг хязгаарлах улс орны эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө мэдэгдэхүйц хэмжээгээр харагдаж эхэлсэн гэж үзэж болохоор байна.

Нэг ялтанд ногдох дундаж зардал						
		Нийт төсөв	Хүний тоо /58+1080+20/	ялтны эзлэх хувь		Нэг өдрийн зардал
1.Шууд зардал						
	Дата /500 MB/	5,400,000.00	1,158.00	0.93	5,036,269.43	12.78
	Сим карт	10,800,000.00	1,158.00	0.93	10,072,538.86	25.55
	Бусад зардал					3,274.47
	Дүн	**16,200,000.00**				**3,312.80**
	Жилийн зардал					**1,209,172.71**
2. Шууд бус зардал						
	Алба хаагчдын цалин	1,013,026,800.00	1,158.00	0.93	944,791,834.20	2,396.7
	Тээвэр шатахуун	146,059,200.00	1,158.00	0.93	136,221,015.54	345.6
	Бичиг хэргийн зардал	4,026,000.00	1,158.00	0.93	3,754,818.65	9.5

	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	220,910,000.00	1,158.00	0.93	206,030,051.81	522.7
	Дүн	1,384,022,000.00				3,274.5
Нэг ялтанд ногдох дундаж зардал 2 дахь жил						
		Нийт төсөв	Хүний тоо /58+1500+20/	ялтны эзлэх хувь		Нэг өдрийн зардал
1.Шууд зардал						
	Дата /500 MB/	7,500,000.00	1,578.00	0.95	7,129,277.57	13.02
	Сим карт	15,000,000.00	1,578.00	0.95	14,258,555.13	26.04
	Бусад зардал					2,402.94
	Дүн	**22,500,000.00**				**2,442.01**
	Жилийн зардал					**891,332.07**

ГУРАВ. ТЕХНИКИЙН ТАЛААС ХЯНАЛТ ТАВИХАД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч нь “хориглосон бүсэд нэвтрэх”, “хязгаарласан бүсээс гарах”, “бүсийн хязгаарт ойртсон”, “явах маршрутаас гарсан” зэрэг тохиолдолд цахим бугуйвчид анхааруулах мессеж илгээх болон “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн “хяналтын нэгдсэн систем”-д 24 цагийн турш тасралтгүй “анхааруулга, дохио” дамжуулах горимоор ажилладаг.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг зөвхөн “үүрэн холбоо сүлжээ” орсон газарт хангуулах боломжтой тул Монгол Улсын газар нутгийн “засаг захиргааны нэгжүүд /аймаг, нийслэл, сум, баг, хороо/-д хамгийн түгээмэл тархсан “үүрэн холбооны оператор” болон “2G сүлжээ”

дэмждэг цахим бугуйвчийг сонгон ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж байна.


Ялтанд тавих техникийн хяналтыг “үүрэн холбооны сүлжээний /сим карт, 2G data/” буюу түүний мэдээлэл дамжуулагч/GPS/-ийн тусламжтайгаар гэмт этгээдийн “байршил, хөдөлгөөн”-ийг тогтоож, тухайн мэдээллийг цахим хяналтын системд мэдээлэх байдлаар хяналтыг хэрэгжүүлдэг.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй “цахим бугуйвч” нь БНХАУ-д үйлдвэрлэсэн бөгөөд “2G сүлжээ”-ний “data” буюу интернетийн хурдаар мэдээлэл дамжуулан хяналтыг цахимаар тавих боломжтой байдлаар зохицуулагдсан байна.

“2G сүлжээ нь” тархцын хувьд манай орны нутаг дэвсгэрийг өргөн хамрах хэдий ч мэдээлэл, дохио дамжуулах хурд нь “384 kbps” буюу “3G сүлжээ”-нээс даруй 112 дахин бага хурд, хүчин чадалтайгаас гадна үүрэн холбооны ачааллаас шалтгаалан “...сүлжээ унах, тодорхойгүй хугацаагаар тасрах, мэдээлэл дамжуулагч нь цемент, төмөр, бетон, тоосгоор баригдсан барилга, байгууламж...” болон байгалийн төрөл бүрийн тогтоц /өндөр уул, даваа, нугачаа/-д ойж, сарнин “алдах, хүлцэх” тохиолдол түгээмэл байдаг.

Эндээс үзэхэд ялтан орон сууц буюу “...төмөр, бетон, тоосго...”-оор баригдсан объектод орсон тохиолдолд “...хиймэл дагуулаас цахим бугуйвч байршлын мэдээ хүлээн авах боломжгүй болсоны улмаас...” байршил тогтоогч (GPS)-ийн огноо “...тухайн хөдөлгөөн хийсэн сүүлийн цагт гацаж, дараагийн цэгийг заахгүй байгаа нь ялтныг цахим хяналтаас алдах, ял завшуулах...” эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Зураг 1.Үүрэн холбооны технологийн хөгжлийн зураг.



1. Цахим бугуйвчтай холбоотой асуудал:

Цахим бугуйвч нь “хүний биед харшил өгөхгүй, хүний гар болон хөлд зүүхээр тохируулсан, хөнгөн жинтэй, ус, доргио, шорооны хамгаалалттай, халуун хүйтэнд тэсвэрлэх” боломжтой бөгөөд “таслах, тайлах, оролдох” үед хяналтын нэгдсэн системтд анхааруулга өгөх горимоор ажилладаг бөгөөд “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д нийт 9-10 төрлийн анхааруулга дохио ирдэг. Үүнд:

- Цэнэг дуусаж байна 30%.
- Цэнэг дуусаж байна 5%, Яаралтай цэнэглэнэ үү.
- Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан.
- Маршрутаас гарсан.
- Хориглосон бүсэд 200 метр ойртсон.
- Хориглосон бүсэд нэвтэрсэн
- Бүсийн хязгаарт 200 метр ойртсон.

Зураг 2. Цахим хяналтын системд ирсэн анхааруулгын судалгаа



2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д цахим хяналт ажиллахад нийт 1643 “анхааруулга, дохио” ирсэн бөгөөд “Цахим хяналт, удирдлагын төв”-ийн алба хаагчид хариуцсан шийдвэр гүйцэтгэгч тухай бүр мэдэгдэж, илэрсэн “зөрчил, дутагдал”-ыг тухай бүр арилгаж, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажилласан байна.

“Зорчих эрхийг хязгаарлах хяналтын систем”-д ялтан бүртгэж, хяналтад авсан цаг үеэс хойш хяналтын системд ирсэн нийт анхааруулга дохионоос 87% хувийг “Цэнэг дуусаж байна 30%” гэсэн “анхааруулга,

дохио” эзэлж байгаа нь ялтанд зүүлгэсэн “цахим бугуйвч”-ийн батарей цэнэгээ хангалтгүй барьж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвчаар хяналт тавихад дараах хүндрэлтэй асуудлууд байна. Үүнд:

- Цахим бугуйвчийн цэнэг дууссан тохиолдолд дахин цэнэглэхэд төвөгтэй бөгөөд суурин цахилгааны эх үүсвэрээр зориулалтын цэнэглэлэгч/толин/-ээр бүрэн цэнэглэсэн үедээ *цэнэгээ барих хугацаа нь хагас өдөр буюу 10-12 цагаас хэтрэхгүй;*
- Зориулалт/толин/ цэнэглэгчээр суурин цахилгаан эх үүсвэрт холбож бүрэн цэнэглэхэд дунджаар 1 цаг 30 минутын хугацаа зарцуулдаг бөгөөд цэнэглэх хугацаанд ялтан нь нэг цэгт хөдөлгөөнгүй удаан байрлах шаардлагатай, цахим бугуйвчийн зориулалт/толин/ цэнэглэгч нь хэтэрхий богинохон тул цэнэглэхэд хүндрэлтэй/ толин цэнэглэгч нь 40 см урттай/
- Зөөврийн цэнэглэгчээр “цахим бугуйвч”-ийг зөвхөн 1 удаа бүрэн цэнэглэх боломжтой, зөөврийн цэнэглэгчээр цахим бугуйвчийг бүрэн цэнэглэхэд ойролцоогоор 30-40 минут зарцуулах бөгөөд цэнэг барих хугацаа харьцангуй богино буюу 4-5 цаг.
- Түүнчлэн ял эдэлж буй 20 ялтнаас хүндрэлтэй асуудлын талаар судалгаа авахад 16 ялтан “Цахим бугуйвчийг цэнэглэхэд хүндрэлтэй, цэнэг нь хурдан дуусдаг” гэсэн яриа өгүүлэлтэй байна.

Зураг 3. Гарын цахим бугуйвчийн иж бүрдэл.



“Бүсийн хязгаарт 200 метр ойртсон” анхааруулга 8% хувийг эзэлж байгаа нь шүүхийн шийтгэх тогтоолын дагуу тухайн бүсийг зурж системд

оруулахад хяналтад орж буй ялтан өөрийн зорчих бүсийн хязгаарыг мэдээгүй байдлаас үүдэлтэй.

“Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан” анхааруулга 5% хувийг эзэлж байгаа нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан бүсийн хязгаарыг мэдэхгүй гарах, мөн зарим тохиолдолд цахим бугуйвчаас шалтгаалсан маршрут хэвийн зааж байхад 5-10 секундын хугацаанд байрлал тогтоогч нь үсэрч байрлалыг буруу зааж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Цахим бугуйвч нь “Дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, багасгахад тустай”.

Техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудал.

Зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн хяналтыг хэрэгжүүлэхэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” болон “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”, “Цахим хяналт, удирдлагын төвийн ажиллах журам”, “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын системд нэвтрэх ашиглах журам”-ыг тус тус үйл мөрдлөг болгон ажиллаж байгаа ч дараах хүндрэлтэй асуудлууд байна. Үүнд:

1. “Шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 171 дүгээр зүйлийн “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг сонгох хэсэг”-m “Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно” гэж заасан бөгөөд одоогийн байдлаар хяналтын тоног төхөөрөмжүүдийг “Цахим хяналт, удирдлагын төв” бүрэн хариуцаж байгаа бөгөөд тус хяналтын “тоног төхөөрөмжийг сонгох, ял эдлүүлэх ажиллагаанд ашиглуулах” талаар огт зохицуулаагүй;

2. Мөн хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т “Шийдвэр гүйцэтгэгч ялтанд биечилсэн хяналтыг өдөр, шөнийн аль ч цагт явуулж болно” гэсэн бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ялын техникийн тасралтгүй хяналтын хэрхэн тавих талаар хуулийн зохицуулалт огт байхгүй;

3. 172 дугаар зүйлд “Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирүүлсэн зөрчлийн дохиог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид

мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаархи мэдээллийг хүргүүлнэ” гэж заасан нь нэр томьёоны хувьд зөвхөн “Цахим хяналт, удирдлагын төвийн техник хяналтын ажилтаны чиг үүрэгт хамаарах бөгөөд тус төвийн ерөнхий зохицуулагч болон хяналтын операторын чиг үүрэгт хамаарахгүй байдлаар зохицуулсан байгаа нь тус ялын биелэлтийн нэг мөр хангахад харьяа салбар, нэгжийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нартай харилцан уялдаатай ажиллахад хүндрэл үүсгэхээс гадна цахим, хяналт удирлагын төвөөс мэргэжлийн удирлагын удирдлагаар хангах эрх зүйн зохицуулалт огт тусаагүй байна.

4. “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”-ын 3.2-т “Зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлсэн зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас өмнө 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулсан байна” гэж зохицуулсан ч практикт үүрэн холбооны операторын төлбөрийг сар тутам тухай шаардлагаас үүдэн дээрх зохицуулалт мөрдөгдөхгүй байна./Үүрэн холбооны операторын төлбөрийг сард нь багтаан төлөөгүйн ялмаас 12 ялтны дата дугаар хаагдаж, хяналтаас 2-3 хугацаанд алдсан тохиолдол гарч байсан.

ДҮГНЭЛТ

Дээрхээс дүгнэхэд Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй хяналтын тоног төхөөрөмжүүд шаардлага хангахгүй байна. Үүрэн холбооны /2G сүлжээ/-ний /GPS/ нь байршлаа буруу заадаг, “алдах, хүлцэх” зай ихтэй, ялтанд зүүлгэсэн цахим бугуйвч нь цэнэглэхэд хүдрэлтэй, цэнэгээ хангалтгүй барьдаг зэрэг нь ялтныг техникийн тасралтгүй хяналтаас алдах эрсдэлийг үүсгэхээр байна.

Түүнчлэн цахим бугуйвч нь “2G сүлжээ”-г ашиглан байршлаа тодорхойлон мэдээлэл солилцож, дамжуулдаг бөгөөд “сүлжээний доголдол, мэдээлэл дамжуулах хурд”-аас шалтгаалан ялтны байршлыг буруу мэдээлэлж, байршил тогтоогч нь ялтан “нэг байрлалдаа удаан байсан хамгийн сүүлчийн цэг /хаяг/-т зааж, гацдаг” гэж дүгнэж болохоор байна

Цахим хяналтаар илэрсэн алдаа, дутагдлаас харахад төв суурин газар, тэр дундаа “барилга, орон сууц”-д байгаа ялтны байршлыг тогтооход байршил тогтоогч тухайн цэгтээ гацах, дараагийн байршлыг заахгүй байх,

огт ажиллагаагүй болох эрсдэлтэйгээс гадна нэгдсэн системд хянагдах ялтны тоо нэмэгдсэн тохиолдолд ялтан тус бүрийн цахим бугуйвчийн “GPS огноо”-г нэг бүрчилэн хянаж, байршлаа зөв зааж байгаа эсэхийг тогтооход хүндрэлтэй байна.

Аливаа шинэ ажлыг хэрэгжүүлэхэд алдаа оноо гарах, сурч дадлагажих асуудал түгээмэл байдаг хэдий ч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны бодит нөхцөл байдалд “дүн шинжилгээ, судалгаа хийхгүй орхих”, “техникийн боломжид баригдаж “эрүүгийн хариуцлага, ялын зорилго, үр нөлөөг бууруулах” ялтанд завшуулах, ял гарцаагүй байх зарчим алдагдах нөхцөл байдлыг үүсгэхээр байна.

Шинэ төрлийн ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй “хүндрэл, бэрхшээл”-ийг шийдвэрлэхэд гадаадын улс орнуудын тусламж дэмжлэг авах, төсөл хөтөлбөрт хамтарч ажиллах нь одоогийн нөхцөлд оновчтой шийдвэр боловч цаашид өөрийн орны эрдэмтэн судлаач, зохион бүтээгчдийн “инновац”-ийн бүтээлийг ашиглаж ялын хэрэгжилтийг хангахад ашиглаж буй “тоног төхөөрөмж, техник хэрэгсэл”-ийг Монгол улс өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан дотооддоо үйлдвэрлэж, эдийн засгийн бодит хэмнэлт гаргах боломжтой гэж дүгнэж байна.

САНАЛ

Ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 172 дугаар зүйлд “Цахим хяналт, удирдлагын төв нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд тасралтгүй хяналт тавьж, ял эдлүүлэх ажиллагааг мэргэжлийн удирлагаар хангана” гэсэн заалт нэмэх;
2. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 172 дугаар зүйлийн 172.1-д заасан “Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирүүлсэн зөрчлийн дохиог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ” гэснийг;
3. Цахим хяналт, удирдлагын төвийн ерөнхий зохицуулагч, техник хяналтын ажилтан, хяналтын оператор нь мэдээллийн санд ирсэн “анхааруулга дохио”-г хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилтанд нэн даруй мэдэгдэж, зөрчлийг

арилгуулах, биечлэн хяналт тавих үүрэг, чиглэлийг өгч ажиллана” гэж өөрчлөх;

4. “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”-ын 3.2-т “Зорчих эрхийг хязгаалах ял шийтгүүлсэн ялтан зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас өмнө 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулсан байна” гэсэн хэсэгт;

5. “Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан үүрэн холбооны операторын төлбөрийг хяналтын тоног төхөөрөмж зүүхээс өмнө нийт ял эдлэх хугацаагаар тооцоолж төлнө” гэсэн заалт шинээр нэмэх;

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд тавих техникийн хяналтыг сайжруулах үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дотооддоо зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглаж буй “цахим бугуйвч, хяналтын төхөөрөмж”-ийг үйлдвэрлэх нөөц бололцоог судлах, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах.

2. Цахим хяналт, удирдлагын төвд ашиглагдаж байгаа “2 G сүлжээ”-г дэмжигч цахим бугуйвчийг 3 G сүлжээнд нэвтрүүлэх боломжийг судлах,

3. Шинээр цахим бугуйвчийн хангалт хийх тохиолдолд “3G сүлжээ”г дэмждэг цахим бугуйвчийн хангалт хийх;

4. “3 G сүлжээ”-г нэвтрүүлэх боломжгүй тохиолдолд “2 G сүлжээ”-ний хүчин чадлыг сайжруулах тоног төхөөрөмжийг талаар судалгааг хийж, ял эдлүүлэх ажиллагаанд нэврүүлэх

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Доктор(Phd) Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Уб., 2017.

2. Доктор(Phd) Д.Дамдинцэрэн. “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах эмхтгэл”.Уб., 2021.

3. Жамбалрагчаа, Б Урангоо, Б.Дэнсмаа нар “Монгол Улсын Эрүүгийн хуулин дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага,

өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага". Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд-Инфо сэтгүүл" Уб., 2021.

4. Ч.Болд, Э. Жамбалрагчаа. "Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд: Гадаад орны туршлага". Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Уб., 2018.

5. Ходжалиев. С.А. Теория и практика ограничения свободы как вида наказания. Грозный.,2019. С.75. РФ. /Ходжалиев. С.А. Зорчих эрхийг хязгаарлах ялын онол, практикийн асуудал. Грозний., 2019. 75 дахь тал. Оросын Холбооны Улс.

6. ОХУ-ын хууль тогтоомжийн эмхтгэл 2010. № 14. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_99050/(хандалт-10.01.2018 он)

7. Федеральное государственное унитарное предприятие "Центр информационно-технического обеспечения и связи Федеральной службы исполнения наказаний http://www.citosfsin.ru/company/index.php (хандалт-10.01.2018 он)

8. Kathy Padgett, William Bales and Thomas Blomberg (2006) "Under Surveillance: An Empirical Test of the Effectiveness and Consequences of Electronic Monitoring" Criminology and Public Policy, pages 61 - 91

---o0o---

“ЦАХИМ ОРЧИНД СОШИАЛ ХАЯГ ЭЗЭМШИХЭД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ”

"PROBLEMS OF ENSURING SECURITY IN THE POSSESSION OF SOCIAL ACCOUNTS IN THE ELECTRONIC ENVIRONMENT"



Б.Уянга

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч утга: Монгол улсын Үндсэн хуульд иргэний 18 эрхийг тунхаглан заасан байдаг. Үүнээс Монгол улсын иргэн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх өв залгамжлуулах эрхийн хүрээнд интернэт хөгжсөн орчин цагт кибер орчин дахь өөрийн сошиал хаяг, фэйсбүүк хуудас болох цахим хөрөнгийг хадгалж эзэмших, цаашлаад хөрөнгийн кибер аюулгүй байдлыг хангах асуудлын талаар өгүүлэх болно.

Abstract: The Constitution of Mongolia declares 18 civil rights. From this, Mongolian citizens can fairly acquire movable and immovable property, to possess, own social media account in the cyber environment in the age of Internet development within the scope of inheritance rights, keep and own electronic assets such as Facebook pages, It will also talk about the issue of cyber security

of assets. Түлхүүр үг: Өмчлөх эрх[1], хөрөнгө[2], Кибер аюулгүй байдал[3], кибер орчин[4], кибер орон зай[5], виртуал хөрөнгө[6].

Keywords: ownership rights, assets, cyber security, cyber environment, cyberspace, virtual assets.

Монголчууд бид сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд Монгол улсад интернэт орчин асар хурдтайгаар хөгжиж анх 1G сүлжээнээс өнөөдрийг хүртэл хугацаанд өндөр хурдны 5G хүртэлх сүлжээг нэвтрүүлэн дэлхийн хэмжээнд мэдээллийн эрэн зуунтай хөл нийлүүлэн алхаж байгаа билээ.

Орчин цагт ютюб, фэйсбүүк, инстэграм, твиттер, вэчат, майл хаяг гэх мэт олон нийтийн сүлжээг өндөр хурдны компьютер, андройд болон айпон үйлдлийн систем дэмждэг гар утсыг түгээмэл ашиглан интернэт орчинд хүн бүр ашиглаж, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус шинжтэй мэдээлэл солилцох болсон.

---

[1] Монгол улсын Үндсэн хууль.,УБ.,1992 он, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт "...Монгол улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө..." гэж заасан байдаг. https://legalinfo.mn/mn/detail/367;

[2] Монгол улсын Иргэний хууль.,УБ.,2002 он, 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт "...Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно..." гэж заажээ.
https://legalinfo.mn/mn/detail/299;

[3] Монгол улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль.,УБ.,2021 он, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт "кибер орчин" гэж мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчныг..." хэлнэ гэж заажээ. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061;

[4]Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "кибер аюулгүй байдал" гэж кибер орчинд мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал хангагдсан байхыг…" хэлнэ.

[5] Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт "кибер орон зай" гэж интернэт болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн харилцан хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбар..." гэж заажээ;

[6] Монгол улсын Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай хууль.,УБ.,2021 он, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "виртуал хөрөнгө" гэж аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг..." хэлнэ гэж заасан.
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390242606091;

Технологи хөгжих тусмаа цахим орчны хэрэглээг дагасан иргэдийг залилсан гэмт хэргийн гаралт буурахгүй байна. Тухайлбал,

Манай улсад энэ 2024 оны 2 дугаар сарын байдлаар цахим орчинд үйлдсэн 7560 гэмт хэрэг бүртгэгдсэний 83 хувь нь кибер залилан байна.

Интернет хэрэглэгчийн тоо нэмэгдэхийн хэрээр гэмт хэргийн тоо ч өссөөр. Манай улс кибер аюулгүй байдлын тухай хуулийг 2021 онд батлаад байгаа билээ. Арилжааны банкны мэдээлэл алдагдсан, мөн хувь хүний мэдээллийг аялал жуулчлалын цахим хуудсаар дамжуулан авч, хар зах дээр арилжиж байсанд хариу арга хэмжээ авсныг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал мэдээлсэн байдаг.

Долоо хоногт 40-50 мянга, өдөрт 4-5 мянган цахим халдлага Монгол руу чиглэдэг. Дуудлагын төвд гэхэд 910 дуудлага ирж, иргэд 2.9 тэрбум төгрөгийн залиланд өртсөнөөс 1.7 тэрбум төгрөгийг нь зарцааснаас гадна малчид янз бүрийн аппликейшн ашиглан залилуулах нь ихэсжээ[1] гэсэн судалгаа байна.

Мөн тухайн мэйл хаяг, сошиал хуудсыг эзэмшигч иргэний хувьд өөрийн хувийн мэдээллийг интернэт орчинд хамгаалах асуудал, цаашлаад кибер орчноор дамжуулан өөрийн сошиал хаяг, фэйж хуудас болох цахим хөрөнгийг хадгалж эзэмших ойлголт хуулийн хүрээнд бүрдсэн эсэх, хөрөнгийн кибер аюулгүй байдлыг хангаж хамгаалах чухал байна.

Монгол Улсын Засгийн газар харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр зарлаж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрыг татан буулгаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам дараах бүтэцтэй. Үүнд:

1. Бодлого төлөвлөлтийн газар
2. Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
3. Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

[1] https://montsame.mn/mn/read/339416 oyundelger@montsame.gov.mn 2024-03-12;

4. Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

5. Төрийн захиргааны удирдлагын газар

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар гэсэн зургаан газар, 8 хэлтэстэй, нийт 87 орон тоотой байна[1].

Цахим орчин дахь залилан 2021 оноос эхлэн Монгол гэлтгүй дэлхий нийтэд нэлээдгүй үйлдэгдэж байна. Монгол Улсад үйлдэгдэж байгаа цахим залиланг дотоодод болон хилийн гаднаас үйлдэж байна.

Иргэд хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бараа, бүтээгдэхүүн зэргийг худалдан авахдаа заавал очиж үздэг байсан бол цахим орчин бий болсноор энэ бүгдийг гар утаснаасаа богино хугацаанд хайх, үзэх, захиалах боломжтой болсон төдийгүй төлбөрийг интернэт ашиглан хялбар шилжүүлж байна. Энэ нь иргэдийн цаг хугацааг хэмнэж байгаа сайн талтай ч гэмт хэрэг үйлдэж буй этгээдэд ашигтай байдал үүсгэдэг[2].

Монгол улсын хувьд Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаад удаагүй. Кибер аюулгүй байдлыг хамгаалах хуулийг батлаад 3 жил болж байгаа. Кибер Аюулгүй Байдлын Зөвлөлтэй хөгжиж буй улсын хувьд Монгол улсын иргэн бүрт хүрч ажиллах хүндрэлтэй билээ.

Зураг №1[3].



[1] https://mddc.gov.mn/mn/байгууллагын- түүх-2/
[2] https://police.gov.mn/a/6354
[3] https://www.parliament.mn/nn/16476/;

Засгийн газар үндэсний хэмжээний кибер халдлагын үед ажиллах төлөвлөгөө, стратеги, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт зэргийг баталсан.

Зураг №2.



Нэгэн сонирхолтой судалгааг дурдахад:

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороотой хамтран “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгаа- 2022”-г 2022 оны 2 дугаар сард олон нийтэд танилцуулсан[1] байдаг. Үүнд:

Энэхүү судалгаа нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөмжийн дагуу хийгдсэн Үндэсний хэмжээний анхны түүвэр судалгаа бөгөөд Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг бодитой тооцоход Монгол Улсын тоо баримтыг тусгах, цаашид салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, стратегийн ач холбогдол бүхий төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах суурь судалгаа, статистик мэдээ мэдээллээр хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн өнөөгийн байдлыг үнэлэх ач холбогдолтой.

Цахим хэрэглээний талаарх судалгаа:

Монгол улсын 335 сум, суурин газарт өндөр хурдны интернэт сүлжээ орсноор нийт өрхийн 80 хувь нь интернэт хэрэглэдэг.

[1] chrome-extension://hbgjioklmpbdmemlmbkfckopochbgjpl/https://mddc.gov.mn/wp-content/uploads/2022/08/1645003351062-nso-%D0%9C%D0%A5%D0%A5%D0%A2%D0%A5-Main.pdf

Мөн үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж, 2021 оны байдлаар нийт иргэдийн 97.6% нь гар утас хэрэглэж, үүнээс ухаалаг гар утасны хэрэглээ 84.7%-д хүрсэн.

Монгол улсын **15 ба түүнээс дээш насны** нийт хүн амын 98% нь үүрэн утас, үүнээс 90.4% нь ухаалаг гар утсыг сүүлийн 3 сарын турш хэрэглэсэн байдаг.

Үүрэн ба ухаалаг гар утас хэрэглэдэг иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 79.5% нь үүрэн утас, үүнээс 54.8% нь ухаалаг гар утас хэрэглэдэг[1].

Түүнчлэн Монгол улсын нийт өрхийн 97.9% нь гар утастай, 97.3% нь телевизтэй, 80% нь интернэттэй, 8.1% нь радиотой, 9% нь суурин утастай, 33.3% компьютертой гэсэн судалгаа гарсан байдаг.

Монгол Улсын нэг өрх МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зарцуулсан зардлын дундаж хэмжээ сүүлийн гурван сарын хугацаанд 246.1 мянган төгрөг байсан. Үүний 29% нь тоног төхөөрөмж, 69.9% хувь нь үйлчилгээ, 0.5% программ хангамж, 0.5% контент, 0.1% нь видео тоглоомонд зарцуулсан байдаг.

ХХМТГ-аас гаргасан судалгаагаар

2019 оны байдлаар Монгол Улсад үүрэн холбооны хэрэглэгч давхардсан тоогоор гурван сая 800 мянга байгаагаас ухаалаг утас хэрэглэгч хоёр сая 439 мянга байна. Харин интернэт хэрэглэгч хоёр сая 910 мянга байгаа юм. Сонирхуулахад, Монгол Улсад 2019 оны байдлаар, фэйсбүүк хэрэглэгчдийн тоо 2.2 сая байгаагаас гар утсаараа холбогддог 2.1 сая хэрэглэгч байна. Энэ нь Монгол Улсын 3.3 сая хүн амтай харьцуулахад маш өндөр тоо гэдгийг харуулна. Дахин сонирхуулахад, олон улсын хэмжээнд фэйсбүүк ашиглах дундаж хугацаа 53 минут байхад Монгол Улсад 77 минут байна[2].

Цахим гэмт хэргийн тухай сонирхуулахад:

---

[1] Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороо.,“Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааны танилцуулга-2022.,УБ.,2022 он., 58 дахь тал;

[2] https://montsame.mn/mn/read/246236 munkhbaatar@montsame.gov.mn 2020-12-14 s_munkhbaatar

АНУ-ын хууль сахиулах байгууллагын тайланд бүхий л төрлийн цахим гэмт хэрэг үйлдэгчид жилд 1.5 их наяд ам.долларын хохирол бусдад учруулдаг. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн нийт орлого хамгийн багадаа 1.5 их наяд ам.доллартай тэнцэж байгаа нь ДНБ-ий хэмжээ нь 1.6 их наяд ам.доллар бүхий БНАСАУ-ын нэг жилийн орлоготой дүйцэхүйц байна хэмээн дурджээ. Улмаар цахим гэмт хэргийн хохирол жил бүр 11 орчим хувиар нэмэгдэж, ирэх 5 жилийн хугацаанд 3-5 их наяд ам.долларт хүрч болзошгүй хэмээн салбарын мэргэжилтнүүд тооцоолсон байна[1].

Үүнээс гадна “Facebook”, “Twitter” зэрэг нийгмийн сүлжээг ашиглан цахим гэмт хэрэг үйлдэгчид жилд 3.25 тэрбум ам.долларын хохирол бусдад учруулдаг бөгөөд хохирогчдын тоо жил бүр нэмэгдсээр байна. Энэ төрлийн гэмт хэргийн дотроос нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн нэвтрэх нэр, нууц үг, дансны болон зээлийн картны мэдээлэл зэрэг хувийн мэдээллийг хулгайлах, бусдад зарж борлуулах явдал хамгийн түгээмэл буюу нийт гэмт хэргийн 45-50 хувийг эзэлдэг аж.

Цахим гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэрүүдэд “фишинг” буюу интернэтээр залилан үйлдэх, “сошиал инженерчлэл” буюу хувь хүний сэтгэл зүйн онцлогийг харгалзан сэдэл */мөнгө хожих, тэтгэлэг авах зэрэг/* өгч, итгэл төрүүлэх замаар мэдээлэл цуглуулах, нууцад нэвтрэх болон компьютерийн сүлжээнд төрөл бүрийн вирус, хортой код тараах зэрэг аргууд багтдаг. Үүнээс гадна цахим шуудан ашигладаг нийт хэрэглэгчдийн хувьд спам халдлага хамгийн эрсдэлтэйд тооцогддог байна.

АНУ-ын “Accenture securtiy” байгууллагын 2019 оны “Кибер гэмт хэргээс учирсан хохирол”-ын талаарх тайланд дурдсанаар “фишинг” болон “сошиал инженеринг” хэлбэрийн халдлагад өртсөн байгууллагын тоо 2018 онтой харьцуулахад 16 хувиар өсч, нийт цахим халдлагад өртсөн байгууллагын 85 хувийг эзэлж байна. Харин хортой код ашиглаж үйлдсэн халдлагын улмаас 2018 онд 2.6 сая ам.долларын хохирол учирсан нь өмнөх оноос 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цахим валют/криптовалют буюу бидний хэлж заншсанаар “Биткоин” хэрэглээнд нэвтэрсэн нь иргэдийн төлбөр тооцоог хөнгөвчилсөн ч нөгөө талаар цахим болон бусад гэмт хэргийн гаралтад нөлөөлөх хүчин зүйл болж байна. Гэмт этгээдүүд интернэт орчин дахь цахим мөнгө-санхүүгийн

[1] https://gia.gov.mn/49/item/643

залилан төдийгүй хүний болон эд эрхтний наймаа, хар тамхи, галт зэвсгийн худалдаа, насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах зэрэг хууль бус үйлдэлдээ биткоин ашиглахыг илүүд үзэж байна. Австралийн их сургуулийн судалгаагаар, биткоин нь цахим гэмт хэрэгтнүүдийн төлбөрийн хамгийн таатай хэрэгсэл бөгөөд жилд 76 орчим тэрбум ам.долларын биткоин гүйлгээ хийгдэж байгаа нь АНУ, Европын Холбооны орнууд дахь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус худалдаанаас олох ашиг орлоготой тэнцэж байна хэмээн дүгнэжээ. АНУ-ын цахим аюулгүй байдлыг хангах байгууллага 2021 он гэхэд криптовалют ашиглан үйлдэгдэх цахим гэмт хэргийн тоо мэдэгдэхүйц хэмжээгээр өсөх бөгөөд нийт криптовалютын гүйлгээний 70 орчим хувь нь гэмт хэрэгтэй холбоотой байна хэмээн тооцоолжээ.

Иймээс улс орнууд цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд АНУ-ын хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шинжээчид цахим аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд 17.4 тэрбум ам.доллар шаардлагатай хэмээн үзсэн байна. Мөн олон улсын цахим аюулгүй байдлын зах зээлийн судалгаагаар, 2017-2021 онд цахим аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулагдах нийт хөрөнгө 1 их наяд ам.долларааас давах бөгөөд цахим аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтын зардал л гэхэд 2027 онд 10 тэрбум ам.долларт хүрнэ гэж тооцжээ.

Манай улсын хувьд цаг тутамд өсөн нэмэгдэж буй компьютер, ухаалаг утасны хэрэглээг дагаад цахим гэмт хэргийн тоо жил бүр нэмэгдэж, 2016 онд 97, 2017 онд 195, 2018 онд 659, 2019 оны 5 сарын байдлаар 384 буюу нийт 1,335 цахим гэмт хэрэг бүртгэгджээ. Эдгээрээс дийлэнх нь эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүүхдүүд байдаг бөгөөд энэ нь цахим гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийн талаар мэдлэг дутмаг, бага насны хүүхдэд тавих хараа хяналт сул зэргээс үүдэлтэй юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэгт “Цахим мэдээлэлд хууль бусаар халдсан, цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэсэн, борлуулсан, хор хөнөөлт программ хангамж бүтээсэн, ашигласан, тараасан тохиолдолд 2,700-40,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ.” хэмээн цахим гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан байдаг.

Кибер орчин дахь тулгамдсан асуудлыг тодотговол:

Монгол улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд зааснаар Монгол улсын иргэн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, өмчлөх эрхтэй. Тухайлбал,

Монгол улсын Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "...Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно..." гэж заасан[1].

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт "...Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно..." гэж заажээ.

Эрх зүйн харилцаанд бие даан оролцох, өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах буюу хөрөнгийн шинжтэй харилцаанд оролцохын тулд тухайн хүн хуульд заасан насанд хүрсэн байх ёстой. Гэтэл өнөө цагт 16 насанд хүрээгүй өсвөр насны хүүхдүүд мэйл хаяг нээдэг, мөн Facebook, Twitter, Telegram, Instagram, wechat гэх мэт сошиал хуудас дээр хаяг нээдэг, групп үүсгэж, хүмүүсийг дагагчаар бүртгэдэг, блог хөтөлдөг, youtube суваг хөтөлдөг зэрэг үйлдлүүд нь эд хөрөнгийн шинжтэй, мөнгө олох сэдэлтэй байдаг.

Монгол улсын Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт "...Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна..." гэж,

Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт "...Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, харгалзан дэмжигч/-ийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ..." гэж заасан байдаг.

Илтгэлийн хүрээнд сошиал орчинд идэвхтэй байгаа хүмүүсийг шүүмжлэх гэсэн санаа агуулаагүй болно. Гагцхүү насанд хүрээгүй хүүхдүүд тухайн сошиал хаяг, хуудсаараа дамжуулан юу хийж байгаа нь тодорхойгүй, хянаж байгаа эцэг эхчүүт хүүхдүүдээ юу хийгээд явж байгааг нь мэдэхгүй, хараа хяналтгүй байгаагаас үүдэн кибер гэмт хэргийн хохирогч болох магадлал үргэлж байдаг.

[1] Монгол улсын Иргэний хууль.,УБ.,2002 он., https://legalinfo.mn/mn/detail/299;

Сошиал хаягаа зарах, бусдад шилжүүлэн өгөх зэрэг үйлдлүүд нь хэлцэл байгуулж байгаагийн нэгэн илрэл юм.

Фэйсбүүк болон инстэграмм хаягаар дамжуулан олон дагагчтай болж тодорхой хэмжээний орлого олох, дагагч нараа өсгөн нэмэгдүүлэх зэрэг нь бүгдээрээ эд хөрөнгийн шинжийг агуулж байгаа юм.

Монгол улсын Иргэний хуулийн 10 дугаар бүлэгт эдийн болон эдийн бус баялгийн эрхийн талаар тусгасан. Мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсэгт "...Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь эдийн бус хөрөнгөд хамаарна..." гэж заасан байдаг.

Би Фэйсбүүк, Инстэграмм зэрэг сошиал хаягаар жишээ авч байгаа боловч олон нийтийн сүлжээний компаниуд маш олон байдаг. Тухайн сошиал хаягууд нь тус тус компанийн өмч боловч Монгол улсын иргэний бүртгүүлсэн сошиал хаяг дээрх бүртгэл, түүгээр дамжсан сошиал хуудсыг эзэмших эрх, бусдад хаягаа шилжүүлэх эрх зөвхөн сошиал хуудас эзэмшигч иргэнд үүснэ. Үүнийг бид оюуны оюуны үнэт зүйл гэж харж болно.

Мөн нэг жишээ дурдахад Осоржамаа гэх иргэн өөрийн фэйсбүүк хуудсыг бусдад 20 сая төгрөгөөр зарсан юм.

Монгол улсын Үүрэн холбооны оператор компаниуд болох Мобиком корпорац ХХК, Юнител ХХК зэрэг дээр иргэд дугаар худалдан аваад бусдад үнэ нэмж зардаг жишиг тогтоод удаж байгааг хэн хүнгүй мэддэг. Тухайлбал,

Мобикомын 9911XXXX, Юнителийн 8811XXXX гэх дугаарууд өндөр үнээр зарагддаг. Тухайн дугаарын өмчлөгч бол компани боловч эзэмшигч нь иргэн байдаг. Хүмүүс дугаараа өөрийн хүссэн үнээр зарахаас гадна банк, банк бус санхүүгийн байгууллага зэргээр дамжуулан дугаар барьцаалсан зээл ч авах боломж бүрдсэн.

Дээрх жишээтэй нэгэн адил фэйсбүүк, инстэграмм хуудсаа барьцаалан зээл авах ч боломж байгаа гэсэн үг юм.

Цаашид интернэт хэрэглээ эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа өнөө цагт насанд хүрээгүй хүүхдүүдийн нээсэн фэйсбүүк, инстэграмм гэх мэт цахим хуудаст эцэг эхийн зүгээс хяналт тавих, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны оролцоотойгоор цахим нэрийн хуудсанд хяналт тавих, кибер гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байх нь үр дүнтэй байх болно.

Кибер халдлагууд ихээр гарч байгаатай холбогдуулан дараах зөвлөмжийн дагуу хувь хүн иргэн бүр анхаарч байвал гэмт халдлагаас хамгаалагдах боломж байна. Үүнд:

1. Facebook. Intagram. Twitter гэх мэт олон төрлийн сошиал хуудсаар дамжуулан залилуулахаас болгоомжлох, нэвтрэх нэр, нууц үгээ бусдад задруулахгүй байх, эцэг, эхчүүдийн зүгээс хяналт тавих

2. Цахим шуудан (E-Mail)-д хавсаргасан (doc, docx, pdf, zip, rar гэх мэт) өргөтгөлтэй файлуудыг илгээгчээс асууж баталгаажуулах;

3. Цахим шуудангаар ирсэн сэжигтэй холбоос (link) дээр дарахгүй байх;

4. Сүлжээнд холбогдсон компьютеруудад мэдээлэл тээгч (media storage, flash disk, зөөврийн хард диск)-ийг холбохдоо вирусийн эсрэг программ хангамжаар шалгах;

5. Сэжигтэй вэб хуудас (Not Secured Website) руу хандахаас зайлсхийх;

6. VPN программ хангамж болон вэб хөтөч Extension суулгахгүй, ашиглахгүй байх;

7. Олон нийтийн сүлжээнд тавигдсан мэдээ мэдээлэл (link) дээр дарахгүй байх;

8. Нэвтрэх нууц үгийг 6 сард 1-2 удаа сольж байх, нууц үгийг солихдоо том жижиг үсэг, тоо, тэмдэгт ашиглаж байх;

9. Гар утсанд үл мэдэгдэх гадаад дугаараас (unknown) мессеж болон дуудлага ирсэн тохиолдолд дуудлага ирэхэд авахгүй байх, мессеж линк дээр дарахгүй байхад анхаарах.

ДҮГНЭЛТ

Фэйсбүүк, инстэграм, твиттер гэх мэт сошиал хуудас ашиглан нээсэн хаяг, түүгээр дамжуулан үүсгэсэн хуудас бол эдийн бус баялаг, оюуны үнэт зүйл гэж үзэж болохоор хөрөнгө тул түүнийг насанд хүрээгүй хүүхдүүд эзэмшихэд эцэг эхчүүд хяналт тавьж анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Мөн олон дагагчтай ашиг орлого олж болохуйц сошиал нэрийн хуудас /пэйж/-ыг эх асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгөөр тодорхой төрлийн банк бус санхүүгийн байгууллагад барьцаалан зээл авах хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх боломжийг холбогдох газрын зөвшөөрөлтэйгөөр эрсдэлгүйгээр хийх боломжтой.

Цаашид тухайн цахим хуудас эзэмшигчийн хувьд өөрийн үүсгэсэн цахим нэрийн хуудас болох оюуны бүтээл болсон хөрөнгөө алдахгүйн тулд аливаа кибер гэмт хэргийн хохирогч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг задруулахгүй байхад анхаарах хэрэгтэй юм.

Кибер орчинд урьхидах арга барилаар гэмт хэрэгтнүүд цахим залилангийн гэмт хэргийг ихээр үйлдэж байгаа тул дор бүрнээ анхаарал болгоомжтой байх нь чухал юм.

САНАЛ:

1. Фэйсбүүк, инстэграм, твиттер гэх мэт сошиал хуудас ашиглан нээсэн хаяг, түүгээр дамжуулан үүсгэсэн хуудасны эзэмшигч насанд хүрээгүй хүүхдүүд бол эцэг эх асран хамгаалагчид хяналт тавих

2. Мөн олон дагагчтай ашиг орлого олж болохуйц сошиал нэрийн хуудас /пэйж/-ыг эх асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгөөр тодорхой төрлийн банк бус санхүүгийн байгууллагад барьцаалан зээл авах хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх боломжийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамаар дамжуулан бий болгох-хуудаснуудад бүртгэл хөтлөх

3. Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, танин мэдүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах

---o0o---

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ БИЕЛҮҮЛЭХИЙГ ХОЙШЛУУЛАХ АСУУДАЛ

SENTENCE OF THE COURT SENTENCING THE JUVENILE TO PRISON THE PROBLEM OF DELAY IN EXECUTION



С.Бямба-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн багш, ахлах дэслэгч

Товч утга: Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалт, өсвөр насны хүний эрх зүйн байдлыг Эрүүгийн хуульд ялтан гэж томьёолж, ял эдэлж байгаа гэсэн эрх зүйн үр дагаврыг бий болгосон. Өсвөр насны ялтанг ерөнхийд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад даатган орхиж байгааг өөрчлөх, Хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын оролцоог эрх зүйн орчинд хэрхэн тусгах талаар санал, дүгнэлтийг илэрхийлсэн болно.

Түлхүүр үгс: Өсвөр насны хүн, гэмт хэрэг, хорих ял, шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулах

Abstract: Legal arrangements for delaying the execution of a court sentence imposed on a juvenile**,** The legal status of a teenager is formulated as a convict in the Criminal Code**,** created the legal consequences of being convicted. Change the general release of juvenile offenders to the supervision of the Court's enforcement agencies, Opinions and conclusions are expressed on how to reflect the participation of government organizations responsible for children's issues in the legal environment.

Key words: A teenager, Crimes, Imprisonment, Deferral of Court Orders

Монгол Улсад 2024 оны 1 дүгээр улирлын /2024 оны 1-3 сар/ байдлаар 9980 гэмт хэрэг бүртгэгдсэнээс[1] гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 31 бүртгэгдсэн[2] байдаг.

Мөн 2024 оны 1 дүгээр улиралд гэмт хэргийн улмаас 613 хүүхэд хохирогчоор[3], 311 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн[4], 38 хүүхдэд бодит хохирол учирсан[5] талаарх мэдээллийг Монгол улсын Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээнд дурьджээ**[6].**

Мөн "Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.1 дахь заалтад: "Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрагдах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй" гэж заагаад "хүүхдийн хамгаалуулах эрхийг [7] тодотгон өгсөн боловч хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүнийг хамгаалах, хүмүүжүүлэхэд Гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын оролцоог хуулинд тусгайлан зааж өгөөгүйгээс хүүхдийн эрх зөрчигдөж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь хэн нэг этгээд өөрийн хүч, эрх мэдэл, бие махбодийн болон бусад давуу байдлаа ашиглан хүүхдийн халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөг зөрчиж, гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, түүнийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдэхүйг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэнэ"[8] гэж тодорхойлсноор бол эцэг эх салах[9], хараа хяналт муу тавих, бие махбодь, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсролын хувьд үл хайхрах байдал

---

[1] https://police.gov.mn/resource/information/File/2024/04/08/4nwqojga7nd87oy3/%D0%93%D1%8D%D0%BC%D1%82%20%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3.pdf Хүснэгт

https://police.gov.mn/resource/information/File/2024/04/08/51ir6cdnxpo59jiv/2024.03%20sar%20medee%20-hohirogch.pdf Хүснэгт 1;

[4] https://police.gov.mn/resource/information/File/2024/04/08/n18ntuh140wodd64/2024.03%20sar%20medee%20-Yllagdagch.pdf Хүснэгт 5;

https://police.gov.mn/resource/information/File/2024/04/08/y65sf6tew1ccvslt/2024.03%20sar%20medee%20-Khohirol.pdf Хүснэгт 9-7;

[6] https://police.gov.mn/a/7116;

[7]Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль.,УБ.,2016 он.,Төрийн мэдээлэл эмхэтгэл

[8] Ю.Бадамханд.Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл.,УБ.,2016 он;

[9] https://www.uchral.com/archives/43143 "...2023 оны эхний 5 сард 1743 хос гэрлэлтээ цуцлуулсан...";

гарган анхаарал бага тавьснаас өсвөр насны хүүхдүүд гэмт хэрэг үйлдэж ял шийтгэл авах нь түгээмэл байна.

Гэвч хүүхдүүдийн өссөн гэр бүлийн орчин, амьдарч байгаа газар, найз нөхөд, эцэг, эх нь салсан, үл хайхрах байдал түгээмэл байгааг анхаарах ёстой.

Нийслэлийн хэмжээнд 2023 оны 12 сарын байдлаар хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нийт 74 ялтан, үүнээс 38 хүүхэд, 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 56 ялтан, үүнээс 32 өсвөр насны ялтан хяналтад байна[1].

Үүнээс хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дууссан 2023 онд 18 хүүхэд, 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 10 хүүхдийн хяналтын хугацаа дууссан байна[2].

Мөн 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа өсвөр насны нийт 32 хоригдол байгаагаас 15 эрэгтэй, 1 эмэгтэй өсвөр насны хоригдол анх удаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс оногдуулсан хорих ялыг зан нөлөөлөх сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэхгүй хойшлуулсан хугацаанд[3] дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялыг биечлэн эдэлж байна.

Энэхүү өгүүллийн хүрээнд шүүхээс анх удаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хойшлуулах болон өсвөр хүнд оногдуулсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний Эрүүгийн хуульд заасан зарим төстэй боловч хүүхдийн эрхийг зөрчиж ялгаварласан шинжтэй хуулийн заалт байгааг харьцуулан гаргах, хуульчлах шаардлагатай талыг илэрхийлэх, хорих ял хойшлогдсон хяналтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүмүүжил, төлөвшилд нь эерэгээр нөлөөлөхөд гэр бүлийн орчин, тэднийг шагналын хоногоор урамшуулах, олон улсын жишиг дүрэм, журам, зөвлөмжийг ашиглах нь чухлыг тодорхойлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага,

[1] http://www.niislel.cd.gov.mn/page/1466.shtml?sel=1715 НШШГГ-ын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн мэдээ, тайлан 2023 он;
[2] http://www.niislel.cd.gov.mn/page/1466.shtml?sel=1715 НШШГГ-ын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн мэдээ, тайлан 2023 он;
[3] Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нийгмийн ажил, сэтгэл зүйн албанаас авсан 2023 оны судалгаа;

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо[1], Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийн газар[2]-ын уялдаа холбоог тодорхойлж энэ талаар баримталж буй

[1] Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль.,УБ.,2016 он., 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт зааснаар "...Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг..." хэлнэ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ыг баталсан.

Хууль зүйн хороо, түүний Ажлын алба нь Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэ журамд заасан үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзаж хүүхдийн нас биед тохирсон, хүсэл сонирхолд нийцсэн зөвлөгөө, туслалцаа, дэмжлэг үзүүлж, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг нь ухамсарлуулах, бусдад учруулсан хохирол, гэм хорыг арилгахад хүүхдийг оролцуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөлийг арилгах, сөрөг нөлөөнөөс тусгаарлах зэрэг арга хэмжээг хууль тогтоомжид заасан хүрээнд нийцүүлэн авна.

Хууль зүйн хороо нь аймаг, дүүргэгт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд энэ журамд заасны дагуу туслалцаа үзүүлэн, зөвлөгөө өгч, эрх ашгийг нь хамгаална.

Хууль зүйн хорооны дарга нь тухайн аймаг, дүүргийн Засаг даргын орлогч байна.

Хууль зүйн хорооны гишүүнээр дараах албан хаагч, иргэн ажилладаг. Үүнд:

1. Аймаг, дүүрэг дэх шүүхийн Тамгын газрын дарга;
2. Аймаг, дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор;
3. Аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга;
4. Аймаг, дүүргийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга;
5. Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
6. Аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга;
7. Аймаг, дүүргийн боловсролын асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
8. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
9. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
10. Аймаг, дүүргийн Цагдаагийн газар /хэлтэс/-ын дарга;
11. Аймаг, дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /хэлтэс/-ын дарга;
12. Хүний эрхийн Үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан;
13. Өмгөөлөгчдийн холбооны аймаг, дүүргийн салбар зөвлөлийн дарга /зөвшилцсөнөөр/;
14. Аймаг, дүүрэгт гэр бүл, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/;
15. Аймаг, дүүргийн хүүхдийн элч /зөвшилцсөнөөр/.

[2] Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 20.6 дахь хэсэгт "...Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана..." гэж заасан.

бодлого, түүний хэрэгжилт болон олон улсын зарим туршлагыг судлан тодорхой санал дэвшүүлэхийг эрмэлзлээ.

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна[1].

Олон улсын жишигт нийцсэн 2015 онд батлагдсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн агуулга нь 2002 оны Эрүүгийн хуулиас ялгаатай нь гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн хүүхдэд оногдуулсан ялыг аль болох биечлэн эдлүүлэхгүй байхад чиглэсэн онцлог хууль болсон билээ.

Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн хүнд 5 төрлийн ял оногдуулах, мөн хуулийн 6 дугаар бүлэгт зааснаар 3 төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулж болохоор хуульчилж өгсөн. Үүнээс өсвөр насны хүнийг үйлдсэн гэмт хэргийн байдлаас хамааран нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих гэсэн үндсэн 3 төрлийн ялыг оногдуулах зохицуулалттай. Ял нь ял шийтгүүлснээс үүсэх ялтай байдал гэсэн эрх зүйн үр дагаврыг бий болгох ба Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан хугацаанд хадгалагдана.

Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 7.6.1-т "...Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг[2] үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина..." гэж заасан.

---

[1]Монгол Улсын Эрүүгийн хууль.,УБ.,2015 он., 8.1 дүгээр зүйлийн 2 дахь заалт;

[2] Монгол Улсын Эрүүгийн хууль.,УБ.,2017 он., 2.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ" гэж заасан.

Мөн хуулийн 8 дугаар бүлгийн 8.6.1-т “...Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно...” гэжээ.

Мөн хуулийн 8 дугаар бүлгийн 8.7.1-т “...Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно…”

Дээрх заалтуудыг харьцуулвал шүүхээс үйлдсэн гэмт хэргийн хувьд энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан өсвөр насны этгээд эсхүл анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтанд нэгэн адил хамаарахаар хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн 8.7.2-т “...Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээлгэнэ…” гэж зааснаараа хорих ял хойшлогдсон, тэнссэн өсвөр насны хүнд хүлээлгэх хариуцлага төстэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “...Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш эрхтэй... гэж заасан заалтыг зарим талаараа зөрчсөн.

Учир нь Эрүүгийн хуулийн 8.7.3-т “...Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ...” гэж тусгайлан зааж өгсөн, хорих ял авч ял хойшлогдсон өсвөр насны ялтныг хүүхдийн асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллага хариуцах талаар хуулинд тусгайлан заагаагүй нь үл хайхарч, хуулийн өмнө эрх тэгш байх хүүхдийн эрхийг зөрчсөн.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны хүүхдүүдийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар мэргэжлийн нийгэм сэтгэл албаараа дамжуулан агентлаг хоорондын тусгайлан гаргасан журмын[1] дагуу сургалтад хамруулж, сар бүр сургалтын үр дүнгийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тайлагнаж, үр дүнтэй ажил явагддаг.

Судлаачийн зүгээс хорих ял хойшлогдсон өсвөр насны ялтнуудад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хяналтаа тавьж, Төрийн бус байгууллагыг түшиглэн сургалтанд хамруулдаг. Гэвч хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын оролцоог Эрүүгийн хуулинд тусгайлан заагаагүйгээс энэ асуудалд Хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын оролцоо байхгүй, үгүйлэгдэж байна.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 төрлийн үүрэг хүлээлгэж, 4 төрлийн хязгаарлалт тогтоох талаар хуульд заасан байдаг.

Тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны этгээд болон хорих ял хойшлогдсон өсвөр насны ялтан нэгэн адил шүүхээс Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 7.3.2-т заасан 4 төрлийн үүргээс сонгон хүлээлгэж болохоор заасан хэрнээ өсвөр насны ялтанд нэмж Эрүүгийн хуулийн 7.3.3-т заасан 4 төрлийн хязгаарлалт оногдуулахаар хуульчилж өгсөн байдаг.

Шүүх өсвөр насны ялтанд зарим үед үүрэг хүлээлгэхгүйгээр[2], ихэнх нь үед мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж

---

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга нарын хамтарсан 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/170, А/0138 тоот тушаал “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх журам;

[2]2022 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн Баянзүрх дүүргийн хорих ял хойшлогдсон өсвөр насны хүнд холбогдох 6 хэргийг судалж үзэхэд шүүхээс үүрэг хүлээлгээгүй хорих ялыг хойшлуулсан байсан;

байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх зэрэг үүргийг хүлээлгэж хорих ялыг хойшлуулж байна. Ингэснээр өсвөр насны хүнд зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүрэг оногдуулахгүй болохоор тэднийг зүгээр л бүртгэх ажил хийгдэж байгааг өөрчлөх хэрэгтэй.

Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 7.6.1-т зааснаар хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулахад өсвөр насны хүн анх удаа хөнгөн гэмт хэрэг /хорих ялын дээд хэмжээ 5 жил/ үйлдсэн байхаар нийтлэг зохицуулалтын хэмжээнд тусгасан. Мөн хуулийн 8 дугаар бүлгийн 8.6.1-т заахдаа "...Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ялын дээд хэмжээг 8 жил эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэдэг нь хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хамаарах онцлог бөгөөд тусгай зохицуулалт болсон. Гэвч хоёр өөр бүлэг байсан ч хуулийн нийтлэг болон тусгай зохицуулалт агуулга, мөн чанарын хувьд нэгэн адил төстэй байх шинжийг агуулж чадахгүй байна.

Гэтэл шүүхээс өсвөр насны хүн хөнгөн эсхүл хүнд гэмт хэрэг үйлдсэнээс үл хамааран хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэлх хугацаанд хойшлуулах боломжтой байхаар хуулинд заасан хуулийн хийдэл байна.

Насанд хүрсэн хүн, өсвөр насны хүн хоёрын хооронд нас, боловрол, нийгмийн байр суурь зэргээрээ өөр ялгаатай. Гэвч өсвөр насны хүн ганцаараа эсхүл насанд хүрэгчидтэй бүлэглэн шунахайн сэдэлтээр амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор дахин олон удаагийн үйлдлээр хулгай хийж, өөрийн үйлдлээ бүрэн ухамсарласан байдаг.

Хэрвээ өсвөр насны хүнийг хүнд гэмт хэрэг үйлдсэн ч одоогийн зохицуулалтаар хорих ял оногдуулж, хорих ялыг хойшлуулсаар байна гэвэл Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэгт заасан хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах зохицуулалтанд зарим нэг нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн хийдлийг арилгах хэрэгтэй.

Сургалт-хүмүүжлийн байгууллага: нийгэм-сэтгэл зүйн албатай учир нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авч хохирлоо барагдуулахгүй бол хугацааны өмнө тэнсэн суллагдах эрх үүсэхгүй гэдгийг ойлгуулахаас гадна зан үйлд нөлөөлөх, хөдөлмөрлөх дадал олгох сургалтанд биечлэн бүрэн хамруулснаар эерэг үр дүнд хүрдэг. Мөн өсвөр насны хоригдлыг ерөнхий

боловсролын сургалтанд хамруулж, бичиг үсэггүй, хичээл завсардсан хүүхдүүдийн хүмүүжилд эерэг нөлөө үзүүлдэг.

Мөн тодорхой хүнтэй харилцахыг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглож тогтмол байнгын биечилсэн хяналтыг тавьж, зөвхөн хувийн хэрэгт бүртгэлтэй гэмт хэрэг үйлдэхэд хамааралгүй хүнтэй эргэлт, уулзалтаар уулзахыг зөвшөөрөх, ар гэр рүү нь утсаар яриулах зэрэг нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлсэн үр дүнтэй ажил болдог.

Улсын хэмжээнд тэнссэн этгээд, хорих биечлэн эдэлж байгаа хоригдол, хорих ялыг хойшлуулсан ялтанд сургалтын ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан "Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам"-аар зохион байгуулж байна.

Дээрх журам нь Монгол Улсын хэмжээнд өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эхэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, хорих ял биечлэн эдэлж байгаа, тэнссэн гээд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан бүх хүнийг хамруулсан нийтлэг зохицуулалттай. Гэвч хяналтанд байгаа этгээдүүдийг нас, хүйс, сэтгэл зүйн онцлогоор нь ялгаж тус тусад нь сургалт зохион байгуулах талаар зааж өгөөгүйг өөрчлөх шаардлагатай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас улсын хэмжээнд 2022 оны 4 дүгээр сараас эхлэн НШШГГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэст сургалтанд хамрагдах үүргийн биелэлтийг хариуцсан нэг мэргэжилтэний орон тоог баталсан ч өнөөдрийг хүртэлх хугацаанд дахин орон тооны ажилтан баталж өгөөгүй. Энэ нь 21 аймаг, алслагдсан 3 дүүргийн хэмжээнд хуваан тооцоход хангалтгүй байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, сургалт хариуцсан мэргэжилтний оролцуулж, зан үйлд нөлөөлөх сургалтыг Их үйлсийн бүтээмж сургалтын төвийн[1] багшаар 1 сард нэг удаа тогтмол сургалтанд хамруулж байна. Шийдвэр гүйцэтгэгч

[1] Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн хэмжээнд 2024 онд "Их үйлсийн бүтээмж" сургалтын төв төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.

нараас өсвөр насны ялтны сургалтын үр дүнг сургалт ороход байсан эсэхээс хамаарч зөвхөн бүртгэлээр дүгнэдэг.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны ялтанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дор хаяж 1 хүн батлан даалтанд авч хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулдаг ч төдийлөн үр дүнд хүрдэггүй.

Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 14.4. эцэг, эх хүүхэддээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох ёстой гэж заасан байдаг ч энэ заалт гэмт хэрэгт өртсөн хүүхдүүдийн хувьд зөрчигдөөд байна.

Учир нь эцэг, эх нь салсан тохиолдолд хүүхдээ өөр дээрээ авч өсгөж байгаа аав эсхүл ээж нь бусад харгалзан дэмжигчдийнх нь хамт батлан дааж авдаг. Батлан дааж аваагүй бол надад энэ хүүхэд хамаагүй гэсэн байдлаар ханддаг. Энэ нь Гэр бүлийн тухай хуулинд заасан “Эцэг, эх нь салсан байсан ч үр хүүхдээ хүмүүжүүлэх, хамгаалах үүрэг нь дуусгавар болох үндэслэл болохгүй” гэдгийг тусгасантай зөрчилдөж байдаг.

Эрүүгийн хуулийн 8.7.4-т “...Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно...” гэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны этгээдэд хамааруулж хуульчилсан боловч хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтанд чиглэсэн ийм заалт байхгүй байна.

Мөн өсвөр насны ялтныг батлан даах баталгаа гаргасан асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс Ерөнхий боловсролын сургалтанд хамрагдаж байгаа эсэх, хичээлээ хийх, таслах, тэнэх үйлдэл гаргаж байгаа эсэхэд нэг бүрчилж, биечлэн хяналт тавих боломж байхгүй юм.

Шийдвэр гүйцэтгэгч өсвөр насны ялтныг уруу татаж болзошгүй насанд хүрэгчидтэй уулзаж, харилцахыг хязгаарлах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглож шүүхээс хязгаарлалт тогтоосныг хангуулахаар баталгаа авч тайлбар авах ажлыг сар бүр тогмол хийсэн ч байнгын биечилсэн хяналт тавьж чадахгүйн улмаас яг хаана хэнтэй юу хийгээд явж байгаа эсэхийг мэдэх боломжгүй. Эцэг, эх нь батлан даалтанд авлаа ч гэсэн ажил гэрийн хооронд явсаар өөрийн мэдэлгүй хүүхдээ үл хайхрах нь түгээмэл байна.

Анх удаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс оногдуулсан хорих ялыг хойшлуулсан өсвөр насны ялтныг байнгын хяналт тавьж хүмүүжүүлэхэд ШШГБ[1], ГБХЗХГ[2] хорих ял хойшлогдсон өсвөр насны хүнд шүүхээс даалгасан үүрэг болох зан үйлээ засах сургалтанд нь сэтгэл заслын үйлчилгээ, хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалт, ухуулгуудыг Жендэрийн үндэсний хорооны нэгжүүдтэй хамтран зохион байгуулах эрх зүйн орчин үгүйлэгдэж байна.

Өсвөр насны ялтныг ялаас чөлөөлөхдөө: Эрүүгийн хуулинд хорих ялын дээд хэмжээг 8 жил хүртэл эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд шүүхээс оногдуулсан хорих ялын хугацааг хоёрны нэгээр бодож, ялыг багасган биечлэн эдлэх хорих ялыг 2 жил хүртэл хугацаанд хойшлуулах боломжтой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүрэг, тогтоосон хязгаарлалтын биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэл хийж, тухай бүр нь прокурорт танилцуулж хянуулдаг. Энэ үед прокуророос тавьж буй шаардлага нь зан байдлын тодорхойлолт, сургалтанд хамрагдсан хугацаа, засрал хүмүүжилд хяналт тавьдаг. Хорих ялыг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн ялтанд албан бичгээр мэдэгддэг.

Эрүүгийн хуулий 8 дугаар бүлгийн 8.6.4-т зааснаар “...Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;
[2] Гэр бүл хүүхэд залуучдын хөгжлийн газар;

хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө...” гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186 дугаар зүйлийн 2.6-т “...Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх…” гэж зааснаас болоод практикт ял хойшлогдсон хугацаа дуусмагц шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгож, прокурор ял хойшлуулсан шийдвэрийг шүүх хурлаар оруулж шийдвэрлэхгүй байгааг анхаарах шаардлагатай.

Бусдад учруулсан гэм хорын хохирлыг асран хамгаалагч болох хууль ёсны төлөөлөгч нь төлөхөөр шийтгэх тогтоолд заасан байдаг боловч “...гэмт хэргийн хор уршгийг арилгах...” арга хэмжээний талаарх үүргийг хүлээлгэхгүй байгаа нь буруу байна. Учир нь гэмт хэрэг үйлдэж хорих ял авах үедээ 18 насанд хүрээгүй, хорих ял авч 2 жил хүртэл хойшлогдсон хяналтын хугацаа дуусах үед насанд хүрсэн, бусдад учруулсан гэм хорын хохирол төлөгдөөгүй байвал хорих ялыг биечлэн эдлүүлэх эсхүл хохирлыг нэн даруй төлсөн тохиолдолд ялаас чөлөөлөх асуудлыг шүүх хурлаар нэг мөр шийдвэрлэх нь чухал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 188.1 дахь хэсэгт “...Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, тэнссэн хугацаанд ялтан засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч, шударга хандлагаараа харуулсан, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан ялтны хянан харгалзахаар тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч ялтныг ялаас чөлөөлүүлэх саналыг прокурорт гаргаж болно...” гэж заасан. Тухайлбал, Шүүхээс 6 жилийн хорих ял оногдуулахаар гэмт хэрэг үйлдэж гэм буруутайн тогтоогдож, ял багасгуулж, 3 жилийн хорих ялаар шийтгүүлж, шүүхээс 2 жилийн хугацаанд ял хойшлогдон, эхний 1 дэх жилдээ, хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй, зөрчил гаргаагүй бол ялаас чөлөөлөгдөнө.

<u>Хорих ялыг хойшлуулсан шийдвэрийг хүчин болгохдоо:</u> ШШГтХуулийн 187.2 дахь хэсэгт “...Ялтан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл

шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 6 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учирсан[1], эсхүл хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулж, хорих ялыг биечлэн эдлүүлэх саналаа прокурорт хүргүүлнэ" гэжээ.

Шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрээ хүчингүй болговол өсвөр насны ялтны хяналтын хугацаа хэдэн сар, өдөр, хоног өнгөрсөн, сургалтанд хамрагдсан хугацаанаас үл хамаарч хорих ялыг биечлэн эдлүүлж байгаа нь хүүхдийн эрх зүйн байдлыг дордуулж байна.

Тухайн өсвөр насны хүний хяналтын хугацаанд байсан өдөр, хоног, сарыг хорих ялыг эдэлсэн хугацаанд оруулан тооцдог болох шаардлагатай. Тухайлбал, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солихдоо эдлээгүй үлдсэн ажлын цаг[2], хяналтын хугацааг[3], шагналын хоногийг[4] хасч үлдсэн хугацаанд ялын дүйцүүлж хорих ялаар сольдог.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний эрх зүйн байдал нь Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэгт "...ялтан..." гэж тусгайлан зааж томьёолсон тул сургалтанд хамрагдсан байдал, сар өдрийг харгалзан үзэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 223, 224 дүгээр зүйлд заасантай нэгэн адил сургалтын ажлын бүтээмж, чанарыг үндэслэн 1 сард 10 хүртэл хоногийн шагнаоын хоног олгох, ялтанд олгох шагналын хоногийг нэг улиралд 30 хоногоос илүүгүй байхаар тогтоож өсвөр насны ялтныг урамшуулж, хорих ял хойшлогдсон хугацаа дуусч хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шүүх

[1] Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ.,2017 он. 188.4 дахь заалт;
[2] Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4-т "...Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино..."
[3] Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 3-т "...Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино..."
[4]Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ.,2017 он, 175 дугаар зүйлд "...Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтныг урамшуулах..." талаар заасан.

шийдвэр гаргасан тохиолдолд шагналын хоног, сургалтанд хамрагдсан хугацааг хасч хорих ялыг биечлэн эдлүүлэх тогтолцоо заавал байх ёстой.

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны ялтан хорих ял хойшлогдсон хугацаагаа дуусгаад дахин тодорхой хугацаанд хяналтанд хорих ялыг завшуулахгүй нөгөө талаас гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялыг биечлэн эдэлж байгаа хүүхдүүд шиг хүмүүжиж чаддаггүй. Хэрвээ хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллага хариуцаж байвал дахин гэмт хэрэг үйлдэх нь багасна. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад [1] ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын ял шийтгэлийн байдал. 2023.05.12-ний өдрийн байдлаар.

Хүснэгт 2.

Эрүүгийн хуулийн зүйл анги	**Гэмт хэргийн ангилал**	
	Хөнгөн	Хүнд
11.1 Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах		3 хоригдол. 16-17 насны /4-5 жилийн хорих ялтай/ Анх удаа бүлэглэн
12.1.2.1, 12.1.2.2 Бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах	3 хоригдол. 16-17 насны /1-2 жилийн хорих ялтай/ Анх удаа бүлэглэн	
12.1.4 бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах /хүндрүүлэх нөхцөлтэй/		4 хоригдол. 15-17 насны /5-6 жилийн хорих ялтай/ Анх удаа
17.1.2.1 Хулгайлах	17 хоригдол. 14-16 насны 2-3 жилийн хорих ялтай /Анх удаа ял авсан 12, дахин шийтгэгдсэн 5/	
17.2.2. Дээрэмдэх		5 хоригдол. 15-17 насны 1-2 жилийн хорих ялтай дахин үйлдсэн .

[1] Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын нийгэм, сэтгэл зүйн албанаас авсан 2022 оны 5 сарын судалгаа;

Бүгд	20 хоригдол.	хоригдол.

Дээрх хүснэгтээс 15 хоригдол анх удаа гэмт хэрэг үйлдээд 1-3 жилийн хорих ялаа биечлэн эдэлж байна. Энэ нь эцэг эхийн зүгээс тавих хараа, хяналт алдагдаж бүтэн буюу эцэг эх нь салж сарнисан хагас өнчрөлд орох нь өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэхэд нэг нөхцөл болж байна. Одоогоос 40 гаруй жилийн өмнө 1971 онд Монголд гэр бүл салалтын улмаас өнчирсөн л хайхрагдсан хүүхдүүдийн 12.6% нь гэмт хэрэг үйлдэж, 14.5% нь зөрчилд холбогдсон байгааг[1] тогтоосон байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж буй хэргийн 60 гаруй хувь нь хулгай, үлдсэн хувь нь дээрэм, хүчин, танхай, зодоон бусад хэргүүд зонхилон эзэлдэг[2].

Гэр бүл салалтыг аль болох гаргахгүй байх нь чухал гэдгийг эрдэмтэн Н.Жанцан 1984 онд өөрийн бүтээлдээ "...гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн 400 хавтаст хэргийн материалд судалгаа хийж үзэхэд судалгаанд хамрагдагсдын 33.2% бүрэн биш гэр бүлд хүмүүжсэн, 4.6% нь эцэг эхгүй, 18.1% эцэгтэйгээ, 9.2% эхтэйгээ, 1.3% нь төрөл садныхантайгаа хамт амьдарч байсан байна..." гэж тэмдэглэсэн байдаг[3]. Үл хайхрагдах байдал нь хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг 28 жилийн өмнө баталж, 2013-2017 онд хорих ял авч хойшлогдсон 1273 хүүхэд, хорих ял биечлэн эдэлсэн 134 хүүхдийн ар гэрийн байдалд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн зэргээс харж болно.

Олон улсын гэрээ, конвенц: Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулахыг аль болохоор зайлсхийж, харин нээлттэй "шорон" буюу нийгмээс тусгаарлахгүйгээр эрх чөлөөг нь түр хязгаарлах замаар нийгэмшүүлэх чиглэлийн олон сонголттой ялын төрлийг хэрэглэж, энэ нь "төр, иргэний байгууллага, гэр бүл"[4] гэсэн гурвалсан субъектын хамтын хариуцлагын зарчмаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байдаг.

---

[1] Н.Жанцан, Ю.Цэвээннамжил.,"Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлъе".,УБ.,1975 он., 26 дахь тал;

[2] Б.Наранзаяа. "Насанд хүрээгүй этгээдээс үйлдэгдэж буй хулгайн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ба криминолгийн зарим асуудал" сэдэвт Цагдаагийн дээд сургуулийн дипломын ажил.,УБ.,1999 он., 56 дахь тал;

[3]Н.Жанцан.,"Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам".,УБ.,1984 он., 85 дахь тал;

[4]"Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе".,УБ., 2013 он., 34 дахь тал;

НҮБ-аас гаргасан жишиг дүрэмд[1] энэ талаар тодорхой тусгасан ба энэ нь шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсныг илэрхийлнэ. Хүүхдийн эрхийн конвенцэд хүүхэд бүр эрхээ эдлэхийн тулд шаардлагатай бүхий л олон улсын конвенц болон үндэсний хуулийг хэрэглэх эрхтэй.[2] Насанд хүрээгүй этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засарч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлэхийг харгалзсан байна.[3]

Олон улсад хэргийн нөхцөл байдал шаардахгүй бол насанд хүрээгүй нэг ч хүнийг эцэг, эхийнх нь хараа хяналтаас бүрэн буюу зарим хэмжээгээр гаргаж болохгүйг заасан байдаг боловч энэ журмын хэрэгжилт хангалтгүй байгааг Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас 2013 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр "Ариусахуй ертөнц" сэтгэл зүйн төв, сэтгэл заслын эмнэлгээр "Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцлийг судлах" чанарын судалгааг захиалан гүйцэтгүүлсэн[4] судалгааны жишиг үр дүнгээр дараах байдлаар тайлбарлаж болно.

Уг судалгаанд 2013 онд ял хойшилсон 40 хүүхэд, тэдний эцэг, эх болох 40 хүний хамруулсан байдаг.

Хүснэгт 3.

40 хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг хувь, хэмжээ			**Гэмт хэрэг үйлдсэн насны байдал**	
Хулгайлах /ЭХ-н 17.1/	Дээрэмдэх /ЭХ-н 17.2/	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /ЭХ-н 11.1/	14 насны	15-17 насны гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн
/7/ 17%	/8/ 20%	/19/ 47%	Хулгайлах /ЭХ-н 17.1/	/ЭХ-н 17.2/ /ЭХ-ийн 11.1/

[1] НҮБ-ын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм.,/Токиогийн дүрэм/Ерөнхий Ассемблейн 1990 оны 10-р сарын 14-ний өдрийн 45/110-р тогтоол.

[2]"Хүүхдийн эрхийн конвекц".,НУ.,1989 он.,37(Б);

[3]"Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"., 1966 он.,14.4 дахь хэсэг;

[4]Хууль зөрчлсөн хүүхэдтэй ажиллах арга зүйн гарын авлага., Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар.,УБ.,2016 он., 9 дахь тал;

-	Үүнээс /28/ 70% бүлэглэн үйлдсэн	-	-

Судалгаанд хамрагдсан 40 хүүхдийн 47% нь дээрэм, 20% нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 17% нь хулгайлах гэмт хэрэг, 70% нь **өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг**, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн. Тэднээс 14-өөс доош насныхан нь ихэвчлэн **хулгайн** гэмт хэрэг үйлдсэн бол 15-17 насныхан нь **танхайн гэмт хэрэг, дээрмийн** гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн; 58% нь эхийн, 17% нь эцэг, асран хамгаалагчдын асрамж халамжинд амьдардаг хүүхдүүд гэмт хэрэг үйлдсэн байдаг[1].

Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан Эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүлээх зарим үүрэг [2] -ийн хэрэгжилт хуульд нийцэхгүй, ө.х. эцэг эхийн хараа хяналт муу байна. Үүнд[3]:

Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх, Хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх, Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах,

Хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах; Хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах зэрэг тус тус хангагдаагүйтэй холбоотой гэж үзэж байна.

Гадаадын зарим орны туршлагаас үзэхэд: Оросын холбооны улсын Эрүүгийн хуулинд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусахад шүүх хорих ялыг биечлэн эдлүүлэх шийдвэр гаргадаг. Хойшлуулсан хугацаанд сургалтанд хамруулаад шагналын хоног олгох, сургалтанд хамрагдсан өдөр, хоногийг хорих ялын хугацаанаас хасч тооцдоггүй. Харин Босния Герцеговин улсын “Чука” нөхөн сэргээх, сурган хүмүүжүүлэх төв туршлага авахад болохуйц үр дүнтэй гэж боддог. Түр байрлуулах төв нь ял хойшлогдсон хүүхдэд сургалт, хүмүүжлийн болон мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, хүүхдийн харилцааны чадвар, эцэг, эхийн чадварыг нэмэгдүүлэх, биеийн тамирын арга хэмжээ, тоглоом, олон нийтийн клуб ажиллуулах, төрийн бус

[1]“Монгол улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан /2013-2017/.,УБ.,2018 он., 44 дахь тал;
[2]Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль.,УБ.,2016 он., 10 дугаар зүйл;
[3]Мөн хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.5. 10.1.8, 10.1.10 дахь заалт;

байгууллагатай хамтран ажилладаг. Уг төвд хүүхэд 6 болон 12 сарын хугацаанд 7 хоногийн 4 өдрийг тухайн төвд өнгөрүүлдэг ба 2 ажилтан хөтөлбөрт хяналт тавьж, сайн дурын 8 ажилтан /оюутан/ өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг. Хүүхдийн шүүх нь Чугакийн амжилтыг харгалзаж, хугацааг богиносгосон ба хорихын оронд хүмүүжлийн дээрх байгууллагад шүүхийн шийдвэрийг явуулдаг болсон.

Манай улсад хүүхдийн тусгайлсан шүүх, хүүхдүүдийг байршуулан хүмүүжүүлэх тусгай төв ажилладаггүй. Хорих ял хойшлогдсон өсвөр насны хүн болоод батлан дааж авсан эцэг, эх асран хамгаалагч руу нь чиглэсэн үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтууд явагддаггүй. Иймд Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын оролцоог Эрүүгийн хуульд зөвхөн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох байдлаар хязгаарлаж зохицуулсныг өөрчилж, хорих ял хойшлогдсон өсвөр насны хүний хяналтын хугацаанд хүмүүжүүлэхэд оролцох талаар тусгайлан зааж хуульд тусгайлан зааж өгөх шаардлага үүссэн.

ДҮГНЭЛТ

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний эрх зүйн байдлыг Эрүүгийн хуулинд ялтан гэж томьёолж, ял эдэлж байгаа гэсэн эрх зүйн үр дагаварыг бий болгосон.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны ялтанг ерөнхийд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтанд даатган орхиж байгааг өөрчилж Эрүүгийн хуулинд хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын оролцоог тусгайлан заах шаардлага үүссэн.

Хорих ялыг хойшлуулсан өсвөр насны хүнийг босния герцогевин улсын Чука нөхөн сэргээх, сурган хүмүүжүүлэх төв шиг шүүхээс даалгасан үүргийг хэрэгжүүлэхдээ нийгэмшүүлэх нөхөн сэргээх, мэргэжил олгох, ажил сургуултай байлгах зэрэг тусгайлсан ажлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан явуулах хэрэгтэй.

Өсвөр насны ялтны эцэг эх салсан байхаас үл хамаарч хянан хүмүүжүүлэх, хараа хяналтандаа байлгах үүргийг хүлээсэн батлан даагч эцэг, эх, харгалзан дэмжигчдийг өсвөр насны ялтны хамт үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтанд хамруулах ажлыг явуулж байх нь чухал байна.

Шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулах үедээ заримдаа өсвөр насны хүнд зан үйлээ засах сургалтанд хамруулах үүргийг зааж өгөөгүйгээс зарим хүүхдүүд сургалтанданд хамрагдах боломжгүй болдог. Иймд сургалтанд заавал хамрагдах үүрэг хүлээлгэж хорих ялыг хойшлуулах талаар хуулинд тусгах хэрэгтэй.

Үл хайхрагдах хүчирхийллийн эсрэг сургалтанд батлан даагч, асран хамгаалагч болон өсвөр насны ялтанг хамт хамруулдаг байх нь чухал юм.

Иймд сургалтын ажлын бүтээмж, чанарыг харгалзан ялтанд олгох шагналын хоногийг нэг улиралд 30 хоногоос илүүгүй байхаар тогтоож өсвөр насны ялтныг урамшуулдаг болох зохицуулалт дутагдаж байна.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны ялтны хорих ялыг хойшлуулсан хугацаа дуусгавар болж, ялаас чөлөөлөгдөхгүй эсхүл санаатай шинээр гэмт хэрэг үйлдэж хорих ялыг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шүүх шийдвэр гаргавал эдлээгүй үлдсэн хорих ялын хугацаанаас шагналын хоног, хяналтын бүртгэл, сургалтанд хамрагдсан өдөр хоногийг хасч, эдлээгүй үлдсэн хорих ялын хугацааг биечлэн эдлүүлэх нь хүүхдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх болно.

САНАЛ

1. Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 7.6.1[1]-т “...Шүүх анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ялын дээд хэмжээг 8 жил эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн...”, хөнгөн гэмт хэрэг үйлсэн жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина гэж өөрчлөлт оруулах,

2. Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 8.6[1]-т “...Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтныг хянан хүмүүжүүлэх асуудлыг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ... гэж нэмэлт оруулах,

3. Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 8.6[1]-т “...Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа заавал 7.3 дугаар зүйлийн 2.2-т заасан зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүрэг хүлээлгэхээр тусгах,

4. Эрүүгийн хуулийн 8.6[1]-т, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186.2[1]-т "...Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц сургалтанд хамрагдсан, засарч хүмүүжсэн байдлаас хамаарч сард 10 хүртэл шагналын хоног олгож урамшуулах, сургалтанд хамрагдсан өдөр, хоногийг хорих ялыг биечлэн эдлэх хугацаанаас хасч тооцож болох..." талаар тус тус тусгах

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186 дугаар зүйлийн 2.6[1]-т "...Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага, хорих ял оногдуулсан шүүх болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх…" өөрчлөлт оруулах

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186.2[1]-т "...Хорих ял хойшлогдсон хугацаанд эцэг эх нь тусдаа амьдардаг салсан байхаас үл хамаарч хүүхдээ хоёул үл хайхрахгүй байж батлан дааж асран хамгаалах, үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтанд хамрагдахад байлцах..." талаар тусгах

7. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд зан үйлээ засах сургалтанд хамрагдах үүргийг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий хүүхдэд зааж чиглүүлсэн сургалтын журмыг боловсруулах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ;

1. Олон улсын гэрээ, конвенц:

- НҮБ-ын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм.,/Токиогийн дүрэм/Ерөнхий Ассемблейн 1990 оны 10-р сарын 14-ний өдрийн 45/110-р тогтоол.
- "Хүүхдийн эрхийн конвекц".,НУ.,1989 он.,37(Б);
- "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"., 1966 он.,14.4 дахь хэсэг;
- "Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам"., /Бээжингийн журам/ 1985 оны 11 сарын 29-ний Ерөнхий ассемблейн 40/33 тоот тогтоолоор баталсан./ 18 дахь заалт

2. Хууль тогтоомж, журам:

- Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль.,УБ.,2016 он;
- Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.,УБ.,2017 он;
- Монгол Улсын Эрүүгийн хууль.,УБ.,2017 он;
- Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ.,2017 он;

3. Ном, сурах бичиг, судалгааны ажил, тайлан

- Н.Жанцан, Ю.Цэвээннамжил.,"Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлъе".,УБ.,1975 он;
- Н.Жанцан.,"Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам".,УБ.,1984 он;
- UNICEF.,Хууль зөрчсөн хүн хүүхдийн асуудал Монголд.,2002 он;
- Б.Наранзаяа. "Насанд хүрээгүй этгээдээс үйлдэгдэж буй хулгайн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ба криминолгийн зарим асуудал" сэдэвт Цагдаагийн дээд сургуулийн дипломын ажил.,УБ.,1999 он;
- "Хүүхдийн эрх хүүхэд хамгаалал".,УБ.,2011 он;
- "Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе".,УБ., 2013 он;
- Хууль сахиулах үйл ажиллагаа, онол, практикийн тулгамдсан асуудал.,УБ.,2016 он.,/Д.Насанбат.,"Хорих байгууллагын ялтан болон хорих байгууллагаас суллагдсан хүмүүст явуулсан нийгэмшүүлэх ажлын үр нөлөө" илтгэл/,
- Хууль зөрчлсөн хүүхэдтэй ажиллах арга зүйн гарын авлага., Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар.,УБ.,2016 он;
- Ю.Бадамханд.Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл.,УБ.,2016 он;
- Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан.,УБ.,2017 он;
- "Монгол улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл" судалгааны ажлын тайлан /2013-2017/.,УБ.,2018 он;

---o0o---

ҮЕ ҮЕИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛЫГ ОНОГДУУЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

HISTORICAL TRADITION OF SENTENCES OF COMMUNITY SERVICE IN CRIMINAL LAW



Ч.Нансалмаа

ДХИС-ийн Удирдлагын академийн 8013 дугаар дамжааны суралцагч, ахлах дэслэгч

Судалгааны ажлын товч утга:

Монгол улсад эрүүгийн хариуцлагын тогтолцоо хууль эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгалаа олж, нийгэмд хор уршигтай ямар үйлдэл эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож, ялтанд оногдуулж байсан ялын төрлүүд үүнээс тэр тусмаа одоогийн эрүүгийн хуулийн ялын нэг төрөл болох нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулж ирсэн түүхэн уламжлалыг судалж, цаашид хэрхэн уг ял эдлүүлэх ажиллагааны хяналтын үйл ажиллагааны тогтолцоог сайжруулах, ялын үр нөлөө, ач холбогдолыг дээшлүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Abstract: How the system of criminal responsibility in Mongolia is reflected in the legal documents, the types of punishments given to convicts are considered crimes, and the types of punishments given to convicts, especially the historical tradition of community service, which is a type of punishment in the current criminal law. , how to further improve the system of supervision of the sentencing process, and to determine ways to improve the effectiveness and significance of the sentence.

Түлхүүр үгс: ял шийтгэл, эрх зүйн баримт бичиг, ялын үзэл баримтлал

Key words: sentence, legal documents, and sentencing concepts

ОРШИЛ

Төр эрх зүйн түүхэн уламжлалын арвин их түүхтэй манай улсын хувьд олон улсын болон өнөөгийн нийгмийн өөрчлөлт хувьслын цаг үетэй хөл нийлүүлэн хууль эрх зүйн орчныг шинэчлэн хуулийн хариуцлага

хүлээлгэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхдээ ял завшуулахгүй байх, хүний эрхийг зөрчихгүй ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох нь зүйтэй юм.

Бусдын эрх ашгийг хөндсөн бус үйлдэл, эс үйлдэхүйг тодорхойлж, хариуцлага тооцож, шийтгэдэг тогтолцоо түүхэн цаг үе бүрд байсаар ирсэн. Хүннхү улсын хэв хуулиас өнөөгийн мөрдөгдөж байгаа эрүүгийн хуульд заасан хориглосон үйлдэл, эс үйлдэхгүй бүрд хуульд заасан ял оногдуулж байгаа нь нөгөөтэйгүүр шударга ёсны зарчимд нийцэхүйц бодлого юм. Эрүүгийн хуулийн шинэчлэн найруулсан 2002 оны эрүүгийн хуульд шинэ нэршлээр тусгагдсан "Нийтэд тустай ажил хийлгэх ял" нь гагцхүү гэмт хэрэгтнийг цээрлүүлэхээс гадна нийгэмд үр ашигтай үр дүн өгөхүйц ялын санкц байснаараа ач холбогдолтой.

Монгол улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн явцад хэрхэн уламжлагдаж, шинэчлэгдэж ирсэн түүхийн хуудсыг судалж, үе үеийн эрүүгийн харицулага, тэр тусмаа нийтэд тустай ажил хийлгэх ялыг хэрхэн хэрэгжүүлж байсан түүхийн баримтаас давуу болон сул талыг тусгахын зэрэгцээ онцлогийг илэрхийлж, ялын бодлогын үзэл баримтлал, хандлагыг судлахыг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Түүхийн эх сурвалжаас үзэхэд хүмүүсийн хамтын ажиллагаа, хамтдаа баялаг бүтээх, амьдралын хэв маягт зайлшгүй хэрэглэгдэх хэрэгцээний эд үйлийг бий болгох зэрэг үйл ажиллагаа үүссэн цаг үеэс улс орны нийгмийн байгуулал бий болсон гэж үзэхээр байна. МЭӨ IV зууны үед үүсэн бүрдсэн Хүннүгийн холбоо нь төв ба Дундад ази дахь анхны томоохон төрийн бүрдлийг бий болгосон. Өөрөөр хэлбэл Хүннүгийн үеэс овог аймгууд Улсын захиргаа цэргийн хуваарь болох Түмтийн хуваарьт оруулсан[1] нь төрт улсын шинжийг агуулсан тогтолцоо юм. Төрт ёсны тогтолцоо нэгэнт бий болсонтой холбоотой овог аймгийнхаа нийгмийн олон төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага үүссэн.

Дэлхий дахины хүн төрлөхтний түүхэнд гол төлөв төрд тэрсэлсэн, хүний амьд биед халдсан (алсан, гэмтээсэн), эд хөрөнгөд халдаж хулгайлсан, дээрэмдсэн, байгаль орчинд хор хохирол учруулсан шинжтэй байсан[2] талаар Энэтхэгийн "Ману"-гийн хууль, "Хаммурапи хаан"-ы

[1] Ж.Болдбаатар, Д.Түндээжанцан, Монгол улс төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997 он, 13 дахь тал

[2] С.Жанцан, Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть. Уб., 2014. 9 дэхь тал

хуульд тусгасан байдаг. Нийгмийн харилцаа өргөжихийн хэрээр хүмүүсийн сэтгэлгээ хандлага өөрчлөгдснөөр нийгэмд эмх замбараагүй байдал үүссэнээр төрийн зохицуулах асуудал ч олширч, зөрчигдсөн эрхийг хамгаалах, гэмт үйлдэл үйлдэгчид хариуцлага тооцох, цээрлүүлэх зорилгоор ял шийтгэл үүссэн.

МЭӨ III зууны үеэс нийтэд тустай ажил хийлгэх ялын мөн чанарыг агуулсан ял шийтгэлийн төрөл хэрэгжиж байсан нь түүхэнд дэлгэрэнгүй бус хэдий ч түүхэн эх сурвалжид хэрхэн авч үзсэнийг мөлжигч нийгэм, Феодалын нийгэм, Ноёлогч анги, Капиталист нийгмийн үед гэмт хэрэгт тооцдог байсан үйлдэл эс үйлдэхүйг харьцуулан судлахад бүхий л цаг үед эд хөрөнгийн харилцаа, гэр бүлээс гадуурх харилцаа, хаад ноёдын эсрэг үйл хэргийг үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулдаг байсан байна.

Тухайн цаг үеийн хууль эрх зүйн үзэл баримтлалыг тухайлан авч үзвэл:

Мөлжигч нийгэмд гэмт хэрэгтэй тэмцэх гол арга нь эрүүгийн ялын бодлого байв. Тухайн үед ноёлогч ангийн хэмжээгүй эрхэт байдал, дарлагдсан ангийн бүлэг хэсгүүдийн хоорондын зөрчилдөөн, гэмт хэрэг гарах нөхцөл шалтгааныг бий болгож байв. Хуулийн агуулга төрийн эрх мэдэл, халдашгүй байдал, хүний амь нас, бие махбодь, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд байсан бол цаазлах, эрхтнээс хагацуулах, бие мах бодийг зовоох, тарчлаах, эд хөрөнгийг хураах, хүнд хөдөлмөрт зүтгүүлэх, хөөн зайлуулах, гутаах[1] зэрэг ялын төрлийг ашигладаг.

Боолын нийгэмд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд боол болгох ял шийтгэж, хүнд хөдөлмөрт зүтгүүлж, байсан нь одоогийн нийтэд тустай ажил хийлгэх ялын утгыг агуулсан ял юм.

Феодалын нийгэм, ноёлогч ангийн үед гэмт хэрэгтнийг өөрсдөдөө ашигтайгаар хөлсгүй хөдөлмөр хийлгэх замаар материаллаг ашиг олох бодлого баримтлаж байсны үндсэн зорилго бол эд эрхтэнийг хөдөлмөр эрхлэх явцад бэртээн ноёлогч бүлгийн эсрэг тэрслэн бослого үймээн гаргах боломжгүй болгох явдал байв[2]. Түүхийн баримтаас үзвэл эрүүгийн харицулага буюу ял шийтгэлийн бодлого харгис хэрцгий, ялын зорилго ниймгийн үзэл баримтлалаараа хаад ноёд, ноёлогч бүлгийн эрх ашгийг хамгаалсан чиг хандлагатай байсан байна. Харин эртний болон дунд үеийн гүн ухаантнууд, соён гэгээрүүлэгч нарын ял шийтгэлийн зүй бус бодлогыг

[1] С.Жанцан, Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть. Уб., 2014. 11 дэхь тал
[2] Мөн тэнд 13 дахь тал

эсэргүүцэж, харгис хэрцгий ял шийтгэлийн бодлого нь гэмт хэрэгтэй тэмцэх бус харин ч улам хүний ёс суртахууныг доройтуулдаг тул энрэнгүй ёсны зарчмыг чл шийтгэлийн бодлогод баримтлах нь зүй ёсны юм гэх номлолыг бий болгосон гүн ухаантан бол Аристотель, Платон нар юм. Феодлын нийгмийн задралын дараагаар ноёлогч анги хүмүүсийн аж амьдралыг улам доройтуулж, аль болох ял оногдуулж, тэднийг хүнд хөдөлмөрт зүтгүүлж өөрсдийн эрх ашгийг хамгаалсаар байв.Гэвч энэ нь цаг үеийн өөрчлөлт хөгжлийн явцад зайлшгүй үүссэн ниймгийн олон төрлийн харилцааг зохицуулахын хажуугаар эрх баригч нарт бэрхшээл үүсгэх болсон бөгөөд ниймгийн амьдралын хөгжлийн өөрчлөлтийн үед хорих ялын үр нөлөөний сөрөг үр дагаврыг ойлгон, ялын бодлогыг зөөлрүүлэх нь гэмт хэргийг багасгах үр дүнд хүргэх боломжтой гэж үзсэн нь дэлхий дахинд хорихоос өөр төрлийн ялын бодлого бий болгожээ.

Монгол эртний улсуудын хэв болон бичмэл хуульд дурдснаар тухайн үеийн нийгмийн харилцаанд тулгурласан эрүүгийн ялын бодлого байсаар ирсэн. Дээр дурдсанчлан Хүннү улсын үеэс төрийн байгуулал бий болсонтой холбоотой ял шийтгэлийн төрөл нь цаазаар авах, хорих (үйлдвэр урлалд зүтгүүлэх), өмч болон гэр бүлийг хураах, бэрээдэх, **хүнд ажилд зүтгүүлэх** зэрэг байв.

Их Монгол улсын бутралын үеийн эрх зүйн гол эх сурвалж болох “Алтан хааны цааж бичиг”, “Арван номын цагаан цааз”, “Халхын цааз эрхэмжийн бичиг”, “Их засаг хууль”, “Монгол-Ойрдын хууль”, “Юан улсын нэвтэрхий толь” зэрэг хуулиудад **“үйлтгүүлэх ял буюу биеийн хүчний хүнд хүчир ажил хийлгэх”** гэх нэршилтэйгээр тусгагдсан байдаг[1].

Манжийн үеийн “Манж чин улсын хууль”, “Халх журам”, “Монгол цаазын бичиг” гэсэн гол гурван хуулиудад гэмт хэрэг үйлдсэн хүмүүст цаазаар авах, ташуурдах, цөлөх, хорих, хэргэм зэрэг эвдэх, торгох, хөрөнгө хураах, боол болгох, **түлээ түүлгэж ус дамнуулах[2]** зэрэг ял шйитгэлийн төрөлтэй байжээ. Монгол цаазын бичигт ялыг дотор нь үндсэн болон нэмэгдэл ял гэж ангилах ойлголт анх бий болгосон онцлогтой бөгөөд албадан ажил хийлгэх ялыг анх нэмэгдэл болон үндсэн ялаар оногдуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг байна[3].

---

[1] С.Батбаяр Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016. 13 дахь тал

[2] С.Батбаяр Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2016. 14 дэх тал

[3] С.Жанцан, Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть. Уб., 2014. 60 дэхь тал

Богд хаант Монгол улсын үе буюу 1921 оны үед төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг түшмэд, шашин номын зүтгэлтэнгүүд өмнөх түүхэн цаг үед хэрэглэж байсан ял шийтгэлийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, эрүүгийн хариуцлагын тогтолцоог улам боловсронгүй болгож Олноо өргөгдсөн Богд хааны зарилгаар тогтоосон "Монгол улсын хууль зүйн бичгийн 65 дэвтэр эмхтэгэлд зургаан сараас хоёр жилийн хугацаагаар **"үйлтгэх" буюу "албадан ажил хийлгэх"** ялыг оногдуулдаг байсан нь түүхийн хуудаснаа хууль цаазын чухал үйл явдал болсон тухай эх сурвалжийг С.Батбаяр Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлог магистрын зэрэг горилсон бүтээлийнхээ ишлэлд дурджээ.

Ардын хувьсгал өрнөсөн 1921 онд эрх зүйн шинэ эрин ирсэнтэй холбоотой 1921 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр "Тангарагийн гэрээ"-г Ардын засгийн газар, Богд хаан хоёрын эрхлэх үйл ажиллагааны ялгаа заагийг тогтоосноор эрүүгийн эрх зүйтэй холбоотой асуудал засгийн газрын мэдэлд шилжиж, эрүүгийн эрх зүйн хуучин хууль цаазыг хүчингүй болгож, "Ардын засгийн газрын хурлаас гаргасан хуульчилсан акт" (хурлын тогтоол), "Улс төрд онц ноцтой хэргийг таслуулахаар засгийн газраас байгуулсан комиссын тогтоол" гэх хэлбэрээр эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг шинэчлэн гаргасан. Хувьсгалыг ялалтын үр нөлөөгөөр нийгмийн харилцаанд гарсан эрс өөрчлөлтүүдийн үр нөлөөнд гадаад улсын иргэдтэй холбоотой маргаан, зөрчлүүд үүсэх болсонтой холбоотой эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хууль тогтоомжинд олон улсын хууль дүрмийг судлан, тусгах, мөн дотоодын эрх ашгийг хамгаалах үндсэн хуультай болох шаардлага үүссэн. Түүхэн цаг үеийн эрүүгийн ял шийтгэлийн төрөлд одоогийн нийтэд тустай ажил хийлгэх ялын нэршил, оногдуулж ирсэн түүхэн уламжлалыг системчлэн дурдвал:

Хүснэгт1.


№	Түүхэн цаг үе	Эрх зүйн баримт бичиг	Ялын нэршил
1	Хүннү улс (IV зууны үе)	Зан заншлын ёс горимууд, бичигдмэл бус, заншлын хэм хэмжээ, Түүхийн тэмдэглэл	хүнд ажилд зүтгүүлэх
2	Их Монгол улсын бутралын үе (XII зууны эх)	"Алтан хааны цааж бичиг", "Арван номын цагаан цааз", "Халхын цааз эрхэмжийн бичиг", "Монгол-Ойрдын хууль", "Юан улсын нэвтэрхий толь"	үйлтгүүлэх ял

3	Манжийн үе	“Манж чин улсын хууль”, “Халх журам”, “Монгол цаазын бичиг”	түлээ түүлгэж ус дамнуулах
4	Богд хаант Монгол улсын үе (1911 он)	“Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”	“үйлтгэх” буюу “албадан ажил хийлгэх”
5	Шинэ үндсэн хууль батлагдаж, ардчилал бий болсон цаг үеэс хойш	1926 оны шүүх цаазын бичиг	100 өдрөөс хэтрэхгүй хугацаатай засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
6		1929 оны шүүх цаазын бичиг	Хорихгүйгээр албадан ажил, үйлдвэр хийлгэх
7		1931 оны Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль	Хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг гүйцэтгэх
8		1934 оны шүүх цаазын бичиг	Албадан ажил хийлгэх
9		1942 оны эрүүгийн хууль	Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх
10		1947 оны эрүүгийн хууль	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
11		1961оны эрүүгийн хууль	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
12		1986 оны эрүүгийн хууль	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
13		1996 оны эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт	Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял
14		2002	Албадан ажил хийлгэх
15		2015	Нийтэд тустай ажил хийлгэх
16		2017 оны нэмэлт өөрчлөлт	Нийтэд тустай ажил хийлгэх

Одоогийн мөрдөгдөж байгаа эрүүгийн хуульд заасан нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтанд зохион байгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162, 163, 164, 165, 166 дугаар зүйлүүдэд заасны дагуу зохион байгуулахаар хуульчилсан.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны сүүлийн гурван жилийн байдлаар

Хүснэгт 1. нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүний тоон мэдээ[1]



Тоон мэдээнээс дүгнэвэл нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтны тоо 2021 онд 19.1 хувь, 2022 онд 25.9 хувиар тус тус жил бүр өссөн дүнтэй байна

Иймээс хорихоос өөр төрлийн ялын энэ төрлийг хэрхэн үр ашигтай зохион байгуулах нь олон талын нийгэмд эерэг үр дагаврыг бий болгож, ял эдлүүлэх ажиллагааны мөн чанарыг алдагдуулахгүй зохион байгуулахын тулд нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага зайлшгүй үүсээд байна.

ДҮГНЭЛТ

Аливаа улс орон оршин тогтнох үндэс суурь нь төрийн бодлогын үзэл баримтлал улс орны сайн сайхны төлөө төлөвлөгдсөн, зарчимтай байхаас гадна дэлхийн хөгжлийн чиг хандлагыг даган цаг үетэйгээ хөл нийцүүлэн хувьсан өөрчлөгдөх чадвартай байх юм.

Эртний улсын эрх зүйн үндсэн шинжид гэмт хэрэг хэмээн тооцдог үйлдэл эс үйлдэхүй, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцооны зорилго ялтныг тарчлаах, хаад, ноёд өөрсдийн эрх ашгийн төлөө үнэ хөлсгүй хөдөлмөрлүүлж байсан нь одоогийн нийтэд тустай ажил хийх ялын зорилгын эсрэг үзэл баримтлалыг агуулж байсан байна. Мөн дахин гэмт хэрэг үйлдэх, ноёлогч ангийн эсрэг тэмцэл үймээн гаргуулахгүй байх зорилгоор хүнд хүчир ажил хийлгэж байх хугацаанд нь эд эрхтнийг нь гэмтээх бодлого баримталж байсан тухай түүхийн эх сурвалжид дурдсан

[1] (https://www.ncs.cd.gov.mn/, 2024

байна. Монгол улс төр эрх зүйн түүхэн хөржлийн явцад ард иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалахаас гадна нийгэмд гэмт хэрэг гарах нөхцөл шалтгааныг судалж, гэмт үйлдлээс иргэдийнхээ эрхийг хамгаалах чадвартай хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хянаж, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх бодлого түүхэн үе бүрд нийгмийн хувьсан өөрчлөлт, дэлхий нийтийн чиг хандлагыг даган тухай бүр өөрчлөн шинэчлэгдэж чадаж байсан нь өнөөгийн эрүүгийн хариуцлагын тогтолцоо бүрэлдэн тогтнох үндэс болжээ.

Төв азийн нүүдэлчдийн түүхийг өгүүлэх Хүннү улсаас МЭӨ 209 оноос Богд хаант Монгол улсын үе 1911 он хүртэл, Ардын хувьсгал ялж, Монгол улс тусгаар тогтносон бие даасан улс болж, үндсэн хуулиа тунхаглан батласан 1924 оноос одоогийн хэрэгжиж буй эрүүгийн хариулага хүлээлгэх ялын мөн чанар, зорилго, хэрэгжүүлэх арга зам харьцангуй дэвшилтэд замналыг туулан ирсэн гэж дүгнэж байна. Дээрх он цагийн ялын зорилгыг харьцуулахад хүний эрхийг хүндэтгэх, эрүүгийн харицлага хэн бүрд эрх тэгш үйлчлэх, ялын бодлогын үндсэн мөн чанар зэрэг олон асуудлууд харилцан адилгүй байгаа нь хөгжлийн явцад эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, гэмт явдалтай тэмцэх, эрх зүйн зохицууллатын үр нөлөөг өөрчлөлт шинэчлэлийн давалгаатай тодорхой цаг хугацаанд боловсруулах, зэрэг олон ач холбогдол бүхий харилцааг хөгжлийн чиг хандлагадаа шингээж чадсан байна гэж дүгнэж байна.

Мөн Хорихоос өөр төрлийн ялын үндэс суурь Хүннүд гэмт хэрэгтнийг бэрээдэх, хөрөнгийг хураах, хүнд хөдөлмөрт зүтгүүлэх, цаазаар авах шийтгэлийн дөрвөн төрөлтэй байсан[1] улсын үеэс эхлэлтэй бөгөөд эрх зүйн шинэтгэлийн явцад ялын зорилго өөрчлөгдөж, төрөл нэмэгдсэн.

Ардчилсан нийгэмд олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хүний эрхийг дээдлэх зорилгоор дотоодын эрүүгийн хуулийн ялын тогтолцоонд нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд хүнлэг, энрэнгүй байх, ял шийтгэл гарцаагүй байх цаашлаад улс орны эдийн засаг, ялтны хувийн байдлыг харгалзан үзэх нарийвчилсан эрх зүйн орчинг бүрдүүлж байгаагаараа онцлог хууль гэж үзлээ.

Монгол улсын ял шийтгэлийн бодлого нийгмээс тусгаарлаж хорих ял эдлүүлэхээс илүүтэй ялтныг нийгмийн орчинд гэмт хэрэг үйлдэхгүй байх хандлагыг төлөвшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх ёс

[1] Ж.Болдбаатар, Д.Түндээжанцан, Монгол улс төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997 он, 19 дахь тал

суртахууныг төлөвшүүлэх зорилгыг агуулж нийтэд тустай ажил хийлгэх ялын төрлийг илүүд үзэж байгаа нь сүүлийн жилүүдэд ялтны тоо өссөн дүнтэй байгаа нь харуулж байна.Судалгааны ажлын нийтэд тустай ажил хийлгэх ялын эрх зүйн зохиуццлалтыг сайжруулах боломжийг бий болгох үүднээс судлаачийн зүгээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны хувийн байдлыг дордуулж, нэг гэмт хэрэгт давхар хариуцлага хүлээлгэхгүй байх үүднээс тодорхой төрлийн эдийн засгийн бололжуудийг бий болгох
- Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэх байгууллагын жагсаалтыг шинэчлэн өөрчлөх
- Ялтны өөрийн амьдралын санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлдэг ажил хөдөлмөрөө алдахгүйгээр ял эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Ял эдлүүлж байгаа гэрээгээр үүрэг хүлээсэн байгууллагын

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Төрийн мэдээлэл, Т. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.
2. Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
3. А.Алтанзул. (2007). Албадлагын арга хэмжээ, ял. Улаанбаатар.
4. Г.Г.Ф.Гегель. (n.d.). Фильсофия прова.

---o0o---

ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ, ЭРХ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

TRADITION OF FIGHTING FRAUD CRIME, LEGAL ANALYSIS



П.Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хурандаа

Хураангуй: Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөх шалгах арга зүйн асуудлыг авч үзэхийн өмнө тухайн гэмт хэргийн мөн чанар, эрүүгийн эрх зүйн, криминалистик шинжлэх ухааны тодорхойлолтыг нарийвчлан үзэх нь чухал бөгөөд залилах гэмт хэргийн криминалистик тодорхойлолтыг судлахын тулд Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн хууль, тогтоомжуудын холбогдох зүйл, заалтыг судлан үзэх нь зүй ёсны хэрэг юм.

Abstract: Before considering methodological issues of specific crime investigation, to see in detail of definition of crime, criminal law, the description of criminalistics science is critical and in order to study fraud crime`s the description of criminalistics, Mongolia`s historical criminal law, norms, related matter, provisions is must.

Түлхүүр үгс: Залилах, Иргэний эрх зүйн гэрээний харилцаа, хуурах, зохиомол, нөхцөл байдал, сүсэг бишрэл, бодит байдлыг нуух, төөрөгдөлд оруулах, урьдын харилцааны явцад бий болсон итгэл, албан тушаалын байдал, ноцтой хохирол, амьдралын эх үүсвэр болгох

Key words: Fraud, contractual relationship of civil rights, cheat (trick), fictitious conditions, devotion, hide reality, to confuse, trust that built from previous relationships, position, major damage, to make source of life.

УДИРТГАЛ

Монгол Улсад 1921 онд Ардын хувьсгал ялж, ардын шинэ төр засаг тогтоон бэхжүүлэхийн зэрэгцээ ард ангийн эрх ашгийг илэрхийлсэн хувьсгалт хууль ёс, дэг журмыг хэвшүүлэн тогтоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрүүгийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж ирсэн түүхэн эх сурвалжаас харагддаг. Монгол Улсын анхдугаар их хурал 1924.11.8-нд нээгдэж улс орны тулгамдсан олон асуудал шийдвэрлэсний нэг нь анхны Үндсэн хуулийг 1924.11.26-нд баталж БНМАУ-гэж улсаа тунхаглан зарласнаар Монгол улсын эрх зүйн цоо шинэ тогтолцоонд шилжих түүхэн үе эхэлсэн байна[1].

1926.1.15-нд Монгол Улсын анхны Эрүүгийн хууль, буюу Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг, мөн оны 11 дүгээр сарын 11-нд тусгай ангийг батлан гаргажээ. БНМАУ-ын 1926 оны шүүх цаазын бичигт Монгол Улсын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан салбар хууль буюу Эрүүгийн хуулиар зохицуулалтыг зааж өгчээ. Шүүх цаазын бичгийн 1 дүгээр зүйлийн тайлбарт гэмт хэргийн ойлголтыг "Аливаа цааз хууль дор заасан эл явдлыг гэмт хэрэг дор тооцвоос зохино"[2] гэж анх удаа хуульчилж өгсөн юм. Уг хуулийн 30 дугаар бүлэгт хулгайлах, булаах ба дээрэмдэх зэргээр бусдын эд хөрөнгийг сүйтгэх нь хэмээн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчилсны дотор Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа залилан мэхлэх гэмт хэргийг хулгайлах, булаах, дээрэмдэх зэрэг гэмт хэргүүдээс тусад нь бие даасан байдлаар бүрэлдэхүүнийг тогтоон, оногдуулах ял шийтгэлийг тодорхойлж өгсөн байна.

Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 214 дүгээр зүйлд залилан мэхлэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан.Тухайлбал,

214 дүгээр зүйл: Ашгийг хичээж мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс 6 сараас 5 жил хүртэл гянданд хорино.

215 дугаар зүйл: Дээрх зүйлд дурдсан гэмт явдлын улмаас улсын ба ард олноор байгуулсан газруудын хөрөнгөнд сүйтгэл гаргаваас 1-7 жил

[1] БНМАУ-ын түүх. Уб., 1969. III боть. 215 дахь тал.
[2] И. Дашням, Д. Далайбаяр, нарын эмхэтгэсэн БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл (1926). Уб., 2002. 6 дахь тал.

хүртэл гяндан хорихоос гадна хөрөнгийг нь бүрэн буюу заримыг нь албанд хурааж болно.

216 дугаар зүйл: Энэхүү цааз бичгийн 214 дүгээр зүйлд дурдсан гэмт явдлыг үйлдэхэд айлган доромжлох зэрэг арга хэрэглэвээс 1-6 жил хүртэл гяндан хорино"[1].

Дээрх заалтуудаас үзэхэд тухайн үед залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг а/ашгийг хичээж; б/залилан мэхэлж; в/бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг; г/ашиглан шингээх гэсэн байдлаар тогтоож өгсөн байна.

1929 оны Шүүх цаазын бичигт. Шүүх цаазын бичгийн Тусгай ангийн 29 дүгээр бүлэгт Хулгайлах булаах ба дээрэмдэх зэргээр бусдын эд хөрөнгийг сүйтгэх нь хэмээн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг системчилсний 216, 217, 218 дугаар зүйлүүдэд залилан мэхлэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан байна.

216 дугаар зүйл. Ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс 5 жил хүртэл хормой.

217 дугаар зүйл. Дээрх зүйлүүд дор дурдсан явдлын улмаас ард олноор байгуулсан газрын хөрөнгөн дор сүйтгэл гарваас 1-7 жил хүртэл хорихоос гадна хөрөнгийг бүрэн буюу заримыг албан хурааж болмуй.

218 дугаар зүйл. Энэхүү цаазын бичгийн 216 дугаар зүйл дор дурдсан гэмт явдлыг үйлдэхүй дор дарлан доромжлох зэрэг арга хэрэглэвээс 1-6 жил хүртэл хормой"[2].

1934 оны Шүүх цаазын бичигт: "Эд хөрөнгийн гэмт хэргүүд" хэмээх 7 дугаар бүлгийн 143 дугаар зүйлд залилан мэхлэх гэмт хэргийг "...Бусдын мөнгө буюу эд хөрөнгийг ба эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар шилжүүлэн авсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино" гэж заажээ.

Тийнхүү бусдын эд хөрөнгийг эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар шилжүүлэн авах явдал үйлдсэнээс улсын ба олон нийтийн газруудад үлэмжхэн хохирол учруулсан бол 1-5 жил хүртэлх хугацаагаар хорих, хөрөнгийг бүрэн буюу заримыг нь хураах ял шийтгэвэл зохино. . ."3 гэж

[1] И.Дашням,Д. Далайбаяр, нарын эмхэтгэсэн БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл (1926). Уб., 2002. 14 дэх тал.
[2] Монгол Улсын Үндэсний төв архив. Ф-284. Т-1. х/н-610. 81 дэх тал.
[3] БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. Уб., 1934. 34 дэх тал.

нэг заалтад /143 дугаар зүйлд/ уг гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинжийг цуг хуульчилсан боловч, ялыг өөр өөрөөр тогтоосноор бүрэлдэхүүнүүдийг ялгах боломж бүрдүүлжээ. ..."Хэн хүн алив хутагт хувилгаан хэмээх нэрийг хэрэглэх буюу олгох зэргээр олныг мэхлэх..." /116 дугаар зүйл/, "...хүмүүсээс тусгай зүйлд итгэмжлүүлэхээр өгсөн...эд хөрөнгийг ашгийг хичээж, хувьд ашиглан шийтгэх, шамшигдуулах..."/142 дугаар зүйл/, "Цэргийн гавьяаны одон тэмдэг болон үйлдвэрийн гавьяаны одон тэмдгийг зүүх эрхгүй этгээд нараас зүүсэн..." /149 дүгээр зүйл/ зэрэг гэмт үйлдлүүдийг залилан мэхлэх гэмт хэргээс тусдаа бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан нь зүйлчлэлийн асуудал зохих түвшинд хүрсэн хүрсэн байна.

Залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд а/хорих, б/эд хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах ялыг шийтгэхээр заасан. Өөрөөр хэлбэл, хүндрүүлэх байдалтайгаар буюу залилан мэхлэх гэмт хэргийн улмаас улс, олон нийтийн газруудад үлэмжхэн хохирол учруулбал эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэхээр хуульчилжээ.

БНМАУ-ын 25 дугаар Бага хурлаас 1942.1.17-ны өдөр гаргасан тогтоолоор "БНМАУ-ын Эрүүгийн хууль"-ийг баталсан нь шинэ Үндсэн хуулийн агуулгад бусад хууль тогтоомжуудыг нийцүүлэх ажлын хүрээнд урьд хэрэглэж байсан Шүүх цаазын бичгийн (1934 оны) хүчин чадлыг дуусгавар болгож, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа "Эрүүгийн хууль" нэртэйгээр кирилл үсгээр хэвлэгдэж,[1]хүчин төгөлдөр мөрдөгдөх үндэс болжээ.Тус хуулийн "Эд хөрөнгөний гэмт хэргүүд" хэмээх 8 дугаар бүлгийн 178 дугаар зүйлд "Итгэснийг тэсрүүлэн бусдын мөнгө хөрөнгө буюу эрхийг авахын тулд санаатайгаар залилан мэхлэх аргыг хэрэглэвэл 3 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ. Бусдын эд хөрөнгө ба мөнгийг эзэмшин эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар авсныг улсын ба олон нийтийн газруудад алдагдал хохирлыг учруулсан байвал нэгэн жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорьж, хөрөнгийг бүрэн буюу заримыг хураавал зохино" гэж зааснаар залилан мэхлэх гэмт хэрэг нь өөрөө бие даасан гэмт хэргийн шинжтэй болохыг анхлан тодорхойлжээ. Энэхүү хуулиар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгсдэд хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар ял шийтгэж байжээ[2]. Мөн Эрүүгийн хуулийн 31 дүгээр

[1] Соёл гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол зааврууд ын системчилсэн эмхэтгэл. УБ.,1962. 6 дахь тал, ШУА-ийн мэдээ. УБ.1963. №3.66 дахь тал, МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд. Уб.,1985.боть 346 дахь тал.
[2] БНМАУ-ын Эрүүгийн хууль. -Уб.,1947

зүйлд зааснаар ашигт шунасан (Залилан мэхлэх) гэмт хэргийг үйлдэж хорих ялаар шийтгүүлэх тохиолдолд уг ялтны тэтгэвэр авах эрхийг хасах үндэслэл болдог байв.

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуулийн[1], тусгай ангийн "Иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэрэг" хэмээх V бүлгийн110 дугаар зүйлд Залилан мэхлэх гэмт хэргийг тодорхойлохдоо: а)Залилан мэхэлж итгэлийг эвдэх, замаар иргэдийн амины хөрөнгө буюу түүнийг эзэмших эрхийг авч ашиглавал 3 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.б)Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай буюу бүлэглэж буюу давтан үйлдсэн, эсхүл хохирогч этгээдэд их хэмжээний хохирол учруулсан бол хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах эсхүл хураахгүйгээр 7 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ",

114 дүгээр зүйл: Улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулсан, дээрэмдсэн, хулгайлсан, булаасан хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд залилан мэхлэх буюу шунахай зорилгоор далайлган сүрдүүлэх гэмт хэрэг үйлдвэл хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах буюу хураахгүйгээр 2-8 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ гэж тус тус заажээ.

1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн[2]127 дугаар зүйлд Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг залилан мэхэлж ашиглан шамшигдуулах гэмт хэргийг тодорхойлохдоо:

1. Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар авсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн зуугаас хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюултай рецитив гэмт хэрэгтэн хийсэн бол эд

[1] БНМАУ-ын хуулиуд. I. Уб., 1980. 63 дахь тал.
[2] БНМАУ-ын Эрүүгийн хууль. Уб., 1987.

хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

Тус хуулийн 5 дугаар бүлэгт Иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэргийг системчилж, 157 дугаар зүйлд дараах байдлаар залилан мэхлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан.

1. Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар иргэдийн амины эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас хохирогчид үлэмж хэмжээтэй хохирол учирсан уг үйлдлийг онц аюултай рецитив гэмт хэрэгтэн хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

Эрүүгийн хуулийн 127 дугаар зүйлд заасан социалист өмчийг залилан мэхлэх гэмт хэргийг 157 дугаар зүйлд заасан залилан мэхлэх гэмт хэрэгтэй харьцуулахад гэмт хэргийн бүрэлдэхүүн зөвхөн объектоороо л ялгагдан зүйлчлэгдэх бөгөөд, залилан мэхлэх гэмт хэргийн халдлагад социалист өмч өртвөл 127 дугаар зүйлээр зүйлчилж, ялын бодлого нь бүх заалтаар 157 дугаар зүйлээс хүндэрч заагдсан онцлог харагддаг.

Монгол улсад 1990-ээд оноос нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамарсан шинэчлэлт, өөрчлөлтийн уур амьсгал эрчимжиж, 1990 оны 9-р сард БНМАУ-ын АИХ-ын чуулганаар Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль батлан гаргасны 2 дугаар бүлэгт улсын эдийн засгийн үндсийг социалист аж ахуйн систем, үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээр өмчлөх социалист өмч гэж тодорхойлж байсныг хүчингүй болгож олон хэвшилт өмчтэй эдийн засгийг хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ заалт хожим 1992 оны шинэ Үндсэн хуульд тусгалаа олсон билээ. Үндсэн хуульд орсон энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу 1990 оны 12 дугаар сарын 28-нд “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдаж, хувийн болон нийтийн өмчийг гэмт халдлагаас адил тэгш хамгаалах явдлыг Эрүүгийн хуулийн нэг чухал зорилт болгожээ. 1986 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 3, 5 дугаар бүлгийн зүйлүүдийг нэгтгэж 3 дугаар бүлгийг өөрчлөн найруулсан билээ. 1961 оны Эрүүгийн хуулиас хойш улс, хоршоолол, олон нийтийн эд

хөрөнгө, иргэдийн амины эд хөрөнгө гэж Эрүүгийн хуулиар тусад нь ялгаатай хамгаалж байсан бол бусдын эд хөрөнгийг "Залилан мэхэлж ашиглан шамшигдуулах" гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 127 дугаар зүйлд хуульчилж, 157 дугаар зүйлийг хүчингүй болгожээ. Монгол Улсын Их хурлаас 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль” -ийг баталсан байна.Уг Эрүүгийн хуулийн тусгай ангийн "Өмчийн эсрэг гэмт хэрэг"-ийн 3 дугаар бүлгийн 127 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж ашиглан шамшигдуулах" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар хуульчилсан байна.

1 дүгээр хэсэг: Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар бусдын эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 25000-200000, хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2 дугаар хэсэг: Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жилээс 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 50000-500000 төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3 дугаар хэсэг: Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас бусдад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюултай гэмт хэрэгтэн хийсэн бол 5-15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1993 оны Эрүүгийн хуулийг практикт хэрэглэх явцад нэг мөр ойлголт өгөх үүднээс "Өмчийн эсрэг гэмт хэрэг"-ийг тайлбарласан УДШ-ийн бүгд хурлын тогтоолууд 1991, 1997 онуудад гарч байсны дотор залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг хэрхэн ойлгох талаар өгсөн албан ёсны тайлбарууд өнөөдөр ч эрүүгийн эрх зүйн онол практикт үнэ цэнээ алдаагүй байна.

1999.07.21-ний өдөр Монгол Улсын Их хурлаас 127.1 дүгээр зүйлд "Банкнаас авсан зээлийг төлөхөөс санаатайгаар зайлсхийж их хэмжээний хохирол учруулах" хэмээх гэмт хэргийг залилан мэхлэх гэмт хэрэгтэй төсөөтэй гэж үзэн шинээр хуульчилж, харьцангуй, хүнд ял оноохоор зааснаас гадна, тэр үед Эрүүгийн хуульд байхгүй зохицуулалт болох "учирсан хохирлыг нөхөн төлүүлж" гэсэн санкцыг суулгасан нь амьдралд төдийлөн тохиромжтой бус зөв шийдэл болж чадаагүй гэж судлаач үздэг. Энэ хуулиар залилан мэхлэх гэмт хэрэгт тэр дундаа улс, олон нийтийн эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэгт ял оногдуулахдаа харьцангуй хүндрүүлж тусгайлан авч үздэг байсан өмнөх хуулийн агуулга байхгүй

болсон нь нэг талдаа, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн ялын бодлого суларч, уг гэмт хэргийн гаралт нэмэгдэх нэг төрлийн нөхцөл болсон гэж үздэг.

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг гэсэн ойлголтыг анх удаа 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын Их хурлаас баталсан Эрүүгийн шинэ хуулийн тусгай ангийн 7 дугаар хэсэгт бие даасан байдлаар хуульчилсан нь Эрүүгийн хуулийн системчлэлд чухал хувь нэмэр оруулсан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийг тодорхойлсон эрүүгийн эрх зүйн гурван хэм хэмжээг шинээр хуульчлан тогтоосон байдаг.

148.1-д:Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэлх хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

148.2-т: Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалтан байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3-т:Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ .

Хууль тогтоогч дээрх зүйлийн I хэсэгт /148.1/ уг гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжийг, II хэсэгт /148.2/ энэ гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг, III хэсэгт /148.3/ дээрх 1,11 хэсгүүдэд заагдсан

гэмт хэргийг онц хүндрүүлэх шинжийг зааж өгсөн байна. Энэ байдлаас үзэхэд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг нь:

- үндсэн бүрэлдэхүүн

- хүндрүүлэх бүрэлдэхүүн

- онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэж үзэж болно.

Энэ хуулиар залилан мэхлэх гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжид уг гэмт хэргийг өмчийн эсрэг бусад гэмт хэргээс ялгагдах,залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэх хамгийн анхдагч ерөнхий объектив, субъектив шинжийг тодорхойлж өгсөн байдаг. Ингэснээрээ уг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авахад ялыг хүндрүүлж үзэх, үндсэн бүрэлдэхүүнээс нийгмийн хор аюулын хэр хэмжээгээр үлэмж их нөхцөл байдлуудыг хуульчилсан юм. Тухайн гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авахдаа онц хүндрүүлж үзэх буюу үндсэн, хүндрүүлэх бүрэлдэхүүнээс нийгмийн хор аюулаар онц их нөхцөл байдлыг тодорхойлж өгсөн байна. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг ялгавартайгаар тогтоосны гол учир холбогдол нь тухайн гэмт хэрэгт эрүүгийн эрх зүйн үүднээс үнэн зөв үнэлэлт дүгнэлт өгөх, амьдрал бодит байдалд янз бүрийн байдлаар үйлдэгдсэн тохиолдолд нийгмийн хор аюулыг оновчтой тодорхойлох тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн тус бүр эрх зүйн өөр өөр үнэлэмжийг төрүүлж байдагт оршино.

Монгол Улсад 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3 дэх хэсгийн 3.2-т "олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын арга" ашиглан бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эзэмших, өмчлөх эрхийг авах үйлдлийг залилах гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан ч мөрдөгч, прокурор, шүүгчдийн хувьд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэх шинэлэг байдалтай байгаа билээ.

Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл, Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй[1]. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн

[1] Монгол Улсын Үндсэн хууль. Уб., 1992

өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө", "Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй"[1] гэж заасан нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объект болно.

Халдлагын зүйл нь бусдад залилагдсан эд хөрөнгө байна. Бусдын эд хөрөнгө гэж Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд тодорхойлсон өөр этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа эд юмсыг ойлгоно. Энэ гэмт хэргийн обьектив тал нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан идэвхтэй үйлдэл байна. Залилах гэмт хэргийг хохирлын хэмжээ шаардахгүй, хэлбэрийн шинжтэйгээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авснаар гэмт хэрэг төгсдөг байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт залилах гэмт хэрэг гүйлдэх аргыг заасан учраас обьектив талын үндсэн шинжийг илэрхийлж, гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд энэ гэмт хэргийг хуурах, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах аргаар үйлдсэн байна.

Гэмт хэргийн обьектив талын шинж болох үйлдлийн аргыг диспозицид дэлгэрэнгүй заасан нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэрэг, иргэний эрх зүйн зөрчлөөс ялгагдаж байна.

Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан гэж хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийг төөрөгдүүлсний үндсэн дээр түүний зөвшөөрлийн дагуу хариу төлбөргүйгээр, бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн өмчлөлд хууль бусаар авах үйлдлийг хэлнэ.

Хуурах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр, үйлдлээр эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх, өмнөх харилцаанд тулгуурлан итгэл эвдэхийг ойлгоно.

[1] Иргэний хууль. Уб., 2002

Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хуурамч бичиг баримт, эд зүйл, цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, техник хэрэгсэл ашиглах, тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргийг ойлгодог.

Дээр дурдсан тайлбараас... Цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, техник хэрэгсэл ашиглах гэсэн заалт нь бидний авч үзэж байгаа цахим орчинд залилах гэмт хэрэгт шууд хамааралтай учир тэдгээрийн талаар болон мөн тэдгээрт шууд хамааралтай бусад ойлголтууд тус бүрд нь нарийвчилсан тодорхойлолт өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Үүнд: компьютер гэж өөрийнх нь үйлдлийг зохицуулах үүрэгтэй программаар тодорхойлогдсон удирдлагын дор мэдээллийг боловсруулах автоматчилагдсан үйлдэл гүйцэтгэгч төхөөрөмжийг хэлнэ.[1]

Компьютерын дагалдах төхөөрөмжүүд гэж хамтарсан байдлаар өгөгдлүүдтэй хавсран ажиллах төрөл бүрийн үүрэг, зориулалт бүхий бүрдэл хэсгүүд- (хувилагч болон дамжуулагч төхөөрөмжүүд, мэдээлэл тээгч бие даасан хэрэгсэл, төхөөрөмжүүд) гэх зэргийг ойлгоно.[2]

Компьютерын сүлжээ гэдэгт компьютеруудын өөр хоорондын холбоос эсвэл тооцоолох төхөөрөмж (жишээ нь серверүүд), компьютер хоорондын холбоосыг ойлгоно. Компьютерын программ буюу программ хангамж гэдэг бол тооцоолох төхөөрөмжид зориулагдсан үйлдлийн дэс дарааллын зааварчилгаа мөн.[3]

Өгөгдлийн урсгал гэж дээр нэр дурдсан сүлжээ, эсвэл дагалдах төхөөрөмжүүдээр шилжин байршиж байгаа, боловсруулагдаж байгаа мэдээллүүдийг нэрлэнэ.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нэгэн төрөл болохынх нь хувьд залилан мэхлэх гэмт хэргийн тухайд хэрэглэгч гэдэгт нэг талаас

---

[1] Оросын Их нэвтэрхий толь бичиг. 30 дугаар боть. .Ред. Кравец С.Л. -М. 2009. С.52-59.

[2] НҮБ-ын “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрхзүйн зарчил гаргагчидтай хэрхэн харьцах тухай” 10 дугаар Чуулганы материалууд. 5 дугаар зүйл. Вена. 2000 оны 04 сарын 10-17. A\CONF 187\10

[3] Тушканова,О.В. Терминологический справочник судебной компьютерной экспертизы. Справоч.пособие. М. 2005. С.109.

хохирогч тал гэмт санаа зорилгоор ашиглагдаж байгаа компьютер өгөгдөл эсвэл мэдээллийн бүрэлдэхүүн, нөгөө талаас мөнхүү гэмт хэргийг үйлдэж буй этгээдийг тус тус ойлгоно.

Зохиомол байдлыг зориудаар бий болгох гэж эд хөрөнгийн эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх, хууран мэхлэхийн тулд зохиомол байдлыг зориуд бий болгохыг ойлгоно.

Сүсэг бишрэлийг далимдуулах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хохирогчийн сүсэг бишрэл, шашны итгэл үнэмшлийг ашиглан төөрөгдүүлэхийг ойлгоно.

Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах гэж дампуурсан ажиллагаа нь зогссон, доголдсон, санхүүгийн алдалтай, хөрөнгө оруулалт шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авахыг ойлгоно.

Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж гэдгийг шууд ойлгож, хэрэглэнэ.

Залилах гэмт хэргийн субьектив шинж нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субьектив санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон байдгаараа залилах гэмт хэрэг нь гэрээний эрх зүйн маргаанаас ялгагдана.

Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинж: Албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн гэж хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээний үндсэн дээр олгогдсон албаны бүрэн эрх, албан тушаалын байдлаа бусдыг залилж, түүний эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлэн авах гэмт үйлдэлдээ давуу тал болгон ашигласан байхыг ойлгоно[1].

Бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсан, эсхүл тавин мянган нэгжтэй

[1] Эрүүгийн хууль. Уб., 2015, 7 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг

тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсныг ойлгоно.

Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж залилах гэмт хэргийг гурав ба түүнээс дээш удаа үйлдэж олсон хууль бус орлогоороо өөрийгөө болон гэр бүл, бусдыг тэжээн тэтгэж байгаа явдлыг ойлгоно.

Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон аж ахуйн үйл ажиллагаа явуулах замаар үйлдсэнийг ойлгоно. Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйвар гэж бусдыг элсүүлэх эрх олж авахын тулд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардан, бусдыг элсүүлсний төлөө мөнгө өгөх бизнесийн хууль бус үйл ажиллагааг хэлнэ. Энэхүү хууль бус үйл ажиллагаа нь нэгдүгээрт бараа, бүтээгдэхүүн дээр суурилж, бараа эргэлтэд анхаардаг олон шатлалт маркетингийн арга бөгөөд хүн элсүүлж, сүлжээ үүсгэн, бараагаа олон хэрэглэгчид хүргэх зорилготой байдаг бол хоёрдугаарт, гарт баригдах бодит эргэлтгүй боловч их мөнгө амлаж, хүн элсүүлдэг пирамид тогтолцооны луйвар тус тус хамаарна. Хүндрүүлэх шинжид энэ үйлдлийн аргыг хуульчилсан нь практикт түгээмэл үйлдэгдэж, иргэдэд их хэмжээний хохирол учруулдаг "Сүлжээний луйвар"-тай тэмцэхэд ач холбогдолтой.

Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэж гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдэл үйлдсэнийг ойлгоно.Тайлбар, зүйлчлэл:

• Залилах гэмт хэрэг бусад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тухайлбал, хулгайлах, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах гэмт хэргээс өмчлөгч хууртагдан итгэсэн учраас гэмт этгээдэд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ сайн дураараа өгсөн байдгаараа ялгаатай.

• Залилах гэмт хэргийн тухайд гэмт этгээд анхнаасаа бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авааД буцаан өгөхгүй, өмчлөх эрхийг сэргээхгүй байх санаа зорилготой байх бөгөөд ингэхийн тулд өмчлөгчийг хууран мэхэлж, төөрөгдүүлсний улмаас эд хөрөнгө, эд хөрөнгийг эрхийг шилжүүлэн авсан байна.

• Гэрээний харилцаа нь Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсэж, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас

үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл, гэрээний эрсдэлийг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж, бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн бол залилах гэмт хэргээр зүйлчилнэ.

• Байгалийн давагдашгүй хүч, нийгэм, эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилах гэмт хэрэг гэж үзэхгүй.

• Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх арга дээр үндэслэгдсэн, шунахай сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрх, харилцан тодорхой үр дүнд хүрэхийн тулд хийгддэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, үүнийгээ гэрээний нэг тал урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал хохирогч нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилах гэмт хэрэг гэж үзнэ.

Бусдыг эд хөрөнгийг зээл нэрээр халхавчлан залилах нь уг зээлийг буцаах төлөх бодит баталгаагүй, тухайлбал, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь байлаа ч гэсэн эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, түүнчлэн, Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээр иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагдана.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Залилах гэмт хэрэг болон иргэний эрх зүйн маргааны ялгаатай болон төсөөтэй талуудыг авч үзвэл. Үүнд:

Ялгаатай төсөөтэй шинж	Залилах гэмт хэрэг	Гэрээний харилцаанаас үүссэн маргаан	Тайлбар

		(зөрчил)	
Объект	Бусдын өмчлөх эрх	Эд хөрөнгийн сонирхол	---
Халдлагын зүйл	Эд хөрөнгө, мөнгө	Мөнгө, эд хөрөнгийн эрх, анз, олох байсан орлого	---
Объектив тал	Хуурах, төөрөгдүүлэх, Итгэл эвдэх аргаар бусдын өмчлөлийн эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар шилжүүлэн авсан үйлдэл	Гэрээгээр хүлээсэн үүргээ зохиох ёсоор биелүүлэхгүй үйлдэл, эс үйлдэхүй	---
Субъект	16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай хувь хүн	Хувь хүн, хуулийн этгээд байх болно.	---
Хохирол	Ердийн бүрэлдэхүү--ний хувьд хохирол шаардахгүй	Мөнгө, эд хөрөнгийн эрх, анз, олох байсан орлого	Шууд бус Хохирол тооцдог эсэхээрээ ялгаатай.
Субъектив тал	Хариу төлбөргүйгээр,	Ашиглан	Субъектив санаа

	өөрийн өмчлөлд авч буйгаа мэдэж, түүнийг хүсэж үйлдсэн гэм буруугийн шууд.санаатай хэлбэртэй,шунахай сэдэлтэй.	шамшигдуулах шинжгүй	зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлэхээсээ өмнө бий болсон. (Дурдсанаас бусад тохиолдол)
Хариуцлага харилцааны онцлог	Төр давуу эрхтэй буюу гэмт этгээдэд хүлээлгэж оролцоно.	Оролцогч талууд тэгш эрхтэй оролцоно.	---

Эрдэмтэн, судлаачдын бүтээлд шашинтай холбоотойгоор хүнийг хуурч залилсан болон сүсэг бишрэлийг далимдуулах гэж тайлбарладаг. Уг үйлдлийг аргаар үйлдсэн хэрэг одоогоор бүртгэгдээгүй байна.

Дампуурсан, үйл ажиллагаа нь зогссон, доголдсон, санхүүгийн алдагдалтай, хөрөнгө оруулалттай шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгийн өмчлөх эрхийг шинжлүүлэн авч бусдыг төөрөгдөлд оруулсан 131 хэрэгт шийдвэрлэсэн хэргийн судалгаа.

Залилах гэмт хэргийг ах, дүү, эцэг, эх, хамаатан садан, танилын хүрээгээ ашигласан үлдэлтэй 87 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна[1].

	Үйлдлийн арга	Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
	Хуурч	349	41 хувь

[1] Я. Батханд Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, боловсронгуй болгох арга зам. хууль зүйн докторын диссертаци. Уб., 2022. 95 дахь тал

	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	117	14 хувь
	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	161	18 хувь
	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0 хувь
	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	138	17 хувь
	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	87	10 хувь

Эрүүгийн хуулийн тусгай 17.3 дахь хэсгээр шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн 293 магадлалд дүн шинжилгээ:

	Үйлдлийн арга	Шинжилсэн хэрэг	Эзлэх хувь
	Хуурч	127	43 хувь
	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	48	16 хувь
	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	57	19 хувь
	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0 хувь
	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	39	13 хувь
	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	22	8 хувь

Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн УДШ-ийн 185 дугаар тогтоолд дүн шинжилгээ хийхэд:

№	Үйлдлийн арга	Шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
1	Хуурч	111	60 хувь

2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	18	9 хувь
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	21	11 хувь
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0 хувь
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	24	13 хувь
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	11	6 хувь

Залилах гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн практик болон шийдвэрлэлтийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор хууль сахиулах байгууллагын алба хаагчдаас анкетын аргаар судалгаа авахад:

Судалгаанд хууль сахиулах байгууллагын 200 ажилтан, албан хаагчид хамрагдсан бөгөөд тэдний 28 хувь нь прокурорын байгууллагын прокурор, 27 хувь өмгөөлөгч, 22 хувь нь Авлига, тагнуул, цагдаагийн байгууллагын мөрдөгч, 21 хувь шүүгч, 2 хувь эрдэм шинжилгээний ажилтан, бусад албан хаагч эзэлсэн байна. Судалгаанд хамрагдсан оролцогчдын 88 хувь нь залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан, ихэнх тохиолдолд хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгож, цахим хэрэгсэл ашиглаж, гэрээгээр халхавчилж залилах гэмт хэрэг үйлддэг байна.

Залилах гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад 53 хувь нь олон улсын гэрээ, конвенцыг судлах, гэмт хэргийн бодит хохирлыг нарийвчлан тооцох аргачлалыг бий болгох шаардлагатай байна.

Хүн, хуулийн этгээдийн эрх зүйн мэдлэг тутмыг байдал нь гэрээгээр халхавчилсан залилах гэмт хэргийг бий болгоход хүргэх нэг шалтгаан болж байна.

Залилах гэмт хэргийн хохирлын хэмжээг эрүүгийн хуульд нарийвчлан тогтоох шаардлагатай эсэхийг тодруулахад 90 хувь нь онц их хэмжээг нэмж оруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Залилах гэмт хэрэг үйлдэгдэгчдийн арга нь улам бүр нарийсаж Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн шинжүүдээр хязгаарлагдахгүй, тохиолдолд хууль бус аргаар үйлдэгдэж байх тул шийдвэрлэхэд хүндрэлтэй нь судалгааны явцад тогтоогдсон байна.

---o0o---

ГАЛТ ЗЭВСГИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ЯЛ, ОНЦЛОГ

PUNISHMENT AND CHARACTERISTICS OF CRIMES RELATED TO ILLEGAL TRAFFIC OF FIREARMS

Ц.Очгэрэл
ДХИС-ийн докторант, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Эрдэм шинжилгээний өгүүлэлд галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ялын ойлголт, түүний онцлогийг нээн гаргав.

Түлхүүр үг: галт зэвсгийн хууль бус эргэлт, хууль зүйн хариуцлага, эрх зүйн позитив буюу эергүү хариуцлага, эрх зүйн негатив буюу сөргүү хариуцлага, эрүүгийн хариуцлага, торгох ял, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял.

Галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ялын тухай асуудлыг хөндөхийн өмнө хууль зүйн хариуцлагын ойлголтыг авч үзэх шаардлагатай гэж бид үзэв. Хууль зүйн хариуцлага нь эрх зүйн мөн чанар, түүний чиг үүрэг, зарчим, нийгмийн зорилгыг илүү тодорхой илэрхийлнэ. Хууль зүйн хариуцлага гэсэн ойлголт нь олон талт, нарийн төвөгтэй байдлаараа эрх зүйн зөрчил, эрх зүйн хэм хэмжээ, төрийн албадлага, эрх зүйн харилцаа, эрх зүйн хэрэглээ, эрх зүйн зан үйлтэй илүү нягт холбоотойгоор тайлбарлагдах бөгөөд энэ шинж нь өнөө цагийн Монгол Улсад эрх зүйн онол болон хууль зүйн шинжлэх ухааны хоёр хандлагыг тодорхойлж байна.

Эхний хандлагыг баримтлагчид нь хууль зүйн хариуцлагыг эрх зүйн зөрчлийн шууд үр дагавар гэж үздэг бол, нөгөө нэг хэсэг нь түүнийг эрх зүйн хариуцлагатай холбож үзэх төдийгүй, мөн ирээдүйн үйл ажилтай холбон үзэж байна[1].

Эрх зүйн негатив буюу сөргүү хариуцлага нь санкцын хэрэгжилт; төрийн албадлагын арга хэмжээ; ял (шийтгэл); эрх зүйн зөрчилд нийгмээс үзүүлэх хариу үйлдэл, эрх зүйн зөрчлөөс урган гарсан хууль зүйн үүрэг,

[1] Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. -Уб., 2021. 370 дахь тал.

өөрийн зан үйлийн төлөө хүлээж буй үүрэг; албадлагын нөлөөллийн арга хэмжээг хүлээх чадвар; нийгэмд аюултай үзэгдэлд өгөх үнэлэмж болон түүнийг үйлдсэн этгээдийг буруутгах хэлбэр гэж ойлгож байна.

Мөн эергүү буюу позитив хариуцлагыг авч үзэх өөр хандлага бас бий. Энэ хариуцлагыг үүргийн ухамсар, үүргийн мэдрэмж, хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг болон тухайн үүргийн хэрэгжилт, мөн түүнчлэн урамшууллын арга хэмжээг хэрэглэх нөхцөл гэж ойлгож байна[1].

Эрүүгийн хариуцлага нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл юм. Монголын эрүүгийн эрх зүйн мэргэжилтэн, судлаачид хууль зүйн хариуцлага, түүний дотор эрүүгийн хариуцлага гэж юу болох талаар дээр дурдсаны дагуу хоёр өөр хандлагыг баримталж байна.

Дээрх хандлагуудтай холбоотойгоор эрүүгийн хариуцлагыг ялтай адилтгаж үзэх, эсвэл эдгээр нь хоёр өөр зүйл гэж үзэх байр суурь зонхилж байна.

Проф. Г.Совд эрүүгийн хариуцлагыг «төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх олон талт ажиллагааны хамгийн хүнд, тусгай арга хэмжээ, тодорхой субьектын хувьд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний үр дагавар болгон эрхийн байдалд нь урт хугацаагаар нийгмээс тусгаарлах, түүгээр ч барахгүй амьд явах эрхэнд нь халдах хүртэл хязгаарлалт тогтоож байгаа явдал» [2] гэж тодорхойлсон нь үндсэндээ эрүүгийн хариуцлагыг ялтай адилтган үзсэн гэсэн үг юм.

Проф. С.Жанцан эрүүгийн хариуцлагыг «гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд эрүүгийн хуулийн хэм хэмжээг хэрэглэсний үр дүн, эрх зүйн үр дагавар гэж явцуу утгаар тодорхойлж болох юм»[3] гэж үзсэн нь дээрх байр суурьтай ижил байгааг харуулж байна.

Харин акад. С.Нарангэрэл эрүүгийн хариуцлагыг «гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн хэргээ эрүүгийн хуулийн дагуу хариуцах үүрэг, түүний бодит хэрэгжилт» гэж үзсэн нь анхаарал татаж байна.

---

[1] Мөн тэнд. 371 дэх тал.
[2] Совд, Г. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. -Уб., 2002. 59 дэх тал.
[3] Жанцан, С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (Ялын тухай сургаал). II боть. -Уб., 2004. 104 дэх тал.

Акад. С.Нарангэрэл, проф. Ж.Эрдэнэбулган нар [1] эрүүгийн хариуцлагын онцлог шинжийг дараах байдлаар тоймлож үзсэн байна:

1) Эрүүгийн хариуцлага нь юуны өмнө үйлдсэн гэмт хэргээ хариуцах тухайн этгээдийн хүлээх үүрэг бөгөөд энэ үүргийн хэрэгжилтийг төр, тусгай (хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүх зэрэг) байгууллагаараа дамжуулан хангана. Гэмт хэрэг илрээгүй байсан ч гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацаа үйлчилнэ.

2) Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой хэлбэрийн журамлал (процедур)-ыг буй болгож хэрэглэхийг шаардана.

3) Эрүүгийн хариуцлагын агуулга нь гэм буруутай этгээдийг үйлдсэн гэмт хэрэгт нь буруутгаж, түүний эрх, эрх чөлөөнд албадан хязгаарлалт тогтооход оршино. Энэ нь юуны өмнө үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан таслан сэргийлэх албадлагын арга хэмжээ (хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэх, түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, барьцаа авах, цагдан хорих зэрэг) авах, дуудан ирүүлэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах зэргээр илэрнэ. Хэрэв шүүх ял ногдуулбал ял шийтгүүлэгч ногдуулсан ялын агуулга болсон эрх, эрх чөлөөнд тогтоосон хязгаарлалтыг амсаж, түүнийг даван туулах зайлшгүй шаардлагыг үүсгэнэ.

4) Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийн үйлдсэн үйл, гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй болох нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага нь ял ногдуулахгүй байх (эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх) болон ял ногдуулах хоёр хэлбэрийн аль нэгээр бодитой хэрэгжинэ.

5) Ял ногдуулсан тохиолдолд ял эдэлж ялтай хугацаа дууссаны дараа эрүүгийн хариуцлагын асуудал сая эцэслэгдэнэ.

6) Эрүүгийн хариуцлага нь нийгмийн шударга ёсыг тогтоох, гэмт халдлагаас хамгаалах, шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэн чухал хэрэглүүр болно.

---

[1] Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж
(Нэгэн сэдэвт бүтээл). -Уб., 2019. 30 дахь тал.

Монгол Улсын Эрүүгийн хуульд (2015) эрүүгийн хариуцлага ба ялын ялгааг нарийвчлан тусгаж чадаагүйгээс улбаалж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг Эрүүгийн хуульд зөв томьёолж чадахгүй болж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх институтыг цуцлахад хүргэсэн байдаг[1].

Гадаад орны эрүүгийн эрх зүйн ном бүтээлүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд эрүүгийн хариуцлагын агуулга, мөн чанар чухам юу болох талаар эрдэмтэн, судлаачдын байр суурь зөвхөн дээр дурдсан хоёр хандлага, тухайлбал, 1) эрүүгийн хариуцлага ял шийтгэл хоёр ижил агуулгатай; 2) эрүүгийн хариуцлага нь үйлдсэн хэргээ хариуцах тухайн этгээдийн үүрэг; зэргийг оруулаад өөр хэд хэдэн үзэл баримтлал байгаа болох нь бидний судалгаанаас тодорхой боллоо. Эдгээр нь:

- эрүүгийн хариуцлага ял шийтгэл хоёр ижил агуулгатай;
- эрүүгийн хариуцлага нь үйлдсэн хэргээ хариуцах тухайн этгээдийн үүрэг;
- эрүүгийн хариуцлага нь ял шийтгэлтэй холбоотой цээрлэлийг үүрэх үүрэг
- эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэний улмаас түүнд оногдуулсан шийтгэлтэй холбоотой эрх зүйн байдал
- эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэгтэнд төрийн нэрийн өмнөөс шүүхийн яллах тогтоолоор хүлээлгэж буй гэсгээл
- эрүүгийн хариуцлага нь эрүүгийн эрх зүйн харилцаа мөн бөгөөд талууд нь нэг талаас төр, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн этгээд байна.

Эдгээр үзэл баримтлал, хандлагуудтай холбоотойгоор проф. А.И.Рарор эрүүгийн хариуцлагыг «энэ нь гэмт хэрэг үйлдсэний төлөө, үйлдсэн хэргээ хүлээж шүүхийн өмнө зогсох гэмт этгээдийн үүрэг, гэмт этгээдийг болон түүний гэмт үйлдлийг шүүхийн тогтоолоор төрийн нэрийн өмнөөс буруутгах гэсгээл, оногдуулсан ял болон эрүүгийн эрх зүйн албадлагын бусад арга хэмжээ, түүнчлэн ялтай байдал зэрэг хэд хэдэн элемент, бүрдэл хэсгээс үүссэн иж бүрэн ойлголт мөн юм» [2] гэж тодорхойлсонтой бид санал нэгдэж байна.

[1] Мөн тэнд. 31 дэх тал.
[2] Уголовное право России. Части Общая и Особенная: учебник (Под ред. А. И. Рарога). - М., 2008. С. 47.

Дээрх тодорхойлолтоос үзэхэд «эрүүгийн хариуцлага» гэх ухагдахуун нь ял (шийтгэл) гэсэн ухагдахуунаас илүү өргөн хүрээтэй, нэг нь нөгөөгөө агуулгадаа багтаасан өргөн хүрээтэй, иж бүрэн ойлголт мөн болохыг бид харж байна.

Харин ял (шийтгэл) бол шүүхийн тогтоолоор томилж буй төрийн албадлагын арга хэмжээ мөн юм. Гэмт хэрэг үйлдсэн буруутай болох нь тогтоогдсон этгээдэд ялыг хэрэглэх ба энэ нь тухайн этгээдэд Эрүүгийн хуульд тусгасан эрх, эрх чөлөөг нь хасах, хязгаарлах байдлаар хэрэгжинэ. Нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоох, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх, шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ялыг хэрэглэнэ.

Ял нь дараах үндсэн шинжтэй:

1) Ял нь эрүүгийн хуулиөр тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ;

2) Ялыг төрийн нэрийн өмнөөс шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулна;

3) Ялыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд (санаатай болон болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдсэн) хэрэглэнэ;

4) Ялын мөн чанар нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөөг хуульд заасны дагуу хасах болон хязгаарлахад оршино;

5) Хуульд заасан журмын дагуу ялыг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад ялын зорилгыг тодорхойлсон бөгөөд энэ нь:

- Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх;
- Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх;
- Хохирлыг нөхөн төлүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх явдал юм.

Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх заалтад ялын төрлийг заажээ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:

1.1. торгох ял;

1.2. нийтэд тустай ажил хийлгэх ял;

1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;

1.4. хорих ял;

1.5. эрх хасах ял.

Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн ялд хамааруулна. Харин торгох, эрх хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэж болно.

Ял нь галт зэвсгийн хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн чухал хэрэглүүр гарцаагүй мөн бөгөөд уг төрлийн гэмт хэргийг үйлдсэний төлөө хүлээлгэх төрийн албадлагын арга хэмжээ гэдэг утгаараа түүнийг оновчтой тогтоох, зөв хэрэглэх асуудал нэн чухал, тулгамдсан зүйл болоод байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.4 дүгээр зүйл (Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших) гэмт хэргийн ялыг «байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж тогтоожээ.

Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалтад торгох ялын ойлголтыг дараах байдлаар өгсөн байна:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгж (цаашид «нэгж» гэх)-тэй тэнцүү хэмжээгээр мөнгөн торгууль оногдуулахыг торгох ял гэнэ.

2. Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

3. Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

4. Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

5. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

6. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг торгох ялаар солихгүй.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд хорих ялын ойлголтыг дараах байдлаар өгсөн байна:

1. Гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад байлгахыг хорих ял гэнэ.

2. Нээлттэй, хаалттай хорих байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно.

3. Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнийг зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад тусгаарлаж хугацаатай хорих ялыг эдлүүлнэ.

Хорих ял бол Монгол Улсын эрүүгийн хуульд заасан үндсэн бөгөөд ялын хамгийн хатуу төрөл юм. Энэ ялын агуулга нь ялтныг олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, тодорхой дэглэм бүхий хорих тусгай байгууллагад эрх чөлөөг нь хасах болон хязгаарлахад оршино.

Проф. С.Жанцан «Хорих ял нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, ялтанд эрхийн хязгаарлалтаар дэмжсэн хатуу цээрлэл амсуулах, ялтнаас дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа зарим тогтворгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл юм»[1] гэж үзсэн байна.

Монголын шүүн таслах ажлын практикт 10 жилийн байдлаар дунджаар нэг жил тутамд гэм буруутай 8000 шахам этгээдэд хорих (баривчлах ялыг оруулан) ял оногдуулж иржээ. Энэ нь нэг жилд нийт ял шийтгүүлэгсдийн 90 шахам хувийг эзэлж байна.

Хорих ялыг хугацааг манай улсын өмнөх эрүүгийн хууль тогтоомжид үндсэн болон тусгай хугацаа хэмээн тогтоож ирсэн нь нэг талаар нийгмийн аюулаар их биш гэмт хэрэгт хорих ялыг болж өгвөл хэрэглэхгүй байх, нөгөө талаар нийгмийн аюулаар их гэмт хэрэгт ялын бодлогыг сулруулахгүй байлгах шинжлэх ухааны үндэслэгээний тусгал юм. Тухайлбал, 1961,1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд зургаан сараас 10 жил, 2002 оны Эрүүгийн хуулиар хорих ялын үндсэн хугацааг нэгээс арван таван жил байхаар тогтоож байжээ[2].

[1] Жанцан, С. Ялын тухай сургаал. 198 дахь тал.
[2] Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. 704 дэх тал.

Харин 2015 оны Эрүүгийн хуулиар хорих ялын хугацааг зургаан сараас хорин жил хүртэл байхаар, хорих ялыг нээлттэй ба хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр заасан.

Хорих ял нь яллагдагчийн эрхийг хатуу чангаар хязгаарлахын сацуу, нийгмийн тодорхой сөрөг үр дагаврыг (нийгэмд харш харьцаа үүсгэх, гэмт орчны дадал зуршилд суралцах, гэр бүлийн материаллаг байдал дордох, салж сарних зэрэг) өөртөө тээж байдгийн хувьд илүү цээрлүүлэх нөлөөтэй. Ийм тул хорих ялыг яллагдагчийг хүмүүжүүлэх, ял шийтгэлийн зорилгыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд л хэрэглэх ёстой юм.

Галт зэвсгийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл нь Монгол Улсын хууль тогтоомжоор харьцангуй хүнд биш гэж үзэж болохоор байдаг.

Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан (20.4) гэмт хэрэгт нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар, Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан (хохирогч нас барсан бол) (20.6.2) гэмт хэрэгт хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилсан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.5 дугаар зүйл (Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх) гэмт хэргийн ялыг «Галт зэвсэг, түүний бүрдэл хэсгийг хууль бусаар бэлтгэсэн, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар бэлтгэсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж тогтоожээ.

Мэргэжилтнүүд галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын хувьд бусад бүрэлдэхүүнээс, тухайлбал, галт зэвсгийг олж авах, шилжүүлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, илгээх үйлдлүүдээс илүү аюултай болохыг анхааруулж байна. Галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх үйлдэл нь энэ төрлийн бусад гэмт хэргийг үйлдэх үүд хаалгыг нээж өгдөг гэж онцлогийг нь тодорхойлжээ. Тийм болохоор Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид галт зэвсгийг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийг хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй байлгах,

эдгээрт оногдуулах ялыг ялгамжтай, сонголттой байхаар хуульчлах шаардлагатай гэсэн саналыг бид дэвшүүлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.6 дугаар зүйл (Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах) гэмт хэргийн ялыг «байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» (20.6.1.) гэж заасан.

2.Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» (20.6.2.) гэж ялын хэмжээг зааж өгсөн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг (Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг)-т тусгасан Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших (28.7) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; хүндрүүлэх бүрэлдэхүүнд нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (28.8) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих (28.9) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; хүндрүүлэх бүрэлдэхүүнд хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээ заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг (Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг)-т тусгасан Террорист үйлдэл хийх (29.8) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр заасан.

Харин Террорист үйлдэлд бэлтгэх (29.9) гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байна.

Террорист үйлдэл хийх, Террорист үйлдэлд бэлтгэх гэмт үйлдлүүдийн тухайд эдгээр нь нийгэмд учруулах хор аюулаараа асар их байдаг тул ял шийтгэл нь мөн их байгаа юм.

Монгол Улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II Протоколд нэгдэж орсон, 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр уг баримт бичгийг соёрхон баталсантай холбогдуулан цаазаар авах ялыг бүрмөсөн халсан билээ. Энэ Протоколын 1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт «Энэхүү Протоколд нэгдэн орсон аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд хэнийг ч цаазалж үл болно»[1] гэж заажээ. Үүнтэй уялдуулан 2015 онд Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг цуцалж, түүний оронд бүх насаар нь хорих ялыг шинээр бий болгосон юм.

Бүх насаар нь хорих ялын агуулга нь хугацаатай хорих ялын нэгэн адил ялтныг олон нийтээс тусгаарлахад оршино. Хорих ялын нэгэн төрөл болсон энэ ялын их хатуу чанга байдал нь нэгдүгээр, ялын хугацаа байхгүй, хоёрдугаарт, ял эдлүүлэх онцгой нөхцлөөр хангагдах байдлаар илэрнэ.

Бүх насаар хорих ял эдэлж буй этгээдийг хаалттай хорих байгууллагын онцгой дэглэмд эдлүүлж, аюулгүй байдлын чангатгасан арга хэмжээ хэрэглэх шаардлага зайлшгүй үүснэ. Монгол Улс яваандаа цаазаар авах ялыг бүрэн цуцлах нь зайлшгүй мучраас түүний бэлтгэл болгож цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд хугацаагүй хорих ялаар солих тухай нэмэлтийг 1993 оны 6 сарын 7-ны өдрийн хуулиар оруулсан юм. Үүнийг акад. С.Нарангэрэл «бүх насаар нь хорих ял» биш гэж үзсэн байна. Хугацаагүй хоригдож буй этгээд гучаас доошгүй жил хорих ял эдэлсний дараа нийгэмд аюулгүй болсон онцгой тохиолдолд түүнийг ялаас чөлөөлөх асуудлыг шүүх шийдвэрлэдэг байсан. 2002 оны Эрүүгийн хууль батлагдсаны дараахан Д.Дэмбэрэлцэрэн «Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ялын тухай бүлгийн нэг дэвшилттэй заалт нь Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд уучлал

[1] Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. 76 дахь тал.

үзүүлсэн тохиолдолд хугацаагүй хорих ялаар сольж байсныг 30 жил болгон өөрчилсөн явдал болно»[1] гэж бичиж байв.

Хэрэв 2002 оны Эрүүгийн хуулиар дурдсан журмыг ийнхүү өөрчлөөгүй бол эдүгээ манай улс бүх насаар нь хорих ялыг эдлүүлэх бүх талын бэлтгэл ажиллагааг хангасан байх бодит боломж байсан юм хэмээн акад. С.Нарангэрэл, проф. Ж.Эрдэнэбулган нар байр сууриа илэрхийлжээ[2].

[1] Дэмбэрэлцэрэн, Д. Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий анги: өөрчлөлт, шинэчлэлт, эргэцүүлэл.
-Уб., 2002. 231 дэх тал.

[2] Нарангэрэл, С., Эрдэнэбулган, Ж. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж
(Нэгэн сэдэвт бүтээл). -Уб., 2019. 262 дахь тал.

МОНГОЛ УЛСАД ХОХИРОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

LEGAL STATUS OF THE VICTIM IN MONGOLIA SOME ISSUES TO CONSIDER



Б.Наргулан

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Түлхүүр үг: Хохирогч, хохирогчийн эрх зүйн байдал, Шударгаар хандуулах эрх, бодит хохирогч, нуугдмал хохирогч, мэдэх эрх, аюулгүй байх эрх, нотлох эрх, хөндөгдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх;

Key word: The right to fair payment, victim, legal status of the victim, actual victims, latent victims, right to know, the right to be safe, right of proof, the right to redress the rights that have been violated.

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-д хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”. 16-р дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй” 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” Хэмээн эрх зүйт

төрийн үзэл баримтлалийн үндсэн дээр иргэний эрхийг тунхаглаж, түүний баталгааг төр хангах үүргийг тусгасан.[1]

Төр иргэн хоёр харилцан үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан өнөө үед төрөөс иргэдийн өмнө хүлээх хариуцлага улам өндөрсөж, төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг шийдвэрлэх, нөхөн төлүүлэх асуудал хууль зүйн болоод нийгмийн тулгамдсан асуудал болсон байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, аюулгүй байдлыг хангахаас гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийг нотлох ажиллагааны үр дүн шууд хамаарах болж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1985 онд "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал" (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) баталж, түүний үзэл санааг хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон.

Тунхаглалд зааснаар, хохирогч гэсэн ойлголтод:"...гишүүн улсуудын дагаж мөрдөж байгаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглахыг хориглосон хуулиудыг оролцуулаад, Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие мах бодийн болон оюун санааны хохирол учирсан, сэтгэл санааны дарамтад орсон, эд хөрөнгийн хохирол учирсан, эсвэл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно[2]" гэж тодорхойлжээ.

Мөн "хохирогч гэдэг ойлголтод зарим тохиолдолд хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээлгэн тэтгүүлэгчдээс гадна тэжээн тэтгэгч, түүнчлэн хүнд байдалд орсон хохирогчид тусламж үзүүлэх оролдлого хийж байгаад хохирсон хүмүүс хамаарна" гэж заажээ.

"Хохирогч[3]"–ийг тодорхойлохдоо "Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ" гэжээ. Мөн 8.2 дугаар зүйлд хохирогчийн 15 эрхийг хуульчлан тодорхойлсноос хохирсон

[1] Ж.Батмөнх. "Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал" Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан.
[2] Ж.Батмөнх. "Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал" Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан.
[3] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд

эрхээ сэргээхтэй холбоотой дараах үндсэн 4 эрхийг хуульчилсан байна. Үүнд:

- хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гарган өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;

- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;

- шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах.

" Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй[1]", "Төрөөс...хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцана[2]" гэж тус тус заасан. Гэвч гэмт хэргийн улмаас учирсан хохирол арилахгүй, зөрчигдсөн эрх нөхөн сэргээгдэхгүй байгаа нь нийгмийн өмнө тулгамдсан асуудал боллоо.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хохирогч нь зөвхөн хувь хүн, хуулийн этгээд, хэрэв хувь хүн нас барсан, эсвэл эрх зүйн чадамжгүй болсон бол түүний гэр бүл, төрөл садангийн хүн байж [3] болохыг хуульчилжээ. Иймд дам хохирсон этгээдүүдийг гэмт хэргийн хохирогч гэж тооцох онол, хууль зүйн үндэс байгаа юм.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хохирогч гэсэн тодорхойлолт нь НҮБ-ын 1985 оны тунхаглалд заасан тодорхойлолтод агуулгын хувьд үндсэндээ адил учраас манай улсад гэмт хэргийн хохирогчийг өргөн хүрээгээр авч үзэх хандлага нэгэнт тогтсон гэсэн дүгнэж болно.

---

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн *Арван зургадугаар* зүйлд
[2] Монгол Улсын Үндсэн хуулийн *Арван долдугаар* зүйлд
[3] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8-р зүйлийн 1-д

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хохирогчийн тухай ойлголт нь объектив ***(агуулга)*** ба субъектив ***(хэлбэр)*** шалгууруудын албан ёсны нэгдэл мөн. Объектив шалгууураар илэрхийлэгдэж байгаа ***(de facto)*** хохирогч нь материаллаг эрх зүйгээр, субъектив шалгууураар илэрхийлэгдэж байгаа хохирогч нь процессын нэг оролцогчийн хувьд ***(de jure)*** хууль ёсоор хүлээн зөвшөөрөгддөг.

Гадаад улс орнуудын эрүүгийн материаллаг эрх зүйн ойлголтоор гэмт хэрэгт бодитойгоор хохирсон нийт хохирогчдыг гэмт хэргийн бодит хохирогч ***(actual victims),*** гэмт хэрэгт бодитойгоор хохирсон боловч ямар нэгэн шалтгаанаар албан ёсны тоо бүртгэлд ороогүй бодит хохирогчдыг нуугдмал ***(latent victims)*** хохирогч гэж тооцож байна.

Хохирогчийн эрхийг хамгаалах, хангах олон улсын стандарт нь дараах хандлага чиглэлтэй байгаа нь бодлого баримтын дүн шинжилгээгээр харагдаж байна. Үүнд:

- **<u>Шударгаар хандуулах эрх</u>** төр нь өөрийн нутаг дэвсгэр дээр гэмт хэргийн хохирогчид учирсан хохиролтой холбоотой хууль зүйн болон ёс суртахууны хариуцлагыг хүлээх
- **<u>Мэдэх эрх;</u>** хохирогч нь гэмт хэрэгтний тухай болон байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс гаргасан шийдвэрийн тухай тодорхой мэдээлэл хүлээн авах
- **<u>Аюулгүй байх эрх</u>** гэмт хэрэгтэн, түүний төрөл төрөгсөд, хамсаатан, дотны нөхдийн өшөө авалт, сүрдүүлгээс айж байгаа хохирогч нь гэмт этгээдийн эрхийн зарим нэмэгдэл хязгаарлалтыг шаардсан, төрийн эн тэнцүү хамгаалалтанд байх
- **<u>Зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, хохирлоо арилгуулах эрх</u>**; гэмт хэргийн улмаас учирсан бие махбодийн ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл зүйн хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр, мөн төрөөс тогтоосон, нийгмийн халамжийн тогтолцооноос нөхөн төлбөр авах
- **<u>Нийгмийн халамж, дэмжлэг туслалцаа авах эрх</u>** гэмт хэргийн хохирогч нь эхний ээлжид эрх зүйн туслалцаа, нийгэмийн дэмжлэг, хамгаалалтыг бололцооны хэрээр авах зэрэг эрхээр тодорхойлогдож байгаа юм.

Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан хохирогчийн эрхийг олон улсын стандартад нийцүүлэн дараах байдлаар нь:

- Шударгаар хандуулах, шүүхээр хамгаалуулах эрх;
- Өөрийгөө өмгөөлөх, бусдаар өмгөөлүүлэх ба төлөөлүүлэх эрх;
- Нотлох эрх;
- Мэдэх эрх;
- Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
- Хөндөгдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх;
- Аюулгүй байх эрх;
- Нийгмийн халамж, тусламж авах эрх гэж ангилж болно.

1. **Хохирогчийн шударгаар хандуулах эрх** нь олон улсын хохирогчийн хамгаалалтын тухай олон улсын баримт бичгүүдэд зааснаар: хүн бүр хууль, шүүхээр хамгаалуулах; төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх; гэмт хэрэгт хохирсон гэдгээ хүлээн зөвшөөрүүлж, хохирогчоор тогтоолгох; эрх мэдэл бүхий байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгээгүй тухай шийдвэрийг эргэж авч үзэх талаар өргөдөл гомдол гаргах, шүүхэд шууд хандах эрх зэргийг тунхагласан байна. Эдгээр баримт бичгүүдэд зааснаар төр нь төрийн байгууллага, түүний албан тушаалтнаас гэмт хэргийн хохирогчидтой шударгаар харьцах, тэдний эрэлт хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, нийгмийн халамж, туслалцаа авах, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, мэдээлэл авах талаарх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх төрийн хариуцлагыг тогтоож өгсөн байна.

Хуулиар эрх олгосон бол хамгаалах хэрэгслийг нь хамт өгөх ёстой" (Ubi jus ibi reme dium) гэсэн римийн эрх зүйн хэлц үг бий. Төр нийгмийн зүгээс хүний тодорхой эрх, эрх чөлөө бодитойгоор хэрэгжих баталгааны зохих механизмыг бүрдүүлээгүй бол хувь хүний эрх зүйн байдал нь зөвхөн тунхаг шинжээр үлдэнэ.

Эрх зүйн баталгаа нь улс төр, нийгмийн болон хууль зүйн баталгаанаас бүрдэх учраас гэмт хэрэгт хохирсон этгээдийн эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тусгай байдал гол байр суурьтай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хувь хүний эрхийг хангах механизм нь: "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны зорилго зорилтыг нарийн тодорхойлох, оролцогч нэг бүрийн эрх зүйн байдлыг нэгдмэл логик дэс дараатайгаар журамлах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд хувь хүний эрхийг бодитойгоор хангах хамгаалах, түүний дотор албан тушаалтнаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон зорилтуудыг хангах үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн үр дагаварыг тогтоох, мөн эрүүгийн журмаар хууль бус, үндэслэлгүйгээр мөрдөгдөж байгаа этгээдийг цагаатгах арга хэрэгслийн тогтолцоог журамлах зэргийг багтаасан арга хэрэгслийн тогтолцоо" мөн гэж тодорхойлж болно.

"Иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй[1]гэж заасан.

Хохирогчийн шүүхээр хамгаалуулах эрх нь өөртөө: өөрийн субъектив эрхийг хамгаалуулахын тулд шүүхэд хандах эрх; энэ талаар мэдээлэл авах эрх; шүүхийн бүрэлдэхүүн хууль ёсны байх эрх; шүүх ажиллагаанд биеэр оролцох эрх; гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо арилгуулах эрх; шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхүүд тус тус багтана.

Манай өнөөгийн нөхцөлд гэмт хэрэгт хохирсон этгээд нь шүүхэд хандаж, шударга шийдвэр гаргуулах боломжтой ч уг шийдвэрийг ханган биелүүлэх, эрхийг нь нөхөн сэргээх, нийгмийн халамж тусламж дэмжлэг авах, эцэст нь аюулгүй байдлаа хангуулах механизм, эрх зүйн тодорхой зохицуулалт илт дутагдаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлд: *Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх*" гэж заажээ. Энэ хуулийн 1.4.37 дугаар зүйлд зааснаар "яллах" тал гэдэгт прокурор, "өмгөөлөх тал" гэдэгт шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний хариуцагч, түүний төлөөлөгчийг ойлгоно гэжээ. Энэ агуулгаар шүүх хуралдааны мэтгэлцээн нь зөвхөн улсын яллагч ба шүүгдэгч, түүнийг өмгөөлөх талын */шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний хариуцагч, түүний төлөөлөгч/* хооронд явагдах учраас, хохирогч, иргэний нэхэмжлэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, төлөөлөгч, өмгөөлөгчид нь нь мэтгэлзэхдээ прокуророор дамжуулах, эсвэл шүүх хуралдаан дээр мэтгэлзэх боломжгүй, зөвхөн 1.4.1.20 дугаар зүйлд заасан

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд зааснаар:

оролцогч талууд тэгш эрхтэй байх ерөнхий нөхцөл буюу хүсэлт, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэхэд оролцох, үг хэлэх зэргээр хязгаарлагдмал хүрээнд “мэтгэлзэх” логик харагдаж байгаа юм.

Хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ: “Мэтгэлцээний сонгодог хэлбэр бол мэтгэлцээний эхлэл буюу гараа нь талуудад адил байх боломжийг хангаж өгөхийг ихээхэн чухал гэж үздэг. Иймээс шүүхийн хэлэлцүүлгийн эхэнд талууд өөр, өөрийн байр суурийг илэрхийлсэн эхлэлийн үг ээлжлэн хэлдэг онцлогтой. Харин манай орны хувьд шүүхийн хэлэлцүүлэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурор оролцож, яллах, цагаатгах талын нотлох баримт нэгэн зэрэг цуглуулсан улсын яллагч яллах дүгнэлт уншиж сонсгохоос эхэлнэ /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1.1 дугаар зүйлийн Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоосны дараа гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ/

Энэ нь яллах талын эхлэлийн үг юм. Харин хэлэлцүүлгийн эхэнд яллагчтай адил эхлэлийн үг хэлэх эрхийг өмгөөлөх талд олгоогүй юм”[1] гэж онцлон тэмдэглэжээ. Тэрээр цааш нь: “Мэтгэлцүүлэн шүүдэг буюу мэтгэлцэх зарчим бүхий улс орнуудад шүүгч төвийг сахисан байр суурьтай байх ба байцаалтыг шууд явуулахгүй. Мөн төвийг сахисан байдлаа хадгалахын тулд байцаалтад оролцож, асуулт тавихаас аль болох зайлсхийдэг журамтай. Хууль зүйн ухааны доктор, профессор Ж.Бямбаа: “Манай шинэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “оролцогчдын” болон “бусад оролцогч”-дын процессын баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, орчин цагийн шаардлага, нийтлэг жишгийн дагуу эрс нэмэгдүүлсэн боловч талуудын эрх тэгш байх болон мэтгэлзэх зарчмын жинхэнэ утгаар үйлчлэх цар хэмжээг анхан шатны шүүн таслах ажиллагааны хүрээнээс өргөжүүлэн авч үзэх онол, практикийн үндэслэл одоогоор алга” гэж дурдсан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дугаар зүйлийн 1.37 хэсэгт “яллах тал” гэж прокурорыг, 1.16 хэсэгт ”өмгөөлөх тал” гэж шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч,

[1] Ж.Батмөнх. “Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал” Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан.

иргэний хариуцагч, түүний төлөөлөгчийг ойлгоно гэжээ. Харин хохирогч нь шүүх хуралдаанд ердийн хуульд заасан журмын дагуу мэдүүлэх хүрээнд оролцох учраас гэмт хэрэгтнийг хохирогчийн өмнөөс бус, харин төрийн нэрийн өмнөөс яллагч-прокурорын саналтай нийцээгүй зөрөөтэй байгаа өөрийн байр суурийг бүрэн дүүрэн илэрхийлэх боломжгүй юм.

Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд хохирогч нь мэтгэлцээний яллах талын бүрэн гишүүнээр хязгаарлахгүй, улсын яллагчтай байр суурь зөрөөтэй үед шүүх хуралдаан дээр өөрөө хувираа яллах эрхтэй.

Судлаачийн үзэж байгаагаар мэтгэлзэх зарчмын хэрэгжилтийг жинхэнэ ёсоор хангахын тулд нэг талаас, талуудын мэтгэлзэх, байр сууриа харилцан илэрхийлэх боломж адил тэгш байх, нөгөө талаас хохирогчийг яллах талын бүрэн эрхт гишүүний байр суурийг эзлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн *"яллах тал гэж прокурор, өмгөөлөх тал гэж хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, түүний төлөөлөгчийг"* гэж нэмэлт өөрчлөлт оруулах саналтай. Цаашид шүүх хуралдааны процедурыг шүүхийн мэтгэлцээний сонгодог загварт оруулж, өөрчлөх шаардлагатай. Материаллаг хэм хэмжээний хэрэгжилтийг хангах процедур, процесс байхгүйгээр зөвхөн тунхаглалын шинж чанартай болно.

Монгол Улсын Үндсэн хуульд: "иргэн нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй"[1]гэжээ.

Өргөдөл гаргаж, шийдвэрлүүлэх боломж нь хохирогчийн байцаан шийтгэх ажиллагааны хамгийн гол чухал эрхүүдийн нэг мөн. Энэ эрхийн тусламжтайгаар хохирогч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд нөлөөлөх боломжтой болно. Өргөдөл нь хүсэлт болон гомдол гаргасан шинжтэй байж болно.

Хохирогчийн хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохих зүйл, заалтуудад тодорхой заасан байна. мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах /8.2.1.3/; шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 12 дахь хэсэг.

татгалзан гаргах тухай хүсэлт гаргах /8.2.1.11/ эрхийг тусгайлан зааж өгсөн боловч, хууль тогтоогч нь хохирогчоос гомдол, хүсэлт гаргах тохиолдол бүрийг нарийвчлан зааж өгөөгүй юм.

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1.12 хэсэгт : эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах эрхийг тусгажээ.

*2.**Хохирогчийн өмгөөлөх, өмгөөлүүлэх ба төлөөлүүлэх эрх**.*Монгол Улсын Үндсэн хуулийн *Арван зургадугаар* зүйлд хүн бүрийн ”өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах” эрхийг нь баталгаажуулсан юм. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлийн 1.12 хэсэгт: “...өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;”-ийг хангах тухай заажээ.

Судалгаагаар хуулийн байгууллагын ажилтнууд хохирогчид өмгөөлүүлэх эрхтэйг танилцуулдаг гэж хохирогч нарын 60 хувь, харин хуулийн байгууллагын ажилтнуудын 99.3 хувь нь хохирогч нарт өмгөөлүүлэх эрхтэйг нь танилцуулдаг хэмээн[1] тус тус хариуллаа.

Ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан өмгөөлөгч нар хэлэхдээ хохирогчийн хувьд өмгөөлөгч авна гэдэг нь хохирсон дээрээ дахин хохироход хүрдэг тул гэмт этгээдтэй харьцуулахад өмгөөлөгч авах нь бага байдаг гэж үзсэн билээ. Өөрөөр хэлбэл хуульд аль аль нь өмгөөллүүлэх, төлөөлүүлэх эрхээр хангагдах ёстой ч бодит амьдрал дээр хохирогч тэр болгон өмгөөлөгч авах эдийн засгийн чадамжгүй, тэгээд ч хуулийн байгууллагын ажилтнуудын хандлага ч хохирогчийн энэ эрхийг хангах тал дээр санаачлагагүй ханддаг байна.

Хохирогчийн эрх зүйн байдал нь түүний эрхийн чадвар, чадамжаас шалтгаалан өөр өөр байна. Хохирогчийн эрхийн чадвар бол гэмт халдлагаас шүүхээр хамгаалуулах эрхийг эзэмших чадвар мөн. Иймд: нас, бие, сэтгэл санааны байдлаас хамаарахгүй гэмт хэргийн улмаас хохирсон хүн болгон эрхийн чадвартай байна гэж үзнэ. Өөрийн эрх, эрх чөлөөг өөрөө хамгаалах болон бие дааж байцаан шийтгэх ажиллагаанд

[1] Ж.Батмөнх. “Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал” Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан

оролцох эрхтэй байх буюу эрх эдэлж, үүрэг хүлээх чадамжийн асуудлыг шийдвэрлэх нь ихээхэн нарийн төвөгтэй байдаг.

3. ***Нотлох эрх.*** Монгол Улсын ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлд зааснаар нотлох баримтын эх сурвалжид, “Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадлагаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл ” байхаар заажээ. Мөн хуулийн 8.2.1.2 дугаар зүйлд хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах; 16.1 дүгээр зүйлд тэднээс эрхээ эдлэх энэ хэлбэрийг “нотлох баримтыг цуглуулах нэг” арга гэж хуульчилсан байдаг.

Хэрэв хохирогч буюу түүний төлөөлөгч нь эрүүгийн хэргийн талаар нотлогдвол зохих байдлуудыг баталсан, эсвэл үгүйсгэсэн мэдээлэл, баримт сэлт байгаа бол тэд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчид гаргаж өгөх эрхтэй. Энэ тохиолдолд мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хохирогч болон түүний төлөөлөгчийн гаргаж өгсөн эд мөрийн баримт, буюу бичиг баримтыг олж авсан нөхцөл байдлын талаар мэдүүлэг авах үүрэгтэй. Мөн нотлох баримтыг илрүүлсэн нөхцөл байдал, тэдгээрийн онцлог шинжүүдийг тодорхойлсон протокол үйлдэнэ. Хохирогч, түүний төлөөлөгчид нь нотлох баримт гаргаж өгөх эрхээ хэрэгжүүлэх явцдаа нотлох баримтыг илрүүлэх зорилгоор явуулж байгаа мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

Хохирогчоос баримт сэлт гаргаж өгөх нь сайн дурын ажиллагаа мөн. Хэрэв хохирогчийн зүгээс баримт сэлт гаргаж өгөхгүй байгаа тохиолдолд тухайн эд зүйлийг хураан авах, шаардлагатай бол нэгжлэг хийх боломжийг хуульд тусгасан байна.

Мөн хохирогч нь гэмт хэргийг нотлох зорилгоор мэдүүлэг өгөх эрхтэй. Хохирогч нь энэ эрхээ мэдүүлэг өгөх, эсвэл өөрөө бичиж өгөх

замаар хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд мэдүүлэг өгөх санаачилга нь хохирогчийн талаас гарсан байна. Харин хохирогч сайн дураар мэдүүлэг өгөөгүй тохиолдолд энэ үйлдэл нь эрх бус, харин үүрэг болон хувирч байгаа юм. Иймд хохирогчийн мэдүүлэг нь зөвхөн өөрийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгсэл, түүний эрх төдийгөөр үл хязгаарлана

Мөрдөн шалгах ажиллагааны боломжуудын дотор мэдүүлэг өгөх эрх нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой: хохирогч-хувь хүн нь зөвхөн өөрөө мэдүүлэг өгөх замаар энэ эрхээ хэрэгжүүлж болно. Хувь хүний болон хуулийн этгээд-хохирогчийн төлөөлөгчийг байцаах тохиолдолд гэрчийг байцаах журмаар асууна.

Хохирогчоос нотлох эрхийнхээ хүрээнд гэмт хэрэгтнийг халуун мөрөөр нь буюу цаашид эрэн сурвалжлах, түүнийг илэрсэн нөхцөлд баривчлах эрх байгаа юм. Мөн техникийн болон бусад туслалцаа үзүүлэх боломжтой хохирогч-хуулийн этгээдийг байцаан шийтгэх ажиллагаанд татан оролцуулах, мөн гадаадын зарим орны туршлагаар, эрэн сурвалжлах ажиллагаанд хувийн хамгаалалтын болон мөрдөлтийн бүтэц, нэгжийг ашиглах ирээдүй ойрхон байна гэдэгт найдаж байна.

Хохирогчоос улсын яллах ажиллагааны хувьд дэмжих нь зөвхөн туслах шинжтэй байдаг. Хохирогч болон түүний төлөөлөгч нь төрийн яллагчаас хараат бус бие даан үйл ажиллагаа явуулах эрхийг хуульчлах шаардлагатай. Прокурор яллахаас татгалзсан бол хохирогч нь шүүгдэгчийн гэм бурууг нотлох бүх үүргийг хүлээн авсанаар, илүү чухал ач холбогдолтой болох ёстой.

4. ***Мэдэх эрх (мэдээлэл авах, мэдээллээр хангуулах эрх).Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын*** 19 зүйлд:”хүн бүр мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан ...хүлээн авах эрхтэй”, ***Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын Тунхаглалын*** 4 зүйлд:” ...Албан болон албан бус механизмаар дамжуулан хохиролоо нөхөн төлүүлэхийг зорьсон хохирогчид тэдний эрхийг нь мэдээлж тайлбарлаж байх...Хүнд гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд байцаан шийтгэх ажиллагааны хугацааны явц, үр дүн, хохирлын хэмжээ, тэдний оролцох талаар мэдээлэл өгөхөөс гадна тэд энэ тухай мэдээлэл хүсвэл зохих мэдээллээр хангана” гэж тус тус заажээ. ***Европын Холбооны Сайд нарын Хорооноос гишүүн улсуудад өгсөн эрүүгийн эрх ба эрүүгийн процессын хүрээнд хохирогчийн***

харьцангуй байдлын Зөвлөмж [1] R (85) 11. А.(Цагдаагийн түвшинд) гэсэн §2.3-т*:"* Цагдаагийн байгууллага нь хамтын ажиллагааны болон эрх зүйн болон практикийн тусламж, мөн эрх зүй зөрчигчийн болон төрийн талаас нөхөн төлбөр авах боломжийн тухай хохирогчид мэдээлэх ёстой. Хохирогч нь цагдаагийн мөрдөн байцаалтын үр дүнгийн тухай мэдээлэл авах боломжтой байх ёстой" гэж тус тус заажээ.

Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хийх, хүлээн авах эрхтэй[1] гэж заасан.

Хохирогч, түүний төлөөлөгч нь өөрийн үндсэн болон байцаан шийтгэх ажиллагааны эрх, үүргийн тухай мэдээллийг байцаан шийтгэх ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах, эдгээр эрхээ хэрэгжүүлэх боломжийг шаардах эрхтэй.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжоос үзэхэд хохирогчийн эрхийг хангахад чиглэсэн мөрдөн шалгах ажиллагааны ажиллагааны эрх, үүргийг тайлбарлах; эрх үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хоёр үндсэн арга хэмжээг зааж өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан нийт хохирогч нарын 43 хувь нь хохирогчийн эрхийн тухай мэдээллийг их төлөв хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн танилцуулснаар мэдэж авдаг гэж ингэж хариулснаас харагдаж байна. Үүнээс гадна өмгөөлөгчөөсөө, таньж мэддэг хүмүүсээрээ дамжуулан авахын зэрэгцээ хохирогчийн эрхийн талаарх мэдээллийг огт авч байгаагүй буюу өгч байгаагүй гэж арван хохирогч тутмын нэг нь хариулав.

Хүснэгт 1. Хохирогчийн эрхийг тайлбарлах талаар судалгаанд хамрагдсан хохирогч, хуулийн байгууллагын ажилтнуудын хариултын хувийн жин[2]

Хохирогч	**Хуулийн байгууллагын ажилтнууд**

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн *Арван зургадугаар зүйлийн* 17 дах хэсэгт

[2] Ж.Батмөнх. "Хохирогчийн эрхийг хамгаалах зарим асуудал" Legaldata. 2024.02.22 –ны өдөр хандсан

Хуулийн үг бүрийг нэг бүрчлэн тайлбарлаж өгдөг (7%)	Хуулийн үг бүрийг нэг бүрчлэн тайлбарлаж өгдөг (16.9%)
Хуульд байгаа заалтыг ерөнхийд нь тайлбарлаж өгдөг (28.6%)	Хуульд байгаа заалтыг ерөнхийд нь тайлбарлаж өгдөг (45.6%)
Хохирогчид эрх, үүргийг нь уншиж өгдөг (27.6%)	Хохирогчид эрх, үүргийг нь уншиж өгдөг (27.2%)
Хохирогч эрхээ мэдсэн байдаг тул өөрөөр нь уншуулдаг (5.4%))	Урьдаас бэлтгэн боловсруулсан хохирогчийн эрх үүргийг сайтар уншуулдаг (5.1%)
Өмгөөлөгчөөр дамжуулан эрх, үүргийг нь танилцуулдаг (7.6%)	Өмгөөлөгчөөр дамжуулан эрх, үүргийг нь танилцуулдаг (3.7%)
Тайлбарлаж өгдөггүй (23.8%)	Хариулахад хүндрэлтэй (1.5%)

Хуулийн байгууллагын ажилтнуудын бараг тал орчим хувь нь хохирогчид эрх үүргийг нь ерөнхийд нь тайлбарлаж өгдөг гэж үзсэн нь бусад хариултуудаасаа хамгийн давтамж өндөртэй хариулт болж байна. Харин хохирогч нарын хувьд мөн ерөнхийд нь хэлж өгөх эсвэл эрх үүргийг нь тайлбарлах маягаар эрх үүргийг нь танилцуулдаг гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан хохирогч нарын дээрх хариултад дүн шинжилгээ хийж үзвэл гурван хохирогч тутмын нэг нь хуулийн байгууллагын ажилтнуудын зүгээс эрхийг нь огт тайлбарлаж өгдөггүй эсвэл өмгөөлөгчөөр дамжуулан эрх үүрэгтэйгээ танилцсанаас үзэхэд хохирогчид эрх үүргийг нь тайлбарлаж өгөх үүргээ биелүүлэхгүй байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн ер нь хохирогч эрхийнхээ тухай мэдээллийг өөрөө уншиж судалдаг гэж чанарын судалгаанд оролцсон хохирогч, өмгөөлөгч нар тэмдэглэсэн юм.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж байгаа этгээд нь бүх ажиллагааг хийж дууссан, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл энэ тухай хохирогч, түүний төлөөлөгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ. Хэрэг бүртгэлт, мөрдөн

байцаалт дууссаныг мэдэгдсэний дараа хохирогч, түүний өмгөөлөгчид хэргийн бүх материалыг, харин иргэний нэхэмжлэгч түүний төлөөлөгчид зөвхөн иргэний нэхэмжлэлд холбогдох хэсгийг танилцуулна. Хохирогчийн өмгөөлөгч хүсвэл түүнд хэрэгт авагдсан эд мөрийн баримт, соронзон болон дүрс бичлэгийг танилцуулж болно. Хохирогчид хэргийн материал танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэх ба түүнд ямар материал танилцуулсан, хохирогч ямар хүсэлт гаргасан зэргийг тусгана. Хохирогч хэргийн материалтай танилцах үед бичгээр хүсэлт гаргасан бол хэрэгт хавсаргана. Хэргийн материалтай танилцах үед хохирогчоос гаргасан хүсэлтийг хэрэг бүртгэгч хүлээн авч хангах, эсвэл хэрэгсэхгүй болгож энэ тухай тогтоол гаргана. Хохирогч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоосон хугацаанд хэргийн материалтай танилцах ба хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийн материалтай танилцах боломжийг бүрдүүлнэ. Хохирогч нь хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол прокурорт гомдол гаргаж болно.

Монголд мэдээлэл авах эрхийн хувьд хохирогч, түүний төлөөлөгч нь өөрийн үндсэн болон байцаан шийтгэх ажиллагааны **эрх, үүргийн тухай мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах, эдгээр эрхээ хэрэгжүүлэх боломжийг шаардах эрхтэй болов**ч, гэмт хэргийн талаарх хэрэг шийдвэрлэх ажиллагааны **цар хүрээ, хугацаа, явц, гаргасан шийдвэрийн талаар болон гэмт этгээдийн талаарх мэдээллийг авах нөхцөл бололцоо хомс** байна.

Бидний үзэж байгаагаар мөрдөн шалгах ажиллагааны онол, практик, гадаад улс орнуудын туршлагаар гэмт хэрэгт өртөгдсөн этгээдийг гэмт хэргийн хохирогчоор тооцож, түүнд эрх, үүргийг нь танилцуулахын хамт, түүний эрхийг бичиж гардуулах үүргийг эрх бүхий алба хаагч хүлээх шаардлагатай.

*6. **Эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах.*** Үндсэн хуульд: “Монгол хэл бол албан ёсны хэл мөн. Энэ нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө[1]” гэж заасан. ЭЭХХШТХ-д: “Мөрдөн шалгах ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулах” болон

[1] Монгол Улсын Үндсэн хуулийн 8-р зүйлийн 2 дахь хэсэг.

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч этгээд нь монгол хэл мэддэггүй бол өөрийн эх буюу мэддэг хэл, бичгээр, хараагүй, хэлгүй, дүлий этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, хэргийн холбогдох бүх материалтай бүрэн танилцах эрхээр хангагдах” зарчмыг тусгаж өгсөн юм.

Монгол хэл мэдэхгүй хохирогч нь орчуулагч, харин хараагүй, хэлгүй, дүлий хохирогч нь хэлмэрчээр дамжуулан байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхээр бүрэн хангагдсан юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хохирогчийг орчуулагч, хэлмэрчээр хангах үүрэг хүлээнэ.

- Гэмт хэргийн хохирогч нь хэл мэддэг, аль хэр мэддэгийг тодруулах;
- Хохирогчид орчуулагч хэлмэрчтэй байх эрхийг тайлбарлах;
- Хохирогчийг орчуулагчаар хангах зэрэг ажиллагаа явуулна.

*7. **Хөндөгдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх.*** Монгол Улсын Үндсэн хуульд: иргэн нь “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх”, төр нь” хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар” заажээ. Хохирогч нь эрүүгийн хэрэг үүсгэхээс шүүхийн хэлэлцүүлэг эхлэх хүртэл хугацаанд гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлоо нөхөн төлүүлэх буюу сэргээлгэх, энэ талаар шаардлага тавих эрхтэй Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд хохирогч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсвэл түүний учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд, тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ. Эрүүгийн хэрэгт холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхгүй. Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ нь хэргийн талаар нотолбол зохих асуудлын /ЭХХШТХ-ийн 16.2/ нэг учраас түүнийг тогтоох үүрэг шүүхийн өмнөх байцаан шийтгэх ажиллагааг явуулах байгууллага, албан тушаалтанд ногдоно.

Хэрэв гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан тухай хангалттай мэдээлэл байвал хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүх, прокурор нь иргэний нэхэмжлэл гаргах боломжоор хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Эдгээр арга хэмжээнд:

- Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан этгээдийг тогтоох;
- Иргэний нэхэмжлэлийг хангах үүднээс эд хөрөнгийг эрэн сурвалжлах /үзлэг, нэгжлэг хийх/;
- Эд хөрөнгийг битүүмжлэх;
- Түүний бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа орно

ДҮГНЭЛТ

Хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нэхэмжлээд зогсохгүй, мөн бие махбодийн болон сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх эрхтэй. Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох явцад, эрх зүйн нэгэнт тогтсон уламжлалыг хадгалахын хэрээр нийгмийн эрх зүйн өндөр ухамсрын хүмүүжлийн нэг чухал баталгаа болсон хууль тогтоомжийн тогтвортой байдал хангагдана. Эрх зүй зөрчигч, түүний төлөө хариуцлага хүлээж байгаа этгээдээс хор уршиг арилгуулах эрхийн эд хөрөнгийн агуулга нь: эд хөрөнгөө буцаан авах эрх; үрэгдсэн эд хөрөнгөө нөхөн төлүүлэх эрх; гэмт хэрэгт хохирох явдалд учирсан зардлыг нөхөн төлүүлэх эрх; үйлчилгээ авах эрх /гэмт хэргийн улмаас гэмтсэн эрүүл мэнд, эд хөрөнгийн байдлаа нөхөн сэргээх/; зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх; сэтгэл санааны хохирлоо арилгуулах эрх зэргээс бүрдэнэ.

Мөрдөн шалгах ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл нь иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө болон эд хөрөнгөтэй холбоотой үүссэн харилцаа буюу иргэний эрх зүйн зохицуулах зүйлд хамаарах учраас, иргэний болон хөдөлмөрийн маргаанаас үүссэн нэхэмжлэлийг хангах ажиллагааны журам адил учраас, энэ асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгалаа олсон байна.

---o0o---

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХЭД, ӨСВӨР НАСНЫХНЫ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШИГ

MENTAL HARM TO ABUSED CHILDREN AND ADOLESCENTS



Ц.Нандинцэцэг

ДХИС ШМИ-н БУТЗШТ-ийн багш, цагдаагийн ахмад

ТОВЧ УТГА

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ангиллаар 0-9 насыг хүүхэд нас, 10-19 насыг өсвөр нас хэмээн үздэг бөгөөд харин хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж 18-аас доош насны хүүхдүүдийн эсрэг үйлдэгдсэн бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл болон үл хайхрах байдал гэж тодорхойлжээ.

2022 оны байдлаар дэлхий дахинаа 2-4 насны 300 сая хүүхэд асран хамгаалагчийн зүгээс биемахбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг бол 0-17 насны 5 охидын нэг нь, эрэгтэй 13 хүүхэд тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэсэн тоо баримт байна. Монгол улсад 2019 онд хийсэн судалгаагаар СЭМҮТ-д бэлгийн хүчирхийлэлд өртсөний удмаас 69 хүүхэд, өсвөр насныхан тусламж үйлчилгээ авсан ба тэдний 64 % нь сэтгэл гутралтай, 34.8% нь амиа хорлох оролдлого хийж байсан байна.

Монгол Улсад 2023 оны 07-р сарын 1-нээс эхлэн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн аргачлалыг боловсруулан, хэрэгжүүлж эхлээд байна. Иймд бид хүчирхийлэлд өртсөний улмаас сэтгэцэд учирсан хохирлоо тогтоолгосон, нөхөн төлүүлсэн байдлыг судлан тогтооход хэрэгцээ, шаардлагатай юм.

Abstract: According to the classification of the World Health Organization, 0-9 years is considered childhood and 10-19 years is considered adolescence, while violence against children is defined as physical violence,

emotional violence, sexual violence and neglect committed against children under 18 years of age.

As of 2022, 300 million children between the ages of 2 and 4 are physically and emotionally abused by their guardians worldwide, while one in 5 girls aged 0-17 and one in 13 male children are sexually abused. According to a study conducted in Mongolia in 2019, 69 children and teenagers received care from sexual violence victims at the National Medical Center, 64% of them were depressed and 34.8% tried to commit suicide.

In Mongolia, starting from July 1, 2023, a payment method has been developed and implemented to eliminate and compensate for the harm caused to human psyche due to crime. Therefore, it is necessary and necessary for us to study and determine the state of psychological damage caused by violence and compensation.

Түлхүүр үг: Хүүхэд, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хор уршиг

Keywords: children, violence, mental health, harm

Хүүхэд хамгаалалын хуулинд 2016 онд зааснаар Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн тодорхойлолтийг санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ гэж томьёолжээ. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд сэтгэцийн хувьд байнга айдастай амьдрах нь хүүхдийн хооллох, унтах дадал хэвшилд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд эрүүл бус болж, цаашлаад сэтгэцийн эмгэг үүсгэх хор уршигтай юм. Улмаар, хүчирхийллийн гэрч болж байсан хүүхдүүд үүнийгээ үлгэр дуурайлал болгож, хүүхэд насандаа ба насанд хүрсэн хойноо ч өөрөө *хүчирхийлэл* үйлдэх нь цөөнгүй тохиолддог байна. Хүүхэд байхдаа хүч хэрэглэсэн шийтгэл хүртэж байсан хүүхдүүд нь сэтгэцийн эрүүл мэнд доройтох, танин мэдэхүйн хөгжил хоцрох, сургалтын хоцрогдолд орох, илүү түрэмгий,нийгмээс тусгаарлагдмал байх зэрэг эрүүл мэнд, зан үйлийн олон асуудалтай болдог гэдгийг судалгаанаас тогтоосон байна. Дэлхий даяар хүүхдийн хүчирхийллийн тархалтын тооцоолол өөр өөр байдаг. Иранд энэ нь зүй бус харьцсан байдал, суралцаж буй газраас хамаарч 4.7-91.6% байна.Хүүхдийн хүчирхийлэл нь хүүхэд насанд болон ирээдүйн бие махбодь, сэтгэл санаанд сөргөөр нөлөөлдөг бөгөөд цаашлаад гэр бүл болоход ч хүндрэл учруулдаг тухай олон улсын судлаачдын

судалгааны сэдэв болсон байна. Үүнээс хүүхдийн хүчирхийлэл, сэтгэцийн эмгэгийн хоорондын хамаарлыг улс орон бүрт сайн судлагдсан. Тухайлбал 2018 онд Дэлхийн 21 улсад хийгдсэн судалгаанд хүүхдийн хүчирхийлэл болон сэтгэцийн 12 төрлийн эмгэгийн хамаарлыг судлахад хамааралтай гэсэн үр дүн гарсан байна.Хүүхдийн хүчирхийлэл нь өсвөр үеийнхний сэтгэцийн эмгэг, сэтгэцийн болон зан үйлийн эмгэг, мансууруулах бодис хэрэглэх, бие махбодийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх зэрэг янз бүрийн эмгэгүүдтэй холбоотой болохыг нотлох хэвлэлийн тоймууд олон байна. Жишээлбэл, хүүхдийн сэтгэл санаа, бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэл нь сэтгэлийн хямралд хүргэх хамгийн ноцтой эрсдэлт хүчин зүйл болохыг тогтоожээ.Бусад судалгаанууд нь бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болон сэтгэлийн хямрал, сэтгэл түгших эмгэг хоорондын хамаарлыг үнэлж, бэлгийн хүчирхийллийн хүнд хэлбэрүүд нь сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй болохыг мөн тогтоосон байна Энэ бүгдээс харахад хүүхдийн хүчирхийллийн тархалт, төрлийг тодорхойлж, илрүүлэх нь сэтгэцийн эмгэгийг бууруулахад чухал ач холбогдолтойг харуулж байна. Судлаачдын үзэж байгаагаар Хүүхэд насны сэтгэл зүйн гэмтэл гэдэг нь хүүхэд насанд тохиолдсон аймшигтай, аюултай, хүчирхийлэл, амь насанд заналхийлсэн бие махбодын гэмтэл хийгээд хувь хүний үнэт зүйлийг хөндсөн сэтгэлийн цохилтыг тухайн цаг мөчид нүдээрээ харж, сэтгэлээрээ мэдэрч, биеэрээ туулж өнгөрүүлсэн үйл явдлыг хэлдэг гэж дүгнэжээ.Манай улсын хувьд хүүхдийн хүчирхийллийн тархалтыг тодорхойлох, цаашлаад сэтгэцийн эмгэгтэй хамааруулан судалсан судалгаа хязгаарлагдмал байгаа юм.

Гадаад улс орнуудын хүүхдийн хүчирхийллийн талаарх зарим судалгаануудад Josie Spataro, Paul E. Mullenнарын судалгаанд 16 ба түүнээс бага насны 1612 хүүхдийн (1327 эмэгтэй, 285 эрэгтэй) бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдал болон сэтгэцийн эмгэгийн хамаарлыг судалсан байна. Хүчирхийлэлд өртсөн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн аль аль нь судалгааны хугацаанд нийт хүн амын хяналтын бүлэгтэй харьцуулахад (12.4% v. 3.6%) сэтгэцийн эмчилгээнд хамрагдсан нь хамаагүй өндөр байжээ. Хүүхдийн сэтгэцийн эмгэг, хувь хүний эмгэг, түгшүүрийн эмгэг, нөлөөллийн эмгэгийн хувьд өндөр байсан бол шизофрени өвчний хувьд тийм биш юм. Хохирогч эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хамаагүй илүү эмчилгээ хийлгэсэн байна (22.8% v. 10.2%).Эрэгтэй (харьцангуй эрсдэл=7.2, 95% CI 5.5–9.6, P<0.001) болон эмэгтэйчүүдийн (харьцангуй

эрсдэл=3.3, 95% CI 2.8–3.9, P<0.001) хяналтын хүн амтай харьцуулахад хавьтлын түвшин мэдэгдэхүйц өндөр байв Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ авсан байдал нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хамаагүй илүү байсан (22.8% v. 10.2%, $\chi2$=12.13, P<0.001). Хүүхдийн эмгэгийн ангилалаар эрэгтэйчүүд зан үйлийн эмгэг (1.8% v. 0.2%, $\chi2$=13.87, P<0.001) болон бусад хүүхдийн сэтгэцийн эмгэг (5.6% v. 1.0%, $\chi2$=27.95, P<0.001) эмэгтэйчүүдээс илүү их байв. Шизофрени (1.1% - 0.8%) болон гол нөлөөллийн эмгэг (0.7% - 1.1%), сэтгэл түгшүүр (2.8% v. v.) зэрэг эрэгтэй, эмэгтэй хүйсийн хооронд мэдэгдэхүйц ялгаа олдсонгүй. Судалгаа нь эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хоорондын холбоог баримтжуулж, хүйсийн хооронд хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд үзүүлэх хариу арга хэмжээ бага зэрэг ялгаатай байж болох ч эрэгтэй хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн ихэнх сөрөг үр дагавартай холбоотой болохыг харуулж байна.

Noemí Pereda, Georgina Guilera, Maria Fornsнарын судалгаанд Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тархалтын мета-анализыг олон улсын хэмжээнд 22 орныг хамарсан 65 нийтлэл тус судалгаанд орсон. Үр дүнгээс эрэгтэйчүүдийн 7.9%, эмэгтэйчүүдийн 19.7% нь 18 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.Энэхүү мета-анализын үр дүнд дүн шинжилгээ хийж буй улс орнуудад хүүхдийн бэлгийн хүчирхийлэл ноцтой асуудал болж байгааг харуулж байна.Энэхүү судалгаагаар олж авсан үр дүн нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн асуудал нь дүн шинжилгээ хийсэн бүх улсад ихээхэн хэмжээний асуудал болдгийг баталж байна. Одоогийн мета-анализын үр дүн нь эпидемиологийн чиглэлээр хамгийн эхэнд хийгдсэн судалгаа юм. Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл нь дүн шинжилгээ хийсэн улс орон бүрт ноцтой асуудал гэдгийг харуулж байгаа тул маш чухал хэвээр байгаа бөгөөд энэ нь өмнөх тоймуудын дүгнэлттэй нийцсэн нь тогтоосон байна.

Гадаадын улс орнуудад хүүхдийн хүчирхийллийн талаар судалсан байдлуудыг дүгнэхэд хүүхдийн хүчирхийлэл нь дэлхий дахинаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг бөгөөд сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг болохыг олон орны эрдэмтэн судлаачид сонирхож байгаа бөгөөд хүүхдийн хүчирхийллийг илрүүлэх нь урт хугацаандаа гарах эмгэг өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх гол арга зам байж болох юм.

Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийн хэлбэрүүд, хүчирхийллийн улмаас сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн

байдлыг судлах зорилго тавьж, уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллав.

Үүнд:

1.Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн хүчирхийллийн хэлбэрүүдийг судлан тогтоох

2.Хүчирхийлэлд өртсөний улмаас хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршигийн судлан тогтоох

3.Шүүхээс хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөрийг тогтоосон байдлыг судлан тогтооход оршино.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын Шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт хүчирхийлэлд өртсөн 0-17 хүртэлх насны хүүхдүүдийн 2023-2024 оны статистик мэдээнд аналитик судалгааны агшингийн загвараар, асуумж судалгааны болон дагах судалгааны аргаар шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн дүгнэлтэнд баримтын судалгаа хийв.

Судалгааны эх олонлог нь ШШЕГ-ын Шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт хүчирхийлэлд өртсөн 0-17 хүртэлх насны шинжилгээнд хамрагдсан хүүхдүүд байна. Шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт 2023-2024 оны статистик мэдээгээр 161 хүүхэд шинжилгээнд хамрагдсан байна. Судалгаанд шаардлагатай түүврийн хэмжээг тооцохдоо нэг түүврийн хувь тооцох таамаглалын хүрээнд дараах томьёогоор тооцов. Тооцоололд итгэх интервалыг 95.0%, алдааны хязгаарыг 0.05, таамаглалын суурь түвшинг 0.5 байхаар тооцсон.

$$n = \frac{[Np(1-p)]}{\left[\frac{d^2}{Z^2_{\frac{1-a}{2}}} * (N-1) + p * (1-p)\right]}$$

$$= \frac{[2 * 161 * 0.5(1-0.5)]}{\left[\frac{0.05 * 0.05}{95 * 95} * (161-1) + 0.5 * (1-0.5)\right]} = 91$$

N – Эхолонлог 161

$Z^2_{\frac{1-a}{2}}$ – Судалгааны таамаглалын итгэх интервал, 95.0%

d – Алдааны хязгаар- 0.05

P – Таамаглалын суурь түвшин - 0.5

Дээрх томъёогоор тооцоход хүчирхийлэлд өртсөний улмаас Шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт үйлчлүүлсэн 91 хүүхдийг судалгаанд хамруулах шаардлагатай байгаа ба бид судалгааны санамсаргүй түүврийн алдаанаас сэргийлж түүврийн хэмжээг 10%-иар нэмэгдүүлж 105-110 хүүхдийг хамруулав. Хүчирхийлэлд өртсөн хүүхдээс судалгаа авахдаа асуумж судалгаа, хүүхдийн сэтгэлзүйн зүйн гэмтэл, сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор олон улсад өргөн хэрэглэгддэг стандарт сорилуудаар мэдээллээ цуглуулна. 0-9 насны хүүхдээс асуумж авах боломжгүй тул зөвхөн гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчаас асуумжийг авах ба 10-17 насныхнаас асуумжийг өөрөөс нь авав.

1. Хүүхдийн сэтгэл зүйн гэмтлийг үнэлэх – CTQ (Childhood Trauma Questionnaires)- / 6 асуумж/

2. Стресс, сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн түвшинг үнэлэх – DASS-21 (Depression, Anxiety, and Stress Scale)- / 21 асуумж/

Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, стрессийн түвшинг үнэлэх – 21 асуумж буюу DASS-21 асуумж нь сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, стрессийн түвшинг үнэлэхэд зориулагдсан, өвчтөн өөрөө бөглөх боломж бүхий асуумж сорил юм. Оролцогч өгүүлбэр бүрийг уншсаны дараагаар өнгөрсөн долоо хоногийн хугацаанд тухайн нөхцөл байдал танд хэр зэрэг тохиолдсоныг илэрхийлэх үүднээс 0, 1, 2, 3 гэсэн тооны аль нэгийг сонгон дугуйлна. Буруу зөв гэсэн хариулт байхгүй тул өгүүлбэр бүр дээр хэт их цаг зарцуулах шаардлагагүйг сануулна.

Оноонууд нь дараах утгатай байна.

0Надад ийм зүйл огт тохиолдоогүй

1Надад бага хэмжээгээр эсвэл хааяа нэг тохиолдсон

2Надад нэлээдгүй хэмжээгээр эсвэл хэсэг хугацааны туршид тохиолдсон

3Надад маш ихээр эсвэл урт хугацааны туршид тохиолдсон зэрэг болно.

Сэтгэл гутралын хэмжүүр нь сэтгэлээр унах эмгэг, итгэл найдваргүйбайдал, амьдралүнэцэнэгүй санагдах, өөрийгөөдорд үзэх

байдал, аливаад сонирхол болон оролцоо буурах байдал, таашаал үл мэдрэхболонидэвхигүй сул байдал зэргийгүнэлдэг. **Сэтгэл түгшилтийн хэмжүүр**ээр түгшилт нь хүчтэй сэтгэл хөдлөл, хүний биеийн булчингийннөлөө, нөхцөлбайдлаас урган гарах сэтгэл зовнил, түгшүүрийн нөлөөллөөс үүдэх субъектив шинжийг үнэлдэг. **Стрессийн хэмжүүр** нь архаг,тодорхой бус сэтгэл хөдлөлүүдийг тухайлбал амарч тайвшрахад хүндрэлтэй байдал, сэтгэл санаа тогтворгүйтэх, амарханбухимдах, уурлах,догдлох, хямрах, хэт цочромтгой хариу үйлдэл үзүүлэх зэргийг үнэлдэг.

Хүснэгт 1. Стресс, сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн түвшинг үнэлэх асуумжийн үнэлгээ

	Сэтгэл гутрал	**Сэтгэл зовнил**	**Стресс**
Хэвийн	0-9	0-7	0-14
Бага зэрэг	10-13	8-9	15-18
Дунд зэрэг	14-20	10-14	19-25
Хүнд	21-27	15-19	26-33
Маш хүнд	28+	20+	34+

DASS-21 нь DASS-42 асуулгын товч хувилбар тул дугуйлсан оноонуудыг 2-оор үржиж эцсийн оноог бодож гаргав.

Дата мэдээлэлд статистик боловсруулалтыг SPSS 29.0 (IBM Corp) программыг ашиглан хийж гүйцэтгэн, тойм статистикийн үр дүнг илэрхийлэхдээ шугаман хувьсагчдын дундажутга (стандарт хазайлт) эсвэл медианаар, бүлэглэсэн хувьсагчдын тархалтыг хувиар тус тус илэрхийлнэ. Эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлохын тулд нэг болон олон хувьсагчтай ложистик регрессийн шинжилгээг ашиглав. Таамаглалыг шалгахдаа ач холбогдлын түвшинг p утга 0.05-аас бага тохиолдолд статистик үнэн магадлалтай хэмээн тооцов.

ҮР ДҮН

Шүүхийн шинжилгээний хүрээлэнг түшиглэн, Монгол улсад анх хэрэглэж байгаа “Хүний сэтгэцэд учирсан хор уршигийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийг тооцох аргачлал”-ыг ашиглан, хүчирхийлэлд өртсөн

хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршигийг тогтоох судалгаа хийж байгаад оршино. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоосноор хүчирхийллийн улмаас хүүхдэд үүсч болох сэтгэцийн эмгэгийг эрт оношлох, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах, үүссэн гэм хорыг арилгах, сэтгэцийн гэмтэл, хор уршгийг арилгах нөхөн төлбөрийг шүүхээс тогтоож өгснөөр эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн байдалд сэтгэл ханамж үүсэх боломжийг нэмэгдүүлнэ.

ДҮГНЭЛТ

Хүүхдийн нас, хүйсээс хамааран өртсөн хүчирхийллийн хэлбэрүүд ялгаатай байх ба хүүхэд, хөвгүүд биемахбодын хүчирхийлэлд, өсвөр насны охид бэлгийн хүчирхийлэлд илүү өртөж байна. Хүүхэд, өсвөр насныхан өртсөн хүчирхийллийн хэлбэр, нас хүйсээс хамааран сэтгэцийн хохирлын 1-5-р зэрэглэлийн аль нь ч тогтоогдох боломжтой байна. Сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэл хүнд, нөхөн төлбөрийн хэмжээ их байх тутам нөхөн төлбөр төлөгдөх магадлал бага байх боломжтой байв.

ЭХ СУРВАЛЖ

1. Weru, M. W. (2013). *Impact of violent conflict on pre-school children (a case of 2007-2008 post election violence in Kibera, Kenya)* (Doctoral dissertation, University of Nairobi).

2. Dahake, P. T., Kale, Y., Dadpe, M., Kendre, S., Shep, S., & Dhore, S. (2018). Impact of Child Abuse & Neglect on Children: A. *Journal of Dental Research*, *1*(1), 36-49.

3. Eslami-Shahrbabaki, M., Haghdoost, A., Sabzevari, L., Eslami-Shahrbabaki, A., & Kalantari, M. (2014). Prevalence of Child Abuse in 15-17 year old Students. *Zahedan Journal of Research in Medical Sciences*, *16*(5), 11-15.

4.Mahram, M., Hosseinkhani, Z., Nedjat, S., &Aflatouni, A. (2013). Epidemiologic evaluation of child abuse and neglect in school-aged children of qazvin province, iran. *Iranian Journal of Pediatrics*, *23*(2), 159.

5.Stephenson, R., Sheikhattari, P., Assasi, N., Eftekhar, H., Zamani, Q., Maleki, B., &Kiabayan, H. (2006). Child maltreatment among school children in the Kurdistan Province, Iran. *Child abuse & neglect*, *30*(3), 231-245.

---o0o---

СУРГАЛТЫН ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ ЯВЦ, АРГА ХЭЛБЭР

COGNITIVE PROCESSES AND METHODS OF TRAINING



Э.Батбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд сургалт, сурахуйн онолын үндэс, тухайн онолын үзэл санаа ямар агуулгыг илэрхийлдэг талаар мөн танин мэдэхүйн үйл явц нь сургалтын ямар арга хэлбэрээр зохион байгуулдаг талаар товч авч үзсэн болно.

Abstract: In this article, the basis of the theory of teaching and learning, the content of the theory's ideas, and the way in which the cognitive process is organized as a learning method are briefly discussed.

Түлхүүр үг: Сургалт, сурахуйн онол, танин мэдэхүй үйл явц

Key word: Theory of teaching and learning and cognitive processes

Удиртгал. Сургалт гэж аливаа шинжлэх ухааныг танин мэдэхийн тулд сургалтын зорилго, агуулга, орчин, арга барил, сургагч, суралцагч, туршлага зэргийг бүрдүүлж мэдлэг, чадвар бий болгодог ойлголт юм. Тиймээс тухайн өгүүлэлд суралцагчдад мэдлэг, чадвар олгох арга барилыг бүрэн төгс эзэмшүүлэх, хичээл сургалтын явцад онол, арга зүйг ашиглах, зохион байгуулах, үр дүнг харьцуулах шаардлагатай үзэж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Сургалт, сурахуйн онолын үндэс, үзэл санаа: Сурган хүмүүжүүлэх ухаан, сургалтын практикийн түүхэнд догматик, уламжлалт, хөгжүүлэх, прагматик зэрэг олон хэв маягийн сургалтыг хэрэгжүүлж ирсэн. XIX дунд

үеэс эхлэн уламжлалт сургалтыг улам боловсронгуй болгох шаардлага гарч, улмаар хөгжүүлэх сургалтын үзэл санаа газар авах болсон бөгөөд XX зуунд олон хувилбарууд бий болсон гэж үздэг байна. Өнгөрсөн зууны дунд үеэс эхлэн когнитив онол, хүмүүнлэгийн онол, конструктив хандлага олон оронд газар авч XX зууны эхэн үеэс эхлэн прагматик сургалтын үзэл санаа АНУ болон Европын орнуудад дэлгэрсэн[1].

Манай улсад уламжлалт сургалт, түүнтэй зэрэгцэн хөгжүүлэх болон прагматик сургалтын элементүүд хэрэгжиж ирсэн. Сургалтын ямарваа нэг үзэл санаа онол нь нийгмийн хөгжлийн хэрэгцээ, зорилготой нягт уялдаа холбоотой байдаг. Тухайлбал, социализмын үед шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй хүн бэлтгэх нийгмийн хэрэгцээг хангахад уламжлалт сургалтын арга технологи тохирч байсан бол өнөө үед нийгэм, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээр нийгэм нь сургууль, боловсролоос бие даан хийж бүтээх, өрсөлдөх чадвартай хүн бэлтгэхийг шаардах болсон байна. .

Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангадаг төгс сургалтын онол гэж байдаггүй ба сургалтын үзэл онолуудыг сайн судалж, мөн чанарыг нь танин мэдэж, эдгээрийг бүтээлчээр хэрэглэвэл сургалт үр дүнтэй болох магадлалтай.

Прагматик үзэл санаа. Энэ үзэл санаа нь XIX зууны төгсгөл үед гарч ирсэн ба гол үндэслэгч нь АНУ-ын судлаач, филсофич Д.Дьюи юм. Тэрээр 1899 онд “Сургууль ба нийгэм” хэмээх алдарт зохиолоо бичсэн бөгөөд 1-р бүлэгт “хүүхэд ширээний ард олон цаг томоотой сууж, багшийг анхааралтай сонсох ажлыг өдөр бүр хийж байна. Хичээл болгон хоорондоо ижилхэн, уйтгартай, хүүхдийн юу бодож, юу хүсэж мөрөөдөж байгаа нь сургууль, багш нар, шийдвэр гаргагч нарт огт хамаагүй, Ийм сургалт хүүхдийг яаж ядрааж залхааж, бас өвдөхөд хүргэж байна” гэсэн дүгнэлт хийжээ. Д.Дьюигийн үзсэнээр тэр үеийн сургалтын хүндийн төв нь багш, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хичээл гэх зэрэг байв. Сургуульд орж буй хүүхэд үүнд цаг хугацаа, хүч тэнхээгээ зарцуулж байна хэмээн шүүмжилсэн. Энэхүү дэвшүүлсэн санаагаа Коперникийн үзэл онол[2]-той жишиж үзэн сургалтын төв нь “хүүхэд” юм, түүнийг даган бусад зүйл эргэлдэн өөрчлөгдөнө гэж үзсэн.

---

[1] “Сургалтын зарим үзэл онол: мөн чанар, хэрэглээ” гарын авлага.

[2] Дундад зууны одон орон судлалд огторгуйн төв бол дэлхий биш нар юм гэсэн санаа дэвшүүлж шинжлэх ухаанд хувьсгал хийж байсан.

Энэ үзлийн төлөөлөгчид хүн аливаа зүйлийг барьж үзэх, үнэрлэх, амтлах зэрэг үйлийг хийж байж сая танин мэддэг гэж үздэг байсан. Орчин үед прагматизм хөгжиж боловсронгуй болсоор байгаа ба тулгуур үзэл санаа нь:

- ✓ Сургалт суралцагчийн эрэлт хэрэгцээ, сонирхол, туршлагад тулгуурлана.
- ✓ Суралцагч сурах олон төрлийн үйл ажиллагаанд оролцож байж сая мэдлэг туршлагаа амьдралдаа хэрэглэх чадвартай болно гэх мэт.

Сурахуйн тухай конструктив үзэл санаа. Боловсролын сэтгэл судлалын хамгийн чухал зарчмын нэг бол багш нар сурагчдад зүгээр нэг бэлэн мэдлэг өгөх явдал биш юм. Консртруктив онол бол сурахуйн тухай онол гэж барууны тэр дундаа АНУ-ын судлаачид үздэг. Суралцагчид өөр өөрийн санаа бодол, туршлагадаа тулгуурлан өөр өөрийн ойлголт мэдлэг бүтээнэ. Багш мэдлэг бүтээх үйл явцыг хөнгөвчлөхийн тулд дараах арга замаар тусална.

- ✓ Мэдээллийг сурагчдад утга учиртай, ач холбогдолтой болгох;
- ✓ Мэдээллийг сурагчдад оновчтой болгох /их биш, хэт хүнд биш болгоно гэсэн үг/;
- ✓ Нээлт хийх аятай боломж бүрдүүлж өгөх;
- ✓ Суралцагчдад өөрсдөө санаа бодлоо хэрэгжүүлэх боломж олгох;
- ✓ Суралцагчдад үзэж байгаа зүйлээ ухаарч ойлгох боломж өгөх;
- ✓ Суралцагчдад эзэмшсэн сурах арга барилаа ухамсартай ашиглах боломж өгөх гэх мэт.

Эдгээр санаан дээр суурилсан суралцахуйн онолуудыг “сурахуйн конструктив онолууд” гэж нэрлэдэг.

Конструктив хандлага. Конструктив хэмээх үг нь **construct** буюу бүтээх, зохиох, барих гэсэн утгатай англи үг юм. Хүүхэд багадаа конструктор хэмээх тоглоомоор тоглож энгийн эд зүйлээр байшин, машин болон бусад дуртай зүйлээ зохион бүтээдэг. Конструктив хандлага нь сурахуйн тухай нэг л урсгал бөгөөд түүнд бид бүтээлчээр хандаж ашиглах нь зүйтэй. Энэ хандлагыг сурахуйн бусад хандлага, үзэл санаа, арга барилтай хослуулан хэрэглэх нь зөв зүйтэй шийдэл юм.

Оюун ухааны үйлдэл шатлан төлөвших онол. Оросын нэртэй сэтгэл судлаач П.Я.Гальперин 1960-аад оны үед удаан хугацааны туршилт судалгааны үр дүнд "оюун ухааны үйлдэл шатлан төлөвших" онол боловсруулсан. Энэ онолын гол санаа нь сурагч шинэ үйлдэл эзэмших нь анхандаа түүнийг гүйцэтгэх нөхцөлд идэвхтэй баримжаалахыг шаарддаг, гадна орчны юмстай гүйцэтгэх үйлдэл нь дотоод оюун ухааны үйлдэл болж шилжих замаар хүртэх, сэтгэх, үйлдэл төлөвшдөг явдал юм. Хүртэх, сэтгэх үйлдэл төлөвших үе шат:

- ✓ үйлдлийг эзэмших сэдэл бий болгох үе
- ✓ үйлдлийн тухай баримжаалал өгөх үе
- ✓ үйлдлийг биечлэн хийж гүйцэтгэх үе
- ✓ үйлдлийг ярьж гүйцэтгэх үе
- ✓ дотроо бодож гүйцэтгэх үе
- ✓ үйлдлийг олон удаа хийсний эцэст аяндаа хийх үе

Хоёр. Уламжлалт сургалтын арга

Уламжлалт сургалт. XIX зууны дунд үеэс багш мэдлэгийг сурагчдад тайлбарлан ярьж ойлгуулах ба хүүхэд ойлгосон зүйлээ багшдаа ярьж өгөх болсноор уламжлалт сургалтын суурь бий болсон. Уламжлалт сургалтын явцад сурагчдаар дасгал хийлгэх, бие даалган ажиллуулахыг эрхэмлэдэг. Гэвч багш нар сурагчдын хийх, бодох, ярих зэргийг авч хийдэг болсон нь багшийн тайлбарласныг цээжлэн тогтоогоод эргүүлж мэдээлдэг идэвхгүй нэгэн болгосон. Сүүлийн үед уламжлалт сургалтаас татгалзах гэсэн сөрөг өнгө аясаар хэрэглэх болжээ. Гэтэл уламжлалт сургалт нь олон сайн талтайг харгалзан үзэх нь зүйтэй. Тухайлбал, сурагчдын мэдлэгийг бататгах зорилгоор олон янзын даалгавар, дасгал, бодлого зэргийг ашигладаг, уламжлалт сургалтын мөн чанарын давуу тал болох сурагчдад системтэй их мэдлэг олгодог[1] зэргийг дурдаж болно.

Хөгжүүлэх сургалт. XIX зууны дунд үеэс эхлэн хүүхдийг хөгжүүлэх, түүнд бие дааж сэтгэн бодох арга барил эзэмшүүлэх үзэл /Европын орон тэр дундаа Германы дэвшилтэд сурган хүмүүжүүлэгч А.Дистервег/ хүчтэй болж улмаар XX зуунд хөгжүүлэх сургалт бие даасан онолын нэгэн урсгал

[1] Уламжлалт сургалтын мөн чанарын талаарх ойлголтыг Ичинхорлоо.Ш., Сургалтын зарим үзэл онол: мөн чанар, хэрэглээ, 2013 он, 6-7 дахь тал

болсон байна.1920-1930 оны үед Оросын нэртэй сэтгэл зүйч Л.С.Выготский хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх асуудлаар өөрийн үзэл онолоо дэвшүүлснээр хөгжүүлэх сургалтын сэтгэл зүйн үндэс тавигдсан. Тэрээр оюуны хөгжлийн ойрын бүсийн онолдоо хүүхдийн оюун ухаанд хөгжлийн өнөөгийн ба ойрын бүс гэж үзсэн байна.

Багш нар сургалтаа зохион байгуулахдаа хүүхдийн оюуны хөгжлийн өнөөгийн бүст тулгуурлаж, ойрын бүс рүү чиглүүлэн явуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

Хөгжүүлэх сургалтын талаар Оросын судлаачдын хийсэн бүтээлүүдэд гол төлөв хүүхдийн оюун ухааны хөгжлийг авч үзсэн онцлогтой.1980-аад оноос Оросын шинийг санаачлагч багш нар "Хамтын сурган хүмүүжүүлэх ухаан" гэсэн шинэ үзэл санаа, арга барилыг дэвшүүлсэн. Хүүхдийг амжилттай сурган хүмүүжүүлэх, хөгжүүлэх нь чухал гэдгийг онцолсон. Жишээлбэл, хүүхэд амжилттай сурч хөгжихөд багш туслах биш түүний хамтран зүтгэгч байх, хүүхдэд өөрийнх нь хүч тэнхээг мэдрүүлж, өөртөө итгэдэг болгох, хүүхдийг тодорхой бэрхшээлтэй учруулж, түүнийг даван туулах арга барилтай болгох, хүүхдэд тал бүрийн сонголт хийх боломж олгох гэх мэт.

Асуудал шийдвэрлэх сургалт. Орчин үед хүний амьдрал олон төрлийн асуудлаар дүүрэн, тиймээс өсвөр үеийнхэнд амьдралынхаа аливаа асуудлыг ул суурьтай авч үзэн шийдэх арга барилыг сурах явцад эзэмшүүлэх явдал сургалтын нэг чухал зорилт болсон. Нийгмийн хөгжил, шинжлэх ухаан техникийн дэвшил зэрэг хүмүүсээс бүтээлч чадавх улам их шаардах болсон өнөө үед суралцагчийн бүтээлч чадварыг хөгжүүлэх явдал чухал хэвээр байна. Энэ агуулгаараа асуудал шийдвэрлэх сургалт хэзээ ч хуучрахгүй бөгөөд багш нар энэ сургалтын үзэл санаа, арга зэргийг бүтээлчээр хэрэглэж цааш хөгжүүлэх явдал чухал юм.

Программчилсан сургалт. Уг сургалтын үндэслэгч нь АНУ-ын судлаач Н.Краудер, Б.Скиннер, С.Пресси, Оросын судлаач Н.Ф.Талызина, А.М.Матюшкин, Л.Н.Ланда нар юм. Энэ сургалтын гол зорилго нь сургалтын процессыг оновчтой удирдан жолоодох ажиллагааг сайжруулах, сурах үйл ажиллагааг урьдаас төлөвлөн хөтөлж, сурагч сурах үйлийн системийн үйлийг гүйцэтгэснээр амжилттай сурах явдал юм.

Программчилсан сургалтын мөн чанар нь дараах зүйлээр тодорхойлогддог. Тухайлбал, хичээлийн материалыг тодорхой хэсгүүдэд

хуваадаг, хичээлийн процесс нь дэс дараатай альбомуудаас бүрдэх ба алхам болгон нь тодорхой хэмжээний мэдлэг, түүнийг эзэмших оюуны үйлүүдээс бүрддэг, алхам бүр нь хяналтаар төгсдөг, сурагч хяналтын даалгаврыг зөв хийвэл дараагийн алхам руу шилждэг, сурагч хяналтын даалгаврыг буруу хийвэл алхам руу буцан орж нэмэлт тусламж, тайлбар авдаг, сурагч болгон алхмыг өөртөө тохирсон хурдаар гүйцэтгэдэг, хяналтын үр дүн багш, суралцагчдад ил тод, сурагч алхам бүрийг өөрт тохирсон хурдаар гүйцэтгэдэг, багш зохион байгуулах үүрэг гүйцэтгэж сурагч нэг бүртэй ажилладаг, сургалтын үйл явцад техник хэрэгслийг өргөн хэрэглэдэг. Уг сургалт нь дотроо программчилсан сургалтын шугаман систем, энэ систем нь сурагч бүр алхмыг программд урьдчилан боловсруулсан дарааллаар хийж гүйцэтгэх болон программчилсан сургалтын салаалсан систем, түүний алхмын бүтэц нь 3 хэсэгтэй ба ялгаатай тал нь хянах хэсэг нь асуулт ба түүнд өгөгдсөн олон янзын хариултаас бүрдэх гэж 2 төрөл байдаг.

Сурагч төвтэй сургалт. Францын нэрт соён гэгээрүүлэгч Жан Жак Руссо “Эмиль ба хүмүүжлийн тухай” зохиолдоо хэрэглэсэн. Тэрээр “багш хүмүүжүүлэгч нар хүүхдийн ойлгохгүй байгаа зүйлийг хүчээр ойлгуулах гэсээр байгаад түүний сурах дур сонирхлыг үгүй хийдэг. Хүүхэд бодит амьдрал орчноос хэрэгтэй, ашигтай зүйлээ өөрөө олоод авдаг ухаалаг нэгэн учраас түүнийг албадахгүй орхих юм бол тэр хэрэгтэй бүхнээ өөрөө олоод сурна гэсэн санааг дэвшүүлсэн. Сурагч төвтэй сургалт нь суралцагчийн авьяас чадавх, хэрэгцээ сонирхол, эрх, эрх чөлөө зэргийг эрхэмлэсэн, түүнд чөлөөтэй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж чадсан сургалтын нэг чиглэл ба Европын олон оронд амжилттай хэрэгжсэн.

Сургалтын үр дүн. Эцэст нь хүн шинэ мэдээллийг урьд нь эзэмшиж байсан зүйлтэйгээ харьцуулж, шүүлтүүрээр нь боловсруулж дууссаны дараа оюун ухаандаа нэгтгэдэг. Энэ үйл явцын үр дүнд бий болсон мэдлэг нь урьд өмнө олж авсан мэдээллүүд болон тухайн хүнд танилцуулж байсан мэдээллүүдээс ялгаатай болох ойлголт юм.

ТАНИН МЭДЭХҮЙН ОЙЛГОЛТ, ҮЙЛ ЯВЦ

Танин мэдэхүйн үндсэн ойлголт. Нийгмийн танин мэдэхүйн онол нь бидний өмнө нь тодорхойлсон энэхүү ерөнхий санаанаас гадна суралцах үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг ойлгоход маш хэрэгтэй бусад ойлголтуудыг багтаасан болно. Жишээлбэл, бидний хүлээн авсан шинэ

мэдээлэл бүрийг урьд өмнө тохиолдож байсан бусад ижил төстэй туршлагатай уялдуулан шалгаж үздэг гэж заасан байдаг.

Нөгөөтэйгөөр, энэхүү онол нь "ажиглалтын сургалт" гэж нэрлэгддэг түүнийг харуулсан бусад хүмүүсийг ажигласнаар л шинэ зан төлөв, санаа бодлыг олж авах боломжтой гэдгийг баталж байна. Нэмж дурдахад нийгмийн танин мэдэхүйн онолоос үүдэлтэй сургалтын үйл явц нь тухайн орчин биш ч гэсэн шинэ мэдээллийг хамгийн сайн аргаар олж авахын тулд субъектүүдын сэтгэл хөдлөлийн чадварыг дээшлүүлэхэд чиглэгддэг хамгийн тохиромжтой.

Танин мэдэхүйн сургалт. гэдэг нь уламжлалт сургалтын үзэл баримтлалыг хүний тархины үйл ажиллагааны талаар сүүлийн хэдэн арван жилд шинээр нээсэн нээлтүүдтэй хослуулсан нэр томьёо юм. Тиймээс энэ нь бидний оюун ухаан үр дүнгээ сайжруулахын тулд хэрхэн ажилладгийг харгалзан үздэг сургалтын хэлбэр юм. Танин мэдэхүйн сургалтын онол нь шинэ мэдээлэл хүлээн авах бүрдээ үүнийг цээжлэхээсээ өмнө тархиа боловсруулж, шүүж авдаг болохыг нээснээс үүдэлтэй юм.

Танин мэдэхүйн зан үйлийн онол. Танин мэдэхүйн зан үйлийн онол бол клиник сэтгэлзүйн ертөнцөд хамгийн чухал байр суурь эзэлдэг. Энэ нь хүний зан байдал, сэтгэл хөдлөл, итгэл үнэмшлийн хоорондын харилцааг судлахад чиглэгддэг. Эдгээр гурван хүчин зүйл харилцан бие биедээ нөлөөлдөг бөгөөд хүний туршлагыг ойлгоход үндэс суурь болно. Танин мэдэхүйн зан үйлийн онолыг сэтгэлзүйн эмчилгээний ертөнцөд түгээмэл ашигладаг. Энэхүү хандлага нь тухайн хүний бодол санаа, итгэл үнэмшил, зан аашийг өөрчлөх, тэдний сэтгэлийн байдал, ертөнцтэй харьцах харьцааг дээшлүүлэхэд чиглэгддэг. Сургалтын түвшинд танин мэдэхүйн зан үйлийн онол нь бидний цээжлэх мэдээлэлд онцгой нөлөө үзүүлдэг гурван элемент байдаг гэж өөрсдийгөө хэрхэн хардаг, хүрээлэн буй ертөнцийг хэрхэн хүлээн авч байгаа байдал, бидний бодож байгаа байдал зэрэг нь ирээдүйг хөгжүүлэх болно гэж хэлдэг.

Танин мэдэхүйн үйл явцын онол. Танин мэдэхүйн сургалтын онол нь бид зөвхөн шинэ мэдлэг олж авдаггүй гэдгийг баталж байна: шинэ мэдээллийг дотооддоо нэвтрүүлэх бүрдээ бид өмнө нь хадгалж байсан мэдлэгийнхээ өөрчлөлтийг бий болгодог. Тиймээс энэхүү онолын тайлбарласан үйл явц нь бусад ижил төстэй онолуудаас нэлээд өөр юм. Нэг талаас энэ сэтгэлзүйн онол нь бид хэзээ ч эхнээс нь сурч эхлэх боломжгүй

гэж баталж байна. Эсрэгээр, хүн аливаа сэдвээр урьд өмнө сурч мэдсэнээр олж авсан урьдчилсан таамаглал, хасалт эсвэл санаа бодлоороо үргэлж тодорхой мэдлэгтэй байдаг. Үүнээс үүдэн аливаа шинэ сургалтад шинэ мэдээлэл тухайн хүний тархинд аль хэдийн орсон байсан зүйлтэй харьцах шаардлагатай болдог. Энэ нь шинэ мэдлэгийг танилцуулсны дагуу хадгалах боломжгүй, харин хувь хүний оюун ухааны шүүлтүүрээр удирддаг гэсэн үг юм. Танин мэдэхүйн сургалтын онол нь шинэ мэдлэг олж авах дөрвөн алхмыг ярьдаг. Дараа нь бид тус бүрдээ яг юу бүрдэхийг харах болно.

Сурах гэж юу вэ? Хүн яаж сурдаг вэ? гэдэг асуудлыг судалдаг шинжлэх ухааныг когнитив сэтгэл судлал буюу суралцахуйн сэтгэл судлал[1] гэж нэрлэдэг бөгөөд орчин үед олон чиглэлтэйгээр хөгжиж байна. Хийсвэр түвшинд боловсролын философи, боловсролын онолын загварууд энд яригддаг бөгөөд эндээс хоёр чиглэл давуу хөгжиж ирсэн.

Мэдлэг бүтээх арга. Суралцагч харах, сонсох, хүртэх зэрэг сэрж мэдрэх эрхтнийхээ тусламжтайгаар мэдээллийг хүлээн авна. Өөрийн гэсэн утга өгөгдөөгүй, зөвхөн сонссон, харсан мэдээлэл нь хүний богино хугацааны санамж дээр ирж боловсрогдоно. Гэвч маш их хэмжээний мэдээлэл энэхүү санамжид хүрч чадалгүйгээр гээгдэх боломжтой байдаг. Мэдээллийн алдагдлыг багасгахын тулд суралцагчдын амьдралд байдаг, тэдний сонирхлыг татсан, тэдэнд сэдэл төрүүлэх сэдэв, асуудлаас сургалтыг эхлэх нь зүйтэй. Энэ нь дурын нэг асуудал биш, харин сургалтаар авч үзэх шинжлэх ухааны асуудлыг “дотроо агуулсан” байх учиртай.

Мэдээллийг боловсруулж, мэдлэг болгох. Мэдээллийг боловсруулах, мэдээллийг мэдлэг болгох хоёр арга зам байна. Гаднаас өгч буй мэдээлэл буюу багшийн хэлж ярьсан зүйлийг тэр чигээр нь хүлээн авах. Энэ үед хүлээн авсан мэдээлэл нь “цээжилсэн мэдлэг” байдлаар салангид байж байгаад мартагдана. Багш судлах зүйлийн талаар суралцагчид ямар төсөөлөл, мэдлэгтэйг тандаад, түүнийг тооцон сургалтыг зохион байгуулах нөхцөлд сурагчдын мэдлэг өмнөхөөс илүү цэгцтэй, илүү зөв, илүү өргөн хүрээний мэдлэг болон буцаж хадгалагдана.

Мэдээллийг хадгалах. Гадаад мэдээлэл ба өөрийн төсөөлөл, сонирхолд суурилан өөрийн зорилго, стратегийг идэвхтэй бүтээнэ. Сурч буй хүнд бодол санаа, сэтгэлгээгээ хянаж, шалгаж, зохицуулдаг нөөц байдаг. Энэхүү метакогнитив процессийг хариу үйлдлээр хэрэгжүүлдэг.

[1] http://ncle.mn/esd/files/1.2.2_gadnii_udirdlagatai_suraltsahuigaas_uuriin_udirdlaga.pdf

Өөрийн суралцахуйг тодорхой зорилгод хүрэхэд чиглүүлнэ. Иймд танин мэдэхүй, сэтгэлгээ, сэдэл тэмүүлэл, хандлагатай холбоотой үйл явцаа энэхүү зорилгод зохицуулан, боловсронгуй болгоно. Сургалтын амжилт нь зөвхөн гадаад нөхцөл байдлаар (материаллаг орчин) тодорхойлогдохгүй. Харин сурч буй хүн өөрийн танин мэдэхүй, сэтгэлгээ, сэдэл тэмүүлэл, хандлагаа сургалтын амжилттай хэрхэн уялдуулж байгаа нь шийдвэрлэх үүрэгтэй.

Мэдээллийг хэрэглэх. Өөрийн удирдлагатай суралцахуй Танин мэдсэн, өөрөө бүтээсэн мэдлэг, чадвар хандлагаа хөгжүүлэх ямар ч нөхцөл байдалд шилжүүлэн хэрэглэх чадварыг хэлнэ. Өөрийн удирдлагатай ба гаднын удирдлагатай суралцахуйг хэрэглэхдээ:

- ✓ Хаана, хэнд, хэдийд аль нь давуу байх вэ?
- ✓ Холимог хэлбэр
- ✓ Үүргийн хуваарилалтын ач холбогдол
- ✓ Мэргэжлийн соёл зэргийг нягталж тунгаах хэрэгтэй болно.

Суралцахуй ба багшлахуйг дараах байдлаар ойлгож, хэрэгжүүлэх хэрэгтэй.


1. Сурч буй хүний үйл ажиллагаа нь өөртөө хариуцлага хүлээсэн, өөрийн удирдлагатай, мөн багийн үйл ажиллагаанд баримжаалсан байна. Түүнчлэн ингэж сурахад шаардлагатай когнитив ба социал цогц чадамжийг эзэмших ба танин мэдэхүйн аргыг мөн сурах учиртай.

2. Когнитив цогц чадамж ба хариуцлагатай, өөрийн удирдлагатай суралцахуйн цогц чадамжийг ижил хэмжээнд дэмжих, ингэхдээ харилцан адилгүй суралцагчдын бие даасан болон багаар ажиллах сургалтын хэлбэрүүдийг ашиглах. Сургалт нь сурч буй хүмүүс, багшилж байгаа хүний хамтын үйл ажиллагааны үр дүн гэж ойлгох.

3. Багшийн ажил: Багийн хүрээнд сургалт ба түүний орчныг сайжруулах ахисан түвшний, удирдлага бүхий өөрчлөлтийн үйл ажиллагаа (хичээлийн хөгжил). Төсөл хэрэгжиж байгаа орон нутагт мэргэжил дээшлүүлэх замаар сургалтын хөтөлбөр ба сургах арга зүйгээ байнга өөрчлөх.

Дээрх агуулгын хүрээнд судалгаа авч үзэхэд:

График 1.Багш суралцагчдад мэдээллийг хүргэж, хүлээн авахад бэлддэг байдал




Хүснэгт 1. *Багш суралцагчдад мэдээллийг хүргэж, хүлээн авахад бэлддэг байдал*

	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
	Багш лекцийн хичээлд ашиглах танилцуулгыг бэлддэг байдал	35	0	52	6
	Багш лекцийн хичээлд ашиглах нэмэлт материалаар хангадаг байдал	30	6	64	13
	Багш лекцийн хичээлийг ойлгомжтой тайлбарладаг байдал	36	4	45	9

“Мэдээллийг хүртэж хүлээн авахад бэлдэх” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хуваах суралцагчдаас судалгаа авахад маш сайн-17.5, сайн үнэлгээ-43.3 буюу дийлэнх хувийг, дунд-26.3, хангалтгүй-4.6 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 2. Мэдээллийг хүртэж хүлээн авах байдал




Хүснэгт 2. Мэдээллийг хүртэж хүлээн авах байдал

	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
	Лекцийн хичээлийн агуулгын тодорхой байдал	32	95	55	3
	Хичээлийг дэлгэрүүлж унших материалыг зааж өгдөг	33	83	61	8
	Лекцийн хичээлийг дэлгэрүүлж унших хэрэгцээ шаардлагатай	28	95	56	6

“Мэдээллийг хүртэж хүлээн авах байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хуваааж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-15.5, сайн үнэлгээ-45.5 буюу дийлэнх хувийг, дунд-28.6, хангалтгүй-2.8 буюу дунджаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 3. Мэдээллийг ухаарч ойлгох байдал




Хүснэгт 3. Мэдээллийг ухаарч ойлгох байдал

	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
	Хичээлийн агуулга логик дэс дараалалтай байдаг	29	90	61	5
	Хичээлийн явцад шинэ мэдлэг олж авдаг	30	100	50	5
	Хичээлийн төгсгөлд өөрийн гэсэн дүгнэлтийг хийж чаддаг	33	77	67	7

“Мэдээллийг ухаарч ойлгох байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хуваж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-15.3, сайн үнэлгээ-44.5 буюу дийлэнх хувийг, дунд-29.6, хангалтгүй-2.8 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 4. Мэдээллийг бататгаж мэдлэг олгох байдал




Хүснэгт 4. Мэдээллийг бататгаж мэдлэг олгох байдал

	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
	Лекцийн хичээл, семинарын хичээл уялдаа холбоотой байдаг	37	82	59	5
	Семинарийн хичээлээр зөвхөн лекцийн хичээлийг бататгадаг	33	83	59	8
	Семинарын хичээлээр бие даана жиллаж чаддаг	40	88	50	5

“Мэдээллийг бататгаж мэдлэг олгох байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хуваж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-18.3, сайн

үнэлгээ-42.1 буюу дийлэнх хувийг, дунд-28, хангалтгүй-3 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 5. Мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших




Хүснэгт 5. Мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших

	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
	Онолын мэдлэгийг ашиглах боломж гардаг	34	89	58	3
	Кейс, бодомж дээр ажиллахад онолын мэдлэг хангалттай байдаг	29	91	56	8
	Лекцийн хичээлээр олж авсан мэдлэг мэдээлэл дасгал, бодлого ажиллахад ашиглагддаг.	33	83	60	7

“Мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хуваж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-16, сайн үнэлгээ-43.8 буюу дийлэнх хувийг, дунд-29, хангалтгүй-3 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

График 6. Мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдал



Хүснэгт 6. Мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдал

	Үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дунд	Хангалтгүй
	Би өөрийгөө үнэлж шүүмжилж чаддаг	34	91	56	2
	Би өөрийн алдааг хүлээн зөвшөөрч илүү сайжруулах арга зам хайдаг	42	83	55	3
	Багшийн үнэлгээтэй би санал нийлдэг	34	79	58	9

“Мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдал” үйл явцыг 3 үндсэн шалгуурт хуваж суралцагчдаас судалгаа авахад маш сайн-18.3, сайн үнэлгээ-42.1 буюу дийлэнх хувийг, дунд-28.1, хангалтгүй-2.8 буюу дундажаас бага гарсан үр дүнг дээрх үзүүлэлтээс харж болно.

ДҮГНЭЛТ

Иймд багш нар суралцагчдад мэдлэг, мэдээллийг хүргэх, сургалт зохион байгуулахад сурган хүмүүжүүлэх ухааны мэдлэгээс гадна сэтгэл зүйн шинжлэх ухааны талаарх ойлголт мэдлэгийг, сургалтын үйл явцтай хэрхэн уялдуулах, сургалтад удирдагчийн байр сууринаас хандах бус суралцагчийн танин мэдэх үйл явцад оролцогч, чиглүүлэгч, зөвлөгчийн байр сууринаас оролцох, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжигч болохыг ойлгуулах арга зүйг сургалтад түлхүү ашиглах нь зүйтэй гэж үзлээ.

Багш хүний өдөр тутмын хийж гүйцэтгэж буй сургалт, түүний талаарх онол, үзэл санаа, ойлголт ухагдахуун, сургалтын төрлөөс шалтгаалан ямар арга, арга зүйг хэрэглэх, энэхүү арга зүйг хэрэглэж сурах нь бидний олгох гээд байгаа мэдээллийг суралцагчид хэрхэн өөрийн болгож боловсруулж сурах, сурах үйл ажиллагаа болгох шаардлагыг олж харан өөрийн судалгааны ажлаас эх сурвалж авч асуулга хэлбэрээр 100 гаруй суралцагчыг хамруулан, багш мэдээллийг хүртэж хүлээн авахад бэлдэх, бататгаж мэдлэг олгох байдал суралцагч мэдээллийг хүлээн авах, ухаарч ойлгох байдал, мэдлэгийг хэрэглэх чадвар, хандлага төлөвших, мэдлэг чадвараа хянах, үнэлэх байдлаар тус тус асуулга боловсруулахад маш сайн, сайн үзүүлэлт 60%-70% хувь, 30%-40% хувьд дунд, хангалтгүй гэж хариулсан нь сурах, суралцах үйл явцад суралцагчийн хандлага мөн багшийн заах арга зүй ямар түвшинд байгааг тодорхой харуулж байна гэж дүгнэлтэд хүрлээ.

ЭХ СУРВАЛЖ

1. НОМ, СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА

1. Ш.Ичинхорлоо., Сургалтын зарим үзэл онол: Мөн чанар, хэрэглээ. УБ хот, 2013 он

2. Ш.Ичинхорлоо., Дээд сургуулийн сургалт: Онол, арга зүй, УБ хот, 2015 он

3. Ш.Ичинхорлоо., Сурахуй хийгээд сурах арга , УБ хот, 2019 он

4. Жантэн Каяа., Багшид өгөх зөвлөгөө, Емпати хэвлэлийн газар, 2 дахь хэвлэл

5. ХСИС-ЭЗНУС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны багшийн хөгжлийн асуудалд: Онол, арга зүйн хэлэлцүүлгийн эмхэтгэл, УБ хот, 2018 он

2. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. https://mn.wikipedia.org/wiki/

http://ncle.mn/esd/files/1.2.2_gadnii_udirdlagatai_suraltsahuigaas_uuriin_udirdlaga.pdf

---o0o---

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS OF INVESTING IN CHILDREN'S DEVELOPMENT

Ц.Өнөболд

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Хураангуй: Хүний хөгжлийн хамгийн эрчимтэй, чухал үе болох бага насны хөгжил, боловсролыг дэмжих нь насан туршийн ухаалаг хөрөнгө оруулалт болохыг олон судалгаа нотолж байна. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хамгаалал, хөгжил боловсролыг нэгдмэл хандлага, арга зүйгээр дэмжиж ажиллах нь Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын нэг болж байна. Тогтвортой хөгжлийн зорилтууд болон Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал 2030-д зургаа хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж, хамгаалал, хөгжил боловсролын зорилтуудыг илрүүлэх үзүүлэлтийг нарийвчлан тусгасан. “Хүн болгон адилгүй хүлэг болгон жороогүй гэдэг ардын зүйр цэцэн үгэнд хүүхэд бүрийн зан төлөв, сэтгэлзүйн байдлаасаа хамаараад сурах арга барил, чадвар өөр гэдгийг илэрхийлдэг. Эдгээр чадвар хүүхдийн бага насанд нь бүрэлдэн бий болж, насан туршдаа хэрэглэх олон чадавхийг бий болгодог байна. Үүнийг Эдийн засгийн салбарын Нобелийн шагналтан Жеймс Хекман “Хүний капиталын онолыг ашиглан ядуу амьдралтай гэр бүлүүдэд учирч буй тэгш бус байдал нь хүний капиталын хөгжлийн түвшин доогуур ялангуяа танин мэдэхүйн чадварын тэгш бус байдлаас үүдэлтэй гэдгийг нотолсон. НҮБ-гийн сангийн гүйцэтгэх захирал “ Улс орны хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлэх эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг дэмжих, тэгш боломжийг өргөжүүлэх нэн ядуурлыг арилгах хамгийн чухал арга зам бол бага насны хүүхдэд хөрөнгө оруулах юм гэжээ. Бидний балчир насандаа туулж өнгөрүүлсэн туршлага тархины хөгжилд нөлөөлж, насанд хүрсэн хойноо ямар хүн болоход нөлөөлдөг.

Тиймээс судалгааны ажилдаа хүүхдийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын онолын агуулгыг судлан, эцэг эхчүүдийн хүүхдийнхээ

хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтын талаарх ойлголт, ямар бэрхшээл байгааг тодруулан цаашид шийдвэрлэх арга замыг хамтран зөвлөлдөж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор энэхүү илтгэлийг бичлээ. Илтгэл нь оршил \түлхүүр үг, судалгааны зорилго, зорилт, сэдвийн үндэслэл, судалгааны арга зүй, судалгааны ач холбогдол, шинэлэг тал, дэвшүүлж буй таамаглал, \ Үндсэн хэсэг \ Онолын ойлголт, судалгааны хэсэг, туршиж хэрэгжүүлсэн байдал ,судалгааны үр дүн, \ Төгсгөл хэсэг \ Судалгааны ерөнхий дүгнэлт, ном зүй \ гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

Summary:Numerous studies show that supporting early childhood development and education, the most intensive and critical period of human development, is a wise lifelong investment. Supporting the health, nutrition, care, protection, development and education of young children with a unified approach and methodology is becoming one of Mongolia's priority development goals. The Sustainable Development Goals and Mongolia's National Development Concept 2030 include detailed indicators for detecting health, nutrition, care, protection, and development goals for children under the age of six. "Every person is not created equal. The proverb means that every child has different learning methods and abilities depending on their behavior and psychological state.These abilities are formed at a young age and create many abilities that can be used throughout life. James Heckman, winner of the Nobel Prize in Economics, used the theory of human capital to prove that inequality in poor families is caused by low levels of human capital development, especially inequality in cognitive abilities.

The Executive Director of the United Nations Fund said that investing in young children is the most important way to eradicate extreme poverty and promote inclusive economic growth that will increase the country's prosperity and expand equal opportunities. The experiences we go through in childhood affect the development of the brain and shape the person we become as an adult.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монголын ард түмний харилцааны үнэт зүйлсийн нэг нь “Миний хүүхэд надаас илүү сайхан амьдрах ёстой” хэмээх философи төдийгүй өрх гэр бүл, ээж аав бүр үр хүүхдийнхээ төлөө бүхнийг зориулах нандин уламжлалтай. Орчин үеийн нийгэм, гэр бүлийн амьдралын хэв шинж энэхүү нандин уламжлал алдагдаж байна. Ээж, аав нар ажилтай, завгүй гэдэгт өөрийгөө итгүүлж улмаар үр хүүхдэдээ цаг гаргаж хамтдаа байх нь багасаж, хүүхдээ үл хайхрах, дэлгэцийн хамааралтай болох, хараа

хяналтгүй орхих, эсвэл ажил, хэн нэгнээс шалтгаалсан уур бухимдлаа хүүхдээ гаргах, тэднийг хараан загнах, зодох зэргээр зүй бусаар харилцах нь буурахгүй байна. Бага насны хүүхэдтэй холбоотой санаатай болон санамсаргүй гэмт хэргийн тоо өдөр тутам нэмэгдсээр. Нөгөө талаас өрхийн орлогын түвшин доогуур, ядуу зүдүү амьдралтай байх нь гэр бүлд бага насны хүүхдийн хөгжлийг зохистой хэлбэрээр дэмжиж чадахгүй байх бас нэгэн шалтгаан болж байна. Учир нь 3 настай хүүхдийн тархи насанд хүрсэн хүний тархинаас хоёр дахин илүү идэвхтэй, хурдтай, уян хатан байдаг. Гэтэл тархины хурд буюу уян хатан байдал нь 7 насны орчимд 50 хувиар буурдаг гэдгийг тархи судлалын эрдэмтэд нотолж байна [1]

Тогтвортой хөгжлийн зорилт 4.2. 2030 он гэхэд бүх охид, хөвгүүд бага насны хүүхдийн хөгжил, асаргааны чанартай үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, улмаар бага боловсрол эзэмшихэд бэлтгэгдсэн байна. Энэхүү зорилт нь бага насны хүүхдэд оруулах хөрөнгө оруулалт нийгмийн тогтвортой хөгжлийн тулгуур гэдгийг илэрхийлж байна.

Монгол улсын үндсэн хуулийн 17.2 “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” [2] гэж заасан нь эцэг эхийн хүлээсэн үүргийг чухалчилж, ухамсарлуулах үндэс нь болж өгсөн.

Хүүхдийн хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтын тухай

Дэлхийн өнцөгт булан бүрт бизнесийн салбарт ажиллаж буй биенесменүүд өөртөө хэрэгтэй, ирээдүйд ашиг олж чадах салбарт хөрөнгө оруулж ашгаа тооцоолдог. Тэгвэл хүн төрөлхтөний хамгийн үнэ цэнэтэй зүйл юу вэ? Энэхүү асуултанд олон хариулт ирэх боловч, эцсийн дүнд энэ бол бидний хойчийг залгамжлах үр хүүхэд гэдэгтэй хүн бүр санал нийлэх биз. Өнөөдрийн байдлаар монголд 1 сая гаруй хүүхэд өсч, хүмүүжиж буй боловч, тэдгээр хүүхдүүдийн хэдэн хувь өөрийн амьдралыг хэний ч гар харахгүй цогцлоож чадах чадвартай болж байгааг хэн ч таашгүй. Улс орон хүчирхэг болохын тулд хүн амын өсөлтөө анхаарах хэрэгтэй. Хүнээ өсгөхийн тулд хүүхдийнхээ ирээдүйд оюуны болоод материаллаг хөрөнгө оруулалтыг хийснээр бид өндөр хөгжилтэй орнуудтай мөр зэрэгцэн алхах болно. Эдийн засгийн салбарын Нобелийн шагналтан Жеймс Хекман “Бага

[1] Нилсон, 2000

[2] Монгол улсын Үндсэн хууль.,УБ.,1992 он; 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, https://legalinfo.mn/mn/detail/367 ;

насны хүүхдийн хөгжилд оруулсан хөрөнгө нь эдийн засагт хамгийн өндөр өгөөжтэйг тодорхойлсон. (Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтын өгөөжийн муруй

Зураг 1. Хөрөнгө оруулалтын өгөөж



Хүний тархины хөгжлийн хамгийн эрчимтэй үе болох зургаа хүртэлх насанд хоол тэжээл, хайр халамж, энэрэнгүй сэтгэл дутагдвал хожим нь засаж залруулах боломж бага, бас маш өндөр зардалтай аж. Ядуу төрсөн эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд амьдардаг сэтгэцийн өдөөлт хүмүүжил багатай хүүхдүүд баян өссөн хүүхдүүдээс оюун санааны хувьд хоцрогдолтой өсөх магадлал өндөр байдаг. Эдгээр хүүхдүүд хичээлдээ тааруухан, ур чадвар муутай, хамгийн бага цалин авдаг. Хүүхдийн амьдралын эхний хэдэн жил онцгой чухал байдаг. Хүүхдийн бага нас нь хүний эрүүл мэндэд чухал ач холбогдолтой. Хүний капиталын хуримтлал нь амьдралын мөчлөгийн динамик үйл явц бөгөөд ур чадварыг бий болгодог байна. Дараах 3 санаа нь бага насны хүүхдийг ойлгох түлхүүр болж байна.

1. Насанд хүрэгчдийн чадавхийг төлөвшүүлэхэд гэр бүлийн амьдрал, хүүхдийн бага нас чухал үүрэг гүйцэтгэдэг. Ж.Хейкман чадвар нь төрөх үед тогтдоггүй, харин эцэг эхийн хүүхэддээ оруулсан хөрөнгө оруулалтаас шалтгаалдаг ба сул талыг нь зөв хэмжих нь эцэг эхийн хүмүүжил, тууштай байдал, хяналт чухал үүрэгтэй гэж үзээ.

2. Олон чадвар нь хувь хүний нийгэмд ажиллах чадварыг бүрдүүлдэг. Үндсэн чадварууд нь танин мэдэхүй болон танин мэдэхүй бус аль аль нь амьдралын олон салбарт амжилтад хүрэхэд тусалдаг.

3. Чадвар бүрэлдэх нь синергитик шинж чанартай байдаг. Учир нь нэг чадвар нь нөгөө чадвараа сайжруулдаг. Өөрөөр хэлбэл чадвар

чадваруудыг бий болгодог. Танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус чадварууд динамикаар харилцан үйлчилж, хөгжлийн хувьслыг бий болгодог. Эцэг эхчүүд тууштай байх, хамтран ажиллах, урам зориг өгөх цагийг илүүд үзэх нь хүүхдийнхээ капитал буюу чадварт хөрөнгө оруулж байгааг илэрхийлдэг байна. Тэрээр зургаа хүртэлх насны хүүхдийн хөгжилд оруулсан 1 доллар тутмын өгөөж нь 12.90 доллар болохыг тооцоод, "Энэ хөрөнгө оруулалт нь зөвхөн боловсрол эзэмшиж буй хүмүүсээс гадна улс орны эдийн засгийн хөгжилд өндөр ашигтай" учраас хөгжлийн стратегийн амин чухал хэсэг гэж дүгнэжээ.

4. Ж.Хекман хэлэхдээ, "Төрийн албан тушаалтнууд хүүхдийн амьдралын үе шат бүр нь нөгөөгөөсөө хамааралгүй, өмнөх болон ирээдүйд хүлээж буй зүйлтэй холбоогүй юм шиг, амьдралынхаа туршид даршилсан газар амьдарч байгаа мэт хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр боловсруулдаг. Бодлого боловсруулагчид хүүхэд, залуучуудад тогтвортой, үр ашигтай хөрөнгө оруулалт хийснээр өөрийгөө нөхөж чадна гэдгийг ухамсарлаж эхлэх цаг нь болсон."Урьдчилан сэргийлэх боломжтой байсан зүйлийг засч залруулахын тулд хожим мөнгө төлөхөөс илүүтэйгээр хүүхдийн чадавхийг нэмэгдүүлэх боломжтой Тиймээс бид амьдралынхаа эхний жилүүдэд илүү цогц арга барил буюу "эхнээсээ тэгш байдал"-аас эхлэх ёстой.

"НҮБ-ын Хүүхдийн сангийн Гүйцэтгэх захирал Энтони Лэйк хэлэхдээ, "Биологи бол хувь тавилан биш бөгөөд хүүхдүүдийн амьдралын эхний өдрүүд, он жилүүд нь тэдний ирээдүйг бүрдүүлж, тодорхойлдог гэдгийг шинжлэх ухаан бидэнд харуулж байна. "Бид энэ шинжлэх ухааныг түгшүүрийн хонх болгон хувиргах хэрэгтэй - учир нь сая сая хүүхдийн хөгжил яаралтай эрсдэлд орж байна. Яг одоо бага, дунд орлоготой орнуудын хүүхдүүдийн 43 хувь нь танин мэдэхүйн чадавхдаа хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Аль ч улс хамгийн залуу иргэдийнхээ тархины чадавхийн бараг тал хувийг, тэр дундаа бага, дунд орлоготой орнуудыг алдах эрсдэлтэй байж чадахгүй.[1]

АНУ-ын сэтгэл зүйч, эдийн засагч, социологич, хүн ам зүйч, улс төр судлаач, нийгмийн ажилтан, эмнэлгийн эмч нар хүүхдийн хөгжилд нөлөөлж буй үйл явцын талаар дүгнэн, хүүхдэд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хэрхэн ухаалгаар нэмэгдүүлэх, тэдний сайн сайхан байдал болон хойч үеийнхээ бүтээмжийг дэмжих нь чухал гэж үзжээ.

[1] НҮБ-ын Хүүхдийн сангийн Гүйцэтгэх захирал Энтони Лэйк

Хүүхдэд хийгдэж буй хөрөнгө оруулалтыг судалж, хүүхэд насанд хүрсэн хүний хувьд ажил, гэр бүл, нийгэмд амжилт гаргахад шаардлагатай ур чадваруудыг хөгжүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцэн, ядуурал, тэгш бус байдлын мөчлөгийг эвдэх хүүхдэд хөрөнгө оруулалт хийхээс илүү сайн арга байхгүй гээд 5 үндсэн чиглэлд хөрөнгө оруулалтыг өргөжүүлэхийг санал болгосон байна.

1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөр;

2. Хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн бага насны хүүхдийн оролцоо;

3. Хүүхэд асрах, сургуулийн өмнөх боловсролын чанарыг дээшлүүлэх арга хэмжээ;

4. Хичээлийн дараах болон зөвлөх хөтөлбөрүүд;

5. Бага орлоготой гэр бүлийн өндөр чадвартай залуучуудын коллежид хамрагдах түвшинг дээшлүүлэх хөтөлбөрүүд. [1]

Судлаач Ж.Хейкманаас гадна Вашингтоны Lancet сэтгүүлийн судалгааны тайланд

“Бага насны хүүхдийн хөгжилд хөрөнгө оруулах нь илүү олон хүүхэд, олон нийтийг цэцэглэн хөгжихөд нь чухал ач холбогдолтой болохыг тогтоожээ. Эрүүл мэнд, хоол тэжээл, анхаарал халамж тавих, аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах, эрт сургах зэрэгт чиглэсэн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээнүүд нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Дэлхийн Банк, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг байгууллагууд энэхүү цуврал арга хэмжээнд хувь нэмрээ оруулж, заавар өгсөн. Бага насны хүүхдийн хөгжилд дэлхий нийтийн үүрэг амлалтыг нэмэгдүүлэхийн чухлыг онцолж байна. Идэвхгүй байдлын үр дагавар нь зөвхөн одоо төдийгүй ирээдүй хойч үедээ нөлөөлдөг. Хүүхдийн тархи эхний 2-3 жилд амьдралын бусад үетэй харьцуулахад илүү хурдан хөгждөг. Бага насны хүүхдүүд хоол тэжээл, өдөөлт, хамгаалалтгүй байх үед хор хөнөөлтэй үр


[1] Sheldon Danziger, Russell Sage FoundationPreviously, University of Michigan8 Ph.D. Economics,

дагавар нь гэр бүл, нийгэмд урт хугацааны хор хөнөөл учруулж болзошгүй юм. [1]

СУДАЛГААНЫ ХЭСЭГ


Эцэг эх бүр хүүхэддээ хөрөнгө оруулалт хийж чадаж байна уу? Хүүхдийнхээ хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтад ямар бэрхшээл тулгарч байна вэ? Хөрөнгө оруулалт гэдгийг эцэг эхчүүд юу гэж ойлгодог вэ? гэсэн ерөнхий агуулгыг тодруулах зорилгоор Улаанбаатар хотын БЗД, Хан-уул дүүргийн 151 эцэг эхчүүдээс асуулгын аргаар судалгаа авч боловсруулллаа. Судалгаанд 91 эмэгтэй, 60 эрэгтэй хамрагдлаа.


1.Хүйсийн харьцаа





2. Нас








Оролцогчдын хүйсийн харьцааг харвал эмэгтэйчүүд хүүхдийнхээ ирээдүйд илүү анхаардаг болох нь харагдаж байна. Насны үечлэлээр харвал 36-аас дээш насныхан судалгаанд идэвхитэй хамрагджээ.

3.Оролцогчдын ажилладаг байгууллага

4.Та хүүхэддээ зав гаргаж чадаж байна уу?










[1] Профессор Линда М.Ричтер, ДСТ-NRF-ийн Хүний хөгжлийн шилдэг төв, Витватерсрандын их сургууль, Йоханнесбург, Өмнөд Африк.

Судалгаанд оролцогчдын 36-38 хувь төр болон хувийн хэвшилд ажилладаг ба 56 хувь нь хүүхэддээ зарим үед л зав гаргаж чаддаг гэж хариулжээ. Үүнээс харахад эцэг эхчүүд хүүхэддээ гаргах цаг зав хомс байгааг харуулж байна.

5.Та хүүхэддээ хэзээ зав гаргах боломжтой байдаг вэ? Гэсэн асуултад



Оролцогчдын 70,5 хувь нь амарсан үедээ л хүүхэддээ зав гаргах боломжтой гэж хариулнаас харахад ажлын цагаа өөрсдөө гаргадаг хувийн хэвшилд ажиллаж байгаа эцэг эхчүүд хүүхэддээ гаргах цаг зав тун ховор байх магадлалтай. Зориуд цаг гаргаж буй 27 хувийг эзэлж буй эцэг эхчүүдэд талархмаар. Улс орныхоо ирээдүйд үнэтэй хөрөнгө оруулалт хийж байгаа хэрэг юм.


6.Та хүүхдийнхээ хөгжилд оруулж буй хөрөнгө оруулалтыг юу гэж ойлгодог вэ гэсэн асуултыг эрэмбээр жагсаавал

1. Боловсрол
2. Хүүхэддээ хөрөнгө оруулах ёстой
3. Ирээдүйн баталгаа
4. Гэр бүлийн хүмүүжил, цаг баримтлах хоёр хамгийн том хүмүүжил
5. Оюунд нь хөрөнгө оруулах
6. Сонирхлыг сонсож, сурч боловсрох хэрэгцээг нь хангах
7. Сэтгэл оюун санааны боловсрол
8. Хүмүүжил, хүүхэддээ өгч болох бүх зүйл
9. Чин сэтгэлийн харилцаа, зөв хайрлах, ирээдүйдээ итгэлтэй болгох, сургааль
10. Байх ёстой зүйл
11. Эрх чөлөө
12. Сургалтад хамруулах
13. Хэдэн төгрөг өгөхөөс шалтгаална-?

Дээрх хариултуудаас харахад эцэг эхчүүд хөрөнгө оруулалт гэдгийг боловсрол, зөв хайрлах, гэр бүлийн хүмүүжил, цаг баримтлах, чин сэтгэлийн харилцаа гэж ойлгож байгаа эцэг эхчүүд хүүхэддээ цаг зав гарган хүнийг хүн болгоход илүү анхаардаг гэж үзэж байна. Түүнчлэн хүүхэддээ өгч болох бүх зүйл гэсэн хариултад оюуны болон материаллаг хөрөнгө оруулалтыг хоёуланг ойлгож болно. Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнэтэй баялаг бол үр хүүхэд, тэдний хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.


6.Та хүүхэддээ өгч буй хамгийн чухал хөрөнгө оруулалтыг юу гэж боддог вэ?

.



Дээрхи асуултад эцэг эхчүүдийн 25 хувь аюулгүй орчин, 29 хувь нь эрүүл, мэнд, боловсрол, 30 хувь хүмүүжил, төлөвшил, 6,8 хувь нь эд хөрөнгө гэж хариулснаас харахад орчин үеийн эцэг эхчүүд эд хөрөнгийг хүүхдэд өгөх хөрөнгө оруулалт гэж үзэхгүй байгаа нь сайшаалтай.

7.Та хүүхэддээ хөрөнгө оруулж чадаж байна уу? 8.Та ямар хөрөнгө оруулж байна вэ?




Дээрхи асуултын хариултаас харахад эцэг эхчүүдийн 65.9 хувь нь хүүхэддээ хөрөнгө оруулалт хийж чадаж байна гэж үзсэн бол 29.5 хувь чадахгүй байна гэж хариулсан байна. 29.5 хувийг эзэлж буй хариултын цаана нийгмийн олон асуудлуудын дунд хүүхэддээ цаг, мөнгө гаргаж чадахгүй байгаа эцэг эхчүүдийн төлөөллүүд юм. Эцэг эхийн төлөөллийн 63.6 хувь нь оюуны хөрөнгө оруулалт, 25 хувь нь материаллаг хөрөнгө оруулалт өгч байна.

9. Та хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулахад ямар бэрхшээл тулгарч байна вэ? гэсэн асуултад



Эдгээр хариултууд санхүүгийн хязгаарлагдмал байдал, цаг наргүй ажлын ачаалал, нийгмийн аюултай нөхцөл, үе тэнгийхэний сөрөг дадлаас болж, хүүхдийн ирээдүйд хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгааг илэрхийлж байна. Эцэг эхчүүд бид санхүүдээ баригдаад наад захын материаллаг хэрэгцээг хангаад, хүмүүжил төлөвшилийг нь орхигдуулаад байх хандлага ажиглагддаг.

10. Тулгарч буй бэрхшээлийг шийдэх арга замуудаас нэрлэнэ үү? гэсэн асуултад




Эдгээр хариултууд эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжилд өөрийн боломжоороо хөрөнгө оруулах аргаа шийдэж буй боловч, оролцогчдын 18 хувь нь мэдэхгүй, мөн хариулаагүй байгаагаас харахад мухардалд орсон байгаа нь харагдаж байна. Дээр шараар бичигдсэн хэсгүүд бол хөрөнгө оруулалтын чухал арга замууд гэж дүгнэж байна. Өөрөө хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулж чадаж байгаа ч хүмүүжилгүй, хайхрамжгүй хүүхдүүдээс болж сөрөг үр дагавар бий болж байгаа нь тэдний хариултаас харагдаж байна.

Судалгааны үр дүн

- Эцэг эх болгон хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулах хэрэгцээ их байгаа хэдий ч хэрэгцээг хангах санхүү болоод цаг наргүй ажлын ачаалал, үл ойлголцлоос болоод бэрхшээл тулгардаг байна.
- Судалгаанд оролцогчдын ихэнхи хувь хүүхдийнхээ оюуны боловсролд хөрөнгө оруулалтад илүү анхаарч, цаг үеийн шаардлагыг бүрэн ойлгож байгаа ч, зөвхөн боловсролд нь анхааралд сэтгэлийн боловсрол, хүмүүжлийг нь орхигдуулж байгаа нь ажиглагдлаа.

Хүүхдийхээ хөгжилд хэрхэн хөрөнгө оруулалт хийх вэ?

Хүүхдийн эрхийн конвенцед нэгдэн орсноор төр засгийн зүгээс хойч үедээ анхаарах, тэдэнд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Хорвоод төрүүлсэн үрээ хүний дайтай өсгөж, хүмүүжүүлэх нь эцэг эх бүрийн туйлын хүсэл байдаг. Бид судалгааны үр дүнд үндэслэн хүүхдийнхээ хөгжилд хэрхэн хөрөнгө оруулах талаар ямар арга зам, боломж байгааг эрэлхийлэв. Монголын нийгэмд амьдарч буй гэр бүлийн амьдралын түвшин харилцан адилгүй боловч, эцэг эхчүүд юуны өмнө дараах чиглэлд анхаарлаа хандуулж, хөрөнгө оруулалт хийснээр өөрийнхөө төдийгүй хүүхдийнхээ ирээдүйд үнэтэй хувь нэмэр оруулах болно. Үүнд:



1. **Эрүүл мэнд**-Хүний амьдралын эхний 1000 хоногт нь эрүүл мэндийн суурь тавигдаж, бие эрхтэн хөгжин дархлаажиж, оюун хөгжлийн эх суурь тавигдаж, бодисын солилцооны хэтийн төлөв тодорхойлогддог тул эцэг эхчүүд ураг эхийн хэвлийд бүрэлдэн бий болсон мөчөөс эхлэн 2 нас хүртэлх хугацаанд хүүхдийг хамруулах ёстой вакцин, авах ёстой аминдэм, асаргаа сувилгааны талаар маш сайн мэдээлэлтэй байх нь эрүүл мэндийн чухал хөрөнгө оруулалт болно.

2. **Боловсрол-** Тархины жингийн 87% нь (энэ нь 1100 грамм орчим) гурав хүртэлх насанд бүрддэг.[1] Тархины хөгжлийн үндсэн жор нь "өдөөлт ба хариу үйлдэл" байдаг байна. Энэ нь хүүхэд өөрийн шулганаа, нүүрний хувирал, дохио зангаагаараа насанд хүрэгчдийн анхаарлыг өөртөө хандуулж чаддаг ба насанд хүрэгчид түүний хариуд уян зөөлнөөр дуудах, инээмсэглэх, хүссэн үйлдлийг нь хийх өгөх явдал юм. Эцэг эхчүүд янз бүрийн тоглоомын аргаар хүүхдийнхээ юу бодож байгааг мэдэж авах. Жишээ нь Жо-Харригийн сэтгэлийн цонх арга[2]

3. **Хүмүүжил, орчин –** Эрүүл аюулгүй нийгэмд хүүхдээ өсгөхийн тулд эцэг эхчүүд хараа, хяналтаа өндөржүүлж, шаардлагатай тохиолдолд сургалтад хамрагдаж, мэдээлэл авч байх ёстой. Эцэг эхчүүд бол хүүхдийнхээ толь байдаг. Ялангуяа хүүхэд аавынхаа хэлсэн үг сургааль, үйлдлийг хамгийн сайн тогтоодог гэдгийг эрдэмтэд судалгаагаар тогтоосон тул гэр бүл дэх аавын үүргийг өндөржүүлж, хүүхдийнхээ насны онцлог, зан чанарын талаар мэдлэг мэдээлэл сайтай байх нь аавуудын гэр бүлдээ оруулж буй хөрөнгө оруулалт юм. Бага боловсролын түвшинд суралцаж байгаа хүүхдүүдийн эцгийн боловсрол, ажил эрхлэлт, өрхийн орлого нь анхаарал, сэтгэхүйн хөгжилд нөлөөлсөн. [3]

4. **Хоол тэжээл-** Хоногт хэрэглэвэл зохих нэр төрлийн хүнсийг насандаа тохирсон давтамж, хэмжээгээр хэрэглэж буй хүүхдийг "Зохистой байдлаар хооллож буй хүүхэд" хэмээн үнэлэгддэг байна. Манай улсын 6-23 сартай хүүхдийн 43.8 хувь зохистой байдлаар хооллож байгааг судлаачид илрүүлсэн. [4] Зохистой байдлаар хооллож буй хүүхдийн үзүүлэлт хот хөдөөгөөр, бүс нутгаар, өрхийн аж байдлын түвшнээр ялгаатай, тэгш бус байдал бий болсоор байна. Судлаач Ж.Хейкман хүүхдийн хөгжилд бага

[1] Декабан, 1978
[2] Чадамжид суурилсан сургалтын гарын авлага.,УБ.2013
[3] Боловсролын хөгжил, судалгаа арга зүй.,УБ 2018
[4] Бага насны хүүхдийн цогц хөгжил., 2020

насанд нь илүү анхаарвал эдийн засгийн үр өгөөж, хүүхдийн ур чадварын үзүүлэлтэд эерэгээр нөлөөлдөгийг баталсан эрдэмтэн юм.

5. **Хөрөнгө-** Оюуны болоод материаллаг хөрөнгө, сэтгэлийн боловсрол болох хүмүүжил төлөвшлийг бага насанд нь зөв чиглүүлж чадвал, үнэлж баршгүй үнэт хөрөнгө бий болно. Өнөөгийн нийгэмд бид хүүхдийнхээ оюунд хөрөнгө оруулж байгаа гэх боловч, сэтгэлийн боловсрол, хүмүүжлийг орхигдуулсны улмаас ялангуяа өсвөр насны хүүхдийн санаанаас гарамгүй гэмт хэргүүд нийгэмд бий болсоор байна.

Энэ бүхний дүнд эцэг эхчүүд бид хүүхдийнхээ хөгжилд хөрөнгө оруулахын тулд өөрсдөө эхлээд гэр бүлийн боловсролтой, эцэг эх байх ямар үнэ цэнэтэй вэ гэдгийг ухаарч ойлгох шаардлагатай байгаа нь нийгэмд гарч буй хүүхдийн эрх зөрчигдсөн, хохирсон олон жишээг бид бэлхнээ харж байна.

ДҮГНЭЛТ

Ирээдүйд нөөц бий болгох хүлээлтэйгээр өнөөгийн нөөцийг хуваарилан ашиглах үйл ажиллагаа бол хөрөнгө оруулалт. Хүн болж төрсний утга учрыг ойлгох гэж өөрт байгаа боломжоо үр хүүхдийнхээ төлөө хэрэгтэй цагт нь ашиглаж чадах ухаан бол эцэг эхийн тэдэнд өгч буй үнэт хөрөнгө юм. Бидний судалгаагаар дэвшүүлсэн:

Таамаглал 1 “Хүүхдийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтыг онолын үүднээс судлах нь түүн дэх бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох боломжтой” гэсэн таамаглал Ж.Хейкийн “Хүний капиталын онолыг ашиглан ядуу амьдралтай гэр бүлүүдэд учирч буй тэгш бус байдал нь хүний капиталын хөгжлийн түвшин доогуур ялангуяа танин мэдэхүйн чадварын тэгш бус байдлаас үүдэлтэй гэсэн онолын агуулгаар тодорхойлогдож байна. Нийгэмд тэгш бус байдлыг багасгахын тулд төрөөс бага насны хүүхэд рүү чиглэсэн эрүүл мэнд боловсрол, хүмүүжлийн цогц бодлогыг хэрэгжүүлж, санхүүжүүлэх хэрэгтэй.

Таамаглал 2 Эцэг эхийн хүүхэддээ зарцуулах цаг хомс байдаг нь санхүүгийн эрх чөлөөгүй байдалтай холбоотой гэсэн таамаглал хүүхдийнхээ хөгжилд оруулах хөрөнгө оруулалтад учирч буй хамгийн түгээмэл бэрхшээл нь санхүүгийн асуудал байдаг тул гэр бүлдээ зарцуулах цаг хомс байдаг нь судалгаанаас харагдаж байна. Цаашид ажил олгогчид шаардлагатай тохиолдолд ажилчдынхаа ажлын цагт уян хатан байх нь улс

орны ирээдүй болсон хүүхдийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно. (Дархан хотын засаг даргын захирамжийн жишээ)

Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнэтэй баялаг бол үр хүүхэд, тэдний хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.

Бага насны хүүхдийн хөгжлийн асуудлыг зөвхөн хэдэн цэцэрлэгийн барилга барихаар хязгаарлах бус, Монгол Улсын хөгжлийн үндэс нь хүний, ялангуяа бага насны хүүхдийн хөгжил гэдгийг хүн бүр ойлгож бага насны бүх хүүхдийнхээ хөгжилд чиглэсэн нийтийн хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй юм.Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнэтэй баялаг бол үр хүүхэд, тэдний хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.

Цаг үеэ олсон хөрөнгө оруулалт бизнест ашиг орлого авчирдаг бол үр хүүхдийнхээ ирээдүйд зориулан бүтээж буй үйлдэл бүр тань эцэг эх байхын үнэ цэнийг бий болгоно.

Энэ бүхнээс үзвэл эцэг эхийн хүүхдийнхээ ирээдүйд оруулж буй хөрөнгө оруулалтыг хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүмүүжлийн анхдагч үед нь өгч чадвал гэр бүл төдийгүй улс орны эдийн засаг, хүний хөгжлийн тулгуурыг бий болгодог болох нь судалгаанаас харагдаж байна.

“Эцэг эхчүүд, бодлого боловсруулагч нарт хүргэх санал зөвлөмж”

- Эцэг эхчүүд хүүхдийнхээ насны онцлог, зан төлөвийн талаар мэдлэг мэдээлэлтэй байх
- Гэр бүлийн боловсролыг (Хэрхэн хүн байх, хүн бүтээх ухаан) шат дараатайгаар сургалтын системд оруулах, зохион байгуулах
- Ажлын ачаалалаас шалтгаалан ажил олгогчид ажилчиддаа цагийн уян хатан байдлыг бий болгох
- Эцэг эхчүүд бол хүүхдийнхээ ментор байх ёстой. Мэддэг чаддаг зүйлээ бусадтай хуваалцдаг, бусдаас суралцдаг байх
- Эцэг эхчүүд хүүхдээ хүмүүжлийн эрэг арга зүйгээр хүмүүжүүлдэг байх
- Хүүхдийн хамгийн чухал үед эхний 1000 хоног байдаг тул төрөөс ээжүүдэд олгогддог мөнгөн дүнг үе шаттайгаар нэмэгдүүлэх
- Эцэг эхчүүд өөрийн хүүхэд хүмүүжүүлэх ямар хэв загвартай гэдгээ мэддэг байх (О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд)

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Бага насны хүүхдийн цогц хөгжил. УБ 2020

2. Багш мэргэжлийн багц хөтөлбөрт хүмүүжлийн эерэг аргын үзэл санааг тусгах зөвлөмж.УБ 2009

3. Боловсролын хөгжил, судалгаа, арга, зүй., УБ.2018

4. О.Мягмар. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд

5. Багшийн хөгжил мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын гарын авлага

6. Чадамжид суурилсан сургалтын гарын авлага., УБ.2013

---o0o---

ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫН СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГТ ТУЛГУУРЛАН НИЙГЭМШҮҮЛЭХ АСУУДЛЫГ СУДАЛСАН НЬ

THE STUDY OF SOCIALIZATION BASED ON THE PSYCHOLOGICAL CHARACTERISTICS OF FEMALE PRISONERS



Д.Буянхишиг

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 5321 дүгээр дамжааны суралцагч, ахлагч

Товч утга: Хорих ангид ял эдэлж буй эмэгтэй хоригдлыг нийгэмшүүлэхэд хоригдлын сэтгэл зүйн байдал онцгой нөлөө үзүүлдэг. Хорих ангиудад мэргэжлийн сэтгэл судлаач ажилладагүйн улмаас сэтгэл зүйн тусламж хангалттай түвшинд хүрч чаддаггүй. Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд гэмт хэрэгт холбогдох нь давамгайлж байгаа учир түүнийг хоригдлын сэтгэл зүйтэй холбон судлах нь хоригдлыг нийгэмшүүлэх болон сэтгэл зүйн үүднээс нөлөөлөл үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Эмзэг, мэдрэмтгий байдал, тусгаарлагдах, хязгаарлалт, хаалттай орчин

Abstract: The psychological state of the prisoner has a special effect on the socialization of the female prisoner in the penitentiary. Due to the lack of professional psychologists in prisons, psychological care is not available at an adequate level. In recent years, women have become more involved in crime, so it is important to study it in connection with the psychology of the prisoner in order to influence the socialization and psychological aspects of the prisoner.

Keywords: Vulnerability, sensitivity, isolation, restriction, closed environment

Хураангуй: Монгол улсад хорих байгууллага тэр дундаа эмэгтэйчүүдэд ял эдлүүлэх хорих анги ганц байдаг бөгөөд эмэгтэй хүний

төрөлхийн сэтгэл зүйн онцлог шинж зэргээс шалтгаалан ял эдлэх хугацаандаа сэтгэл санааны тогтворгүй байдал үүсэх хоорондоо зөрчилдөх явдал гаргах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл өндөр зэрэг асуудлууд байна.

Бүх цаг хугацаанд буюу социалист нийгмийн үед үйлчилж байсан хууль тогтоомж эрх зүйн шинэтгэлийн хүрээнд үе шаттайгаар өөрчилж ардчилсан үзэл баримтлал бүхий үндсэн хуульд нийцүүлэн хүний эрхийг дээдэлсэн эрх зүйт нийгмийг цогцлоон хөгжүүлэх талаар тодорхой асуудал хийгдэж байгаа ч хорих ангид хоригдож буй эмэгтэй ялтны эрхийг хамгаалах талаар шийдвэл зохих асуудал практикт нэлээдгүй байгааг анзаарч, шийдвэрлэх арга замыг энэхүү илтгэлээрээ тодруулахыг зорилгоо.

Сэтгэл судлалын шинжлэх ухааны чухал салбар болох пенитенциарны сэтгэл судлалын онол буюу хорих байгууллагын сэтгэл судлал манай улсад харьцангуй сүүлд боловч хөгжиж эхэлж байгаа нь таатай юм. Хүний гэмт зан үйл юунаас үүдэлтэй, сэтгэлзүй нь бусдаас юугаар ялгаатай болохыг шинжлэх ухааны үндэстэйгээр тогтоох зайлшгүй шаардлага өнөөдөр манай нийгэмд хурцаар тавигдаж байна.

Судалгааны зорилго: Ял эдэлж буй эмэгтэй хоригдлын сэтгэлзүйн онцлогийг судалж, сэтгэл зүйн байдалд тулгуурлан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах, эмэгтэй хоригдлын эрхийн хэрэгжилтийг хангахад судалгааны ажлын зорилго оршино.

Сэдвийн судлагдсан байдал:Эмэгтэй хоригдлын сэтгэл зүйн байдлын талаар Монгол улсад дагнан судалсан ном, сурах бичиг, гарын авлага ховор байдаг нь харагдлаа. Эрдэм судалгаа ажлын хүрээнд Их Засаг олон улсын их сургуульд Г.Сарантуяа “Хорих ял эдэлж буй эмэгтэй ялтныг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зарим арга зам” 2009 он, Их засаг олон улсын их сургууль М.Дөлгөөн “Хорих ял эдэлж буй хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтны сэтгэл зүйн онцлогт тулгуурлан нийгэмшүүлэх асуудал” 2012 он тус тус магистрын дипломын ажил хамгаалсан байна.

Удиртгал: Эмэгтэй хоригдолд ял эдлүүлэх ажиллагааны түүхэн уламжлал: Монгол Улсын төр гэм буруутай этгээдийн хэргийг шүүн хэлэлцэхдээ төрт ёсоо дээдлэн ялд унагаж, түүний ялыг эдлүүлж ирсэн өнө эртний түүхтэй. Кидан улсын үед 745 онд газар гяндан хийж ялт хүнийг хорьдог байсан. (Ж.Болдбаатар, 2008, хуудсд. 32-33)

Ял гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь нотлогдсон этгээдийг хүмүүжүүлэх /нийгэмшүүлэх/ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн нэрийн өмнөөс түүнд оногдуулж буй албадлагын онцгой арга хэмжээ юм.

Эмэгтэйчүүдийн хорих анги нь 1921 онд байгуулагдсан гяндан салаанаас улбаатай бөгөөд эрэгтэй хоригдлын дээл, хувцас хэрэглэлийг эмэгтэй хоригдлуудаар оёулж хангаж байсан түүхтэй.

1974 онд 240 хүн хүлээн авах хүчин чадалтайгаар байгуулагдсан. Монгол улсад ганц байдаг Эмэгтэйчүүдийн хорих анги нь:

- Нээлттэй
- Хаалттай гэсэн дэглэмээр хорих ял эдлүүлдэг.

Одоогийн байдлаар эмэгтэйчүүдийн хорих ангид нийт 278 эмэгтэй ял эдэлж байна.

- Нээлттэй дэглэмд-247
- Хаалттай дэглэмд-16
- Нярай хүүхэдтэй-15

Хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн байдал туйлын хурцаар илэрдэг бөгөөд анх удаа хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хоригдол, давтан гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хоригдлуудын сэтгэл зүйн онцлог байдлыг нь харгалзан хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй байдаг.

Сэтгэл судлал нь хэсэг бүлэг хүмүүс, хамт олон ба бие хүний сэтгэцийн үйл ажиллагаа тэдгээрийн сэтгэцийн тухай шинжилдэг болон хүний сэтгэц түүний үйл ажиллагаа сэтгэцийн үзэгдлүүд зүй тогтлыг тал бүрээс нь иж бүрэн судалдаг шинжлэх ухаан юм.

Хорих байгууллагын сэтгэл зүйн судалгаанууд хоригдол бие хүнийг судлах, түүний засрал хүмүүжлийн түвшнийг тодорхойлох, засрах эрмэлзлийг хөшүүрэгдэх, илүү өгөөжтэй аргыг эрж хайхад зориулагдсан зорилго чиглэлтэй байдаг.

Хоригдлыг хөдөлмөрт татан оролцуулах тэдний дунд хүмүүжлийн ажил зохиох, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, мэргэжил олгох ажил

зохион байгуулж байгаа нь сэтгэл зүйн мөн эмчилгээ болж өгдөг. Хорих ангийн сэтгэл зүйч гэж хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг хэлнэ. (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал , 2019.06.07)

Гэвч энэ чиглэлээр мэргэжлийн “Сэтгэл судлаач” болон “Хорих байгууллагын сэтгэл судлал”-аар мэргэшсэн алба хаагч дутмаг байна. Хоригдолтой ажиллахад хоригдлын сэтгэл зүйчээр мэргэшсэн алба хаагчид байвал илүү үр дүнтэй.

Пенитенциарны сэтгэл судлал нь олон нийтээс тусгаарлагдсан нөхцөлд хорих ял эдэлж буй ялтнуудын сэтгэл зүйн онцлог, нийгэмшүүлэх үйл ажиллагааны сэтгэл зүйн болон хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхэд сэтгэл судлалын ухааны арга зүйг хэрхэн хэрэглэх асуудлыг судалдаг хууль зүйн сэтгэл судлалын нэг салбар юм.

Пенитенциарны сэтгэл судлал нь хоригдлуудад сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх, нийгэмшүүлэх үйл ажиллагааны явцад тэдний сэтгэл зүйн онцлогийг хэрхэн харгалзаж, тэдэнд нийгэмд эерэг зан төлөвийг хэрхэн төлөвшүүлэх асуудлын талаар практик зөвлөмж боловсруулах чиг үүрэгтэй юм. Хорих байгууллагууд хоригдлын ялыг эдлүүлэх, хүмүүжүүлэх хуулиар хүлээсэн чиг үүргээ үр ашигтай биелүүлэхэд хоригдлын зан төлөвийн гажуудал /эвдрэл/ сэтгэл зүйн онцлогийг судалж улмаар тэдний хувийн онцлогуудын талаар мэдлэгтэйгээр тэдэнд нөлөөлөх явдал хамгаас чухал юм. (Д.Батжаргал, 2012, хуудсд. 32-33)

Үндсэн хэсэг: Эмэгтэй хоригдлын сэтгэл зүйн тухай ойлголт, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэх

Монгол эмэгтэй хүний сэтгэл зүйн онцлог нь хийсвэр сэтгэлгээ болон сонсголын ой санамж өндөр, тунгаан бодохгүйгээр ярьдаг. Хэн нэгэнд сэтгэлээ уудлан ярихад тайвширч стресс нь тайлагддаг. Дайчин шинж чанартай байдаг.

Хорих ял эдэлж буй эмэгтэйчүүд нь нийгмээс тусгаарлагдсан явдалд эрэгтэйчүүдийг бодвол өвөрмөц хурцаар ханддаг. Сэтгэц, физиологийн зохион байгуулалтын онцлогоос шалтгаалан тэдгээр нь сэтгэлийн өндөр хөдөлгөөнтэй байдаг бөгөөд бүлгийн сэтгэл зүйн нөлөөнд амархан автдаг. Эмэгтэйчүүд нь гэр бүлээсээ хол байх тусгаарлагдах асуудлыг илүү хүндээр

хүлээн авдаг ба сэтгэл зүйн байдал нь илүү их өөрчлөгдөж тогтворгүй байдаг. (М.Дөлгөөн, 2012)

Гэмт хэрэг үйлдэж буй эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь хүн алах буюу залилангийн гэмт хэрэгт холбогдон хорих ялаар шийтгүүлсэн.

- Энэхүү байдлыг сэтгэл зүйтэй холбон тайлбарлавал: Хүн алах гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хүний зан төлөв сэтгэл зүйн хувьд танхай балмад зан авиртай, цочмог ууртай, биеэ барих чадваргүй, сэтгэл санааны хямралд орсон, нийгмийн үнэт зүйл, ашигтай харилцаанаас хөндийрсөн, амиа хичээх, өөртөө туйлын хайртай байх хандлагатай.

Мөн нөхцөл байдлын түгшүүр буюу түр зуурын шинжтэй түгшүүр, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн байдал, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан, бага насны сэтгэл зүйн гэмтэл зэрэг нь энэхүү гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлдөг байна.


Залилангийн гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй хүний зан төлөв сэтгэл зүйн хувьд шунаг сэтгэлтэй, нийтийн үнэт зүйл, нийгмийн жижиг бүл болох гэр бүл, хамт олны харилцаанаас хоцорч нийгэмтэйгээ дасан зохицох чадвар муу байдгаас амар хялбар аргаар мөнгө олж амьдрахын тулд энэхүү гэмт хэргийг үйлддэг.

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл нь их хэмжээний өрөнд орсон, амжиргааны эх үүсвэргүй, эрхэлсэн ажилгүй, боловсролгүй, нийгэм ба хувийн амьдралын нөхцөл байдалтай холбоотой байна.

Эмэгтэй хоригдлуудад сэтгэл зүйн тусламж үзүүлэхэд зайлшгүй анхаарах үе шат нь сарын тэмдгийн үе, төрсний дараах болон өмнөх үе түүнчлэн ар гэрийн эргэлт, уулзалтын байдал, шинээр ирсэн болон суллагдах үеийн сэтгэл зүй ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Хорих байгууллагын нөхцөлд дасах явцад эмэгтэйчүүд идэвхгүй, хайнга, гунигтай, түгшимтгий, сүйрийн байдалтай ханддаг. Тэдгээр нь түүнчлэн тогтворгүй шинж чанартай, орчны сөрөг нөлөөнд амархан автамтгай, уцаартай, гомдомтгой, сэтгэлийн хямралд орох нь илүүтэй. Хорих ял эдэлж байгаа ялтны дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин бага байдаг. Энэ нь эмэгтэй хүний нийгэмд гүйцэтгэдэг үүргээр тодорхойлогдоно. Гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн дунд залуу нас болон идэр насандаа яваа эмэгтэйчүүд зонхилно. /18-25, 26-35 нас/

Эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдэлж буй хоригдлын насны судалгааг дараах байдлаар харуулав. Залуу насны эмэгтэй хоригдлуудаас гэмт болон ёс суртахуунгүй зан үйлээсээ болж, эцэг эхтэйгээ харьцаа муудсан байх нь цөөнгүй тохиолдоно. Төрөл төрөгсөдтэйгөө тасарсан харьцаа холбоог нь сэргээж өгөх явдал тэдгээрийн засрал хүмүүжлийн угтвар нөхцөл болж болохыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид цаг ямагт санаж ажиллах нь зүйтэй.



Олонх эмэгтэй ялтнууд үр хүүхэдтэй байдаг бөгөөд тэдэндээ янз янзаар ханддаг. Цөөн тооны зарим нэг нь эхийн сэтгэлгүй авирладаг бол нөгөө хэсэг нь үр хүүхдэдээ байнга сэтгэл нь зовж байдаг. Иймд эхийн сэтгэлийг нь хөгжөөж идэвхжүүлж байх нь хүмүүжлийн ажилд чухал нөлөөтэй. (С.Жанцан, 2001, хууд. 397)

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар хоригдлын ар гэрийн амьдралыг сайтар судалж мэдсэнээр тэдгээрт цаг тухайд нь тусалж болдоггүй үйлдэл хийхээс нь урьдчилан сэргийлэх, зан үйлийн зөв шугамыг нь зааж, бэрхшээлийг гэтлэн давахад дэмжлэг үзүүлэх боломжийг олгоно. Мөн эмэгтэй хоригдлын анатоми, физиологийн болон сэтгэл зүйн онцлогуудыг тэднийг хүмүүжүүлэх үйл ажиллагаанд зайлшгүй харгалзах шаардлагатай. Гэр бүл зөвхөн ял эдлэх хугацаанд төдийгүй суллагдсаны дараа хүртэл чухал юм. Гэр бүлтэй гэр бүл нь хүлээж буй хоригдол эмэгтэйчүүд нь амьдрал ахуйн болон ажил хөдөлмөрийн бэрхшээлтэй бага учрах нь дамжиггүй.

Эмэгтэй хүний физиологийн онцлог нь итгэл хүлээх , хэн нэгэнд сэтгэлээ уудлан ярихад тайвширдаг, стресс тайлагддаг нь судалгаагаар нотлогдсон байдаг. Иймд хуулийн хүрээнд албан хаагчийн ёс зүйн түвшинд хоригдолтой ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай.

Гадаад орнуудад хийгдсэн судалгаа

1. Өмнөдийн хорих байгууллага дахь эмэгтэй хоригдлууд болон тэдний хүүхдүүдийн амьдрах нөхцөлийг судалсан Доктор Шила Парвиний Энэтхэгт хийсэн судалгаа (U.P.Jails)

Энэ судалгаа нь шоронд хорих ял эдэлж байгаа эмэгтэйчүүд болон тэдэнтэй хамт хоригдож байгаа хүүхдүүдийн нөхцөл байдал, сэтгэл зүйн байдлыг судласан юм. Өнгөрсөн 30 жилд эмэгтэйчүүдийн гэмт хэрэгт холбогдон хохирогчоор татагдсан түвшин өссөөр байсан ба Энэтхэгт 2006 он хуртэл 14657 буюу эмэгтэйчүүдийн 3.9% нь хоригдох ялаар шийтгүүлжээ. Энэтхэгт эмэгтэйчүүдийн гэмт хэрэгт холбогдож байгаа байдал нь мартагдсан сэдэв болоод байна. Энэ сэдвээр судалгааны ажлууд ч цөөн тоогоор хийгдсэн байдаг.

Шоронд хоригдон ял эдэлж буй эмэгтэйчүүдийн болон тэдэнтэй хамт хоригдож буй хүүхдүүдийн сэтгэл зүй болон эрүүл мэндэд сөрөг нөлөөллүүд илэрсээр байна. Эдгээр ял эдэлж буй эмэгтэйчүүдэд тулгарч буй гол асуудлуудыг дурьдвал амьдарч буй орчин, хэрэглээний зүйлсийн дутагдмал байдал, гэр бүлтэйгээ уулзах давтамж цөөн, боловсрол болон ажил эрхлэх боломж хомс, эрүүл мэндийн анхан шатны тусламжууд хомс, эмэгтэй хоригдлуудын бүлэг дахь биеийн болон бэлгийн дарамт, хоригдож буй эхчүүдийн үр хүүхдүүддээ үзүүлж буй дарамт, харь элгийн буюу харь улсын хоригдлыг дарамтлах үл хүндэтгэх байдал зэрэг асуудлууд байдгийг судлан тогтоосон байна.

Энэхүү судалгаагаар хорих ангид хоригдож буй эмэгтэйчүүдийн 72.4% нь сэтгэл зүйн байнгын түгшүүртэй, зовнилтой байдаг ба байнга айдастай, сэтгэл гутралтай байдаг, амьдрах итгэлгүй болсон хэмээн дүгнэлт гарсан боловч шийдвэрлэх арга замыг оновчтой тусгаж өгөөгүй юм.

2. Шорон дахь эмэгтэйчүүд судалгаа (team, 2014)

Энэхүү судалгаа нь 2014 онд АНУ-д хийгдсэн судалгаа ба:

- ✓ Эмэгтэй хориглуудын ямар нэг хөтөлбөр, боловорол болон хөдөлмөр эрхлэх боломж
- ✓ Сэтгэцийн өвчин, тархины бэртэлтэй болон хөдөлмөрийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлуудыг дэмжих
- ✓ Эмэгтэй хоригдлуудын өөрийгөө гэмтээх болон амиа хорлох оролдлогууд дээр төвлөрсөн судалгаа юм.

Шорон дахь эмэгтэйчүүдийн дунд хийгдсэн судалгааны үр дүнд эмэгтэй хоригдлуудад эд материалын дутагдал, зохион байгуулалтгүй байдал, хэрэглээний зүйлсийн чанар муу байдал болон харгалзагч нарын дээрэнгүй байдлын талаар илрүүлжээ.

3. Эрүүгийн шүүхийн тогтолцооны эмэгтэй хоригдлуудын сэттэл зүйн хэрэгцээг тодорхойлох судалгаа (prison, 2009)

Өнгөрсөн 20 жилд Австралийн эмэгтэйчүүдийн гэмт хэрэгт холбогдож байгаа түвшин 26%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрээс мансууруулах бодис хэрэглэх, архидан согтууруулах эсвэл танхайрах гэх мэт хөнгөн хэлбэрийн гэмт хэргээр урт хутацаагаар ял эдлэж байгаа юм. 2009 оны NSW-гаас эмэгтэй хоригдлууд дээр явуулсан судалгаанаас харахад:

✓ 45% нь гэр бүлийн болон бусад насанд хүрэгчдийн хүчирхийлэлд өртөж байсан

✓ 80% нь тамхины хамааралтай

✓ 38% нь 1 жилийн турш эрүүл мэндэд хортой байдлаар нөлөөлөх алкохолын төрлийн зүйл хэрэглэж, 16 хувь нь архины шууд хамааралтай байсан

✓ 78% нь хууль бусаар мансууруулах бодис хэрэглэж, 32 хувь нь тариур ашиглан мансууруулах бодис хэрэглэж байсан

✓ 20% нь бэртэл гэмтлээс болж эмнэлгээр үйлчлүүлж

✓ 27% нь амиа хорлохыг завдаж

✓ 49% нь 16 эсвэл насанд хүрээгүй байхдаа хүүхэд гаргаж

✓ 45% нь 10-14 насандаа сургуулиа хаяж

✓ 67% нь 6 сар гаран хутацаанд ажилгүй байж, 25 хувь нь 10 болон түүнээс дээш хугацаанд ажил эрхлээгүй

✓ 66 хувь нь эсрэг хүйстэнтэйгээ харьцах харилцаанаасаа дарамт хүчирхийлэлд өртөж байсан байна.

Австралийн хорих байгууллагын сэтгэл судлаачийн ажлын зорилго нь хоригдол бодит байдлыг сайтар ойлгож хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэхэд оршино. Үүний тулд хоригдолтой үр ашигтай агуулга бүхий харилцаа тогтоож зөв оношлон ажиллах бэлтгэл хийх хэрэгтэй. Хорих анги доторх төрөл бүрийн гаж үзэгдлээс ялтныг сэргийлэх, шаардлагатай үед түүнд туслах үүргийг ажилтан гүйцэтгэнэ. Ялтныг ирэнгүүт бусад ажилтны хамт хүн тус бүрээр судалж нэг бүрчлэн ажиллах хөтөлбөр боловсруулдаг. Тухайлбал:

1. Сэтгэл зүйн боловсруулалт хийх шийтгэгдсэн ялаа үндэслэлгүй гэх буюу үүнээс хөнгөн ял авах байсан гэж үзэх

2. Эрчимжүүлсэн буюу удаан хугацааны - бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, давтан гэмт хэрэгтэн, мансуурагчид

3. Дамжлагын - суллагдахад 9 сар үлдээд байгаа

4. Өргөтгөсөн - оюуны хомсдолтой хүмүүстэй ажиллах

Австрали улсад сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжлүүлэх шийтгэлийн хэлбэр нэлээд түгээмэл болж байгаа бөгөөд үүнд сэтгэл судлаач, нийгмийн ажилтны оролцоо чухал байна.

Хорих байгууллагын тогтолцоон дахь сэтгэл судлаачид дараах үүрэгтэй. Үүнд.

- Ялтнуудын талаарх нийгмийн сэтгэлгээг өөрчлөхөд дэм үзүүлэх буюу тэднийг жирийн иргэдийн адил хүлээн авахыг нийгэмд дасгах

- Гэмт хэргийн золиос, гэрч болсон хүмүүстэй зохиох хөтөлбөрийн үйл ажиллагаад оролцох

- Тухайн ялтны засрал хүмүүжилд хяналттай, тасралтгүй нөлөөлөх, хорихын өмнөх болон суллагдсаны дараа ч гэсэн сэтгэл зүйн туслалцаа үзүүлж нийгмийн ажилтантай хамтран ажилладаг туршлагатай

Судалгааны арга зүй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тусгай архивын 2023 оны 4-р улирлын эцсийн статистик мэдээ

Үр дүн: Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд гэмт хэрэгт холбогдох нь давамгайлж байгаа учир түүнийг сэтгэл зүйтэй нь холбон нийгэмшүүлэх нь дахин гэмт хэрэг үйлдэх сэдлээс сэргийлэх мөн хорих байгууллагад зайлшгүй мэргэжлийн сэтгэл зүйч ажиллах нь хорих ангид гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өөрийн бие эд эрхтэндээ болон бусдыг гэмтээх, муу бодолд автахаас сэргийлэх зэрэг ач холбогдолтой.

ДҮГНЭЛТ

Хорих байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго нь гэмт хэрэг үйлдэгсдэд оногдуулсан ялыг хуулийн хүрээнд эдлүүлэхээс гадна тэднийг хүмүүжүүлэх нийгэмшүүлэх зорилго байдаг нь хүн төвтэй иргэний ардчилсан нийгмийн зарчим зорилгод нийцэж байгаа юм.

Өнөөгийн байдлаар Монгол улсад эмэгтэйчүүдийн хорих анги ганц байдаг бөгөөд 280 гаруй хоригдол эмэгтэй ял эдэлж байна. Хорих ялыг эдлүүлэхдээ тухайн ялтныг зөвхөн цээрлүүлж залхаах замаар шийтгэх бус хувь хүний сэтгэл зүйн онцлогт тулгуурлан хүмүүжүүлж нийгэмшүүлэх нь ач холбогдолтой зөв бодлого болохыг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллага, тэр дундаа хорих байгууллагын үйл ажиллагааны түүхэн туршлага харуулж байна. Гэвч манай улсын хорих байгууллагуудын ялтны сэтгэл зүйтэй ажиллах чиг үүрэг нь хэрэгждэггүй орхигддог нь мөн мэргэжлийн сэтгэл зүйч ажилладаггүй нь ялтныг засарч хүмүүжихэд тэднийг хүмүүжүүлэх нийгэмшүүлэх үйл ажиллагаа учир дутагдалтай байх нэг нөхцөл болж байна.

Гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэй ялтныг ял эдлэхэд сэтгэл зүйд дарамт учруулдаг болон сэтгэлийн дархлааг бий болгон түүнийг өдөөж өгдөг хүчин зүйлүүдийг тодорхойлж, гадаадын зарим орны сэтгэл зүй, нийгмийн ажлын арга туршлагаас судалсан.

Хоригдлыг гэмт үйлдэлдээ гэмших гэмшил нь ял эдлэхэд нөлөөлөх зэрэг нөхцөлүүдийг судлахад задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх, түүхчлэн судлах, хорих ангийн сэтгэл зүйч гэж хэн байх талаар тусгасан болно.

Сэдвийг судалсан судалгаанд үндэслэн гэмт хэрэг үйлдсэн ялтны сэтгэл зүйн онцлогийг судлан тэднийг хүмүүжүүлж нийгэмшүүлэх үйл ажиллагааг сайжруулахад нэмэр болох үүднээс дор дурдсан саналуудыг дэвшүүлж байна.

1. Ар гэрийн анхаарал халамжийг бууруулахгүй байх, тэдний харилцаа холбоог холдуулж хөндийрүүлэхгүй байх нөхцөлийг хангах үүднээс нийгмийн ажилтан, ар гэр, хоригдол гэсэн гурвалсан харилцаа холбоог бий болгох энэ чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

2. Гэмт хэрэг үйлдсэн хоригдлын сэтгэл зүйд чиглэсэн сургалтыг нэмэгдүүлэх ном гарын авлага бэлтгэх, сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх;

3. Хорих ялын хугацааг багасгаж, хорихоос өөр төрлийн ял оногдуулдаг байх. Хорих ял эдэлж буй эмэгтэй хоригдлын хувьд хуульд заасан ялын хугацаа нь өндөр, үүний улмаас ар гэр, найз нөхдөөсөө хөндийрөх, зан суртахууны хувьд эвдрэлд орох, үр хүүхдээсээ холдох зэрэг маш олон муу үр дагаварт хүрдэг;

4. Гэмт хэрэг үйлдсэн хоригдлын сэтгэл зүйд чиглэсэн бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл заслын эмчилгээ хийх, психодинамик сэтгэл заслын эмчилгээ түлхүү хэрэглэх;

5. Сэтгэл засал эмчилгээг үзүүлэхэд дуу чимээ багатай, тайвшрал өгөхүйц, ганцаарчилсан болон олон хүнд нэгэн зэрэг үйлчилгээ үзүүлэхээс гадна арт терапи буюу урлагийн сэтгэл заслын эмчилгээ явуулах стандарт бүхий өрөө кабинеттай болох.


6. Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуульд сэтгэл судлал мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн сэтгэл зүйчдийг пеницентарны сэтгэл судлалын 3 сарын мэргэшүүлэх сургалтын анги нээх, эсвэл 1+1 хөтөлбөрөөр сургах; /Энэ хөтөлбөр БХИС болон ДХИС-Цагдаагийн сургуульд хэрэгжиж эхэлж байна./

7. Монгол улсын хууль зүй, Дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2017 оны 9-р сарын 29-ний өдөр А247/, А/167, 303 тушаал “Алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив” тушаалын дагуу нээлттэй, хаалттай хорих ангид сэтгэл зүйч 50-60 хоригдол тутамд 1 гэсэн нормативыг ханган ажиллах;


8. Нээлттэй, хаалтай дэглэмийн ангиллаар сэтгэл зүйчийн орон тоотой болох;

Судалгааны хэсэг


Гэр бүлийн судалгаа




Боловсролын судалгаа




Ял эдэлж буй дэглэмээр



Урьд ял шийтгэл эдэлж байсан эсэх



Гэмт хэргийн байдлаар



ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

IMPLEMENTATION OF JUVENILE IMPRISONMENT ACTIONS



Н.Гэрэлчимэг

Дотоод хэргийн их сургуулийн сургалт,судалгааны 403-р анги шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521-р дамжааны сонсогч

Товч утга: Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож буй насанд хүрээгүй хүний хүмүүжил, түүнд шаардлагатай эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудлыг судлан, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: It is intended to study the society of minors detained in special institutions for children's upbringing, the legal regulations that define it, and the ways to solve the problems.

Түлхүүр үг: гэмт хэрэг, гэм буруу, нийгэмшүүлэх ажил, хорих ял, боловсрол, сэтгэл санааны байдал

Key word: crime, guilt, social work, imprisonment, education, emotional state,

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүүхэд гэмт хэрэгт холбогдох болсон шалтгаан, нөхцөлийг мэргэжлийнхэн цэцэрлэгт хүмүүжээгүй. Ялангуяа эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдэдээ тавих анхаарал сул, цахим орчны хяналтгүй, зохисгүй хэрэглээ, аливаа мэдээ, мэдээлэлд бодитой дүгнэлт хийх чадамжгүй байдал” нь өсвөр насны хүүхдийг гэмт хэрэгт холбогдоход шууд нөлөөлсөн гэж үздэг. Монгол улс 2023 оны байдлаар нийт 871 Ерөнхий боловсролын сургуультай бөгөөд 771.7 мянган сурагчтай.[1] Хүүхдийг гэмт

[1] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхэд дан ганц цагдаагийн байгууллага биш шат шатны байгууллагууд тэр дундаа гэр бүл асран хамгаалагчид хараа хяналттай байлгах үүрэгтэй. Хэрэв эцэг эх энэ үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэдэг. Монгол улс 2017 он хүртэл насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдлүүлэх ажиллагаа гэсэн агуулгаар хорих ял эдлүүлж байгаад 2017 оноос Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих гэсэг нэр томьёог эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгаж өгчээ. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хоол хүнс орон байр , хувцас хэрэгсэл зэрэг шаардлагатай зүйлээр хангаж хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

Насанд хүрээгүй хүнд хорих ял эдлүүлэх ажиллагааг Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль-ийг үндэслэн явуулдаг.Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг Монгол улсын Эрүүгийн хуульд тусгай бүлгээр зохицуулсан байдаг. Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтэд тустай ажил хийлгэх; зорчих эрхийг хязгаарлах; сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар тус тус заасан байдаг.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь анх 1948 онд “Хүүхдийн колони” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд Шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ялаар шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг биечлэн эдлүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүн хөдөлмөр эрхлэхгүй харин ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалтад хамрагддаг.[1]

Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх

[1] Монгол улсын ерөнхий прокурорын газар, Про подкаст, Архив,

тусгай нэгжтэй байна. Өсвөр насны хоригдол арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар хоригдлыг арван найман насанд хүрэхээс 3 сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. Хоригдлын эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэх хорих ангийн дэглэмийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. Шүүх заасан хоригдлын эдлээгүй үлдсэн ялын хугацаа 2 жилээс илүүгүй тохиолдолд түүний хувийн байдал, төлөвшлийг харгалзан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ялын хугацааг дуусах хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн ял эдлүүлж болно. Өсвөр насны хоригдлын илгээмж авах, түр уулзалт хийх, утсаар ярих тоог хязгаарлахгүй бөгөөд 15 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болно.[1]

Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ. Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна.[2]

Хорих ял эдлүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулж буй Хорих ангийн дотоод журам болон Хорих ангийн харуул хамгаалалтын журам, нийгмийн ажлын аргачилсан зааварт сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагааны талаарх зохицуулалт дутмаг байна.

Статистик үзүүлэлт	**Аймаг**	**Аймгийн код**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022**
18 хүртэлх насны	Улсын дүн	0	956	1356	90	921	1540

Нийгэмшүүлэх ажил гэдэг нь хоригдлыг хорих байгууллагад хүлээн авахаас эхлэн ял эдлэх бүхий л хугацааг хамран, суллахад бэлтгэх, сулласны дараах үйл явцаар дуусгавар болдог сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, анагаах, хууль зүй, нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай нөлөөллийн цогц арга хэмжээг хэлнэ. Нийгэмшүүлэх

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 201 дүгээр зүйл
[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 220 дугаар зүйл

ажиллагааны явцад хорих ангиас хүүхдийн сурч боловсрох эрхийг хангадаг.

Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага юм. Бүх нийтийн ерөнхий боловсрол нь 12 жилийн сургалтын агуулгын түвшин суурь боловсрол гэдэг нь 9 жилийн сургалтын агуулгын түвшин юм.

Албан боловсрол нь боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол нь боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа

Насан туршийн боловсрол бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг Сургалтын орчин боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцааг хэлнэ.

Эдгээр мэргэжлийн сургалт, ерөнхий,суурь боловсрол нь тухайн хоригдлыг эргэн нийгэмшихэд туслах албан боловсрол мөн хэдий ч хорих ялаас хугацааны өмнө суллагдах, ялыг биечлэн эдэлж дууссаны дараа нийгэмээс тусгаарлагдахгүй амьдрахад албан бус боловсрол, насан туршийн боловсрол нь тухайн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх эсвэл засрал хүмүүжилд нь илүү хэрэгтэй байдаг.


Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажил нь хорих ялаар шийтгэгдсэн хүнийг нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцох төлөвшлийг бий болгоход чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, иргэд, бусад нийгмийн байгууллагатай зөв харилцаа үүсгэх, хөдөлмөрийн дадал, хүмүүжил олгох, хууль, дэг журмыг хэвшүүлэх нөлөөллийн цогц үйл ажиллагаа юм.

Манай оронд 1996 оноос хүүхэд хамгаалал, 1999 оноос боловсрол, 2000 оноос хороо, 2002 оноос хорих ял эдлүүлэх ажиллагааны, 2007 оноос

халамж, 2008 оноос эрүүл мэндийн салбарын нийгмийн ажилтнууд бий болон өөр өөрсдийн онцлогийг тусган хөгжиж байна.[1]

Түүнчлэн хорих ангийн “нийгмийн ажил” гэсэн нэр томъёо, ойлголт бий болоод 20-оод жил болсон энэ цаг хугацаанд нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт, нийгмийн ажлын заавар, нийгэмшүүлэх хөтөлбөр зэрэг эрх зүйн бичиг баримтууд боловсрогдон гарсан билээ. Практикт хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас, хүйс, ял эдлэх дэглэмийг ялгаатай оногдуулдгаас нийгмийн ажлыг харилцан ялгамжтай явуулдаг.

/Өсвөр насны хоригдлын тоо сүүлийн 20 жил/



Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад сүүлийн 20 жилийн байдлаар 2132 өсвөр насны хоригдол ял эдэлсэн бөгөөд 2015-2019 он буюу сүүлийн 5 жилийн дунджийг/55/ 2000-2004 оны дундажтай/146/ харьцуулахад 2,3 дахин, 2005-2009 оны дундажтай харьцуулахад 2,4 дахин, 2010-2014 оны дундажтай харьцуулахад 9,1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2000 оны эхэн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Судалгаагаар насанд хүрээгүй хүмүүс 14-17 насандаа согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, 14-15 насанд тэдэнтэй хатуу ширүүн харьцах, 13-14 насандаа бэлэгсийн гэмт хэрэгт өртөх магадлал тус тус өндөр байна. Түүнчлэн хүүхдийн бие, сэтгэл зүйн дээрх онцлог байдал, хууль эрх зүйн мэдлэг, эцэг эхийн хяналт муу

[1] Б.Сүх-Очир. Бодит жишээтэй ажиллах арга зүй. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүл. 2014. №3. 34 дэх тал

зэрэг байдал нь гэмт хэрэгт уруу татагдах, гэмт хэрэг үйлдэх хүчин зүйл болж байна. Учир нь бараг бүх насанд хүрээгүй хүмүүс өөрийн амьдралын дүр төрх, нөхцөл, хүрээлэн буй орчны нөлөө зэргээс гэмт хэрэг үйлдэхэд уруу татагдахад "бэлэн байдал"- д байдаг бөгөөд уруу татагдан гэмт хэрэг үйлдсэнээр тэдний бие, сэтгэлийн хөгжилд ноцтой гэм хор (гэмт хэрэг үйлдэх дадал зуршилтай болгох) учруулдаг, тухайн гэмт хэргийнхээ (ЭХ-ийн 16.1, 16.2) давхар хохирогчид юм.

Өсвөр насны хүнд ял оногдуулах, түүнийг эдлүүлэх талаарх олон улсын баримт бичиг:

Монгол улс НҮБ-ын "Хүүхдийн эрхийн тухай" конвенцод 1990 онд нэгдэн орж хүн төрөлхтний ирээдүйн сайн сайхан байдлыг хангах энэхүү конвенцыг хангах үүрэг хүлээсэн дэлхийн 5 дахь орон болсон юм. НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенц нь анхаарлын гадна үлдэж байсан хүүхдийн эрэлт хэрэгцээг хангах шинэ стандартыг тогтоож, төр нийгмийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалахад хүлээх үүргийг тодорхойлсноороо чухал ач холбогдолтой юм.

1996 оны 05-р сард "Хүүхдийн эрхийг хамгаалах" Монгол улсын хуулийг баталсан юм. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага, ял шийтгэл оногдуулах, хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах эрхийн тухай "Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт" "Хүүхдийн эрхийн конвенц", НҮБ-ын "хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм", "Яллагдагчдын /прокурор/ үүргийн удирдах зарчмууд" НҮБ-ын "насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм"[1],

НҮБ-ын удирдах зарчмууд болон олон улсын баримт бичигт хууль бусаар дур мэдэн хүүхдийн эрх чөлөөг хасаж болохгүй. Түүнийг баривчлах, албадан саатуулах, хорих явдлыг гагцхүү хуулийн дагуу гүйцэтгэх, эцсийн арга хэмжээ болгож аль болох богино хугацаатайгаар хэрэглэхийг заасан байна. Мөн эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүртэй хүнлэг ёсоор харьцаж нэр хүндийг нь хүндэтгэх, эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр эрх зүйн болон бусад шаардлагатай тусламжийг авах, бусдын нөлөөнд автагдаагүй хараат бус байхаар тусгагдсан байна. Тухайлбал: "хүүхдийн эрхийн тухай конвенц"-ийн 37-р зүйлийн "а хэсэгт": 18 насанд хүрээгүй хүүхдийн

[1] Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх.УБ.,.1996 он

үйлдсэн хэрэгт цаазаар авах буюу ямар ч үндэслэлгүйг бүх насаар нь гянданд хорих ял оногдуулахгүй байх гэжээ. НҮБ-ын зургаадугаар чуулганаас гаргасан наймдугаар тогтоолын дагуу 17.1 дүгээр зүйлийн б хэсэгт залуу хүмүүсийн онцлог эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс хорихоос бусад арга хэмжээг аль болох их сонгон хэрэглэхийг дэмжиж байгаа юм. Иймээс нийгмийн аюулгүй байдлыг хангах эрэлт хэрэгцээг харгалзан сонгох өөр төрлийн байгаа арга хэмжээнүүдийг бүрэн ашиглах, шинэ төрлийн сонгох арга хэмжээ боловсруулах нь зүйтэй гэж бодож байна.

Аль ч нийгэмд залуучуудын хэрэгцээ, шаардлага байдаг тул гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай залуусыг хорих ял шийтгэх нь зарим талаараа зохицуулалт дутмаг, мөн нийгэмд нь нийгэмшүүлэх буюу хорихоос өөр төрлийн аргаудад нийгмийн аюулгүй байдлыг хангаж чадах шинэ зохицуулалт хэрэгтэй. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх ёстой боловч тарчлаан зовоон эрхэнд нь хууль бусаар халддаггүй байх нь зүйтэй.

Англи улс:

Английн эрүүгийн эрх зүйн субъект: Аливаа бие хүн Английн харьяат, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлагад татаж болно. Өөрийн статусын дагуу зарим хүмүүс эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгддөг журамтай.

Харин монгол улсад арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэйд арван таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй.

Нэгдүгээрт: Уламжлал ёсоор хаан, хатан гэмт хэрэг үйлдэж болохгүй учир хариуцлагад татагдахгүй.

Хоёрдугаарт: Дипломат эрх ямбийн тухай 1964 оны хуулийн дагуу элчин болон гадаадын элчин сайдын яамны албаны бусад хүмүүс эрүүгийн мөрдөлтөд халдашгүй байх эрх эдэлнэ. Дипломат төлөөлөгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд дээрх эрхээ эдэлнэ. Гэмт хэргийн субъект бие хүний талаар ярихад гол асуудал бол түүний хэрэг хариуцах чадваргүй байдал юм. Английн эрх зүйд хэрэг хариуцах чадваргүй байдлыг нас, сэтгэцийн өвчин, согтууралтай холбон үздэг. Английн эрх зүйд насанд хүрээгүй байдал-ыг хүсэл зориг байхгүйтэй холбогддог бөгөөд энэ нь

эрүүгийн хариуцлага үгүйсгэгдэх шалтгаан болж болно. Англиийн Эрүүгийн хууль тогтоомжид насанд хүрээгүй хүмүүсийг 3 бүлэгт хуваасан байдаг.

-10 хүртэлх насны хүүхдүүд

-10-14 насны хүүхдүүд

-14-17 насны өсвөр насныхан /ял оногдуулахад 17-21 насны хүмүүсийг тэдгээртэй адилтган үздэг/.

17-21 насны хүмүүсийг тэдгээртэй адилтган үздэг.[1]

Хүүхэд ба өсвөр насны хүмүүсийн тухай 1933 оны хууль гарахаас өмнө нийтийн эрх зүйн дагуу 7 нас хүрээгүй хүүхдийг эрүүгийн хариуцлагад татаж болдоггүй байсан. Уг хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг 7, Хүүхэд ба өсвөр насны хүмүүсийн тухай 1969 оны хуулиар 10 байхаар тогтоосон. 10-14 насны хүүхдийн үйлдэлд гэмт хэргийн элементийн аль аль нь Actus reus ба ments rea байгааг ямар ч эргэлзээгүй нотлохоос гадна уг хүүхэд ноцтой хохирол учруулж байгаагаа мэдэж байсныг тогтоосон нөхцөлд л түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно. Англи улсын шоронгийн тухай хууль анх 1952 онд батлагдсан байна. Эрүү, эрүүгийн байдаан шийтгэх болон ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажил тасралтгүй хийгдсэний дүнд 1967, 1977, 1981, 1988, 1991, 1993 онуудад тодорхой шинэчлэл хийгджээ. Англи улсын хорих болон хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт одооч олны анхаарлыг татсаар байна. Англи улсын ял эдлүүлэх байгууллага нь төвийн ба орон нутгийн шоронгийн байгууллагаас бүрдэнэ.

-Насанд хүрээгүй хүмүүст зориулсан ял

Насанд хүрээгүй хүмүүст оногдуулах ял нь Англиийн хууль тогтоомжийн дагуу 17 нас хүрээгүй хүмүүс насанд хүрээгүйд тооцогдоно. Ял оногдуулахад 21 нас хүрээгүй залуусыг тэдэнтэй адилтган авч үзнэ. Хүүхэд болон өсвөр насныхан тухай 1969 оны хуульд зааснаар насанд хүрээгүй хүмүүсийг:

1. Хүүхэд /14 нас хүрээгүй/

[1] Б.Ганчулуун. Англиийн Эрүүгийн эрх зүй. УБ.,2005 он.21-р тал 37 а/ Лхагва.А.Дурдсан бүтээл.УБ.,2008, 2012 он б/ “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл.

2. Өсвөр насны /14-17 нас/ гэж хуваагддаг.

3. 10-14 насны гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хянаптын байгууллагын хяналтад өгөх.

- Гэмт хэрэг үйлдсэн 14-17 насны этгээдэд шүүх гэр бүл, асран хамгаалагчийн хяналтад байлгах шийдвэр гаргах эрхтэй. Энэхүү шийдвэрт гэмт хэрэг үйлдсэн этгээд хянагчийн шаардлагыг биелүүлэх, тусгай тогтоосон хугацаанд тодорхой газар оршин суух, тодорхой өдөр хүмүүжлийн төвд ирэх, 6 цагаас өглөөний 6 цагийн хооронд гэрээс гадагш гарахгүй байх /шөнийн хязгаарлалт/ мөн тодорхой өдрүүдэд ямар нэг үйл ажиллагаанд оролцохыг хориглохыг заасан байдаг байна.

Шүүх 12-15 насны хүмүүсийг хүмүүжлийн хаалттай төвд илгээх, төвд байлгах хугацаа нь 4, 6, 8, 10, 12, 18, 24 сар байна. Тэнд байх хугацаанд нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд хөдөлмөрийн дадлага, боловсрол олгох бөгөөд суллагдахад бэлтгэдэг.

- Залуу хэрэгтнүүдэд зориулсан байгууллагад байлгах ялын доод хугацаа 15-18 насны хүмүүсийн хувьд 2 сар юм. Уг байгууллагаас суллагдсан хүмүүст 22 нас хүртэл нь хяналт тогтооно.

- 1982 оны хуулийн дагуу 21 нас хүрээгүй хүнд албадан саатуулах төв юм уу залуусыг хорих газарт байлгах ял оногдуулдаг байна.

- Онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан этгээд 21 насанд хүрээгүй бол түүнийг тодорхой хугацаагаар насанд хүрээгүй этгээдэд зориулсан “Засан хүмүүжүүлэх хаалттай хорих байгууллага”-д ял эдлүүлэхээр шийдвэр гаргаж болох бөгөөд 15-аас доош насны хөвүүдийг 4 сар, түүнээс бага хугацаагаар хорих ёстой.

Энэ бүхнээс үзэхэд Англи улсад 21-ээс доош насны гэмт хэрэг үйлдсэн хүүхэд, залуучууд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зорилго нь аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх, тусгаарласан ч хамгийн богино хугацаагаар хэрэглэдэг нь харагдаж байна. Мөн Английн эрүүгийн ялын тогтолцоонд насанд хүрээгүй хүмүүст зориулсан ял гэсэн тусгай ялын төрөл байгаа нь сайшаалтай.

Англи улсад насанд хүрээгүй этгээдүүд хүлээлгэх хариуцлага нь манай улстай харьцуулахад бага байдаг бөгөөд богино хугацаанд хүмүүжүүлэх арга хэмжээ авч, амьдралд нь заман хүмүүжүүлэх байгууллагын хар толбо тогтоож үлдээдэггүй нь үнэхээр авууштай.

/ Их Британид өсвөр үеийнхний гэмт хэргийн дахин гэмт хэргийн түвшин хэд вэ?/

Залуучуудын шударга ёсны статистик: 2022-2023 он (хүртээмжтэй хувилбар)

Хүүхэд дахин гэмт хэрэг үйлдэх нь долоон жилээр буурсны дараа 0.9 пунктээр нэмэгдэж, 32.2% болсон бол бүлэгт хамрагдсан хүүхдийн тоо үргэлжлэн буурчээ.

"Youth of Crime UNITED KINGDOM"-ийн хийсэн судалгаагаар



2013-2016 онуудад буурсан үзүүлэлттэй байгаа бол 2017-2018 онд өссөн байна. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, гэрийн хорио зэрэг нь үр нөлөө сайтай нь судалгаанаас харагдаж байгаа бөгөөд хорих ангид биечлэн ял эдлүүлэх нь асуудлыг бүрэн шийдэх арга биш гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Хүүхэд нь сэтгэл зүйн хувьд бүрэн гүйцэд төлөвшөөгүй, ертөнцийг үзэх үзэл тогтоогүй байдаг учир түүнийг хүрээлж буй гэр бүл, эцэг, эх, найз нөхөд, ойр дотны хэн нэгний нөлөөнд автахад маш амархан. Энэ байдал нь орчны таагүй нөлөө (архи дарс хэрэглэх, мансуурах байдалд орох)-гөөр амархан өдөөгдөж элдэв сөрөг зан төлөвтэй болох, гэмт хэрэг үйлдэх, гэмт халдлагад өртөхөд хүргэдэг.

Хүүхдийн бие, сэтгэл зүйн онцлог нь сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхгүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн хувьд сул дорой байх, танилын буруу сонголт, өөрийгөө дутуу үнэлэх зэрэг нь

хохирох эрсдлийг бүрдүүлэх бөгөөд уруу татагч, гэмт этгээдийн боломжийг нэмэгдүүлдэг байна. Тэдний хүсэл тэмүүлэл нь хоригдож, гэр бүл олон нийттэй харилцлах харилцаа холбоо нь цоожтой хаалганы цаана ормогц өөрчлөгдөж эсвэл холбоо тасардаг.

Монгол Улсад өсвөр насны этгээдээс гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй шалтгаан олон боловч хамгийн гол нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын хараа хяналт, анхаарал халамж муу байх, хүүхдийн нас, биеийн онцлогт тохируулан харьцахгүй байх, тэднийг үл хайхрах, тэднийг ойлгохыг хүсэхгүй байх, амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээр хангаж чадахгүй, эсхүл хэт эрхлүүлэх, хүссэн бүгдийг нь биелүүлдэг зэрэг алдаатай үйлдлээс болж байна.

Өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг үйлдэх болсон шалтгааныг :

Гэр бүл салалт, гэр бүлийн байдал хойд эцэг, эхтэй болон хагас өнчин, ар гэрийн хараа хяналтгүй байдал, бусдын сөрөг нөлөө, сониуч, гэнэн томоогүй зан, архины хамаарал, сургууль завсардалт, амар хялбар аргаар мөнгө олох, ядуурал, ажилгүйдэл зэрэг шалтгаан нөхцөлүүдээс үүдэлтэй гэмт хэрэг үйлдэж байна гэж дүгнэлээ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорих ангид биечлэн ял эдлүүлж шийтгэхдээ биш нийгэмд нь өөрийгөө засах боломжийг олгож, зан төлөвийг нь засан, ухамсарлуулах нь чухал. Хүүхдийн хүсэл мөрөөдөл, ертөнцийг харан өнцөг нь ганц удаагийн алдаанаас болж насан туршдаа өөрийгөө буруутгах, гутранги үзэлтэй болох нь нийгмийн асуудал болно гэж ойлголоо.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/
2. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх.УБ.1996 он
3. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл.УБ.,1992 он
4. А.Лхагва. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.УБ.,2015 он
5. Б.Ганчулуун. Англиийн Эрүүгийн эрх зүй. УБ.,2005 он

БУСАД ЭХ СУРВАЛЖ

1. www.gov.uk

2. Монгол улсын ерөнхий прокурорын газар, Про подкаст, Архив,
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

---o0o---

ГЭРЛЭЛТ ШҮҮХИЙН ЖУРМААР ЦУЦЛАХ АЖИЛЛАГАА
JUDICIAL DISSOLUTION OF MARRIAGE



С.Дулам

Дотоод хэргийн их сургуулийн сургалт,судалгааны 403-р анги шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521-р дамжааны сонсогч



Ц.Шинэжаргал

Дотоод хэргийн их сургуулийн сургалт,судалгааны 403-р анги шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521-р дамжааны сонсогч

Хураангуй: Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний зарим зохицуулалтыг боловсронгуй болгох байдлыг судлан ийнхүү цуцалснаас гэр бүлийн гишүүдийн өмнө бий болох хүүхдээ асран хүмүүжүүлэх болон гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг оновчтой зохицуулах хууль зүйн зохих арга замыг тодорхойлох явдал юм.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн: Үүнд:

1. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалт

2. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах ажиллагааны эрх зүйн зарим зохицуулалтыг боловсронгуй болгох нь зэрэг эдгээр болно

Summary: To study the legal regulation of divorce proceedings by court procedure and to improve some of its regulations, to determine the proper legal way to optimally regulate the issue of child custody and the division of common property jointly owned by family members. In order to realize this goal, the following objectives have been set:

1. Divorce by court procedure and its legal regulation

2. These include the improvement of some legal arrangements for judicial divorce proceedings

Түлхүүр үг : Гэрлэлт, эвлэрүүлэн жуучлах, цуцлалт

Key words: Marriage, reconciliation, cancellation

УДИРТГАЛ ХЭСЭГ

Гэр бүл бол нийгмийн анхдагч үүр бөгөөд хувь хүний хөгжилд суурь үндэс нь гэр бүлийн хүрээнд эхлэн тавигдаж төлөвшдөг. Иймд гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг ролийг өндөржүүлэх, хувь хүний төлөвшилд эерэг нөлөөлөх нөлөөллийг дээшлүүлэхэд гэр бүлийн тогтвортой байдал нэн чухал ажээ. Гэхдээ гэрлэлтэд суурилсан гэр бүлийн тогтвортой байдал алдагдан шүүхээр гэрлэлт цуцлуулах явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. гэрлэлт цуцлах нь дан ганц эхнэр, нөхөрт хамааралтай асуудал биш цаана нь хүүхэд байнга сэтгэл зүйн дарамтад орж, чимээгүй хохирогч болон үлдэж багаасаа сэтгэл зүйн дарамтад өртөж ирээдүйд эцэг эх нийгэмд гомдсон, сэтгэл зүйн хувьд доголдолтой нэгэн болохгүй гэсэн баталгаагүй юм. Мөн хүүхдийн эрхийн тухай хуульд заасан Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй.[1] Заасан эрх нь зөрчигдөж байна. Энэ нь гэр бүл хүний хөгжилд нөлөөлөх нөлөөлөлд таагүй байдлыг үүсгэх нь олонтоо тохиолддог. Гэрлэлтийг Монгол Улсын Иргэний хууль болон Гэр бүлийн тухай хууль хуульд заасан үндэслэлээр захиргааны буюу шүүхийн журмаар цуцалдаг. Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах ажиллагааны хүрээнд шүүхийн шийдвэрлэдэг асуудал бол гэрлэгчдийн дундын

[1] Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ, 2021

өмчлөлийн эд хөрөнгийг хуваах болон хүүхдийн асрамж, гэрлэгчид бие биеэ болон хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбогдсон асуудал

Цуцалсан/салсан/ гэдэг нь: Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй байгаа хүнийг ойлгоно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Мөн Шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэр бүлийн эрхийг хамгаална. Төрийн захиргааны болон нийгмийн халамжийн байгууллага нь гэр бүлийн тухай хуульд зааснаар гэр бүлийн эрхийг хамгаална.

Гэр бүлийн эрх зүй нь гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, нийтлэг хүсэл сонирхлыг илэрхийлэн зохицуулах зорилгоор төрөөс зөвшөөрсөн эсвэл тогтоосон төрийн албадлагаар хангагдсан заавал дагаж биелүүлбэл зохих эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм. Гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болох гэсэн энэхүү асуудалд гэрлэлтийн харилцаа дуусгавар болох асуудал хамаарна. Гэрлэлт дуусгавар болох асуудал нь зөвхөн гэрлэлтээ бүртгүүлсэн гэрлэгчдийн хувьд яригдана.

Гэрлэлт гэдэг нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ. Гэрлэлтийн зарчим нь[1]:

- Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ.
- Иргэнийг гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж мөн.
- Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.

[1] 1999 оны “Гэр бүлийн тухай хууль”

• Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ.

Гэрлэлт дуусгавар болох гэдэг нь гэрлэгчдийн хооронд үүссэн гэр бүлийн харилцааг гэрлэгчид болон бусад сонирхогч этгээдийн хүсэлтээр төрийн эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл журмын дагуу зогсоож байгаа ажиллагаа юм[1]. Өрнөдөд олон зуун жилийн турш гэрлэлт бараг цуцалдаггүй байжээ. Онцгой тохиолдолд, тухайлбал гэрлэлтийн хэвийн харилцаа байх боломжгүй үед салалтыг хүлээн зөвшөөрдөг байсан.

Гэрлэлтийг шүүхийн болон захиргааны журмаар цуцална. Харин эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлахыг хориглодог. Энэ нь хүүхдийн эрх ашиг сонирхол мөн эхнэр, нөхрийн эрх ашиг сонирхлыг төрөөс хамгаалж буй явдал юм. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаар харилцан зөвшөөрсөн, тэдний асрамжид 18 хүртэлх насны төрсөн болон үрчилсэн хүүхэд байхгүй, эд хөрөнгийн маргаангүй тохиолдолд гэрлэлтээ цуцлуулахаар иргэний бүртгэл мэдээллийн байгууллагад гаргана. Гэр бүлийн хуульд гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах нэг үндэслэл нь тэдний асрамжид 18 хүртэлх насны хүүхэд байхгүй байх гэж зааж өгсөн байдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гэр бүлийн тухай хуулийг баримтлана.[2]

Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран ран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана. Хэрвээ нэхэмжлэгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /тахир дутуу, бага насны хүүхэдтэй, хүнд өвчтэй хэн нэгнийг асарч байгаа гэх мэт/ хариуцагчийн оршин суугаа газар очиж

[1] А.Дугармаа "Монгол Улсын гэр бүлийн эрх зүй" УБ 2005 он 50 дахь тал
[2] 1999 оны “Гэр бүлийн тухай хууль”

чадаагүй тохиолдолд өөрийн оршин суугаа газрын харьяалах шүүхэд нэхэмжлэлээ гаргана.

- Гэрлэгчдийн болон хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах үүднээс 3 сар хүртэлх хугацаагаар хойшлуулж талуудад эвлэрэх боломж олгоно. Шүүхээс гаргасан эвлэрүүлэх хугацаанд талууд эвлэрвэл шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Хэрвээ гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх эвлэрүүлэх хугацаа авалгүйгээр гэрлэлтийг цуцалдаг. Гэрлэгчид гэрлэлт цуцлах үедээ хүүхдээ хэний асрамжинд үлдээх, хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа тохиролцож болно. Гэр бүлийн гишүүд нь хуваарьт болон дундын өмчтэй байх ба хуваарьт өмчтэй холбоотой асуудалд шүүх оролцохгүй. Хэрвээ гэрлэгчид гэрлэлтийн гэрээ байгуулж түүндээ гэрлэлт цуцлуулахад дундын эд хөрөнгөө болон хуваарьт өмчөө хэрхэн зохицуулах талаар тусгасан бол гэрээний заалтыг дагаж мөрдөнө. Талууд өөрсдөө дундын өмчөө хэрхэн хуваах талаар тохиролцож чадахгүй бол шүүхээс хөрөнгө хуваах асуудлыг шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцлахад гэр бүлийн дундын хөрөнгийг гэр бүлийн бүх гишүүдэд хуваарилна. Өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүүхэд нь эцэг эхийнхээ адил нэгэн хэмжээний эд хөрөнгийг өмчлөх эрхтэй байна гэсэн үг юм. Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн гишүүнд оногдох дундын эд хөрөнгийн хэсгийг тодорхойлоход гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх ашиг сонирхлын үүднээс, түүнчлэн дундын эд хөрөнгөө зүй бусаар ашигласан, нуусан, гэрлэлт цуцалсан нь түүний буруутай үйлдлээс шалтгаалсан нь тогтоогдсон нөхцөлд шүүх өөрөөр тогтоож болно. Гэрлэгчид эд хөрөнгийн хувьд маргаж байгаа тохиолдолд хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэр бүлийн бүх гишүүдэд хуваах ба дараах нөхцөл байдлыг харгалзан гишүүдэд оногдох хувийг өөрөөр тогтоож болно.[1] ҮҮНД: гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн насны болон эрүүл мэндийн байдал, маргаантай байгаа эд хөрөнгийг бий болгоход гэрлэгчдээс оруулсан хөрөнгийн болон хөдөлмөрийн оролцоо, гэрлэлт цуцлахад хэний буруу байсан, гэрлэгчид хөрөнгөө зүй бусаар нуусан, ашигласан байдал.

[1] С. Боловсон “Гэр бүлийн эрх зүй” /лекцийн эмхэтгэл/, УБ, 2006 он, 59-р тал

Шүүх гэрлэлт цуцлах тухай шийдвэртээ хамтран өмчлөх дундын хөрөнгөөс хэн хэнд ямар хөрөнгө ногдохыг тодорхой зааж өгнө. Гэрлэгчид хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө гэрээний үндсэн дээр тохиролцсон байвал түүнийг нь гэрлэгчдийн аль нэгний хүсэлтийг харгалзан эд хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг биелүүлэх тухай захирамж гаргана. Шүүх гэрлэлт цуцлах хэргийг шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг сайтар судлан тогтоож, гэрлэгчдийн болон хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах үүднээс аль болохоор гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна. Харин гэрлэгчид нь бие биеэ байнга хүчирхийлж дарамталдаг нь гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулдаг болох нь тогтоогдвол эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг шууд цуцалж болно. Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд болон Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд харшлахгүй бол гэрлэлт цуцлуулсныг хүчинтэйд тооцно.

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах талаар болон эд хөрөнгийн асуудлаар маргаантай байгаа, 18 хүртэлх насны хүүхэдтэй тохиолдолд гэрлэлт цуцлах асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэх үндэслэл бүрдэж байна.

- Гэрлэлтийг цуцлахыг гэрлэгчдийн хэн нэгэн зөвшөөрөхгүй байгаа
- Гэрлэлт цуцлахыг зөвшөөрсөн ч захиргааны байгууллагад хүсэлт гаргахаас татгалзаж буй тохиолдолд
- 18 хүртэлх насны хүүхэдтэй
- Дундын өмчлөлийн эд хөрөнгийн талаар маргаантай байгаа
- Гэрлэгчдийн хэн нэг нь иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу анхан шатны шүүх гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг хүлээн, маргааныг авч хэлэлцэх бөгөөд дээрхи дурьдсан нөхцөлүүдийг аль нэг үндэслэл нь байхад л шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх боломжтой болно.

Гэрлэлт цуцлахтай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлүүлэхээр гэрлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахдаа хуульд заасан шаардлагыг хангасан байх ёстой.

Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлд:

- Гэрлэгчдийн овог, эцгийн нэр, нэр

- Гэрлэлт хэзээ, хаана бүртгүүлсэн
- Гэрлэлт цуцлах болсон шалтгаан
- Насанд хүрээгүй хүүхэдтэй бол түүний нэр, төрсөн он, сар, өдөр
- Хүүхэд эрүүл саруул бойжиж буй тухай өрхийн эмчийн тодорхойлолт
- Насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх түүнд асрамж тогтоох тухай хүсэлт
- Тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаарх хүсэлт. Энэ талаар хэлэлцэн тогтсон гэрээ байгаа эсэхийг зааж холбогдох нотлох баримтыг хавсаргана.

Үүнээс гадна дараах баримтуудыг нэхэмжлэлд хавсаргах боломжгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах ёстой. Үүнд:

- Гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ эсхүл үрчлэлтийн гэрчилгээний натариатаар гэрчлэгдсэн хуулбар.
- 18 хүртэлх насны хүүхэд сургуульд сурч байгаа бол сургуулийн тодорхойлолт Гэрлэгчид эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээ байгуулсан бол гэрээний нэг хувь
- Эд хөрөнгийн маргаантай бол гэр бүлийн дундын өмчлөлийн эд хоронго болон хуваарьт хөрөнгийн жагсаалт зэрэг хэрэгт ач холбогдолтой нотлох баримт орно.

Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлахаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.

Эвлэрүүлэн зуучлал[1] гэдэг нь талуудын хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхэд “Монгол Улсын эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу дэмжлэг үзүүлэх эвлүүрлэн зуучлагчийн ажиллагааг хэлнэ. Харин “эвлэрүүлэн зуучлагч" гэж тухайн маргаанд зуучлуулахаар талуудын сонгосон буюу зөвшөөрсөн, маргааны

[1] 2012 оны “Эвлрүүлэн зуучлалын тухай хууль”

талаар шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий мэргэшсэн этгээдийг хэлнэ.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 3 сар хүртэл хугацаанд үргэлжлүүлэн, гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүх гэрлэлтийг цуцлана.

Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ. Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусмагц шүүх гэрлэлтийг цуцална. Эвлэрүүлэн зуучлах хугацаа 30 хоног Шаардлагатай тохиолдолд 30 хоногоор 1 удаа сунгаж болно.Дараах тохиолдолд гэрлэлт цуцлахад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс шаардахгүй.

Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс шаардахгүй.

Гэрлэгчид гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлээ шүүхийн нутаг дэвсгэрийн нийтлэг харьяаллын дагуу гаргах ба нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй, тахир дутуу, бусад хүндэтгэн үзэх шалтгаантайн улмаас хариуцагчийн оршин суугаа газарт хандахад бэрхшээлтэй бол өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн шүүхэд гаргаж болно. Мөн нэхэмжлэгч, хариуцагч хаана нэхэмжлэлээ гаргахаа харилцан тохиролцож тогтоож болно.[1] Шүүхэд нэхэмжлэл гаргах:

Нэхэмжлэлд хавсаргах материал

1. Нэхэмжлэл 2 хувь

2. Улсын тэмдэгтийн хураамж тушаасан баримт /КИОСК машин /

3. Гэрлэлтийн баталгаа нотариатаар батлуулсан байна

4. Хүүхдийн төрсний гэргчилгээ /нотариат/

5. Нэхэмжлэл гаргаж буй хүний хорооны тодорхойлолт

6. Хүүхэд эсэн мэнд бойжиж буй өрхийн эмнэлгийн тодорхойлолт

7.Хүүхдийн сургуулийн тодорхойлолт

8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болгосон тухай тэмдэглэл

[1] С.Боловсон “Гэр бүлийн эрх зүй” /лекцийн эмхэтгэл/, УБ, 2006 он, 58-р тал

Нэхэмжлэл гаргах шүүхийн харьяалал

1. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2. Нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл нь ИХШХШТХ-н 62-р зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлага хангасан байх ба гэрлэлтээ хэзээ хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлах болсон шалтгаан, төрсөн ба үрчлэн авсан хүүхдийн байдал, насанд хүрээгүй хүүхдээ хэний асрамжид үлдээх, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаар ямар хүсэлт гаргаж байгаагаа нэхэмжлэлд тодорхойлон бичиж холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна. Шүүх энэ хэргийг хянан шийдвэрлэхдээ доорхи асуудлыг заавал шийдвэрлэнэ. ҮҮНД:

- Насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх
- Хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр нөхрийг хэрхэн тэжээн тэтгүүлэх асуудал
- Гэр бүлийн гишүүний эд хөрөнгийн асуудлыг хамтатган шийдвэрлэнэ.
- Гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэх явцад шүүхээс
- Насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг эхийг тэжээн тэтгүүлэх,
- Насанд хүрээгүй хүүхдийг эцэг эхийн хэн нэг дээр байлгах
- Гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах
- Гэрлэгчдийн хэн нэгийг тэжээн тэтгүүлэх
- Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх, эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх
- Шүүхийн зардлын зохих хувийг урьдчилан гаргуулах, маргалдагч талуудад эвлэрэх боломж олгох хугацаа тогтоож өгөх зэрэг арга хэмжээг авч ажиллана.

Шүүхээс насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжид үлдээх вэ гэдгийг шийдвэрлэхдээ эцэг эхийн тохиролцоог харгалзан үзэх шаардлагатайгаас гадна тохиролцож чадаагүй бол /маргаж байгаа бол/ хүүхдийн нас, эцэг эхийн хайр халамж, амьдралын нөхцөл боломж, ёс суртахууны байдал зэргийг нь харгалзан шийдвэрлэхээс гадна 7 ба түнээс дээш настай хүүхдээс

саналыг нь авна. Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлээд түүнд олгох тэтгэлгийг тогтоож өгнө.

Тэжээн тэтгэх харилцаа нь эцэг эх үр хүүхдээ, үр хүүхэд нь эцэг эхээ, гэрлэгчид нь хөдөлмөрийн чадваргүй эхнэр нөхрөө тэжээн тэтгэхдээ тодорхой хугацаа заадаггүй тул харьцангуй үргэлжилсэн шинжтэй байна. Тэжээн тэтгэх харилцаанд оролцож буй субьектийн байдлаас нь шалтгаалан уг харилцааг эцэг эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг эхээ, гэрлэгчид бие биенээ, төрөл садангийн хүмүүс бие биенээ тэжээн тэтгэх харилцаа гэж ангилан үзнэ. Тэжээн тэтгэх харилцааны ангилал нь хуульд заасан субьектүүдийн хооронд үүсч буй тэжээн тэтгэх үүрэгтэй холбогдон хийгдсэн нь зүйтэй юм. Хүүхэд төрснөөр эцэг эхэд хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг үүсдэг ба хүүхдэд тэжээн тэтгүүлэх эрх үүснэ. Хүүхдийн эцэг эхээрээ тэжээн тэтгүүлэх эрх нь насанд хүртэл нь үргэлжилнэ. Тэжээн тэтгэх эцэг эхийн үүрэгт "хүүхдийн амьдрах эрүүл орчин бүрдүүлэх нэн шаардлагатай хоол хүнс орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлээр хангахыг ойлгохоор заасан байдаг.

Хүүхдийг тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийг эрүүл орчинд өсч хүмүүжихэд хэрэгцээт наад захын зүйлсийг хангахад чиглэгддэг байна. Эцэг эхийн үр хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг нь гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болох үед ч хэвээр үргэлжилнэ.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн тэтгэлэгийг

1.Гэрээгээр

2.Хуульд заасан хэмжээгээр тус тус тогтоож болно.

Гэрлэлт дуусгавар болох үндэслэл[1]

- Гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан
- Гэрлэгчдийн хэн нэгнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.
- Гэрлэлт цуцалснаар гэрлэлт дуусгавар болох
- Гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс
- Шүүхийн шийдвэрийг Улсын бүртгэлийн газарт хүргүүлнэ.

[1] Б.Даваажав, С.Оюунчимэг "Монгол улсын гэр бүлийн эрх зүй" УБ, 2014 он, 58-р тал

Гэрлэгчид нь гэрлэлт цуцалсны гэрчилгээг хүлээн авах хүртэл шинэ гэрлэлтийг бүртгүүлэх эрх хууль зүйн хувьд үүсэхгүй. Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ:

Улсын бүртгэлд бүртгүүлэхдээ бүрдүүлэх материал:

1. Иргэний үнэмлэх

2. Гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр

Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийг хөтөлнө.

Гэр бүл салалтын нийтлэг шалтгаанууд

- Соёлын ялгаа Харь орны хүнтэй гэрлэсэн, мөн хоёр өөр гэр бүлийн соёлын мөргөлдөөн
- Гэр бүлийн гишүүд хариуцлага бүрэн ухамсарлаагүй
- Гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүй
- Санхүүгийн хомсдол, цалин орлого, амьдралын баталгаа
- Шилжилт хөдөлгөөн
- Архидалт, муу зуршил
- Гэр бүлээс гадуурх харилцаа, хууралт
- Хэрүүл маргаан, үл ойлголцол
- Хүчирхийлэл, дарамт шахалт

Гэрлэлт цуцлахад анхаарах асуудал


1.Хүүхэд 7 ба түүнээс дээш настай бол түүний саналыг харгалзан үзнэ. Мөн тухайн хүүхэд амьдрахад орчин нөхцөл нь хэр тохиромжтой вэ? гэдгийг шүүх харгалзан үзнэ.

2. Хариуцагч талын амьдарч байгаа хаягийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргана.

3.Тэжээн тэтгэх


4.Гэр бүлийн дундын эд хөрөнгийг бүх гишүүд тэнцүү хуваана.

Монгол Улсын 2020-2023 оны гэрлэлт, гэр бүл цуцлалтын судалгаа харьцуулалт



Дээрх судалгаанаас 2020 оноос 2023 оны гэр бүл гэрлэлт болон гэр бүл цуцлалтыг харж болно. Гэр бүл гэрлэлт 2020 оноос хойш харьцангуй ихэссэн бол цуцлалт нь мөн адил ихэссэн. Үүнээс дүгнэхэд гэрлэлт хэдий чинээ өссөн ч үр дагавар нь сөрөг үр дагавартай байна.

Монгол Улсын шүүхээр шийдвэрлэгдэж буй гэр бүлийн эрх зүйн маргааны статистик мэдээллийн харьцуулалт



Энэ судалгаанаас зөвхөн гэр бүлийн маргаанаас болж ямар их сөрөг үр дагавар бий болохыг харж байна. Хор уршиг нь хүүхдүүд өнчрөх, сэтгэл санааны хямралд орох, айх ичих гэх мэт зүйлсийг мэдэрнэ. Зарим гэр бүл гэрлэлт шүүхийн журмаар цуцлах ажиллагааны талаар мэдлэггүйн улмаас хүүхдийн тэтгэлэг болон хүүхдээ тэжээн тэтгэх асуудлын талаар маргаантай. Хүүхдийн тэтгэлгээ гаргуулж чаддаггүй байна.

Гадаад орны гэр бүл цуцлалт[1]

[1] www.google.com

Гэрлэлт бол цуцлагдашгүй байнгын холбоо. Энэ хандлагыг баримтлагч улс орнууд гэрлэлт цуцлахыг хүлээн зөвшөөрдөггүй ба гэрлэлт цуцлахыг хориглодог. Гэрлэлтийн харилцаа дуусгавар болох цорын ганц нөхцөл бол эхнэр, нөхрийн аль нэг нь нас барсан, эсвэл шүүхээс нас барсан сураггүй алга болсонд тооцсон байхаар хууль тогтоомжидоо зааж өгсөн. Ирланд, Андорра, Испани, Аргентин, Колумб, Парагвай, Чили зэрэг улсууд энэ хэсгийн ангилалд хамаарна. Ялангуяа католик шашинтай улс орнууд гэрлэлт цуцлахын эсрэг байр суурийг баримталдаг. Өөрөөр хэлбэл гэрлэлтийг ариун нандин, шашны шинжтэй харилцаа гэж үздэг бөгөөд гэрлэлтийн харилцааг дуусгавар болгох нь хүний хүсэл зоригоос үл хамаарна гэж үздэг байна. Сүүлийн үед энэ үзэл хандлага уян хатан шинжтэй болж, зарим нэг тохиолдолд гэрлэгчдийг гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрдөг болсон. Гэвч энэ нь яг үнэндээ гэрлэлтийг цуцалж байгаа хэрэг биш, зөвхөн гэрлэгсдийг тодорхой хугацаагаар тусдаа амьдрахыг зөвшөөрсөн байдаг.

Гэрлэлтийн харилцааг дуусгавар болох асуудалд хандах харьцангуй аядуу хандлага Дани, Норвеги, Швед, Мексик, Япон, АНУ-н зарим муж гэх мэт улс орнууд хуулиндаа гэрлэлтийн харилцааг дуусгавар болгох асуудлыг харьцангуй нээлттэй авч үзэж, зохицуулсан байдаг. Жишээ нь: Францын Иргэний хуулийн хэм хэмжээтэй адил төстэй хэм хэмжээг хуулиндаа нилээд тусгасан Бельгийн Иргэний хуульд гэрлэлт цуцлах үндэслэлүүдийг тодорхой шалгууруудаар нарийвчлан гаргасан байдаг. Дээр нэрлэсэн улс орны заримд хэрвээ гэрлэгчдийн өөрсдөө харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлах үед нөхцөл байдлыг хөнгөрүүлэн авч үзэх журам үйлчилдэг. Тухайлбал, Японд гэрлэгчид харилцан зөвшөөрснөөр гэрлэлтийг цуцалж байгаа бол шүүхийн бус журмаар шийдвэрлэж болдог байна. Энэ үзэл хандлагын гол онцлог бол гэрлэгчдийн хэн нэгний бус, гэрлэгчдийн хоёулангийнх нь хүсэл зориг, зөвшөөрлийн үндсэн дээр асуудлыг шийдвэрлэж байдагт оршино. Энд дийлэнх улс орнууд хамрагддаг ба гэрлэлтийг тодорхой үндэслэлээр цуцлахдаа эхнэр, нөхөр хоёрын харилцан зөвшөөрлийг заавал шаардахгүй. Гэхдээ зөвхөн гэрлэгчдийн аль нэг нь гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн байх ба түүний зэрэгцээ хуульд заасан тодорхой үндэслэлүүд байхыг шаарддаг.

Жишээ нь: Гэрлэгчдийн хэн нэг нь нөгөөдөө үнэнч байж чадаагүй, эсхүл ямар нэгэн ноцтой, шийтгэл хүлээх үйлдэл хийсэн, гэрлэгчдийн хэн нэг нь нөгөөгөө орхиж явсан бол, гэрлэгчдийн хэн нэг нь хамтын амьдралаа

үгүй хийх байдал үүсгэсэн, тухайлбал гэрлэлтийн улмаас үүссэн үүргээ ноцтой зөрчсөн, илт шударга бус, хүнлэг бус хандсан, садарлаж завхайрсаны улмаас хамтран амьдрах боломжгүй болсон бол гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэл гаргаж болно. Үүргээ ноцтой зөрчсөн гэдэгт харгис хэрцгий, хүнлэг бус харьцахыг ойлгоно.

Эхнэр, нөхөр нь 3 жилээс дээш сэтгэцийн өвчтэй байсан бол гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцогч субьектуудын хүсэл зоригоос хамаарч эсвэл хамаарахгүйгээр гэр бүлийн эрх зүйн харилцааны үйлчлэл зогсоно.

Дээр дурьдсан улс орнуудын хууль тогтоомжуудын зохицуулалтаас үзвэл гэрлэлтийн эрх зүйн харилцаа дуусгавар болох 2 үндэслэл байх буюу гэрлэгчдийн хүсэл зоригоос хамаарахгүйгээр гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болох гэрлэгчдийн хүсэл зоригоос хамаарч дуусгавар болох зохицуулалт гарч ирдэг байна.

1.Гэрлэгчдийн хүсэл зоригоос хамаарахгүйгээр дуусгавар бол болох үндэслэлд:

а) Гэрлэгч нас барсан бол эсвэл шүүхээс нас барсанд тооцсон бол

Гэрлэгч нас барсан гэдгийг тухайн этгээдийн нас барсны гэрчилгээгээр тодорхойлно. Гэрлэгчийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрлэлтийг дуусгавар болно.

б) Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноор гэрлэлтийн харилцаа байгаагүйтэй адилтган авч үзэх асуудал гарч ирнэ. Өөрөөр хэлбэл гэр бүлийн харилцаа дуусгавар болох тухай ойлголт нь хууль ёсны гэрлэлт буюу анхнаасаа гэр бүлийн хууль тогтоомжид заасны дагуу гэрлэх нөхцөл журмын дагуу бүртгүүлсэн албан ёсны гэрлэлтийн харилцаа зогсохыг ойлгоно. Харин гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцсоноор гэрлэлтийн харилцаа дуусгавар болох тухай ойлголт нь анхнаасаа хууль бусаар үүссэн гэр бүлийн харилцааг таслан зогсоож байгаа ойлголт юм.

2.Гэрлэгчдийн хүсэл зоригоос хамаарч гэрлэлтийн харилцаа дуусгавар болгох үндэслэлд:

гэрлэлт цуцлах тухай ойлголт багтаж байдаг..

Монгол улс гадаад улсын гэрлэлт цуцлах ажиллагаанд судалгаа хийхэд гадаадын зарим улс орон гэр бүл цуцлалтыг хүлээн зөвшөөрдөггүй. Харин Солонгос, Хятад улсын гэрлэлт цуцлалтын ажиллагааг судлахад монгол улсын гэрлэлт цуцлах ажиллагаатай төстэй байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын хэмжээнд тухайн тоо баримтаар жилд 20000 орчим хосууд гэрлэлтээ батлуулдаг. Цуцлалтын хувьд жилд 3800-4000 орчим гэр бүл гэрлэлтээ цуцлуулдаг. Мөн гэрлэлт болон гэр бүл цуцлалт өмнөх оныхоос өссөн үзүүлэлттэй байна. Шүүх гэрлэлт цуцлалтын дараагаар тэжээн тэтгэх тэтгэмж төлөх хариуцлагыг ногдуулсан ч, тэтгэмж төлөх үүргийн биелэлтэнд тавих хяналт сул, биелүүлэхгүй нөхцөлд оногдуулах хариуцлага сул байгаа нь цуцлалтын дараагаар хуулиар оногдуулсан үүргээ биелүүлэхгүйн улмаас эцэстээ өрх толгойлсон, эх/эцгийн нөхцөл байдлыг доройтуулж хүүхэд хохирч үлдэх эрсдлийг бий болгож, цаашлаад цуцлалтыг далд хэлбэрээр хэмжих арга хэмжээ болж хувираад байна. Энэ тохиолдолд эх, эцэг хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн туслан дэмжих үйлчилгээ байхгүйтэй холбоотой юм. Гэрлэлтийг захиргааны журмаар болон шүүхийн журмаар цуцалдаг. Захиргааны журмаар цуцлахаас бусад тохиолдолд гэрэлтийг шүүхийн журмаар цуцлана. Гэрлэгчид 18 хүртэлх насны хүүхэдтэй эсвэл эд хөрөнгийн талаар маргалдаж байгаа бол тэдний харилцан тохиролцсон эсхүл хэн нэгний түүнчлэн иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй гэж тогтоогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагч гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргана. Шүүх гаргасан нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг гэр бүлийн тухай хууль болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэнэ. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Гэрлэлгчдийн хэн нэг нь байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй эсхүл учруулсан нь тогтоогдсон бол шүүх эвлрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлана. Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусмагц шүүх гэрлэлтийг цуцлана. Шүүх гэрлэлт цуцалсан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор гэрлэлтийг иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

САНАЛ

1. Гэр бүл салалтыг бууруулахад төр бодлогын түвшинд анхаарах шаардлагатай. Тиймээс шинжлэх ухааны мэдлэгт суурилсан боловсролыг иргэдэд олгох хэрэгтэй. Өнөөдөр залуучууд, өсвөр үеийнхэнд гэр бүлийн талаарх мэдлэгийг олгосноор ирээдүйн гэр бүл салалтыг бууруулна.
2. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд
3. Гэр бүлийн тухай хууль шинэчлэ ёстой. Гэр бүлийн гишүүн бүрийн хариуцлагыг нэмэгдүүлж хүүхдийн эрх, гэр бүлд эзлэх байр суурь, хүүхдийн тэтгэмж, эд хөрөнгө хуваах зэргийг нарийн зааж тусгах ёстой.
4. Гэр бүлийн төлөвлөлт сэтгэл зүйн боловсролыг нас насны иргэдэд шатлалтай системээр хүргэх хэрэгтэй.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Гэр бүлийн тухай хууль, УБ, 1999 он
2. Монгол улсын иргэний хууль, УБ, 2002 он
3. Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ, 2021
4. Эвлрүүлэн зуучлалын тухай хууль, УБ, 2014 он
5. С.Боловсон “Гэр бүлийн эрх зүй” /лекцийн эмхэтгэл/, УБ, 2006 он, 58-р тал
6. А.Дугармаа "Монгол Улсын гэр бүлийн эрх зүй" УБ, 2005 он
7. Хууль зүйн үндэсний хүрээлэн
8. www.legalinfo.mn
9. https://m.blog.naver.com

СУДАЛГАА СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистикийн мэдээ
2. Үндэсний статистикийн хороо

---o0o---

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭХ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

REGARDING CHILDREN'S SCHOLARSHIP PROCEDURE



Е.Гүлнур

Дотоод хэргийн их сургуулийн сургалт,судалгааны 403-р анги шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521-р дамжааны сонсогч

Хураангуй: Гэр бүл нийгэмд маш олон үүрэг гүйцэтгэдэг. Гэрлэгсдийн нийгэмд гүйцэтгэх үүргийг тодруулах нь гэр бүлийн нийгмийн үүргийг биелүүлэх нэг үндэс юм. Гэр бүл нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлснээс манай нийгмийн сайн сайхан байдал ихээхэн хэмжээгээр шалтгаална. Манай орны тухайд авч үзвэл нүүдлийн мал аж ахуйгаас суурьшмал амьдралд шилжсэнээр гэр бүлийн нийгмийн үүрэг өөрчлөгдөж, гэр бүлийн амьдрал ахуйд олон талын өөрчлөлт гарлаа. Эмэгтэйчүүд нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдэж зарим тохиолдолд эрэгтэйчүүдээс илүү хөдөлмөрлөх болов. Энэ нь нөхрөө анхааран халамжлах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх боломж багасна гэсэн үг. Ингэснээр гэр бүлийн хэвийн амьдрал алдагдаж, амьдралын хүнд ачааг үүрч, бухимдалд орж цаашилбал гэмт хэрэгт ч орох явдал гарч байна. Эрэгтэйчүүдийн архидалт, танхайралт, хүүхэд тэнэмэл болох явдал ч үүнтэй холбоотой. Энэ бүхний үр дүнд гэр бүл салалт болж тэжээн, тэтгэх тэтгүүлэхтэй холбоотой харилцаа маш хүнд байдалд орж байна.

Түлхүүр үг: Тэжээгч, тэтгүүлэгч, тэжэн тэтгэх үүрэг, тэжээн тэтгүүлэх эрх үүсэх хугацаа, тэтгэлэг нөхөн гаргуулах, тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болох.

ҮНДСЭН ХЭСЭГ

Тэтгэлэг төлнө гэдэг нь юу гэсэн үг вэ?

Энэ нь хөдөлмөрийн чадваргүй, аль эсвэл насанд хүрээгүй буюу өөрийгөө тэжээх чадваргүй гэр бүлийн гишүүнээ тухайн гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай, насанд хүрсэн өөр нэгэн гишүүн нь гэрээ болон хуульд заасан үүрэг, шүүхийн шийдвэрийн дагуу мөнгөн хэлбэрээр эсвэл эд хөрөнгөөр тэтгэж буй хариу төлбөргүй, тодорхой хугацаанд үргэлжилсэн шинж чанар бүхий үйлдэл юм.

Саяны тодорхойлолтод дурдсанчлан, тэжээн тэтгэх үүрэг нь гэр бүлийн харилцаа үүсэж бий болсноос, талуудын хооронд байгуулсан гэрээнээс, мөн тэтгэлэг төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарснаас үүдэн бий болдог. Тэтгэлгийн хэлбэр, хэмжээ, хугацааны асуудлыг тэтгэлэг тогтоох гэрээ эсвэл хуульд заасны дагуу шүүхийн журмаар тогтоодог.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг эх нь насанд хүрээгүй, эсвэл насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй байдаг[1]. Хэрэв эцэг эх нь салсан эсвэл тусдаа амьдардаг бол хоорондоо харилцан тохиролцож, гэрээ байгуулан хүүхдэдээ өгөх тэтгэлгийн хэмжээг тогтоож болно. Эсвэл мэдээж шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой. Хэрэв эхийнхээ асрамжид үлдсэн хүүхдийн эцгээс нь өгч буй тэтгэлгийг эх нь хүүхдийн хэрэгцээнд зарцуулаагүй тохиолдолд эцэг буюу тэтгэлэг төлөгчөөс зориулалтаар нь зарцуулуулахаар шүүхэд хандаж болох зохицуулалт Гэр бүлийн тухай хуульд тусгагдсан байдаг. Мөн тэтгэлэг төлөгч өөр хүүхэдтэй бөгөөд тэдгээр нь тэтгэлэг авагчаас бага орлоготой, тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадвараа алдсан, эсвэл тэтгэлэг авагч хүүхэд өөрөө хангалттай орлоготой болсон бол шүүхээс тэтгэлгийн хэмжээг багасгаж болно.

Хэрэв хүүхдийн эцэг эх нь эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, бусад шалтгаанаар хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа бол эцэг эхээс хүүхдэд олгох тэтгэлгийг асрах байгууллагын дансанд шилжүүлж, үүнээс тэтгэлгийн 50 хувийг хүүхдийн ахуйн хэрэгцээнд зарцуулж, үлдсэн хувийг хүүхдийн нэр дээрх хадгаламжийн дансанд шилжүүлнэ хэмээн хуулиар зохицуулсан байна[2].

Гэр бүлийн тухай хуульд хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг хуульчилж өгсөн. Тухайлбал, 11 хүртэлх насны хүүхдэд тогтоох тэтгэлгийн хэмжээ тухайн бүс нутгийн амжиргааны доод түвшингийн 50 хувьтай

[1] Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30
[2] Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30


тэнцэхүйц, 11-16 нас, суралцаж байгаа бол 18 нас хүрсэн, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтооно гэсэн. Амжиргааны доод түвшин нь бүс нутаг, нийслэлд өөр өөр байх бөгөөд Улаанбаатар хотод 185,300₮ байхаар Засгийн газраас тогтоосон байдаг байна.

Тэтгэлэг тогтоох, төлөх журам:

Тэжээн тэтгэх гэрээний үндсэн дээр төлөгдөх тэтгэлгийг төлөх журмыг талууд тухайн гэрээгээр тодорхойлно. Тэжээн тэтгэх гэрээ байхгүй бол төлбөр тогтоох журам нь шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжаар тодорхойлогдоно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйлд зааснаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх тухай гэрээг байгуулсан бөгөөд түүнийгээ сайн дураар биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр гэрээг биелүүлэхтэй холбогдуулан шүүгч захирамж гаргана[1].

Хүснэгт 1. Тэжээн тэтгүүлэх эрх үүсэх хугацаа



Хүснэгт 2. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

[1] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №8



Судалгаанаас үзэхэд: Тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо сүүлийн 3 жилд эрс нэмэгдсэн нь Монгол Улсын иргэд эрх зүйн мэдлэгтэй болсонтой шууд холбоотой гэж үзэж байна.

Тэтгэлэгийг хуулийн хугацаандаа төлөөгүйгээс болж үүсэх хариуцлага:


Тэжээн тэтгэх тухай гэрээг сайн дураар биелүүлэхгүй байгаа тохиолдолд тэдний хэн нэгний хүсэлтээр шүүгч захирамж гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ. Тэжээн тэтгэх тухай гэрээний дагуу тогтоох тэтгэлгийн хэмжээ нь тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний хэмжээнээс багагүй байна. Тэжээн тэтгэх тухай гэрээний дагуу тогтоох тэтгэлгийн хэлбэрийн хувьд мөнгөн болон эд хөрөнгөөр, хугацаа нь сар, улирал, хагас жил, жилд нэг удаа байж болно. Тэтгэлгийг эд хөрөнгөөр олгохоор талууд харилцан тохиролцсон бол эд хөрөнгийг орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлнэ.

Тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон /хүндээр өвчилсөн, тахир дутуу болсон, эмчлүүлсэн, сургуульд орсон гэх мэт/ үед түүнд нэмэлт тэтгэлэг гаргуулах, эсхүл гарсан зардлыг хариуцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болно. Тэтгэлэг нөхөн төлүүлэхэд тэтгэлэг төлөгч хөдөлмөр эрхлээгүй буюу цалин хөлс, бусад орлогын хэмжээг тогтоох боломжгүй бол тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтална. Тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн хугацааны

тэтгэлгийн хэсгийг буюу бүхэлд нь нөхөн төлүүлэхээс шүүх чөлөөлж болно[1].

Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлнө. Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна[2].

Хүснэгт 3. Тэтгэлэгийг нөхөн гаргуулах үндэслэл журам



Зөрчлийн тухай хуулийн 6.20-р зүйлийн 6-д "Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр тогтоосон сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага

[1] Ч.Дондог. Гэр бүлийн эрх зүй. УБ., 2015 он. 22-23 дахь тал.
[2] Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30

хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан[1].

Энэхүү торгох шийтгэл нь иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр өөрийн буруутай үйлдлээ ухамсарлах боломж олгодог. Нийслэлийн хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхээс жилдээ тэтгэлэг албадан төлүүлэх 600-800 хүсэлт ирдэг байна. Ерөнхийдөө 4500-5000 хүүхдийн тэтгэлгийн баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа аж. Энэ бол зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн хүсэлтийн тоо. Нэг шийдвэр гүйцэтгэгч дээр хүүхдийн тэтгэмжийн 200-гаад материал ногддог байна. Өмнө нь Эрүүгийн хуулийн 120-р зүйлд хүүхдийн тэтгэмжээс зайлсхийсэн бол эрүүгийн ял шийтгэл оноохоор тусад нь хуульчилсан байжээ. Одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуулинд хүүхдийн тэтгэлэг төлөөгүйтэй холбоотой хариуцлагын ямар нэгэн заалт алга.

Хүснэгт 4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт




Судалгаанаас үзэхэд: Шүүхийн шийдвэр гарснаас хойш сайн дурын үндсэн дээр тэтгэлэг төлөөгүй тохиолдолд тэтгэлгийг нөхөн төлүүлэх асуудал яригдах бөгөөд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамж гарснаас хойш тэтгэлэг төлөлт хийгдээгүй болон тэтгэлэг нь тасалдсан тохиолдолд төлөгдөөгүй тэтгэлэг дээр нэмж хугацаа хэтэрсэн алдангийн тооцуулан нөхөн төлүүлэхээр дахин шүүхэд


[1] Зөрчлийн тухай хууль, 2017 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24

хандсанаар энэ эрхээ хэрэгжүүлэх боломжтой болно. Мөн шүүхийн шийдвэрийг сайн дурын үндсэн дээр биелүүлэхгүй, шийдвэр гүйцэтгэх байгууллага тэтгэлгийг төлүүлэхэд онцгой анхаарч ажиллаагүйн улмаас тэтгэлэг авагч нь 18 насанд хүрсэн тохиолдолд хэргийн материалыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хааж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй болно. Учир нь тэтгэлэг авагч 18 насанд хүрч эрх зүйн чадвар, чадамжтай болсон хэдий ч хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр биелэгдээгүй байгаа учир хөөн хэлэлцэх хугацаа үүнд хамааралгүй болно.

Хүснэгт 5. Хүүхдийн тэтгэлэг төлөх үүрэг дуусгавар болох



Хүснэгт 6. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулалт



Судалгаанаас үзэхэд: Хүүхдийн тэтгэлгийн төлбөрийг барагдуулсан, бүрэн дуусгавар болгосон үзүүлэлт нь маш муу байгаа нь Монгол Улсад хүүхдийн тэтгэлэг барагдуулах ажиллагааны хэр зэрэг муу чанартай явагдаж байгааг үзүүлж байна.

ДҮГНЭЛТ

Гадаадын ихэнх оронд гэрлэлтийн гэрээг байгуулж хэвшсэн ба энэхүү гэрээгээр гэр бүл цуцалсан тохиолдолд эд хөрөнгийн маргааныг хэрхэн шийдвэрлэх, тухайлан хүүхдийн тэтгэлэг төлөх талаар тусган талууд баталгаажуулсан байдаг тул тухайн харилцаанд маргаан гарах нь бага байдаг байна. Харин Монгол Улсын Иргэний хуулийн 32 дугаар зүйлд гэрлэгчид зөвхөн хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулахаар заасан тул хүүхдийн тэжээн тэтгэх эрхийн тухай асуудлыг орхигдуулсан байна. Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт гэрлэлтийн гэрээ хийж буй асуудал учир дутагдалтай бага байна. Зүй нь гэрлэлтийн гэрээнд зөвхөн хөрөнгийн асуудал бус үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудлыг тусгасан байдлаар хуульчилж, гэр бүл батлуулахад зайлшгүй гэрээг харгалзан үздэг байх нь зүйтэй гэж үзлээ. Залуучуудад гэр бүл болохын өмнөх эрх зүй, эдийн засгийн мэдлэг, боловсрол дутмаг тул гэр бүл салалт гэх асуудал манай улсад түгээмэл асуудлуудын нэг болсон. Тэтгэлэг гэдэг бол хүүхдийн тухайн үеийн хэрэгцээнд зарцуулагдана гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй. Түүнээс биш ээжид нь өгөөд байгаа юм биш. Тухайн ээж ч гэсэн өөртөө хэрэглэх гээд нэхээд байгаа асуудал биш.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж

1. Гэр бүлийн тухай хууль, 1999 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30
2. Зөрчлийн тухай хууль, 2017 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №8

Хоёр. Ном, сурах бичиг

1. Ч.Дондог. Гэр бүлийн эрх зүй. УБ., 2015 он
2. А.Батбаатар. Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй. Улаанбаатар хот., 2021 он

Гурав. Гадаад эх сурвалж

1. Л.М.Пчельницева Семейное право России учебник для вузов. М., 2001 год

2. "Семейный кодекс Российской Федерации" Статья 75. Контакты ребенка с родителем, родительские права которого ограничены судом

Дөрөв. Цахим эх сурвалж

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан https://www.1212.mn

ХОРИГДЛЫН БИЕ, ЭД ЗҮЙЛД ҮЗЛЭГ, НЭГЖЛЭГ ХИЙХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

ISSUES TO BE CONSIDERED IN EXAMINATION OF PRISONERS' BODY AND OBJECTS



А.Янжин

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт-Судалгааны 403 дугаар анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521 дүгээр дамжааны сонсогч

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтлан ажиллах тухай салбарын хууль тогтоомжид тусгасан байдаг. Үүнтэй холбоотойгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах нь тус салбарын алба хаагчдын үндсэн чиг үүргийн асуудал болж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдож хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулахаас гадна тэдний аюулгүй байдлыг хангах, хамгаалах ажил нь хорих байгууллагын алба хаагчийн үндсэн үүрэгт хамаарна. Тиймээс хорих байгууллагын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгч алба хаагчид хоригдлын биед, өрөөнд үзлэг нэгжлэгийг тогтмол хийж учирч болох аюул эрсдэлийг зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Нэг талаас энэхүү арга хэмжээ нь ял эдлүүлэх ажиллагаанд аюулгүй байдлыг хангах, хамгаалахад чухал үүрэгтэй боловч нөгөө талаасаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрхийг зарим талаараа зөрчиж болзошгүй нөхцөл байдлыг тогтоож түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий шийдлийг эрэлхийлэхийг энэхүү илтгэлээрээ зорилоо.

Түлхүүр үг: Хорих ангийн албан хаагч, харуул хамгаалалтын ажилтан, эрүүл мэндээ хамгаалуулах, хангалт, үзлэг, нэгжлэг, хорих анги, өрөө тасалгаа, халдварт өвчин

УДИРТГАЛ

Үзлэг нэгжлэг гэдэг ойлголтыг гаргаж ирэхийн тулд түүний нэр томьёог зөв тодорхойлж ялгааг нь гаргах нь чухал.

Академич С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг бүтээлдээ “Үзлэг” гэж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэмт хэрэг өдүүлсэн байдал, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор хэрэгжүүлдэг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйлдэл” хэмээн “Нэгжлэг” гэж “Эрүүгийн хэргийн талаар нотлох баримт олж авахад чиглэгдсэн үйлдэл” гэж тус тус тодорхойлжээ.[1]

Харин шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандартын 5 дах хэсэгт зааснаар “Үзлэг” гэж гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлах, хорих байгууллагад хүлээн авч буй ялтан, хоригдогчийн бие, эд зүйлийн хүлээн авах үеийн шинж байдлыг тогтоож, баримтжуулах, хориглосон эд зүйл байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор хүний бие, хувцас хэрэглэл, байр, өрөө техник хэрэгслийг шалгах ажиллагааг;[2]

“Нэгжлэг” гэж хүний бие, хувцас, хэрэглэл, байр, орчинд, хориглосон эд зүйл байгаа гэх сэжиг, таамаг бий болсон, эсвэл гэмт хэрэг, зөрчил үйлдэхдээ ашигласан, ашиглахаар төлөвлөсөн эд зүйл, түүний улмаас үүссэн ул мөрийг илрүүлэх зорилгоор эд зүйлийн угсралтыг бүрэлдэхүүн хэсгээр задалж үзэх зэргээр нарийвчлан хийж буй шалган баримтжуулах ажиллагааг хэлнэ.[3]

Эдгээрээс харахад үзлэг, нэгжлэг хэмээх ойлголт нь өөр өөрийн утгыг илэрхийлэх 2 өөр ойлголт болох нь харагдаж байна. Нийтлэг агуулгаараа үзлэг нь шинж байдлыг тогтоох бол нэгжлэг нь нууж далдалсан эд зүйлийг эрэн хайх гэсэн утгыг илэрхийлж байна.

---

[1] Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар “Хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа”, УБ хот, 2013 он

[2] Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандарт. ШШГЕГ, УБ хот, 2016 он

[3] Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандарт. ШШГЕГ, УБ хот, 2016 он

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчийн эсхүл хоригдол, хоригдогчийн биед, эд хөрөнгөнд үзлэг нэгжлэг хийх тухай ойлголтууд тусгагдсан байдаг.

Миний хувьд энэхүү илтгэлдээ хорих ангийн албан хаагч хоригдол хоригдогчийн биед, өрөө тасалгаанд үзлэг, нэгжлэг хийхэд тулгамдаж буй асуудлын талаар бичихээр зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан үзлэг нэгжлэг хийх үндэслэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 232-р зүйлийн 232.1, 232.2 дах заалт[1], Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24 өдрийн А/209 дугаар тушаалаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”-ын 9-р зүйлээр тус тус олгосон.[2]

Хорих анги нь улсын онцгой объект учраас доор дурдсан нөхцөл байдлууд бий болгохгүйн тулд үзлэг нэгжлэгийг чанартай хийх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Үүнд:

- хорих ангийн аюулгүй байдал
- хориотой эд зүйлсийг олж тогтоох
- хорих ангийн бүсэд эмх замбараагүй байдал бий болгохгүй байх
- өөрийн болон бусдын амь насанд хохирол учруулах
- ямар нэгэн байдлаар сэтгэл хөдлөлдөө захирагдах үндэслэлийг бий болгох
- алба хаагчийн аюулгүй байдлыг хангах

Дээр дурдсан нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох зорилгоор үзлэг нэгжлэгийг алба хаагчид төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, хяналтын доор зохион байгуулж байна.

Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2017 оны 07сарын 04 -ны өдрийн А/183-р тоот “Хорих ангийн дотоод журам”-д хоригдолд өөртөө буюу хорих өрөөндөө хадгалан хэрэглэж болох эд зүйлийг тусгаж өгсөн байдаг.[3]

Үзлэг нэгжлэгийн хуваарийг анги, албадууд өөрийн онцлогт тохируулан 14 хоног тутам шинэчлэн баталж үзлэг, нэгжлэгийн чанар, үр нөлөөг нь дээшлүүлэх нь болзошгүй учрал, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, 2017 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24
[2] Хорих ангийн дотоод журам, 2014 он.
[3] Хорих ангийн дотоод журам, 2017 он

нэг үндэс болно. Үзлэг, нэгжлэгийг доорх дурдсанаар ангилдаг. Үүнд:[1]

График 1. Үзлэг, нэгжлэгийн төрөл



Дээрх дурдсанаар үзлэг нэгжлэг хийж буй хорих ангийн албан хаагч нь үзлэг, нэгжлэгийг хоригдол, хоригдогчийн биед нэг бүрчлэн хүрэлцэх байдлаар халуун гал голомтод ажиллан хорих ангийн харуул хамгаалалт, үймээн самуунаас сэргийлж, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Хэдий албан үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагч ч гэлээ Монгол улсын иргэн билээ. Тиймээс үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээ хамгаалуулах эрхтэй. Албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа амь бие, эрүүл мэнд, ар гэрээ умартан зүтгэж буй албан хаагчдаа ажлын таатай орчин, тав тухтай ажиллах нөхцөл зэргийг бүрдүүлэх нь байгууллагын ирээдүйн хөгжил, дэвшил нэр

[1] Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар “Хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа”, УБ хот, 2013 он

хүндэд ч чухал нөлөө үзүүлнэ гэж бодож байна. Бид жил ирэх тусам хүний нөөцийн хомсдолд орж, манай мэргэжлийг сонгох, сонирхох хүмүүс багассаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар ирээдүйн боловсон хүчинг бэлтгэдэг Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн "Аюулгүй байдал судлал" бакалаврын хөтөлбөрт элсэн суралцагчдын тоог бусад "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл" "Нийгмийн ажил" гэсэн хөтөлбөрүүдтэй харьцуулан үзвэл маш бага тооны элсэгч элсэн суралцаж байна.

Тиймээс бид хэдий хүний нөөцөө нэмэгдүүлсэн ч ажлын байрны нөхцөл, орчин, хангалтаас шалтгаалан албанд зүтгэхээр ирсэн хүмүүсийн санаа бодлыг маш хурдан өөрчлөх нөхцөл болж байна.

Хорих ангийн албан хаагчид үзлэг нэгжлэг хийх явцдаа олон төрлийн халдварт өвчин, бэртэл гэмтэл авч амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байгааг доорх дурдсан судалгаануудаас харж болно.

Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссоос "Эмэгтэй албан хаагчдын ажлын байран дах тулгамдсан асуудлын талаарх судалгаа" 2012 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй албан хаагч нараас дараах судалгааг авсан / байна. Үүнд:

Албан хаагчдаас ажлаа хийж байхдаа яг ямар төлийн бэртэл гэмтэл, өвчин авж байсан талаар санал асуулгаас үзэхэд "Тийм-20%", "Үгүй- 80%" гэсэн үр дүнтэй хариулт өгчээ.

- ✓ Халдварт сүрьеэ өвчин
- ✓ Амьсгалын замын халдварт өвчин
- ✓ Байнгын стрест ордог үүнээс болоод бамбай булчирхай болон зүрхний өвчтэй болж байна.
- ✓ Мөөгөнцөр сүрьеэ тусах магадлал өндөр байдаг
- ✓ Харшилтай болсон
- ✓ Ялтны амьдрах байранд байрлаж ажилснаар тамхины утаанд хордох нүүрээр юм гарах толгой байнга өвдөх болсон.[1] гэж хариулжээ.

Энэхүү асуултыг дүгнэж үзвэл хорих ангийн албан хаагчид, ажлын байран дээрээ ажиллаж байх хугацаандаа маш олон төрлийн жижиг

[1] 199_6524250.pdf (uih.mn)

гэмтлээс эхлэн маш том гэмтлүүдийг авч байсан байна. Дээрх гэмтлүүдээс хорих ангид өрөө тасалгаанд, хүний биед үзлэг нэгжлэг хийхэд авч байсан гэмтэл, халдварууд цөөнгүй тоотой байгаа нь харамсалтай.

Хууль зүй, Дотоод хэргийн Сайдын 2016 оны 12-р сарын 23-ны өдрийн 260 дугаар "Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандарт"-ын арван дөрөвт зааснаар "Үзлэг нэгжлэгийн үед ашиглах багаж, хэрэгсэл"-д дараах зүйлсүүдийг заажээ. Үүнд: Резин болон бусад хамгаалалтын бээлий, амны хаалт, гар чийдэн, энгэрийн камер, металл илрүүлэгч, тольдуур, сэтгүүр, нарийн урт зүү, чимхүүр, хавчуур, соронз /том, жижиг/, уяа, оосор, цус болон хүний биеэс ялгарах биологийн шингэнээр бохирлогдсон байж болзошгүй эд зүйл, зүү, тариур, хурц иртэй зүйл хийх хайрцаг, нэг удаагийн аяга, гялгар уут /*төрөл* бүрийн/, гар ариутгагч, жин хэмжүүр, неон гэрэл, резин болон модон алх, хайч, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл, согтуурлын зэрэг тогтоох багаж, тандагч , хэт ягаан туяаны хяналтын төхөөрөмж, үзлэг, нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл хөтлөх хэвлэмэл маягт зэргийг шалган нэвтрүүлэх байранд үзлэг, нэгжлэгэд ашиглагдах дараах багаж, хэрэгслийг бэлэн байдалд хадгална.[1].

Мөн үзлэг нэгжлэг хийхдээ дараах зүйлсийг баримталж ажиллана гэж тусгасан байна. Үзлэг, нэгжлэг хийх алба хаагч нь Сүрьеэ болон агаар, дуслын замаар халдварлах халдварт өвчтэй этгээдэд үзлэг, нэгжлэг хийхдээ шүүлтүүртэй амны хаалт хэрэглэх, Шингэн, хуурай зүйлийг амтлах, согтуурсан, мансуурсан, хордсон байж болзошгүй этгээдийг шалгахад үнэрлэж үзэх зэргээр мэдэрхүйн эрхтэнээр шалгах нь боломжтой хэдий ч алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй тул дээрх аргаар шалгахаас аль болох татгалзан, зориулалтын багаж хэрэгсэл ашиглана гэж заасан байна. Гэвч бодит нөхцөл байдал дээр хэрэгжилт муу, хараа хяналт сул байгаа нь ажиглагдсан.

461 дүгээр хаалттай хорих ангид танилцах дадлагаа хийх явцад хоригдогчдын бие, өрөө тасалгаанд үзлэг нэгжлэг хийхэд ариун цэврийн шаардлага хангахгүй нүцгэн гараараа хийсэн. Хийж дууссаны дараа гараа угаах ариутгах хэрэгцээ шаардлага үүссэн боловч нөхцөл байдал бүрдээгүй.

Стандарт, журмууд дээр тусгагдсан зүйлүүдийг амьдрал дээр хэрэгжүүлэх нь байгууллага болон удирдлагын шийдвэрлэх асуудлууд юм.

[1] Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандарт. ШШГЕГ. УБ хот, 2016 он

Сайн удирдагчийн нэг шинж нь алба хаагчаа ойлгон, хэрэгцээт зүйлүүд дээр туслалцаа үзүүлэх, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах явдал юм. Гэвч журам стандарт дээр нь хүртэл тусгагдсан зүйлийг хэрэгжүүлэхгүй байгаа нь албан хаагчдын эрх ашгийг хөндөж байна.


Энэхүү илтгэлийн хүрээнд сүүлийн 20 жилийн хугацаанд хорих ангид харуул хамгаалалтын чиглэлээр ажиллаж байгаа 30 албан хаагчдаас дараах судалгааг авсан юм. Орчинд нь ажиллаж, сайнтай муутай бүхий л зүйлийг мэдэж, мэдэрч буй хүмүүсийн санал санаачлагыг сонсосноор албан хаагчдад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх эхлэл болох юм.

Эх олонлог: Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдаас

Түүвэр олонлог: Хорих ангиудын ахлагч бүрэлдэхүүнүүдээс түүвэрлэж 30 алба хаагчаас судалгаа авлаа.


Мэдээлэл боловсруулах:

Зураг 1.




Судалгаанд оролцогчид 23-43 насны алба хаагчид оролцсон байна.

Зураг 2.



Судалгаанд оролцогчдыг хүйсийн байдлаар нь авч үзвэл 83,3% эрэгтэй албан хаагчид эзэлж байна.

Зураг 3.



- Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь (43.3%) 10-20 жил ажилласан туршлагатай албан хаагчид байгаа нь уг судалгаанд мэргэжлийн алба хаагчдыг хамруулсныг илтгэж байна.

4. Хоригдлын бие болон өрөө тасалгаанд үзлэг нэгжлэг хийхэд үүсдэг хүндрэл бэрхшээлээсээ дурдана уу?

- Ариун цэврийн асуудал

- Тусгай хэрэгсэл тоног төхөөрөмж

- Хоригдолын харилцаа

- Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл


- Аюулгүй байдал хангалтгүй

- Дутуу хийдэг

- Байхгүй

Судалгаанд оролцогчид дээрх хүндрэл бэрхшээлийг дурдсан байна. Хариултуудаас харвал үзлэг, нэгжлэг хийхэд хамгийн их тулгамдаж буй асуудал нь ариун цэврийн асуудал, нэг удаагийн хамгаалалтын хувцас дутмаг байгааг харж болно.

Зураг 4.




- Ханиад, томуу, сүрьеэ, амьсгалын замын халдварт өвчин зэргийг авдагийг судалгаанаас харж болно.

- Үзлэг нэгжлэг хийхэд хамгийн наад захын хэрэглэгдэхүүн болох амны хаалт, нэг удаагийн бээлийг хангалтаар олгох нь нэн шаардлагатай байна.

9. Үзлэг нэгжлэг хийхэд нэмэлтээр санал болгох таны санал

Зураг 5.



- Тусгай хэрэгсэл
- Халдваргүйжүүлэлтийн төхөөрөмж
- Металл илрүүлдэг хаалга төхөөрөмж
- Үзлэг хийх төхөөрөмж
- Нэг удаагийн маск, бээлий тогтмол хэрэглэх
- Хамгаалах хувцас хэрэглэлээр хангаж өгөх
- Үнэр дарагч

Судалгааг дүгнэн үзвэл хорих ангийн үйл ажиллагаанд өдөр тутам явагддаг үзлэг нэгжлэг нь албан хаагчдын эрүүл мэндэд маш хүндээр тусч байна. Үүнийг хамгийн хялбараар шийдэх аргыг албан хаагчид нэг

удаагийн бээлий, амны хаалт, хамгаалах хувцас хэрэглэлийг хангалтаар өгөх нь хамгийн зөв арга юм.

ДҮГНЭЛТ

Хорих анги онцгой обьект учраас харуул хамгаалалтын хувьд хуульчлагдсан бөгөөд бие даан болон гадны хүчин зүйлийн нөлөөгөөр үйлдэхээс урьдчилан сэргийлэх эхний алхам бол гарч орж буй бүх хөдөлгөөн, хамгаалалтын бүс, барилга байгууламжид үзлэг нэгжлэгийг чанартай хийх шаардлагатай. Хоригдлын бие, өрөө тасалгаанд үзлэг нэгжлэг хийхэд хорих ангийн албан хаагч ямар нэгэн хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэхгүй учир эрүүл мэндэд нь их бага хэмжээгээр хохирол учирч байна. Үүнийг зохицуулсан “шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандарт”, “Хорих ангийн дотоод журам” зэрэг эрх зүйн зохицуулалтад дээр тусгагдсан боловч практик дээр хэрэгжихгүй байгаа нь алдаа дутагдал болж байна. Манай байгууллагын хувьд хүний нөөц маш чухал байр суурь эзэлдэг гэвч хүний нөөцөө алдах суурь хүчин зүйлүүдээ бүрдүүлж бий болгосоор...

САНАЛ

1. Хорих ангийн албан хаагчдын үзлэг нэгжлэг хийхэд хэрэглэгдэх хэрэглэхүүнүүдийг “резин болон бусад хамгаалалтын бээлий, амны хаалт, гар чийдэн, энгэрийн камер, металл илрүүлэгч, тольдуур, сэтгүүр, нарийн урт зүү, чимхүүр, хавчуур, соронз /том, жижиг/, уяа, оосор, цус болон хүний биеэс ялгарах биологийн шингэнээр бохирлогдсон байж болзошгүй эд зүйл, гялгар уут /*төрөл* бүрийн/**,** гар ариутгагч, жин хэмжүүр, неон гэрэл, резин болон модон алх, хайч, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл, согтуурлын зэрэг тогтоох багаж, тандагч , хэт ягаан туяаны хяналтын төхөөрөмж, үзлэг**,** нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл хөтлөх хэвлэмэл маягт зэргийг шалган нэвтрүүлэх байранд үзлэг**,** нэгжлэгэд ашиглагдах дараах багаж, хэрэгсэл”-ийг бэлэн байдалд хадгалах журмыг баримтлан ажиллах;

2. Журмаар батлагдсан багаж хэрэгслүүдийн ээлжийн бүрэлдэхүүнүүд хүлээн авч тэмдэглэл хөтөлдөг болох;

3. Журам стандартаар батлагдсан багаж хэрэгслүүдийг хүлээлцэх үе шатанд эмч эмнэлгийн байгууллагын ажилтан хяналт тавих;

4. Хорих ангийн эмч ариун цэврийн асуудал дээр хяналт тавих;

5. Хорих ангийн өрөө тасалгаанд үзлэг нэгжлэг хийхэд нэг удаагийн бээлий, амны хаалт, гарын шингэн саван, хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангах;

6. Хоригдол, хоригдогчидын биед үзлэг нэгжлэг хийхэд албан хаагчдын оролцоог багасгах зорилгоор металл илрүүлэгч төхөөрөмж, багаж хэрэгслүүдээр хангах тэгснээр албан хаагчийн өвчлөл авах эрсдэл буурах боломжтой;

7. Хорих ангийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамрагдуулах;

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, тогтоомж

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ 2017. №24

2. Хорих ангийн дотоод журам. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. УБ., 2017. №А/186

3. Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандарт, УБ хот, 2016 он

Нэг сэдэвт бүтээл

4. Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар “Хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа”, УБ хот, 2013 он

5. “Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй албан хаагч нараас авсан судалгаа” 2012 он

6. Ю.Сэрсэнжав, “Хорих ял эдлүүлэх байгууллагын харуул хамгаалалт” УБ хот, 2007 он

7. Ц.Очгэрэл, “Хорих байгууллагын аюулгүй байдал”, УБ хот, 2017 он

8. Р.Оюунбадам, Д.Бадам, “Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт” УБ хот, 2005 он

---o0o---

“МОНГОЛ ТУУРГАТНЫ АВАРГА-2024” ЦЭРГИЙН ГАРДАН ТУЛААНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ойн хүрээнд “Монгол туургатны аварга-2024” цэргийн гардан тулааны аварга шалгаруулах анхдугаар нээлттэй тэмцээн 2024 оны 03 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны зааланд боллоо. Тус тэмцээнд Монгол Улс, ОХУ-Буриад, БНХАУ-ӨМӨЗО, ОХУ-Халимаг, ОХУ-Тува Улсын нийт 28 байгууллага, клубийн 200 гаруй тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдсөнөөс Дотоод хэргийн их сургуулийн баг тамирчид өсвөр үе, насанд хүрэгчдийн ангилалд амжилттай оролцсон юм.





Өсвөр насны ангиллын 70 кг жинд Ахлах сургуулийн 10в ангийн сурагч Б.Алтансүх алтан медаль, насанд хүрэгчдийн ангилалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн 512 дугаар дамжааны сонсогч Б.Намжилмаа -55 кг жинд хүрэл медаль, Хилийн албаны сургуулийн 434 дүгээр дамжааны сонсогч Б.Төрболд -80 кг, Б.Баярсайхан -85 кг жинд хүрэл медаль, Хилийн албаны сургуулийн 433 дугаар дамжааны сонсогч С.Пүрэвсүрэн -85 кг жинд алтан медаль тус тус хүртсэн байна.

ДХИС-ийн баг тамирчдыг дэд хурандаа Ч.Жаргалсайхан, дэслэгч Ш.Одсүрэн нар дасгалжуулжээ.

Тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдад халуун баяр хүргэж, спортын өндөр амжилт хүсье.

"СОНСОГЧИЙН БИЕ ДААН СУРАЛЦАХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД ГУРВАН БАГЦ ЦАГИЙН БОЛЗОЛ ХАНГАСАН СОНСОГЧДОД ЭНГЭРИЙН ТУУЗ ГАРДУУЛЖ ӨГЛӨӨ

Дотоод хэргийн их сургуулийн захирлын тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилд "Сонсогчийн бие даан суралцах хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл, хувь хүний хөгжил, усан спортын гурван багц цагийн болзол хангасан сонсогчдод энгэрийн тууз гардуулах үйл ажиллагаа өнөөдөр /2024.03.25/ жагсаалын талбайд боллоо.

Энэхүү үйл ажиллагаанд Их сургуулийн тэргүүн дэд захирал доктор, профессор, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар оролцож гардуулан өглөө. Энгэрийн туузыг Цагдаагийн сургуулийн 314 дүгээр дамжааны түрүүч Б.Цандэлэг, 311 дүгээр дамжааны түрүүч Э.Агар-Эрдэнэ, 311 дүгээр дамжааны дэд түрүүч Б.Ширмэнбаатар, Сургалт судалгааны 403 дугаар анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн 513 дугаар дамжааны сонсогч С.Маргад нар гардан авч, үе тэнгийн сонсогчдоо манлайллаа.



"Сонсогчийн бие даан суралцах хөтөлбөр"-ийн хүрээнд Их сургуулийн 1, 2 дугаар дамжааны сонсогчид 6 төрлийн сургалтын багц цагийг хангаж, болзлыг бүрэн хангасан сонсогчид "Алдрын од" тэмдэгийн эзэд болох юм.

---o0o---

“МИНИЙ СОНИРХОЛ”, “МИНИЙ БҮТЭЭЛ” ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Сургалт, судалгааны 403 дугаар анги- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас санаачлан Их сургуулийн алба хаагчдын дунд “Миний сонирхол”, цуглуулгын үзэсгэлэн, сонсогч суралцагчдын дунд “Миний бүтээл” уран зураг, уран бичиг, гар урлалын уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнгийн гол зорилго нь Их сургуулийн багш албан хаагчид сонсогч, суралцагчдын бүтээлч хандлагыг дээшлүүлэх, сонирхол хоббиг дэмжих, олон нийтэд хүргэж сурталчилан танилцуулах юм.



Энэхүү үйл ажиллагаанд 70 гаруй багш, албан хаагч, сонсогч суралцагч оролцож, “Миний сонирхол” үзэсгэлэнд багш албан хаагчид өөрсдийн цуглуулдаг мөнгөн тэмдэгт, зохиолчдын гар бичмэл, энгэрийн зүү, ажил мэргэжилтэй холбоотой машин техник, одон медаль, таних тэмдэг зэрэг содон, сонирхолтой 20 гаруй төрлийн цуглуулгаараа оролцлоо. Харин “Миний бүтээл” үзэсгэлэнд оролцсон сонсогч, суралцагчид уран зураг, уран бичиг, гар урлал урлалын үзэсгэлэнд арьсан урлал, керамик урлал, төрөл бүрийн эко бүтээгдэхүүн, уран хатгамал, оёдол зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлгэн танилцууллаа.



“Миний сонирхол” үзэсгэлэнд 31 алба хаагч өөрийн цуглуулгаараа үзэсгэлэн гаргаж, тэргүүн байранд ховор ном, гар бичмэлийн цуглуулгаар Их сургуулийн Олон нийттэй харилцах төвийн эрхлэгч цагдаагийн хошууч Б.Төгсжаргал, дэд байранд "Банкны картын цуглуулга", "Гадаад мөнгөн дэвсгэртийн цуглуулга"-аараа Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн профессор, дэд хурандаа Б.Мөнгөнбагана, гутгаар байранд “Тэмдэглэлийн дэвтэрийн цуглуулга”-аараа Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн “Нийгмийн ажил” хөтөлбөрийн 532 дугаар дамжааны дэд түрүүч Н.Энхтуяа нар тус тус шалгарлаа.

Харин “Миний бүтээл” уралдааны уран зургийн төрөлд 10 гаруй сонсогч, суралцагчид оролцож, тэргүүн байранд "Хөрөг зураг"-ын бүтээлээр Хилийн албаны сургуулийн 413 дугаар дамжааны дэд түрүүч Г.Санчир, дэд байранд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 522 дугаар дамжааны сонсогч А.Анужинжаргал, гутгаар ЭЗНУС-ийн 232 дугаар дамжааны суралцагч Б.Энхсайхан нар шалгарсан юм.

“Миний бүтээл” уралдааны уран бичгийн төрөлд Тэргүүн байранд Ахлах сургуулийн 12в ангийн сурагч М.Мөнхсайхан, дэд байранд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 532 дугаар дамжааны сонсогч Н.Үйжин, гутгаар байранд 512 дугаар дамжааны сонсогч М.Баярмаа нар тус тус байр эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

“Миний бүтээл” уралдааны гар урлалын төрөлд Тэргүүн байранд Ахлах сургуулийн 10б ангийн сурагч Б.Мишээл, дэд байранд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 532 дугаар дамжааны сонсогч Н.Номин, гутгаар байранд 5321 дүгээр дамжааны суралцагч дэслэгч Т.Шинэцэцэг нар шалгарсан

Үзэсгэлэнгийн үйл ажиллагааны төгсгөлд нийт оролцогчдод “Батламж” гардуулав.

---o0o---

СОНСОГЧДЫН 2024 ОНЫ МАРШ, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО

Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, суралцагчдын 2024 оны марш, тусгай бэлтгэлийн тэмцээн 2024 оны 04 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд болж, аваргуудаа тодрууллаа.

Сонсогч, суралцагчдын марш, тусгай бэлтгэлийн сургалт, дадлагад бүрэлдэхүүн сургуулиудаас эрэгтэй 10 баг, эмэгтэй 4 баг хурд, хүч, авхаалж самбаа, мэргэжлийн ур чадвар, үүрэг гүйцэтгэх чадамж, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдсөнөөс эрэгтэй багийн төрөлд тэргүүн байрт ахлах дэслэгч Ж.Даваадорж захирагчтай Хилийн албаны сургуулийн 1 дүгээр баг, дэд байрт цагдаагийн ахлах дэслэгч Ж.Лхагвадорж захирагчтай Цагдаагийн сургуулийн 2 дугаар баг, гутгаар байрт дэслэгч Т.Ариунсүх захирагчтай Хилийн албаны сургуулийн 2 дугаар баг тус тус шалгарав.



Харин эмэгтэй багийн төрөлд тэргүүн байрыг дэд түрүүч А.Гэрэлмаа ахлагчтай Хилийн албаны сургууль, дэд байрыг дэд түрүүч Б.Өсөхбаяр ахлагчтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, гутгаар байрыг сонсогч Б.Есү ахлагчтай Цагдаагийн сургуулийн охидын баг эзэллээ.

Багийн нийлбэр дүнгээр сонсогч, суралцагчдын 2024 оны марш, тусгай бэлтгэлийн тэмцээний аваргаар буюу Хилийн цэргийн 0345 дугаар анги-Хилийн албаны сургууль, удаах байрт Дотоодын цэргийн 804 дүгээр анги-Цагдаагийн сургууль, гутгаар байрт Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль тус тус шалгарсан байна.



Баг, тамирчдад Их сургуулийн дэд захирал бөгөөд штабын дарга, цагдаагийн

хурандаа Г.Буянхишиг болон Захирлын зөвлөлийн гишүүд баяр хүргэж, шагналыг гардуулав. Энэ үеэр сонсогчид жагсаалын үзүүлэх тоглолт үзүүлж, ёслолын жагсаалаар алхлаа.Их сургуулийн сонсогч, суралцагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, цэргийн хэргийн мэдлэг, авхаалж самбааг хөгжүүлэх, хамт олонч, эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд энэхүү марш, тусгай бэлтгэлийн тэмцээн чухал ач холбогдолтой.

Багууд өчигдөр гарааны өмнөх ажиллагаагаар өрсөлдөж, өнөөдөр Гүнжийн хоолой дахь сургалт, бэлтгэлийн төвд иж бүрэн агсамж, буутай марш үйлдэх явцдаа 6 цэгийг дамжин даалгавруудыг гүйцэтгэж аваргуудаа тодруулснаар ийнхүү 2 өдөр үргэлжилсэн сонсогч, суралцагчдын 2024 оны марш, тусгай бэлтгэлийн тэмцээн өндөрлөлөө.

---o0o---

МАНАЙ СОНСОГЧИД ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ДЭЛХИЙН АВАРГЫН ТЭМЦЭЭНЭЭС 8 ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Гардан тулааны насанд хүрэгчдийн “Дэлхийн цом”-ын тэмцээн “Тулаан”, “Өөрийгөө хамгаалах” төрлөөр, Өсвөр үе, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн “Өөрийгөө хамгаалах” төрлөөр ОХУ-ын Москва хотод 2024 оны 04 дүгээр сарын 24-29-ний өдрүүдэд боллоо.

Тус тэмцээнд эх орноо төлөөлж Дотоод хэргийн их сургуулийн Биеийн тамир албаны бэлтгэлийн институтийн ахлах багш, хошууч Х.Оналбек дасгалжуулагчтай Цагдаагийн сургуулийн Аюулгүй байдал-Тусгай бэлтгэлтэй бүлгийн ажилтан хөтөлбөрийн 328 дугаар дамжааны түрүүч Э.Пүрэвдорж, сонсогч П.Мөнхжин, О.Арман, Ө.Өлзийбат, Цагдаа судлал хөтөлбөрийн 323 дугаар дамжааны сонсогч О.Балжинням, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил хөтөлбөрийн 532 дугаар дамжааны дэд түрүүч Б.Урангоо, Шийдвэр гүйцэтгэл-Эрх зүй хөтөлбөрийн 531 дүгээр дамжааны дэд түрүүч А.Анужин нарын бүрэлдэхүүнтэй баг тамирчид амжилттай оролцож, нийт 8 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр 4 дүгээр байрт шалгарсан байна.



Тэмцээнд нийт 28 улсын баг тамирчид гар хөлийн цохилтоос хамгаалах, барьц чөлөөлөх, хутга, буу тулгасан үед няцаалт өгч, баривчлах

арга техникийг үзүүлж хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн дүнгээр 1 дүгээр байрт ОХУ, 2 дугаар байрт Узбекстан, 3 дугаар байрт Казакстан, 4 дүгээр байрт Монгол, 5 дугаар байрт Герман улс тус тус шалгарчээ.

Өсвөр үе, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний 18-23 насны төрөлд -70 кг-ын жинд Цагдаагийн сургуулийн Аюулгүй байдал-Тусгай бэлтгэлтэй бүлгийн ажилтан хөтөлбөрийн 328 дугаар дамжааны сонсогч П.Мөнхжин, -80 кг-ын жинд мөн дамжааны сонсогч Ө.Өлзийбат, -70 кг-ын жинд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Шийдвэр гүйцэтгэл-Эрх зүй хөтөлбөрийн 531 дүгээр дамжааны дэд түрүүч А.Анужин нар тус тус хүрэл медаль хүртсэн байна.

Түүнчлэн насанд хүрэгчдийн дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээний -70 кг-ын жинд Цагдаагийн сургуулийн Аюулгүй байдал-Тусгай бэлтгэлтэй бүлгийн ажилтан хөтөлбөрийн 328 дугаар дамжааны сонсогч П.Мөнхжин, -80 кг-ын жинд мөн дамжааны сонсогч Ө.Өлзийбат, Цагдаа судлал хөтөлбөрийн 323 дугаар дамжааны сонсогч О.Балжинням, -70 кг-ын жинд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил хөтөлбөрийн 532 дугаар дамжааны дэд түрүүч Б.Урангоо, Шийдвэр гүйцэтгэл-Эрх зүй хөтөлбөрийн 531 дүгээр дамжааны дэд түрүүч А.Анужин нар тус тус хүрэл медалийн эзэд болжээ.

Ийнхүү өсвөр үе, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний “Өөрийгөө хамгаалах” төрлийн анхны медалийг Дотоод хэргийн их сургуулийн баг тамирчид эх орондоо авчирлаа.

Манай тамирчдыг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа элчин сайдын яамны зөвлөх, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөгч, цагдаагийн хурандаа О.Зоригт хүлээн авч уулзан баяр хүргэсэн байна.

Өсвөр үе, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний “Өөрийгөө хамгаалах” төрлийн анхны медалийг эх орондоо авчирсан Дотоод хэргийн их сургуулийн дасгалжуулагч багш, баг тамирчдадаа халуун баяр хүргэж, спортын өндөр амжилт хүсье.

---o0o---

“YOUNG WOMENS LEADERSHIP” ХӨТӨЛБӨР АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖЛЭЭ

Дотоод хэргийн их сургуулийн Жендэрийн дэд зөвлөл, Гадаад хэлний институт, Монгол Улс дахь НҮБ-ын Нийгэмлэг хамтран их сургуулийн эмэгтэй сонсогч, суралцагчдын нийгмийн оролцоо, манлайлал, нөлөөлөл, хууль сахиулах салбарт шийдвэр гаргах ур чадварыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэднийг Монголын шинэ үеийн хууль сахиулах салбарын манлайлагчид болоход дэмжих зорилготой “Young women’s Leadership” хөтөлбөрийг амжилттай зохион байгуулж, 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хаалтын үйл ажиллагаа боллоо.



Хөтөлбөрт шалгарсан нийт 24 эмэгтэй сонсогч, суралцагчид Жендэрийн үндсэн ойлголт, Тогтвортой хөгжлийн зорилгууд ба залуучуудын оролцоо, Манлайлал ба манлайллын хэв маяг, Залуучууд, энх тайван, аюулгүй байдал ба залуучуудын манлайлал болон өөрсдийн мэргэжлээ сурталчлах зэргээр олон нийт рүү чиглэсэн олон сонирхолтой үйл ажиллагааг зохион байгуулсан байна.



Хөтөлбөрт хамрагдсан сонсогч, оюутан, сурагчид манлайлах ур чадвараа сайжруулах сургалт, семинар, хэлэлцүүлгүүдэд оролцож, хууль сахиулах салбарт эмэгтэйчүүдийн манлайллын үүрэг оролцоо, манлайллын талаарх ойлголт, зан чанар, хандлагуудын талаарх мэдлэгээ нэмэгдүүлсэн эерэг үр дүнтэй байлаа.

Энэ үеэр Дотоод хэргийн их сургуулийн Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн дэд хурандаа С.Болдбаатар, НҮБ-ын Нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Т.Дөлгөөндусал нар хөтөлбөрт хамрагдсан сонсогчч, суралцагчдад гэрчилгээ гардуулан, амжилт хүссэн юм.

“МАНАЙ СУРГУУЛЬ-90 ЖИЛ” ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойг угтан, Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, “Легал Дата” ХХК хамтран тус их сургуулийн сонсогчдын дунд бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг нээн илрүүлэх, чөлөөтэй сэтгэх боломжийг олгох, монгол хэлний зөв бичиг, найруулгын чадварыг дээшлүүлэх, тэднийг урамшуулах зорилгоор зохион байгуулсан “Манай сургууль-90 жил” эссэ бичлэгийн уралдаан дүнгээ гаргалаа.

Энэхүү уралдаанд Дотоод хэргийн их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын түвшний 1-р дамжааны нийт 46 сонсогч эссэ бичлэгээ ирүүлснээс тэргүүн байранд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 512-р дамжааны сонсогч Т.Номинчимэг, дэд байранд Онцгой байдлын сургуулийн 611-р дамжааны сонсогч О.Амарбаяр, гутгаар байранд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 511-р дамжааны сонсогч Г.Мишээл, тусгай байранд мөн сургуулийн 511-р дамжааны сонсогч Б.Одбаяр нар шалгарсан юм.

Тэмцээнд амжилттай оролцсон сонсогчдыг legaldata.mn-ийг ашиглах алтан, мөнгөн багцын 3-6 сарын эрх, дурсгалын зүйлээр урамшуулж,



шагналыг Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403-р анги-ШШГАС-ийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор /Ph.D/, хурандаа Э.Батбаяр, “Легал Дата” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Баттулга нар гардуулав.

Мөн шилдэг 10 эссэд шалгарсан сонсогчдыг legaldata.mn-ийг ашиглах 1 сарын эрхээр шагнаж урамшуулсан юм.“Манай сургууль-90 жил” эссэ бичлэгийн уралдаанд амжилттай оролцсон нийт сонсогчиддоо сурлагын амжилт хүсье.

---o0o---

МАНАЙ СУРГУУЛЬ-90 ЖИЛ

512 дугаар дамжаа Т.Номинчимэг

Дотоод хэргийн их сургууль нь 1934 онд “Төв сургууль” нэртэйгээр үүсэн байгуулагдсанаас хойш 90 дахь жилдээ сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж, улсыг аюулаас хамгаалах, хууль сахиулах байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэж ирсэн баялаг түүх, уламжлалтай, шинжлэх ухаан, сургалтын томоохон төв билээ. Миний бие Дотоод хэргийн их сургуулийн- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургуулийн нийгмийн ажил хөтөлбөрөөр 2023 оны хичээлийн жилд элсэн суралцаж байна. Эрхэм хүндтэй энэ сургуулийг сонгосноороо би Монгол улсынхаа амар тайван байдлыг сахин хамгаалж, ард иргэдийнхээ амь нас,эрүүл мэнд, эд хөрөнгийг хууль зөрчигч гэмт этгээдүүдээс хамгаалж ,гэмт этгээдүүдийг засан хүмүүжүүлэх , бусармаг үйлдлийг таслан зогсоохын тулд шаардлагатай бол амь биеэ ч үл хайрлан тэмцэх хэрэг гардаг тул хүний жинхэнэ мөн чанарыг таниулдаг шударга алба хэмээн сэтгэл шулуудсан билээ.

“Хүний хамгийн дээд албан тушаал бол хүн байх” гэдэгдээ.Энэ л үгийг сонсогч нартаа заан хүмүүжүүлж буй бидний сургууль. Бага балчир нас минь мөрдөс зүүсэн эрхэм хүндтэй хүмүүсээс салшгүй холбоотой, ухаан орсон цагаасаа тэдгээр хүмүүсийн тэвчээр шаардсан мөч, жаргалтай үе гээд бүх л мөчийг харж, мэдэрч өссөн гэхэд хилсдэхгүй. Миний өвөө, аав, ах гээд хайртай дотны хүмүүс минь энэ л амьдралын замыг туулж ирсэн. Дүрэмт хувцсаа нугалаас гартал индүүдэж аваад харуй бүрийд нойртой нойргүй, хоолтой хоолгүй дүнсийсэн өвлийн үүрээр гараад л явна. Тэглээ гээд тэд минь хэзээ ч хэцүү байна гээд гомдоллож үзээгүй ээ. Аав минь хэлэхдээ “Хэндээ ч гомдоллохов дээ…Өөрийн маань л сонгосон зам учир зовлонгоо хүртэл жаргалтайгаар эдэлдэг дээ” гэж билээ. Энэ л үг бяцхан охин байсан надад асар их зүйлийг ойлгуулж, аавыгаа хархан нүдэндээ яг л бүгдийг чадагч шидтэн шиг л харж биширдэг болсон юм даг. Тэр л цагаас хойш яг л тэр эгэл баатрууд шиг болохыг хүсэж, өөрийн зорилгоо биелүүлэхээр хичээж ирсэн.

Элсэлтийн ерөнхий шалтгалт ойртоэ Дотоод хэргийн их сургуульдаа бүртгүүлэх чухал үе ирсэн юм. Цагдаагийн сургууль, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль, Онцгой байдлын сургууль, Шинжлэх магадлахуй гээд сургууль бүр нь эмэгтэй

элсэгч авч байсан ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийг эргэлт буцалтгүй сонгосон. Шалгалтууд ч дуусаж сургуульдаа тэнцсэн эсэх хариу ирэхийг хоног тоолон догдлон сандарч хүлээснээр тэнцсэн гэх хариугаа хүлээн авсан. Энэ л мөч амьдралаас авсан хамгийн том шагнал минь юм шиг л санагдсан. Гэр бүл минт миний өмнөөс ямар их баярлаж байгааг хараад одоо надад шантрах эрх л байхгүй шүү хэмээн зүрх шулуудсан даа.

Тийм ээ, би одоо чадсан. Энэ хүртэлх хугацаа тийм ч амар байсангүй. Надад шантармаар, уйлмаар, хаяаад явчихмаар өдөр хоног байсан. Тэр бүрт толгойндоо би чинь одоо аав ээжийн эрх шар охин биш цэргийн тангараг өргөсөн эх орны охин шүү дээ хэмээн өөрийгөө хурцалж ирэв. Эргээд бодоход энэ хүнд хэцүү гэж бодож явсан үе бүр минь зүгээр л нэг сорилт байж сайхан дурсамж болон үлдэнэ. Энэ л сургууль минь надад цэргийн зохион байгуулалтын чиглэлээр, сургалтын чиглэлээр бас хамгийн чухал нь хүн байх арга ухааныг л хамгийн сайн зааж сургаж өгсөн. Хүнээс гарч болох бүхий л тэсвэр хатуужил, сэтгэлтйн тэнхээ шаарддаг, өөрийн ар гэр амьдралаа хойш тавин, халуунд халж, хүйтэнд хөрж, байгалийн давагдашгүй нөхцөлд ч чин сэтгэлээсээ хөдөлмөрлөхийг энэ л сургуулиасаа ойлгож авав.

ШШГАС-ийн нийгмийн ажил хөтөлбөрийг сонгож суралцсан минь ерөнхий боловсролын сургуульд суралцаж байх явцад минь мэдээ суваг, цахим орчноор ял эдлээд гарч ирсэн хоригдол эргээд хэвийн амьдралд орж нийгэмших, ажил хийх боломж муу, ард иргэд шоронг хэрхэн муухайгаар хүлээж авч, засан хүмүүжсэн хоригдол нийгэмд ороод хэрхэн гадуурхагдаж байгаа талаарх мэдээлэл миний сэтгэлийг ихээр эмзэглүүлж байсан. Тэд алдсан ч хүмүүжээд дахин зөвөөр амьдрах эрхтэй шүү дээ. Алдсан л бол алдсан гээд нэгнээ газар дор ортол нь дэвсэх чинь хүний ёсноос гажууд гэлтэй.

Шоронгоос суллагдсан хүмүүсийн 75 хувь нь давтан хэрэг үйлддэг гэсэн судалгаа байдаг. Үүнийг багасгахын тулд тэднийг засан хүмүүжүүлэх төрөл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлдэг. Үүнийг нийгмийн ажилтнууд л гүйцэтгэх үүрэгтэй. Дахин нэг ч гэсэн аавын хүү, ээжийн охин амьдралд хөл алдаж, буруу зүйл бүү хийгээсэй хэмээн хүсэж үр дүнтэй ажилласанаар олон олон гэр бүлд аз жаргал авчирч, хичнээн бэтгэрсэн хүмүүсийн элэг зүрхийг дэвтээж, олон олон хүүхэд инээд баясалаар дүүрэн, элэг бүтэн

амьдрана. Энэ л сайхан буян нь дэлгэрсэн ажил мэргэжлийг эргэж буцалтгүй сонгосондоо би баярладаг.

Тийм ч учраас суралцах дөрвөн жилийн хугацаандаа хичээл номондоо шамдан суралцаж, үнэнч шударга, хариуцлагатай албан хаагч болохоор зорилт тавин суралцаж байна. Албан дээр гарахаараа энэ л зорилгоо энэ тэргүүнд тавин олон олон хүнд тус дэм, буян болж төрийн тусгай чиг үүрэгт мэргэжилдээ амь биеэ үл хайрлан ард түмнийхээ төлөө цаг ямагт хичээн ажиллах болно гэдгээ тангараглаж байна.

---o0o---

МАНАЙ СУРГУУЛЬ-90 ЖИЛ

611 дүгээр дамжаа О.Амарбаяр

Сайн байна уу танд энэ өдрийн түмэн амар амгаланг айлтган мэндчилье. Би Эх орныхоо уудам тал нутаг, үзэсгэлэнт байгаль, эх орноороо бахархдаг. Эцэг эхийнхээ сургаалаас суралцаж цэл залуухан, гал халуун насны мөрөөдөл ирээдүйнхээ төлөө Онцгой байдлын байгууллагад ажиллаж хүчин зүтгэхээр зориг,хүсэл шулуудсан аавын хүү байна.

Маш олон давлагаат сүрэг хөлгүүд дундаас гагцхүү би ‘’Дотоод хэргийн Их сургууль’’ гэх гайхамшигтай хөлгийн “Онцгой байдлын Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн” ангид элсэн орж суралцахыг чин сэтгэлийн угаас хүссэн юм. Сайн мэргэжил гэж байхгүй харин сайн мэргэжилтэн л байдаг.

Гал атгаж цэрэг болдоггүй

Ган ширээж цэрэг болдоггүй.

Эх оронтой хүн бүхэн

Элгэн хайраараа цэрэг болдог юм Эр цэргийн албыг хаагаад энэ амьдралынхаа бүхий л цаг хугацааг эх орондоо, ард түмэндээ зориулж явах нь миний чин сэтгэл хүсэл мөрөөдөл билээ.

Мөрөөдөл гэдэг хамгийн том зорилго, зорилготой амьдарч түүнийхээ төлөө тэмцэнэ гэдэг бүр ч эрхэм. Эх орон гэдэг өөрөө эр цэргүүдээрээ хамгаалагдаж байдаг. Хүмүүс бид уурлаж орилж заримдаа эд юмсад уураа гаргаж урж тастаж хагалж шидэж орхидог шиг байгаль эх ч бидэнд гомдохдоо усаа ширгээж, ургамал цэцгээ нууж, тэнгэрт улаанаараа эргэлдэх салхиараа биднийг айлгаж, дөнгөж нахиалах цэцгийн талбай цуурч ингээд харвал байгаль эх хүртэл бидэнд гомддог юм билээ. Магадгүй энэ бүхний дараа хүн төрөлхтөнд тусламж хэрэг болдог. Хэдий насаараа мал малласан хүн ч байгалийн онцгой үзэгдэл цасан шуурга дэгдэж хаана ч юу ч үзэгдэж харагдахгүй болоход гагцхүү хүчин мөхсөддөг шүүдээ.

Миний ирээдүйн хүсэл мөрөөдөл өөрийн эзэмшсэн мэргэжлээ дээшлүүлж суралцахыг хүсэж байна. Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас Тэвдэж явахад тэвнээр тусал гэдэг би яг л үүн шиг байгалийн онц ноцтой Гамшиг, аюулт үзэгдэл, цасан болон шороон шуурга, аадар бороо, үер ус, Ой хээрийн болон объектын гал түймэр гээд л бүхий л хүнд хэцүү үед ард

түмнийхээ төлөө нэг ч гэсэн гэр бүлийг хагацал зовлонг мэдрүүлэхгүйн тулд эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь болж бусдын сайн сайхан, аз жаргалтай элэг бүтэн амьдралын төлөө амь биеэ үл хайрлан эрэлхэг, зоригтойгоор тусалж эд хөрөнгийг нь авран хамгаалахын төлөө энэхүү мэргэжлийг сонгох гэж байгаадаа бахархаж байна.

Цэргийн алба хаагч гэдэг Эр цэргийн тангараг өргөн эх орон ард түмнийхээ амар амгалан аюулгүй байдлын төлөө бүхий л сэтгэл зүрхээ зориулан эр цэргийн албаа хааж буй эр хүнийг хэлэх байх. Тиймдээ ч би жинхэнэ эр цэрэг болохын төлөө хичээнгүйлэн шамдан суралцах болно. Цаг хугацааг хэчнээн хурдан болохыг нас минь нэмэгдэх болгонд мэдэх болсон. Хэрэв хэн нэгэн хүн чиний хувьд аз жаргалтай хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? гэж асуувал би хариулахдаа завгүй хүн гэж хэлнэ учир нь хүн хийх зүйлтэй зорилго тэмүүлэл хүсэл мөрөөдөлтэй хүн л цаг мөч бүрийг хайрлаж цаг хугацаатай уралдан ихийг хийж бүтээж байдаг учраас залуу хүн завгүй байхдаа сайхан. Харин би завгүй өнгөрүүлэх энэ амьдралынхаа цаг хугацаагаа Онцгой байдлын байгууллагад зориулж аварна, хамгаална, тусална гэсэн чиг үүргийн дагуу ард иргэддээ түргэн шуурхай цаг алдалгүй тусалж өөрийнхөө хувь нэмрээ оруулахын төлөө хөдөлмөрлөх болно. Би улсдаа төдийгүй дэлхийн түвшинд бэлтгэгдсэн офицер болохыг хүсдэг. Дэлхий дахинд дайн байлдааны аюул заналхийлэл багассан ч байгалийн гамшигт үзэгдлийн аюул улам нэмэгдэж байгааг бид харж байна. Тухайн үед гамшигт нэрвэгдэж байгаа бүс нутагт очиж, аврах ажиллагаанд оролцох юмсан гэсэн хүсэл төрж байв. Зарим орнуудад далайн хар шуурга, цунами, галт уулын дэлбэрэлт, гал түймэр, өвчин тахал гээд дэлхий нийтийг цочирдуулсан томоохон гамшиг болж байдаг. Энэ бүхэнд Монгол улсаас аврах багийг илгээх боломжтой гэж боддог. Саяхан Турк улсад газар хөдлөлтийн онц аюултай гамшиг тохиолдож, 50 мянга гаруй хүн алтан амиа алдлаа. Дэлхийн 70 гаруй орон аврах багаа илгээж, тусламж үзүүлсэн. Үүний дотор Монгол улсын Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүн Турк улсад амжилттай ажиллаж, улс орныхоо нэрийг өндөрт өргөж чадлаа. Туркийн ард түмэн Монгол хүний онцгой мэдрэмж, өндөр чадвар, мэдлэг туршлагыг гайхан биширч байгааг хараад үнэхээр бахархсан. Ер нь манай Онцгой байдлын байгууллага Турк улсад тусалсан шигээ дэлхийн бүх оронд ажиллаасай. Монгол улсын зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаануудад амжилттай оролцож, дэлхийд нэрээ гаргасаар байна. Яг үүнтэй адил бид ч бас ажиллавал дэлхий дахин

манайхыг “Аврагч Монгол Улс” хэмээн дуудна гэдэгт би бүрэн итгэдэг. Туркийн жишээг хараад би өөрийн англи хэлний мэдлэг болон тусгай тактик, ур чадвараа нэмэгдүүлэх, орчин үеийн техник, технологитой ажиллах тал дээр онцгой анхаарч, олон улсын түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтэн болох ёстойг ойлгож авсан юм.

Аливааг мөрөөдөж бодох амархан түүнийгээ амьдрал дээрээ бий болгож биелүүлнэ гэдэг л хамгийн чухал зүйл. Өсөхийн жаргалыг жаргалд бүү бод Өглөөний нарийг наранд бүү бод гэдэг мэдээж суралцах хугацаандаа нэг ч удаа алдаа гаргалгүй галтай цогтой шантралгүйгээр явна гэвэл худлаа гэхдээ шантрах тоолондоо би өөртөө яагаад эхэлснээ санаарай гэж хэлэх болно. Анх хэчнээн их эрч хүч итгэлээр бүрэн дүүрэн эхэлсэн яг түүн шигээ байх хэрэгтэй гэж өөртөө дахин дахин сануулж өөрийгөө ялан дийлж бас хурцлах болно.

Хүсэл тэмүүлэл хүнийг хөдөлмөрт хөтөлж, хөдөлмөр хүнийг амжилтад хөтөлдөг. Маш олон аавын хөвгүүдтэй мөр зэрэгцэн суралцаж авьяас билэг авхаалж самбаа, ур чадвар, бодол, оюун ухаан, сэтгэл зүрхээрээ ялгарч онцгой сайн байж суралцах болно. Залуус бид эх орныхоо хамгаалагч хариуцагч гэдгээрээ бахархдаг билээ. Эр цэрэг үгүй бол эх орон минь эзгүйрнэ гэдэг шүүдээ. Залуу хүнд зорилго үгүй бол, Эх оронд ирээдүй үгүй гэдэг тиймээс би зорилготой байж хөдөлмөрлөх хэрэгтэй. Хийж бүтээх гэсэн томоохон зорилго тавиад түүнийхээ төлөө эцэж цуцаж шантралгүйгээр зүтгэж байхад амжилтанд хүрнэ.

Булиглах зүрхэнд эх орон, Буцлах зүрхэнд эх орон, Алтан амиа бөглөх юмтай, Аадар бороо үер шиг шаагьсан үгс минь төсөөлөл юм. Эх орныхоо алхам газрын төлөө асгарсан цусаа тогтоох завгүй, эрх чөлөөний түмэн эрхийн төлөө эмээлийн бүүрэг даван унаж байсан өвөг дээдсээрээ бахархаж үл барна. Цэл залуухан насны минь, цэцэг шиг мөрөөдлийн минь үзүүрээс атгаж ирээдүйд хүссэн зорилгодоо хүрэхэд минь тусална гэдэгт би чин сэтгэлийн угаас итгэж байна. Сонгосон сонголтдоо үнэнч байсандаа өөрөөрөө бахархах өдөр хүртэл би тасралтгүй хичээх болно. Хамгаас үнэтэй алтан цаг заваа гарган сэтгэл зүрхнээсээ бичсэн эссэг минь анхаарал тавьж уншсан танд талархъя.

---o0o---

МАНАЙ СУРГУУЛЬ 90 ЖИЛ

511 дүгээр дамжаа Г. Мишээл

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1974 оны 287 дугаар тогтоолоор Нийгмийг аюулаас хамгаалах яамны “Цэргийн тусгай дунд сургууль” байгуулагдаж, Цагдан сэргийлэх байгууллагад ажиллах тусгай дунд мэргэжилтэй боловсон хүчин, мөн Сайд нарын зөвлөлийн 241 дүгээр тогтоолоор “Цэргийн тусгай дунд сургууль”-ийг “дээд” сургууль болгон өргөжүүлж Цагдан сэргийлэх байгууллагад ажиллах дээд боловсролтой алба хаагчийг бэлтгэж эхэлсэн түүхтэй.

Монгол Улсын Засгийн Газрын 2000 оны 17 дугаар тогтоолоор Цагдаагийн дээд сургуулийг анхан шатны үндсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдгээрийг давтан сургах болон, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чиг үүрэгтэй Цагдаагийн академи, 2011 оноос тус их сургуулийн Цагдаагийн сургууль болгон өөрчилж, жилд дунджаар 1200 гаруй офицер, ахлагч, сонсогч, суралцагчдыг суралцуулж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна

Миний багаасаа хүсэж мөрөөдөж ирсэн мэргэжил учраас цагдаагийн алба хаагч гэх мэргэжлийг би туйлаас хүндэлдэг. Хүн өөрийн хийх дуртай ажил мэргэжлээсээ урам зориг авч, түүндээ чин сэтгэл гаргадагтай адил би ирээдүйд сайн мэргэжилтэн болон төлөвжиж чадна гэх хүсэл тэмүүллээр дүүрэн байгаа. Цагдаагийн алба хаагч нь нийгэмд шударга ёсыг түгээгч, бусдад зөвт байдлаараа үлгэрлэгч, төрийн хууль захирамжийг дуулгавартай даган биелүүлэгч, өөрийн мэргэжлийн үнэ цэнийг ухааруулан ажилдаа сэтгэл гаргагч гэх мэт олон чанараараа бусдад үнэлэгдэх ёстой. Миний хувьд цагдаагийн алба хаагчид байх ёстой бүхий л эрхэм чанар ба цогц чадамжуудад суралцах нь миний мөрөөдөл. Хүн бүрийн хувьд бахархал болсон олон зүйлс байдаг билээ. Эрхэм дотны хүмүүс, эх орон, хайртай аав ээжээрээ бид бахархдаг. Харин миний хамгийн том бахархал бол төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэгч цагдаагийн алба хаагчид. Энэ л эрхэм хүмүүсийн хичээл зүтгэл, бусдын төлөө гэх хүсэл тэмүүллээр нийгэмд амар тайван байдал бүрэлдэж байдаг билээ. Тиймээс би ирээдүйд сурч боловсрохыг хүсэж мөрөөдөж буй цагдаагийн алба хаагч гэх мэргэжлээр маш их бахархдаг.

Миний амьдралын хамгийн том зорилго бол албаа нэр төртэйгээр гүйцэтгэгч цагдаагийн алба хаагч болох явдал билээ. Тийм ч учраас бм өнөө цаг үеийн бахархал болсон шилдэг цагдаа нараар бахархдаг. Ард түмнийхээ аюулгүй, амар тайван байдлын төлөө өөрийгөө золиослох цагдаагийн мэргэжилтний тэрхүү агуу сэтгэл бүхнийг хүмүүс үнэлж, тус мэргэжлийн үнэ цэнийг бага ч болов ойлгодог байгаасай гэж би хүсэмжилдэг. Цагдаагийн ерөнхий газар тус байгууллагын бүхий л ажилчдын хувьд улс орон, ард түмнийхээ өмнө тангараг өргөсөн төрийн албан хаагчид бөгөөд төрийн алба, үйл ажиллагааны салшгүй нэг томоохон бүрэлдэхүүн хэсэг. Аливаа улс орны дотоод ба гадаад аюулгүй байдалд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа шууд хамааралтай бөгөөд нийгэмд амар тайван, аюулгүй байдлыг бүрэлдүүлэх эрхэм үүрэгтнүүд бол цагдаа нар билээ. Энэ л агуу эрхэм үүргийг гүйцэтгэгч цагдаагийн байгууллагын нэгэн гишүүн болж эх орныхоо өмнө өргөсөн тангаргаа хичээнгүйлэн биелүүлэх зорилгыг би өвөрлөсөн юм.

Цагдаа хуулийн байгууллагын ажилчид нэн түрүүнд хүний эрхийг хамгаалж, хуулийг дээдлэн ажиллах ёстой. Монгол улсад олон хууль, хуульчилсан актууд батлагдан гарсан боловч тэдгээрийн агуулга, үзэл санаа нь монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалт, зарчмуудтай хир нийцдэг вэ? гэсэн асуулт тавихад хүрвэл бас л бодууштай зүйл гарч мэдэх билээ. Ялангуяа хүний эрхийн салбарт монгол улсын нэгдэн орсон гэрээнүүд бол иргэн, хөдөлмөр, гэр бүл, тэтгэвэр, орон сууцны болон холбогдох олон зүйл хууль тогтоомжуудад заавал тусгах ёстой хэм хэмжээ болдгоороо онцгой ач холбогдолтой. Гэтэл манай практикт энэ нь тэгтлээ тусгагдан уялдаж чадахгүй байх нь олонтаа. Өнөөдөр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүний нэр төрийг гутаахаас, өөрийгөө өмгөөлөх, гэр бүлийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг гэмт хэргийг нуун дарагдуулахаас хэрхэн ялгах эсэх нь манай хуульчдын дунд зарим талаар маргаан үүсгэхэд хүргэх нь бий. Хуулиудын зориулалт болон үйлчлэх хүрээ нь олон түмэнд хүртээмжтэй, тайлбар тодотгол сайтай байх учиртай. Энэ талаас нь авч үзвэл хуулийн бүтцэд тайлбарласан хэм хэмжээ маш ховор байдгаас үүдэн хуулийн заалтыг ихэвчлэн хуульчилсан актуудад томъёолох замаар тайлбарлаж байгаа нь хууль зүйн хувьд төдийлөн зохиомтой зүйл биш юм.

Бид шударга ёс, эрх тэгш байдлыг эрхэмлэн үзэгч шударга ёсны төлөө тууштай тэмцсээр ирсэн монгол хүмүүс гэдгээрээ онцлог. Өнгөрсөн

жилүүдтэй харьцуулахад нийгэмд шударга ёс бага багаар тогтож байгаа ч эрх тэгш байдлыг үгүйсгэлэн хандлага бүхий үйлдлүүд одоо ч гарсаар байгаа нь манай улсын хууль, шүүхийн байгууллагын хууль, журмыг илүү чангатгаж, даган хэвшүүлэх нь чухал болохыг нотлоно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, хуулийн чиглэлийн байгууллагын хамгийн том зорилго нь нийгмийн шударга ёс, эрх тэгш байдалд хяналт тавих явдал байдаг. Монгол улсад маань ардчилал гэгч зүйл бүрэн утгаараа хэрэгжиж, одоогийнхоос илүү амар тайван нийгмийг бүрэлдүүлэхэд гар бие оролцон ажиллах нь миний туйлын хүсэл. Хэн бүхэн шударга байдлыг эрхэмлэн үздэг. Гэхдээ ардчилсан нийгэмд л шударга ёс бүрэн дүүрэн хэрэгжих боломжтой байгаа буюу түүний үр дүнд амар тайван байдал буй болох юм. Шударга ёсыг өөрөөр нийтийн эрх зүйн хэм хэмжээний зохистой байдал хэмээн ойлгож болно. Олон улсын нийтийн эрх зүйн асуудлын хамрах хүрээ нь өргөн бөгөөд олон асуудлыг цогц байдлаар авч үзэх хэдий ч тэдгээрийн дундаас амар тайван байдал, аюулгүй аж төрөх нөхцөлөөр хангагдах явдал, хүний эрх, эрх чөлөөний тухай асуудал зэрэг нь зайлшгүй биелэлээ олох ёстой гол тулгуур хүчин зүйлсүүд мөн.

Цагдаагийн ажилтан хүн нийгэмд эрх зүйг буй болохын төлөө хуулийн дагуу ажил үүргээ гүйцэтгэдэг. Хууль бол бүх нийтээр даган мөрдөх дүрэм, нийгмийн бүх гишүүд хоорондын харилцаа, үйл ажиллагааг зохицуулдаг дүрэм, журам. Хуулийн төсөл нь хууль тогтоох төрийн дээд байгууллага болох парламентаар батлагдсаны дараа хууль үйлчилж эхэлдэг. Хуулийн шударга байдал гэдэг ойлголт нь тухайн газар нутагт, тухайн цаг үед ноёрхож буй нийгэмд тогтоосон ёс зүй, хэв маягтай хэрхэн нийцэж буйгаас шалтгаалдаг. Ийм ч утгаараа хууль нь эрх зүйн болон хэв маягийг өөртөө агуулж байдаг төдийгүй ерөөсөө хууль ба эрх зүйн хооронд ялгаатай тал ажиглагдахгүй тохиолдол ч байх аж. Эрх зүйг ойлгох ойлголт, түүнд хандах хандлага нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үе шат, улс орны хөгжлийн үндсэн чиг, шинжлэх ухааны хөгжил, дэвшлийн нөлөөгөөр өөрчлөгдсөөр иржээ. Эрх зүйгээр соёл иргэншилт нийгэм оршин тогтнох болоцоогүй. Энэ нь нийгмийн зайлшгүй үзэгдэл бөгөөд янз бүрийн давхаргын ашиг сонирхол, нийгмийн шударга ёсны шаардлагыг илэрхийлж, нэг талаас нийгмийн хэсэг бүлгийн бус нийгмийн нийтлэг ашиг сонирхолд үйлчлэх, нөгөө талаас хувь хүний хэрэгцээ ашиг сонирхлыг харгалзан зохицуулсан хэм хэмжээний тогтолцоо юм. Эрх зүй нь нэг талаас бие хүний эрх, эрх чөлөөний баталгаа, нөгөө талаас хүний эрх чөлөөг

хязгаарлах зайлшгүй шаардлагатай хэмжээ хязгаар юм. Харин энэ л эрх зүйг нийгэмд бүрэлдүүлж чадсанаар улс орон илүү амар тайван болно. Эрх зүй нь төрөөс тогтоосон, төрөөс хөмгаалж байдаг зан үйлийн журам, жам ёсны хэм хэмжээ гэж ойлгож болдог. Ийнхүү эрх зүй нь олон шинжийг өөртөө агуулах учир ерөнхий байдлаархүний эрх, эрх чөлөө, шударга ёсны шаардлагыг хангаж, нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор төрөөс тогтоож зөвшөөрсөн, төрийн засаглалын хүч дэмжлэгээр хамгаалагдсан, заавал биелэгдэх, зан заншил хууль зүй, ёс суртахууны зүй зохистой, хэм хэмжээт үйлчлэн зохицуулагч систем хэмээн тодорхойлсон байдаг. Энэ л чухал зүйлийг нийгэмд бүрэлдүүлэхийн төлөө цагдаагийн мэргэжилтэн ажил албаа гүйцэлдүүлдэг нь үнэхээр бахархмаар.

Хүн бүр аз жаргалтайгаар амьдрахыг эрмэлзэж түүнийхээ төлөө хичээл зүтгэл гаргадаг билээ. Аз жаргалтай амьдрал гэдгийг нэг үгээр тодорхойлдог бол амар тайван байх явдал мөн. Амар тайван аж төрөх асуудал нь эрх зүйтэй зайлшгүй холбоотой. Тийм ч учраас эрх зүйг хүгий жам ёсны эрх, эрх чөлөө, шударга ёсыг бэхжүүлэн хамгаалж, нийтлэг хүсэл зоригийг илэрхийлж, нийгмийн харилцааг зохицуулахын тулд төрөөс зөвшөөрсөн буюу тогтоосон, төрийн албадлагаар хамгаалагдсан, бүх нийтээр заавал дагаж хэрэгжүүлбэл зохих хэм хэмжээнүүдийн тогтолцоо хэмээн тодорхойлсон байдаг. Монгол улсын үндсэн хууль ба бусад акт баримт бичгүүд нь бүгд эрх зүй бидний амьдралд хэрэгжиж байгаагийн жишээ мөн. Харин цагдаагийн алба хаагч мэргэжилтэн нь нийгмийн сайн сайхны байдлын төлөө нийтийн эрх зүйг бүрэлдүүлэн ажилладаг хуулийн байгууллагын нэг бие бүрэлдэхүүн. Тус мэргэжилтний ажлын үнэлэмжээр би үнэхээр их бахархдаг учраас энэ мэргэжлийг сонгон суралцах болсон юм. Би сайн цагдаа болон мэргэшиж нийгэмд нийтийн эрх зүйг бүрэн төгс хэрэгжүүлж чадаж гэмээн нийгмийн саар бүхэн үгүй болж шударга ёс, эрх тэгш байдал тогтох билээ.

---o0o---

МАНАЙ СУРГУУЛИЙН 90 ЖИЛ

511 дүгээр дамжаа Б.Одбаяр

1934 онд байгуулагдсан Дотоод хэргийн их сургууль нь бараг зуун жилийн түүхтэй. Тус сургууль нь оршин тогтнох хугацаандаа Монгол Улсын хууль сахиулах болон төрийн удирдлагын салбарыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү эссэ нь Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн 90 жилийн түүхэнд гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, түүхэн нөхцөл байдал, нөлөөлөл, хэтийн төлөв, ирээдүйн хөгжлийн боломжуудыг судлах болно.

Миний суралцдаг Дотоод хэргийн их сургууль байгуулагдсан нь Монгол Улсын түүхэнд чухал үйл явдал болсон. Монгол Улс үүсэн байгуулагдах үедээ уламжлалт нийгмээс орчин үеийн төр рүү шилжиж, өөрчлөлтийн үеийг туулж байлаа. Тус сургуулийг хууль сахиулах байгууллага, төрийн захиргааны байгууллагад ажиллах шинэ үеийн боловсон хүчин бэлтгэх зорилготойгоор байгуулжээ. Тус сургууль байгуулагдсан цагаасаа эхлэн цагдаа, хил хамгаалах алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онгой байдал зэрэг эдгээр салбарт ажиллаж буй хүмүүсийн ур чадвар, ур чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Монгол Улсын Дотоод Хэргийн Их Сургуулийг түүхийн туршид удирдан чиглүүлж, хөгжил дэвшлийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн нөлөө бүхий хүмүүс байдаг. Эдгээр удирдагчид их сургуулийн алсын хараа, чиглэлийг тодорхойлох, төрийн байгууллагууд, олон улсын байгууллага болон бусад эрдэм шинжилгээний байгууллагуудтай хүчтэй түншлэл тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн. Хууль сахиулах болон төрийн удирдлагын хурдацтай өөрчлөгдөж буй орчинд их сургуулийн цаашдын амжилт, ач холбогдлыг хангахад тэдний манлайлал чухал үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн нөлөөллийн нэг гол зүйл бол Монгол Улсын хууль сахиулах, төрийн захиргааны байгууллагыг мэргэшүүлэхэд оруулсан хувь нэмэр юм. Тус их сургууль нь эдгээр салбарт ажиллаж буй хүмүүсийн ур чадвар, мэдлэгийг хөгжүүлэх, тэднийг эх орондоо үр дүнтэй үйлчлэхэд шаардлагатай багаж хэрэгслээр хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Нэмж дурдахад тус их сургууль нь хууль сахиулах, төрийн удирдлагын чиглэлээр бодлого, практикийг

боловсруулахад тус дөхөм болсон хамгийн сүүлийн үеийн судалгааг гаргаж, судалгаа, инновацийн төв байсаар ирсэн.

Цаашид Монгол Улсын Дотоод Хэргийн Их Сургуульд олон боломж, сорилтууд тулгарч байна. Дотоод Хэргийн Их Сургууль нийгмийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлага, даяаршил, технологийн дэвшлийн улмаас тулгарч буй сорилтод дасан зохицож ажиллах ёстой. Их сургууль нь хууль сахиулах, төрийн удирдлагын чиглэлээр судалгаа шинжилгээ, инновацийг дэмжихийн зэрэгцээ боловсрол, сургалтын чанарыг сайжруулахад анхаарах нь нэн чухал юм. Монгол Улс хөгжиж, шинэчлэгдэхийн хэрээр тус их сургууль нь тус улсын хууль сахиулах болон төрийн удирдлагын ирээдүйг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэх болно. Цаашид ч шинийг санаачилж, нийгмийн өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад дасан зохицож ажилласнаар их сургууль салбартаа манлайлагч болж, Монгол Улсын хөгжилд урт удаан хугацаанд нөлөө үзүүлж чадна. Гэсэн хэдий ч ингэхийн тулд их сургууль өөрт тулгарч буй шүүмжлэл, сорилтуудыг шийдвэрлэх, үйл ажиллагааныхаа бүх талаар олон талт байдал, хүртээмжтэй байдал, шилдэг байдлыг дэмжих алхмуудыг хийх шаардлагатай болно.

Бид Дотоод хэргийн их сургуулийн эрдмийн хамт олон дэлхийн хөгжлийн чиг хандлага, эх оронд минь өрнөж буй шинэчлэлийн үйл явц, гадаад орны ижил төстэй сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын тэргүүний жишигт нийцүүлэн хууль сахиулах салбарт үндэсний хэмжээнд тэргүүлэгч мэдлэг, оюуны төв, олон улс, бүс нутгийн хэмжээнд идэвхтэй хамтрагч шинжлэх ухааны хамт олон болон төлөвших зориготой багш , албан хаагч, сонсогч суралцагч бидний эрхэм зорилго билээ.

Миний хувьд тус сургуульд суралцах болсондоо маш их баярладаг. Хүн бүрийн хүсээд орчихдог тийм ч амархан сургууль биш бөгөөд энэ сургуулийн босгыг даван суралцана гэдэг нь үнэхээр бахархууштай нэр төрийн хэрэг билээ. Хүсэл мөрөөдөлтэй, мөн түүнийхээ төлөө тууштай шаргуу хөдөлмөрлөх чадвартай хүмүүсээр хүрээлүүлж энэ сургуулийн нэг эд эс ширхэг болон алхаж, өөр өөрийн авьяас чадвартай олон сонсогч нартай мөр зэрэгцэн суралцаж хамтдаа урагшилж, өөрийгөө дайчилж байна.

Дүгнэж хэлэхэд, Дотоод хэргийн их сургуулийн 90 жилийн түүх бол тэсвэр хатуужил, шинийг санаачлах, нөлөөллийн түүх юм. 1931 онд эгэл

даруухан байгуулагдсан цагаасаа эхлэн тус сургууль нь Монгол Улсын хууль сахиулах, төрийн удирдлагын салбарт тэргүүлэгч сургууль болон өргөжиж байна. Энэ замд сорилт бэрхшээл тулгарч байсан ч их сургууль нь дасан зохицож, хувьсан өөрчлөгдөж, улс орны эдгээр салбарын ирээдүйг тодорхойлсон. Тус их сургуулиас нийгэмд үнэтэй хувь нэмэр оруулсан олон нөлөө бүхий хүмүүсийг төрүүлсэн бөгөөд үр нөлөө нь олон жилийн турш үргэлжилсээр байх болно. Их сургууль нь тулгамдаж буй асуудлуудыг шийдэж, өсөлт, хөгжлийн боломжуудыг ашигласнаар өөрийн давуу тал дээр тулгуурлан, өөртөө болон үйлчилж буй нийгэмдээ гэрэлт ирээдүйг баталгаажуулж чадна.

Монгол Улсын Дотоод Хэргийн Их Сургууль өнгөрсөн хугацаанд ололт амжилтаа эргэцүүлэн бодож, тулгамдаж буй асуудлуудаа шийдвэрлэснээр Монгол Улсын ирээдүйд эерэгээр нөлөөлөхүйц байр суурьтай байна.

---o0o---

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчид мод тарилаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Тэрбум мод-Үндэсний хөдөлгөөн"-ийг өрнүүлэн үндэсний мод тарих өдрийг жил бүр зохион байгуулж байна. Мод тарих үндэсний өдрөөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалахыг иргэдэд уриалдаг уламжлалтай.



Энэ үйл ажиллагааны хүрээнд Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчид 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Богд уулын аманд мод тарих ажлыг зохион байгууллаа.

Мод тариалалтын ажилд 40 сонсогч хамрагдаж, 100 ширхэг нарс мод суулгаж, усалгаа хийж идэвх санаачлагатай ажилласан юм. Энэ үеэр "JCI ЭКО"салбар байгууллагын “Залуу ой” урт хугацааны төслийн хамт олон тус сургуульд “Батламж” гардуулав.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧИЙН НЭРЭМЖИТ “СОНСОГЧИЙН АЛДАР” ГАРДАН ТУЛААНЫ НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит, “Сонсогчийн алдар” гардан тулааны тэмцээн өнөөдөр (2024.05.24) Спортын төв ордонд нээлтээ хийлээ.



Тэмцээний нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар, доктор, профессор, хошууч генерал Ш.Лхачинжав, тэргүүн дэд захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар, дэд захирал, доктор, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат, дэд захирал бөгөөд штабын дарга, цагдаагийн хурандаа Г.Буянхишиг, ЦЕГ-ын дэд дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, цагдаагийн хурандаа Н.Лхагвасайхан, ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа А.Намсаманд, Нийслэлийн шүүх шинжилгээний газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхбат, Үндэсний тагнуулын академийн захирал, хурандаа Наранбаатар, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Монгол Улсын Гавьяат Тамирчин мэргэжлийн боксын дэлхийн хошой аварга Ч.Цэвээнпүрэв, Монгол Улсын Гавьяат Тамирчин, “Шандас ММА” дэвжээний ахлах дасгалжуулагч, холимог тулааны дэлхийн хошой аварга Ж.Нарантунгалаг, ОУ-ын таеквондогийн Монголын холбооны тэргүүн дэд ерөнхийлөгч С.Энхбаатар болон ХЗДХЯ-ны харьяа



агентлаг байгууллагын төлөөлөл, бие хамгаалах гардан тулааны урлагийн клуб, нэгдэл, холбоодын удирдлагууд, баг, тамирчид, хөгжөөн дэмжигчид оролцов.

Тэмцээнийг нээж Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар хэлэхдээ:

“Сонсогчийн алдар тэмцээн нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагч, сонсогч, тулааны урлагийн тамирчдын албаны бэлтгэлжилтийг хангах, сэтгэл зүй, бие бялдрын тэсвэр хатуужил олгох, бусдыг болон өөрийгөө хамгаалах ур чадварыг эзэмшүүлэх, олон улс, тив, дэлхийн хэмжээний тэмцээн, уралдаанд тамирчдыг бэлтгэх зорилгоор зохион байгуулагддаг нээлттэй тэмцээн гэдгээрээ онцлог юм.

Монгол Улсын гавьяат багш, боловсрол судлалын ухааны доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа С.Хаянгарваа “Сонсогчийн алдар” барааны тэмдгийн эзэмших эрхийг 2021 онд төрөлх Их сургуульдаа шилжүүлснээр тус тэмцээний нэр хүндийг цаашид улам өндөрт өргөж явах итгэл найдвар, хариуцлага Дотоод хэргийн их сургуулийн эрдмийн хамт олон бид бүхний өмнө тавигдсан билээ.

Энэ ч утгаараа Дотоод хэргийн их сургуулийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан тус тэмцээний цар хүрээг өргөжүүлэн тэлж, энэ оноос эхлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит болгон зохион байгуулах болсондоо туйлын их бахархалтай байна” гэж онцолсон юм.



Энэ үеэр тэмцээний ерөнхий шүүгч Монгол Улсын Гавьяат Багш, Дэлхийн гардан тулааны холбооны дэд ерөнхийлөгч, доктор, профессор, цагдаагийн хурандаа С.Хаянгарваа ДХИС-ийн удирдлагуудад дурсгалын зүйл гардуулав. Мөн “Сонсогчийн алдар” гардан тулааны тэмцээнд амжилттай оролцон удаа дараа түрүүлсэн, гардан тулааны спортыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Үндэсний бие хамгаалах холбооны ерөнхийлөгч, Чингис хаан

академийн академич, Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан, Олон улсын хэмжээний мастер Д.Отгонбаяр, Ази тивийн аварга шалгуулах тэмцээний “Хүрэл” медаль, Зүүн Азийн боксын спортын хошой “Хүрэл” медальт, Монгол Улсын боксын спортын 12 удаагийн аварга, Боксын спортын олон улсын хэмжээний мастер Д.Зул, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, Олон улсын таеквондогийн холбооны ахлах дасгалжуулагч С.Ган-Эрдэнэ, Холимог тулааны дэлхийн хошой аварга, Монгол Улсын гавьяат тамирчин, “Шандас ММА” дэвжээний ахлах дасгалжуулагч Ж.Нарантунгалаг, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Л.Эрдэнэцогт, Монгол Улсын спортын мастер, Монгол Зоо тэмцээний мөнгөн медальт, ШШГЕГ-ын Санхүү үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Б. Нямгомбо, Боксын спортын олон улсын аварга, ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн магистрын хөтөлбөрийн суралцагч Х.Мандахбаяр, Олон улсын каратегийн хошой аварга, Киокушинкай каратэгийн дэлхийн аварга шалгаруулах “Элит”-ийн тэмцээний мөнгөн медальт, таеквондогийн дэлхийн хошой аварга, Олон улсын хэмжээний мастер, Монголын гардан тулааны шилдэг тамирчдын (MGL-1 FC) холбооны гүйцэтгэх захирал, “Сонсогчийн алдар” тэмцээний шилэгдмэл шүүгч Ө.Гантөмөр, Гардан тулааны олон улсын хэмжээний мастер, хар бүс 3 дан, Төрийн тусгай алба хаагчийн нэгдсэн эмнэлгийн штабын дарга, дэд хурандаа Е.Берикжан, Дэлхийн хошой аварга, Олон улсын хэмжээний мастер, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ажилтан, ахлах дэслэгч Б.Наадам, ШШГЕГ-ын Тусгай ажиллагааны газрын ажилтан Ц.Түвшинзаяа нарын тамирчид, шүүгчдийг Их сургуулийн “Спортын алдар” тэмдгээр шагнаж алдаршуулав.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын "Сүлд" чуулгын дарга, цагдаагийн хурандаа Г.Эрдэнэбаатарт "Клиникийн профессор" цол олгосныг Дэд бөгөөд Штабын дарга, цагдаагийн хурандаа Г. Буянхишиг гардуулан өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит “Сонсогчийн алдар” гардан тулааны энэ удаагийн тэмцээнд “гардан тулаан”, “өөрийгөө хамгаалах” гэсэн хоёр төрөлд 26 багийн 208 тамирчин эрэгтэй 16 жин, эмэгтэй 10 жинд хурд хүч, зориг тэвчээр, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж байна.

“Сонсогчийн алдар” тэмцээнд амжилттай оролцсон баг тамирчдыг “Тулаан” болон “Өөрийгөө хамгаалах” төрөлд хувийн болон багийн

амжилтаар тус бүр байр эзлүүлэн урамшуулахын зэрэгцээ дээрх 2 төрөл тус бүрд түрүүлсэн, нэг тамирчинд “Улаан брет малгай” олгоно.

Мөн “Шилэгдмэл шүүгч”, “Шилдэг дасгалжуулагч”, тулааны төрөлд “Уран зоригтой тоглогч”, өөрийгөө хамгаалах төрөлд “Шилдэг ур чадвартай тамирчин”-г тус тус шалгаруулж медаль, өргөмжлөлөөр урамшуулах бөгөөд багийн дүнгээр тэргүүлсэн багт “Ерөнхийлөгчийн нэрэмжит шилжин явах цом”, мөнгөн шагнал олгох ажээ.

Тив, дэлхий, олон улсын гардан тулааны тэмцээний дүрэм, журам, Монголын уламжлалт тулааны сургалттай уялдуулан олон улсын чанартай тэмцээн болгон өргөжүүлэн 20 дахь жилдээ зохион байгуулж буй Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит “Сонсогчийн алдар” тэмцээнд оролцож буй нийт баг, тамирчдадаа амжилт хүсье.

---o0o---

ТӨГСӨГЧДӨД БОЛОВСРОЛЫН ЗЭРГИЙН ДИПЛОМ, ЭНГЭРИЙН ТЭМДЭГ, ЦОЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА БОЛЛОО

Дотоод хэргийн их сургуулийг төгсөгчдөд боловсролын зэргийн диплом, энгэрийн тэмдэг, цол гардуулах ёслолын ажиллагаа өнөөдөр (2024.06.07) Их сургуулийн Спорт албаны дадлага сургалтын талбайд 11 цаг 40 минутад эхлэн ёслол төгөлдөр боллоо.



Дотоод хэргийн их сургуулийн 90 дэх хичээлийн жилийн төгсөлтийн баярын ёслолын ажиллагаанд Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын Их хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар болон захирлын зөвлөлийн гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Нямгэрэл, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал, бригадын генерал П.Жаргалан, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Д.Мөнгөнжин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга, хурандаа А.Намсаманд, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Уганбаяр, Шүүх шинжилгээний ерөнхий газрын тэргүүн дэд



дарга, доктор, цагдаагийн хурандаа Б.Даваа, Зэвсэгт хүчний жанжин штабын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Д.Дашзэвэг, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, Монгол Улсын гавьяат хуульч, доктор, эрхэлсэн комиссар Х.Буянтүмэн нарын зочид, төлөөлөгчид, эрдэмтэн багш нар, эцэг, эхчүүд оролцов.



Төгсөлтийн баярыг нээж, Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар үг хэллээ. Тэрбээр: Эрдмийн их өргөөний алтан босгыг алхан орж, үе тэнгийн залуустай мөр зэрэгцэн жагсаж, номын ширээнд тохой залган сууж, аюулгүй байдлын эрдэм ухаанд шимтэн суралцаж, оюутан цагийн хүсэл мөрөөдлөө биелүүлэн сургуулиа амжилттай төгсөж буй эрхэм төгсөгчид та бүхэндээ алдар гавьяа дайчин замналын 90 жилийн баялаг түүхтэй Дотоод хэргийн их сургуулийн эрдмийн хамт олны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун баяр хүргэе.

Түүхт их сургуулийнхаа үнэт зүйл, эрхэм бахархал болсон төгсөгч та бүхэн Монгол орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын үе үеийн төр, нийгмийн зүтгэлтэн, генерал, офицеруудын алдар гавьяаг залгамжилж, эрх зүйт төрийнхөө түшиг тулгуур, эгэл ардынхаа өмөг түшиг болж, хууль сахиулах, шударга ёсыг хэлбэрэлтгүй сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэнэ гэдэгт эргэлзэхгүй байна.



Төгсөгч таны ажил үйлс, алдар гавьяа тань Дотоод хэргийн их сургуулийн нэрийн хуудас болж явах учиртайг ямагт

санаж төрөлх сургуулийнхаа алдар нэрийг өндөрт өргөж явна гэдэгт итгэл төгс байна” хэмээв.

Монгол Улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр төгсөгчдөд баяр хүргэж үг хэллээ. Тэрбээр: “Хууль, эрх зүйн салбарын шинэчлэлийн энэ цаг үе, Дотоод хэргийн их сургуулийн хөгжил, дэвшлийн он жилүүдэд тус Их сургуульд элсэн суралцаж, хууль зүй, дотоод хэрэг, аюулгүй байдлын эрдэм ухаанд шимтэн суралцаж, сургуулиа амжилттай төгсөж буй эрхэм төгсөгч та бүхэнд боловсролын диплом, энгэрийн тэмдэг гардан авч буй энэ дурсгалт үйл явдлыг тохиолдуулан халуун баяр хүргэе.

Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Дотоод хэргийн их сургуулийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар дэмжиж ирсний нэг илрэл нь өнөөдрийн та бүхний төгсөлтийн баяраа тэмдэглэж буй энэхүү Спорт албаны дадлага сургалтын байгууламж юм.



Төгсөгч та бүхэн өргөсөн тангарагтаа үнэнч байж, хуулийг ёсчлон биелүүлж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, шударга түвшин, шуурхай, хий зайгүй хөдөлмөрлөж, ажлын эрх ашгийг нэн тэргүүнд эрэмбэлж, төрийн хүний ёс жудгийг эрхэмлэж, албандаа хүндэтгэлтэй хариуцлагатай ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд үүрэг болгож байна” гэлээ.

---o0o---

ТӨГСӨГЧДИЙН “ТУЯАТ ОРОЙН ТООЛЛОГО” ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА БОЛЛОО

Монголын ууган их сургуулиудын нэг 90 жилийн баялаг түүхтэй



Дотоод хэргийн их сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилийн төгсөгчдийн “Туяат оройн тооллого” ёслолын ажиллагаа өнөөдөр (2024.06.07) Их сургуулийн Спорт албаны дадлага сургалтын талбайд ёслол төгөлдөр боллоо.

Ёслолын ажиллагаанд Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа П.Батбаатар, тэргүүн дэд захирал, доктор, профессор, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар, дэд захирал, доктор, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат, дэд захирал бөгөөд штабын дарга, цагдаагийн хурандаа Г.Буянхишиг болон Захирлын зөвлөлийн гишүүд, Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан, ТТАХНЭ-ийн захирал, хурандаа Х.Бат-Ирээдүй, ЦЕГ-ын дэд дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, ШШЕГ-ын тэргүүн дэд дарга, доктор, цагдаагийн хурандаа Б.Даваа, ШШГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн дарга, хошууч Б.Наранбямба болон багш, албан хаагчид, төгсөгчдийн ар гэрийнхэн оролцлоо.



“Туяат оройн тооллого” эхлэхийн өмнө төгсөгчид болон зочдод зориулсан хүндэтгэлийн тоглолт болов. Урлагийн тоглолтын дараагаар төрийн тусгай албаны эгнээнд элсэн орж буй шинэхэн офицерууд алтан мөрдсөө гялалзуулан ёслолын ажиллагаанд жагсаж, Цэргийн гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт Дотоод хэргийн их сургуулийн одонт туг, Хилийн 0345 дугаар ангийн байлдааны тугийг залснаар “Туяат оройн тооллого” ёслол төгөлдөр эхэллээ.



Бүрэлдэхүүн сургуулиуд тус тусдаа “Туяат оройн тооллого” явуулж, Цэргийн албаны зохион байгуулалт, бэлэн байдлын газрын дарга, дэд хурандаа С.Баясгалан нэгдсэн дүнг Их сургуулийн захиралд илтгэв.

Төгсөгчид гурвантаа “Уухай” цуурайтуулахад Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэн харанхуйг гэрэлтүүлэн ёслолын буудлага буудлаа.

Эх орныхоо дөрвөн зүг найман зовхист дотоод аюулгүй байдлыг хамгаалах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг хэрэгжүүлэхээр мордох гэж буй төгсөгчид ёслолын жагсаалаар алхсанаар Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчдийн нэгдсэн туяат оройн тооллого өндөрлөлөө.

---o0o---

"МӨРДӨГЧ КЛУБ"-ЫН ТӨГСӨГЧДӨД СЕРТИФИКАТ, ЭНГЭРИЙН ТЭМДЭГ ГАРДУУЛЛАА

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн дэргэдэх Хүндэт чекист, цагдаагийн хурандаа Ц.Жамъянсэнгээгийн нэрэмжит “Мөрдөгч клуб”-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн төгсөлт боллоо.



"Мөрдөгч клуб”-ийн үйл ажиллагааг 2008 оноос эхлэн зохион байгуулж, гүйцэтгэх ажлын мэргэшүүлсэн ангийг бий болгон жил бүр 30-аас доошгүй сонсогчийг төгсгөдөг юм.

Энэхүү үйл ажиллагаанд Цагдаагийн сургуулийн захирал, Дотоодын цэргийн 804 дүгээр ангийн захирагч, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Б.Хишигтогтох, тэнхимийн багшлах бүрэлдэхүүн оролцож, төгсөгчдөд сертификат, энгэрийн тэмдэг гардуулав.



“Мөрдөгч” клуб нь Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн үндсэн ангийн 3 дугаар дамжааны сонсогчдоос сонгон шалгаруулж, шалгалт авч тэнцсэн сонсогчдыг элсүүлдэг. 2023-2024 оны хичээлийн жилд нийт 37 сонсогч төгсөж байгаа бөгөөд энэ удаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн сонсогчдоос элсүүлэн сургаж төгсгөснөөрөө онцлог байв.